

Г.Нандинбилиг,
С.Амарсайхан, Ц.Март, Д.Нямдорж

УРАН ЗОХИОЛ VIII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
8 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

ННА 74.2
ДАА 373
У-457

Уран зохиол VIII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 8 дугаар ангийн сурах бичиг. /Нандинбилиг Г., ба бус; Ред. Бигэрмаа Р. Тех.Ред. Норжинлхам С. - УБ.2017. - 148х

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99978-61-07-8

ГАРЧИГ

ХӨТӨЧ ҮГ	4
----------------	---

Нэгдүгээр бүлэг. МОНГОЛ АМАН ЯРУУ НАЙРАГ

1.1. ЕРӨӨЛ, МАГТААЛ	8
ГЭРИЙН ЕРӨӨЛ	8
БӨХИЙН ЦОЛ	12
ТҮРҮҮ МОРИНЫ ЦОЛ.....	14
1.2. БААТАРЛАГ ТУУЛЬС	16
ЭРИЙН САЙН ХАН ХАРАНГУЙ	16

Хоёрдугаар бүлэг. ШҮЛЭГ, НАЙРАГЛАЛ

2.1. ШҮЛЭГ	30
Б.Ринчен МОНГОЛ ХЭЛ.....	30
С.Дулам ХҮМҮҮН БИЧИГ	33
О.Дашбалбар ӨВӨГ ДЭЭДСЭЭСЭЭ БИД ЭХ ОРНОО ХҮЛЭЭЖ АВСАН.....	38
2.2. НАЙРАГЛАЛ	41
ЧИНГИСИЙН ЕСӨН ӨРЛӨГТЭЙ ӨНЧИН ХӨВГҮҮНИЙ СЭЦЭЛСЭН ШАСТИР	41
Б.Явуухулан ТЭХИЙН ЗОГСООЛ.....	53

Гуравдугаар бүлэг. ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖ.....

3.1.ӨГҮҮЛЛЭГ	66
Д.Намдаг ҮРЭГДСЭНИЙГ ХҮЛЭЭГЧ	66
Ж.Барамсай ЦҮНХТЭЙ ИНЭЭД.....	75
3.2.ТУУЖ	79
П.Лувсанцэрэн УСНЫ ЭРГҮҮЛЭГ БУЮУ БОРЗООНЫ ЯВДАЛ	79

Дөрөвдүгээр бүлэг. ХОШИН ЖҮЖИГ

4.1. ХОШИН ШОГ ҮЛГЭР.....	98
БАДАРЧНЫ ҮЛГЭРЭЭС	98
ДАЛАН ХУДАЛЧИЙН ҮЛГЭРЭЭС... ..	100
4.2.ХОШИН ЖҮЖИГ	106
Ч.Ойдов ДАЛАН ХУДАЛЧ.....	106

Тавдугаар бүлэг. ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ

5.1 ЭРТНИЙ ГРЕКИЙН ДОМОГ ТУУЛЬС	122
Хомер “ОДИССЕЙ”	124
5.2. ДОРНО ДАХИНЫ ШИДЭТ ҮЛГЭР	136
ШИДЭТ ХҮҮРИЙН ҮЛГЭР	136

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ	146
НОМ ЗҮЙ	148

ХӨТӨЧ ҮГ

Энэхүү сурах бичиг нь таван бүлгээс бүтнэ. Нэгдүгээр бүлэгт монгол аман яруу найргийн уламжлалаас ерөөл, магтаал болон баатарлаг туульсын жишээг авч судалсан бол удаах гурван бүлэгтээ монголын эртний болон орчин үеийн уран зохиолоос судлахаар, тавдугаар бүлэгтээ өрнө, дорнын сонгодог уран зохиолоос уншиж судлахаар оруулсан болно.

Сурах бичгийн нэгдүгээр бүлэг нь монгол аман яруу найргийн уламжлалаас ерөөл магтаал, баатарлаг туульсын хэл, бүтэц, хэлбэрийг задлан шинжилж, уран дүрийн үгийн сангаас суралцах, хоёрдугаар бүлэг нь монголын эртний болон орчин үеийн яруу найргийн бичвэрийг уншиж, мэдэрч хүлээн авах, шүлэг найраглалын хэл, бүтэц, хэлбэрийг задлан шинжилж хариулах чадвараа хөгжүүлэх зорилготой. Гуравдугаар бүлэг нь монголын орчин үеийн өгүүллэг, туужийн бичвэрийг уншиж, тусган хүлээж авах, сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих чадвараа хөгжүүлэх, дөрөвдүгээр бүлэг нь монгол хошин үлгэр болон хошин жүжгийн бичвэрийг уншиж, хошигнол бүтээх аргад суралцуулахад чиглэсэн болно.

Харин тавдугаар бүлэг нь дэлхийн сонгодог уран зохиолын орчуулгаас уншиж, бие даасан уншлагаа чиглүүлэх зорилготой.

Сурах бичгийн асуултууд нь мэдлэг бүтээхэд туслах бол дасгал даалгаврууд нь таны задлан шинжлэх чадварыг хөгжүүлэх замаар уран зохиол унших сонирхол таашаалыг нэмэгдүүлэх болно.

Номын бүлэг бүр нь дотроо хоёр нэгжээс бүрдэх ба нэгж бүрийн агуулгыг дараах байдлаар бүтэцчилэв.

Эхний хоёр бүлэг нь үндсэндээ шүлэглэсэн бичвэрийг судлах бөгөөд яруу найргийг уншиж, задлан шинжилж сурах арга барил эзэмшихэд тусална. Үргэлжилсэн үгийн уран зохиол болон жүжгийн зохиолын бүлгээс өмнө яруу найргийн бүлгийг уншиж судлахын учир нь шүлэг найраглал нь тууж, жүжиг зэрэг томоохон бүтээлээс хэмжээний хувьд богино байдагт оршино. Шүлэг найргийг судалснаар сурагчид бүтэн бичвэрийг шинжилж сурах төдийгүй яруу найраг хэрхэн эхэлж, өрнөж, төгсөж байгаа бүтцийг олж харах боломжтой. Бүлгийн холбогдох асуулт, даалгаврууд нь хичээлийн туршид сурагчдын задлан шинжлэх чадварыг хөгжүүлэхээр загварчилсан ба ахисан түвшний сурагчдын хувьд хувилбарт дасгалаас сонгон хийх, янз бүрийн цаг үеийн яруу найргаас сонгон, бие даасан уншлагаа хөгжүүлэх арга замыг зааж өгсөн болно.

Гуравдугаар бүлгийн эхний нэгж нь өгүүллэгийн бүрэн бичвэрийг задлан шинжлэх чадварыг хөгжүүлэх, удаах нэгж нь туужийн бичвэрээс хэсэглэн авч, бичил дүрслэлийн судалгааг эхлүүлэх ёстой. Энэ бүлгийн асуулт даалгаврууд нь зохиолчид өгүүлэг, туужийг хэрхэн эхлүүлж, орчин, уур амьсгалыг хэрхэн тохируулж, дүр болон сэдвүүдээ хэрхэн хөгжүүлж байгаа дээр төвлөрөх юм. Зохиолоос авсан хэсэглэлүүд нь хүүрнэл зохиолын бичвэрийг бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан шинжлэхэд зайлшгүй чухал хэсэглэлүүд байна.

Дөрөвдүгээр бүлгийн эхний нэгж нь монгол ардын хошин шог үлгэрийн дүр бүтээх болон хошигнол бүтээх аргыг шинжилсэн бол нөгөө нэгж нь Ч.Ойдовын хошин жүжгийн бичвэрээс хэсэглэн авч дүр, өгүүлэгдэхүүнийг боловсруулан хөгжүүлсэн туршлагаас судалсан болно. Асуулт даалгаврууд нь жүжгийн бичвэрийн харагдах байдал болон жүжгийн зохиолч жүжгээ хэрхэн ямар арга замаар эхлүүлж, тайз заслыг хэрхэн тохируулж, дүр болон сэдвээ бүтээдэг арга замуудыг танин мэдэхэд чиглэж байна.

Номын төгсгөлд түлхүүр нэр томъёоны толь, ном зүй зэргийг лавлагаа болгож орууллаа.



Сурах бичгийг хэрхэн хэрэглэх вэ?

Энэхүү сурах бичгийн хуудаснаа та эх зохиолын үндсэн бичвэрээс гадна түүний эргэн тойронд зохиолыг уншиж ойлгоход туслах асуулт даалгаврууд, үгийн тайлбар, түлхүүр нэр томьёо, зөвлөмж гэх мэт нэмэлт бичвэрийг олж харна. Эдгээр нь уран зохиолын хичээлээр судалж буй эх зохиолуудыг бие даан уншихад тань туслах болно.



Түлхүүр нэр томьёо: Энэ нь онолын ойлголт, нэр томьёог товч, энгийн үгээр тайлбарлах ба задлан шинжлэх асуулт, даалгаврын өмнөх зайд байрлуулсан байна.

Зөвлөмж: Энэ тэмдэглэгээ нь таны суралцах явц дахь зарим бэрхшээлийг хөнгөвчлөх, санаа сэдэл өгөх зорилготой. Мөн задлан шинжлэх асуулт, даалгаврын өмнөх зайд байрлана.



Ном уншлагад хөтлөхүй: Энэ нь сурагчид өөрийн сонирхол таашаалаар сонгон унших боломжтой яруу найраг, өгүүллэг, тууж, жүжгийн номуудыг зөвлөж, бие даасан уншлагад чиглүүлнэ.

Бүтээлч урлан: Энэ тэмдэглэгээ нь бүтээх түвшний даалгаврыг заах ба сурагчид өөрийн сонирхлоор сонгон гүйцэтгэх боломжтойн зэрэгцээ ахисан түвшний суралцагчийг өөрийгөө хөгжүүлэхэд чиглүүлнэ.

Зохиолчийн намтар

Үгийн тайлбар

Задлан шинжлэх асуулт даалгавар

Түлхүүр нэр томьёо

Зөвлөмж

Сурагчийн өөрийн үнэлгээ

Дүгнэлт

Ном уншлагад хөтлөхүй

Арга зүйн мэдлэг

	Суралцахуйн зорилтууд	I бүлэг		II бүлэг		III бүлэг		IV бүлэг	V бүлэг
		Ерөөл Магтаал	Баатарлаг туульс	Шүлэг	Найраглал	Өгүүлэг	Тууж	Хошин жүжиг	Гадаадын уран зохиол
Унших	Монголын баатарлаг туульс, иргэний яруу найраг, өгүүллэг, туурь тууж, хошин жүжиг, өрнө дорнын шилдэг зохиолоос уншиж, соёл түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээн авах								
	Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл /ёгтлол, егөөдөл/ -ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлах								
	Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц ба үйл явдлын дарааллыг хүүрнэлийн учир холбогдлоор тайлбарлах								
	Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдвийг хэрхэн өргөжүүлснийг задлан шинжлэх								
	Зохиолын орчин нөхцөл байдал нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг тайлбарлах								
	Зохиолын дүрүүдийн холбоо хамаарлаар гол ба туслах, сөрөг дүрийг тодорхойлох								
	Шүлэглэсэн зохиолын шад, холбоц, айзам хэмнэлийг тайлбарлах								
Бичих	Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмж сэтгэгдлээ бичих								
	Уншсан зохиолын дүр дүрслэлийг тайлбарлах								
	Уншсан зохиолын дүр, орчныг өөрчлөх буюу ёгтлол, егөөдөл ашиглан, үйл явдал өрнүүлэн, богино өгүүллэг зохиох								
Ярих	Шүлэглэсэн зохиолын айзам хэмнэлийг илрүүлэн уран унших								
	Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн бичих								
	Уншсан зохиолыг сонирхолтой ярих, танилцуулах								



I БҮЛЭГ

Б.Шарав. "Үрс гарч байгаа нь"



ЗУРГААС ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

- ▶ Зургийг харах эхний мөчид таны нүдэнд ямар дүр зураг хамгийн тод туссан бэ?
- ▶ Зурагт юу юуг дүрслэн харуулсан байна вэ?
- ▶ Зургийг хараад та нарт ямар сэтгэгдэл төрж байна вэ? Дараах зохиолуудыг уншихдаа монгол ахуй амьдралыг нэгэн хавтгайд дэлгэн харуулсан дээрх зургийн дүр дүрслэлтэй харьцуулан харж, уншаарай.



Нэгдүгээр бүлэг. МОНГОЛ АМАН ЯРУУ НАЙРАГ

1.1. Ерөөл, магтаал

Гэрийн ерөөл

Бөхийн цол

Морины цол

1.2. Баатарлаг туульс

“Эрийн сайн Хан Харангуй” тууль

ЗОРИЛГО:

Энэ бүлгийг судалснаар та монголын аман яруу найргийн уламжлалаас ерөөл магтаал, баатарлаг туульсын хэл, бүтэц, хэлбэрийг задлан шинжилж, уран дүрийн үгийн сангаас суралцана.



1.1. ЕРӨӨЛ, МАГТААЛ

Ерөөл нь аливаа баяр ёслол, хурим найрын үед ирээдүйн аз жаргал, сайн сайхныг бэлгэдэн хэлдэг зан үйлийн уран шүлэглэл юм. Ерөөлийг тусгайлан мэргэшсэн, авьяас билигт ерөөлчид хэлэх бөгөөд тухайн цаг үест тохируулан шууд зохион шүлэглэх нь бий. Ерөөлч малгайгаа төв тэгш өмсөж, гэрийн эзэн юм уу, найрын ахлагчийн зөвшөөрлөөр эдийн манлай хадаг дээр идээний дээж айраг юм уу, сархдыг тавиад, гэрийн баруун талд сөнгийн дэргэд зогсон, хоймор суугаа зочдын өөд хандаж ерөөдөг заншилтай.



Дөрвөн ханатай монгол гэрийг 11 дахин багасгасан "Мимо" гэр
Эх сурвалж: www.naadbrand.com

Бичвэр 1.

ГЭРИЙН ЕРӨӨЛ



УНШИХЫН ӨМНӨ

- Зургийг анхааралтай ажигла. Зурагт юу юуг дүрслэн үзүүлсэн байна вэ?
- Дараах ерөөлийг уншихдаа зохиолын дүрслэлийг зургийн дүрслэлтэй харьцуулан, гэрийн бүтэц хэсгүүдийг хэрхэн дүрслэн магтаж буйг ажиглаарай.

Зээ!

Цаанаа чамин хээтэй
 Наанаа нанжин хээтэй
 Цацаг бүрийдээ найман тахилтай
 Намгүр хадган дээрээ
 Алт мөнгөн хундагатай архийг
 Амсар дүүрэн бялхуулж
 Намайг ерөө гэсийм (гэсэн юм) биз ээ
 Урт цагаан туургатай
 Уран тагнай хаяавчтай
 Далай цагаан дээвэртэй
 Дөрвөөр ширмэл
 Дөрвөн бүслүүртэй
 Ар өвөр тийшээ зөрөгсөн
 Арван хоёр оосортой
 Хойшоо урагшаа зөрөгсөн



ҮГИЙН ТАЙЛБАР

Туурга

Гэр, асар, цацрын хажуу
талаар нөмөргөн бүтээх
эсгий, бөс

Хаяавч

Гэрийн хаяагаар тойруулан
ороох мод, эсгий зэргээр
хийсэн хэрэглэл

Дээвэр

Гэрийн дээр тавих эсгий
хучлага

Бүслүүр

Гэрийг нь тойруулан бэхэлсэн
дээс

Хорол

Хүрд гэсэн төвөд гаралтай
үг. Хорол нь найман тахилд
ордог энх амгалангийн
бэлгэдэл

Норов

Эрдэнэ гэсэн төвөд гаралтай
үг. Үнэт эрдэнийн чулуу

Хас

Ертөнцийн үүсэл, уялдаа
холбоог илэрхийлэн дүрсэлсэн
бэлгэдэлт хээ

Нацаг, нацагдорж /очир

Элдэв гэсэн утгатай төвөд
үг. Бат бөх, цаг хугацааг
даван туулагч эрч хүч, төгс
чадлын бэлгэ тэмдэг

Бадмаанямбуу

Лянхын зүрх гэсэн төвөд
үг. Балба, Индонези, Хятад
зэрэг оронд ургадаг нэг зүйл
модны үр

Тодвон

Бичний гавлаар хийсэн цөгц

Нанжин хээ

Хээнцэр гоёмсог хээ

Найман тахил

Айл гэрийн аз жаргалын
бэлгэдэл бөгөөд цагаан
шүхэр, алтан загас, алтан
бумба, цагаан лянхуа, цагаан
лавай, өлзий утас, ялагч
дуаз, алтан хорол гэсэн энх
амгалангийн бэлгэдэл бүхий
найман дүрс ордог

Хорин дөрвөн оосортой
Бөмбий цагаан өргөө юм байна аа!
Гэрийн доторх нэгэн зүйл
Хорол эрдэнэ тоонотой
Норов эрдэнэ уньтай
Хас эрдэнэ ханатай
Нацаг эрдэнэ хаалгатай
Бадмаанямбуу баганатай
Бат ган тулгатай юм байна аа!
Гэрийн доторх нэгэн зүйл
Бурхны хайрцгийг нээгээд үзвэл
Гэрэлтэнгээс зул
Үнэртэнгээс хүж
Тогосын өд, тодвон цөгц
Эдгээр зүйл цөм бүрэн юм байна аа!
Баруун хойд талын нь авдрыг нээгээд үзвэл
Эр хүмүүний эдэлж хэрэглэдэг нэгэн зүйлээс
Цаас цавуу
Бийр бэх
Эрээн лимбэ
Эрчтэй гурамсан хуйв
Эрийн зодог шуудаг
Хурдан морины хусуур
Хур сүүлний боолтын хамтаар
Эдгээр зүйл цөм бүрэн юм байна аа!
Зүүн хойд талын авдрыг нээгээд үзвэл
Хуй хуйгаар торго
Хунз хунзаар цай
Ховд ховдоор цэмбэ
Эдгээр зүйл цөм бүрэн юм байна аа!
...Зээ!
Санасан болгон саваа дүүрч
Бодсон болгон нь номын ёсоор
Төвшин сайхан бүрэлдэхийн ерөөлийг
Дээш дээш нь дэвшүүлэн сонсоё оо!...

Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном. Монгол ардын аман зохиолын
дээж бичиг, УБ., 1967, 105-106 дахь талаас хэсгэлэн авав

Бичвэр 2.

ГЭР МЯЛААХ ҮГ

Түмэн өлзий бүрдсэн
Төр улсыг бататгасан
Төгс их жаргалын
Төвшин сайн өдөр гэж
Сарын сайныг саатан хүлээж
Өдрийн сайныг өнжин хүлээж
Өнөөдрийн өдрийг
Өлзийтэй сайн өдөр гэж
Өндөр дэнж дээр
Өргөөгөө барьж байгаа юм байна.
Барьсан газрыг шинжилж
Баруун зүүн талаас нь харвал
Барс арслангийн шинжтэй
Байр байдлыг ажиглавал
Бадмалянхуа цэцэг шиг
Бадарч дэлгэрмээр газарт
Барьсан юм байна.
Найман тал руу нь уясан
Наян хоёр оосортой
Ташаа зөрүүлэг бүрийг дарж уясан
Далан хоёр оосортой
Далай цагаан өргөө байна.
Оролцуулж хийсэн зүйлүүдийг
Онцолж заримыг дурдвал
Хойд хангайн бургасаар
Хавирга юуг нь хийсэн
Хандгай бугын зоогоор
Наана цаанаас нь товчилсон
Хана түүнийг мялаая.
Урд хангайн модоор
Унь юуг нь хийсэн
Унага дааганы хялгасаар
Сагалдарга юуг нь хийсэн
Унь түүнийг мялаая.

Хангайн модыг хагалж хийсэн
Харуулын ирээр өөлж хийсэн
Хамаг амьтныг хашин тогтоосон
Хаалга түүнийг мялаая.
Хус модыг цавчиж хийсэн
Хуруу даагыг өрөмдөж хийсэн
Нарны гэрлийг нааш оруулагч
Галын гэрлийг гадагш дэлгэрүүлэгч
Хорол эрдэнийн шинжтэй
Тооно түүнийг мялаая.
Далай цагаан дээвэртэй
Даргар цагаан туургатай
Хошлон хялгасан бүслүүртэй
Тагнай ширээстэй үүдтэй
Угалз ширээстэй өрхтэй
Цөм бүрэн түүнийг мялаая.
Төрийн дөрвөн тогтоотой
Төмөр дөрвөн шийртэй
Ган хуяг цагаригтай
Галын тулга түүнийг мялаая.
Энэ айл нь
Олон малыг гаднаа хураагаад
Оюунтан бүгдийг гэртээ дүүргээд
Өвч хивс дэвсгэртэй
Өнгийн идээ жимс өрөөстэй.
Үрээ даагаа танихгүй баян
Үр хүүхдээ танихгүй өнөр
Төр засаг нь
Төмөр хүрээ мэт батжиж
Төрсөн бид нар нь
Хаврын цэцэг мэт дэлгэрч байхын
Үүрдийн сайхан ерөөлийг
Өндөр дуугаар өөд өөд нь
Өргөн дэвшүүлье ээ!

Ц.Дамдинсүрэн. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой.
УБ 1959 107-110 дахь талаас товчлон авав.

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгавар

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Ерөөл:

- Аливаа баяр ёслол, хурим найрын үед ирээдүйн аз жаргал, сайн сайхныг бэлгэдэн хэлдэг зан үйлийн уран шүлэглэлийг ерөөл гэнэ.

ЗӨВЛӨМЖ

- Танил бус үгийн утгыг тайлбарлахдаа эхлээд хам сэдвээс утгыг таамаглаарай. Дараа нь толь бичиг ашиглан тайлбарлаж бичээрэй. Бичсэн тайлбаруудын ялгааг ажиглаж, дүгнэлт гаргаарай.

1. Гэрийн ерөөлийг уншина уу. Ерөөлийн шүлэгт утгыг мэдэхгүй үг байна уу? Ерөөлөөс гэрийн эсгий эдлэл, оосор бүчийг хэрхэн тоочиж магтсаныг эшлэл авч тайлбарлана уу.
2. Гэрийн доторх эд зүйлийг ямар дарааллаар хэрхэн бүртгэн тоочсоныг ажиглана уу.
3. Ерөөлд “зөрсөн” гэдэг үгийг яагаад “зөрөгсөн” гэж бичсэн бэ? Ямар учиртай гэж та нар бодож байна вэ?
4. Гэр мялаах үгийг уншина уу. Хэдэн хэсгээс бүрдэж байна вэ? Эхлэл хэсгийг ажиглан, өдрийн сайныг шинжсэн, газар нутгийн сайныг шинжсэн хэсгүүдийн доогуур зурж тэмдэглэнэ үү.
5. Ерөөлийн хүнд хандан ерөөж буй гол санаа нь шүлэглэлийнхээ чухам аль хэсэгт илэрч байна вэ?
6. Ерөөлийн бүтэц хэсгүүд нь гэрийн бүтэц хэсгүүдтэй хэрхэн холбогдож байна вэ?
7. Ерөөлд гэрийн эд хэрэглэлүүдийг юугаар хийдэг тухай хэрхэн тусгасан байна вэ?
8. Ерөөлд ямар уран дүрслэл байна вэ? Зохиолоос эшлэл авч, уран дүрслэлийн ямар хэлбэр болохыг тодорхойлж бичээрэй.

Эшлэл	Тайлбар

9. Ерөөлөөс гэрийн мод, бүтцийг нэрлэсэн үгсийг түүж бичээд зурж тайлбарлаарай. Ерөөлд монгол гэрийн тооно, унь, хана, хаалга зэргийг ямар ямар эрдэнээр хэрхэн бэлгэдсэн байна вэ? Эдгээр бэлгэдэлт хээ дүрсийг судалж, тайлбарлаарай.

	Эшлэл	Тайлбар
Тооно	Хорол эрдэнэ	
Унь		
Хана		
Хаалга		
Тулга		

10. Ерөөлийн шүлгийн толгой сүүл холбоц нь, айзам хэмнэлийг задлан шинжилж зохиолоос эшлэл авч тайлбарлана уу.

МАГТААЛ

Монгол хүний бэлгэдэх сэтгэлгээ, үгийн ид чадалд итгэх үзлийн илэрхийлэл болсон зан үйлийн учир зорилго бүхий мэргэжлийн аман яруу найргийн нэгэн зүйлийг магтаал гэнэ. Морь бөхийн цол нь монгол магтаалын өвөрмөц хэлбэр юм. Хүчит бөхчүүдийн хийморь золбоог сэргээж, хүч бярыг нь магтан дуулахыг бөх цоллох гэнэ. Улсын их баяр наадмын гурав, тав, долоогийн даваанд тус тус бөхчүүдийг цоллодог уламжлалтай.

Бичвэр 1.

БӨХИЙН ЦОЛ

Баруун талын засуул сонс оо!
 Бөхийг амлая аа!
 Бүрэн эрхт Монгол Улсын...
 Улс хувьсгалын
 Яруу алдарт ... жилийн ойн
 Их баяр наадмын ...
 Аварга аа ...
 Энэ их баяр цэнгэлийн
 Түгээмэл жавхлан бүрдүүлсэн
 Түмэн олны дотроос шалгарсан
 Монгол даяар алдартай
 Хамаг олноо баясуулагч
 Харилтгүй зоригт
 Хурц гарамгай
 Хурдан шаламгай
 Баатар зоригт
 Бадрангуй хүчит
 Өсөн нэмэх
 Өрнөн дэлгэрэх
 Улам улам сайжрах
 Уран мэхт
 Олон түмний дундаас
 Онцлон шалгарсан
 Бүхний тэргүүн
 Бөхийн магнай
 Идэр залуу
 Аварга аа!
 Танай талын баруун жигүүрт байгаа
 аймгийн залуу бөх
 -ийг амлан авч

Олон түмний өмнө
 Уран мэхийг уралдуулан хийж
 Барин авч барилдаж
 Хүчийг үзье гэв ээ...



Эх сурвалж: www.zms.mn

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Магтаал, цол:

- Хүчит бөхчүүд болон хурдан хүлгийнхээ хийморь золбоог сэргээн бадраах зорилгоор магтан дуулсан аман яруу найргийн нэгэн зүйлийг цол гэнэ. Цол нь магтаалын өвөрмөц хэлбэр юм.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Бөхийн цолыг уншина уу. Цол хэдэн хэсгээс бүрдэж байна вэ? Хэнд хандаж байна вэ?
2. Бөхийн цолны гол санаа зорилго нь шүлгийн аль хэсэгт илэрч байна вэ? Цолыг хэрхэн төгсгөж байна вэ?
3. Бөхийн цолны бүтэц хэсгүүд нь бөхийг амлан авах соёл зан үйлтэйгээ хэрхэн холбогдож байна вэ?
4. Бөхийн цолыг хэн, хэзээ, хаана, хэрхэн дууддаг вэ? Цол дуудах хүнд ямар авьяас чадвар хэрэгтэй вэ? Бөхийн цол дуудахын учир юу вэ?
5. Баяр наадмын бөхийн барилдааны хэдийн даваанд бөх цоллодог вэ?
6. Бөхчүүдийн цол хоорондоо адилхан байдаг уу? Адил биш бол яагаад?
7. Цол дуудаж байх үеийн бөхийн хөдөлгөөнийг нэрлэж, учир утгыг тайлбарлана уу.
8. Бөхийн цолонд ямар дүрслэх хэрэглүүрийг голлон хэрэглэсэн байна вэ? “харилтгүй зоригт”, “хурц гарамгай”, “хурдан шаламгай” гэсэн нь ямар дүрслэх хэрэглүүр болох вэ?
9. Монгол Улсын ямар ямар түүхт ойг тэмдэглэж баяр наадмыг хийдэг вэ? Энэ онд Их Монгол Улс байгуулагдсаны хэдэн жилийн ой тохиож байгаа вэ? Цэгийн оронд гүйцээн бичнэ үү.

БҮТЭЭХ УРЛАН:

Дараах даалгавруудаас сонгон гүйцэтгэнэ үү.

- А. Бөхийн цолыг аялгуулан дуудаж сураарай.
- Б. Улсын их баяр наадмын бөхийн барилдааны цоллож буй бичлэгийг сонсож дуртай бөхийнхөө цолыг дэвтэртээ буулган бичнэ үү.
- В. Бөхийн мэх болоод хурдан морины уяа сойлгыг хэрхэн тааруулж уралдуулдаг талаар ахмад хүмүүсээс сурвалжилга хийж, ангийн ханын сонинд тавиарай.
- Г. Нутгийн сайн бөхчүүдийн тухай түүх домог, хууч яриаг сурвалжлан олж, тэмдэглээрэй. Тэдгээр домогт бөхчүүдийн бял чадлын талаар өгүүлэхдээ уран сэтгэмжээр хэрхэн баяжуулсныг ажиглан судлаарай.



Эх сурвалж: www.eagle.mn

Бичвэр 2.

ТҮРҮҮ МОРИНЫ ЦОЛ

Бүрэн эрхт Монгол Улсын
..... аймгийн сумын
ард-ийн
Өтгөн сүргийн гүүний унага аа!
Хангай дэлхийн сүрийг бадруулагч
Хамаг амьтны ханашгүй
Баяр цэнгэлийн манлай
Төрийн наадмын баясгалан болсон
Түмэн агтын түрүүнд
Түдэлгүй хурдалдаг
Мянган агтын түрүүнд
Мятралгүй хурдалдаг
Мяндсан жолоо сунган гүйдэг
Заан дөрвөн соёог яралзуулсан
Заамал зургаан хүзүүг сунгасан

Төө сайхан чихийг солбилзуулсан
Төгрөг хар нүдийг тормолзуулсан
Туулай сайхан зоог хотолзуулсан
Тураг сайхан биеийг холбилзуулсан
Шашир сайхан дэлийг сагсалзуулсан
Шанам сайхан сүүлийг самбалзуулсан
Эрчимт дөрвөн туурайг жирэлзүүлсэн
Эрдэмт дөрвөн хөлийг гялалзуулсан
Дайрч ирсэн даянгийн хүлэг
Давхиж гарсан хангайн буга
Түмний дуртгал
Даяарын гайхамшиг
Ган зуузай
Галт идэр хүлэг ээ!
Энэ наадмын өмнө
Эрхэм цолыг өргөн дэлгэрүүлсэн
Ирэх наадмын өмнө
Өсөх цолыг тэмдэглүүлсэн
Олон түмэн ардын өмнө
Онц сайхан үзэмж болсон
Эзэн хүнээ баярлуулсан
Ижил олноо арвижуулсан
Магтаж баршгүй эрдэмтэй
Мандуулж баршгүй үзэсгэлэнтэй
Элдэв зүйлийн
Эрдэнэсийн шинж бүрдсэн
Энх амгалан
Түмний эх
Торгон жолоо
Тод магнай хүлэг ээ!



ҮГИЙН ТАЙЛБАР

Шанам

Төвөд, монгол лам нарын
өмсдөг улаан, шар өнгийн
эсгийгээр хийсэн малгай
(шилжсэн утга нь: сагсгар,
самбагар)

Шашир

Дээрээ цацаг бүхий ардаа
залаатай, сүмийн хурал
ёслолын үед өмсдөг малгай

Монгол ардын зан үйлийн аман зохиол.
ШУА., ХЗХ., УБ., 1987, 166-167 дахь тал

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх, асуулт даалгавар

1. Морины цол нь хэдэн хэсгээс бүрдэж байна вэ? Хэнд хандаж байна вэ?
2. Цолд хурдан морины ямар шинжүүдийг хэрхэн онцлон магтсан байна вэ? Эшлэл авч тайлбарлана уу.

	Эшлэл	Тайлбар
Чих	Төө сайхан чих	
Дэл сүүл		

3. Морины цолыг хэзээ, хаана, хэн, хэрхэн дууддаг вэ? Цолоо дуудуулж буй морьдыг хэрхэн мялаах вэ?
4. Энэ морины цол ямар дүрслэх хэрэглүүрээр голлож бүтсэн байна вэ?
5. Хурдан хүлгийг ямар ямар амьтантай адилтгасан байна вэ? Эдгээр адилтгалыг түүж бичнэ үү. “Мяндсан жолоо”, “торгон жолоо”, “шашир дэл”, “шанам сүүл” гэсэн үгсийн утгыг тайлбарлаж, ямар дүрслэх хэрэглүүр болохыг тайлбарлана уу.
6. “- сан” төгсгөл бүхий үйл үгс шүлгийн айзам хэмнэлд ямар үүрэгтэй вэ?
7. Ерөөл, магтаал хоёрын ижил ба ялгаатай талыг дараах харьцуулсан бүдүүвчээр харуулна уу.



БҮТЭЭХ УРЛАН:

Дараах даалгавруудаас сонгон гүйцэтгэнэ үү.

- ▶ Хурдан морины цолыг цээжилж, аялгуулан дуудаж сураарай.
- ▶ Дээрх цолонд дурдсанаас гадна өөрсдийн мэдэх хурдан морины шинжүүдийг жагсаан бичээд, морины цолны хэлбэрт оруулан шүлэглэж, бүтээлийн сангаа баяжуулаарай.
- ▶ Адууны зүс болоод хурдан морины уяа сойлгыг хэрхэн тааруулж уралдуулдаг талаар ахмад хүмүүсээс сурвалжилга хийж, ангийн ханын сонинд нийтлээрэй.
- ▶ Улс даяар алдартай хурдан хүлгийн талаар түүх домог, хууч яриаг олж тэмдэглээрэй.
- ▶ Тэдгээр домогт морины хурд хүчний талаар өгүүлэхдээ уран сэтгэмжээр хэрхэн баяжуулсныг ажиглан судлаарай.

1.2. БААТАРЛАГ ТУУЛЬС

Монгол үндэстний магтах бахдах сэтгэлгээ, тоочин дүрсэлж шүлэглэх түүхэн туршлагын өвөрмөц нэгдэл болсон баатарлаг туульс нь хэм хэмнэл, аяс аялгуу төгс, өвөрмөц аман яруу найраг билээ. Монгол туульсын яруу найргийг туульчид амаар зохиож, амаар уламжлан дамжуулж иржээ.

УНШИХЫН ӨМНӨ

- ▶ Тууль хайлах бичлэгийг сонсохдоо туульч яруу сайхан үг хэллэгийг хэрхэн хэлж дуудаж, ямар айзам хэмнэл үүсгэж байгааг мэдэрч сонсоорой.
- ▶ Мөн туульсын уран дүрийн үгсийн сангаас хичээн суралцаарай.

ЭРИЙН САЙН ХАН ХАРАНГУЙ



Хэсэглэл 1

Эрт нэгэн сайн цагт буюу.
Айхан тохой нутагтай
Алаг уул түшлэгтэй
Аршаан булаг ундтай
Сүн далай услууртай
Сүмбэр уул түшлэгтэй
Хөвчин тал нутагтай
Хөх уул түшлэгтэй
Мянга таван зуун настай
Мяталгүй хаан сайн аавтай
Хатан Дүнгээ гоо сайхан ээжтэй
Газартай гацалдан төрсөн
Тэнгэр нартай тэрсэлцэн төрсөн
Төрсөөр төр улсаа алдаагүй
Гарсаар газар усаа алдаагүй
Долоон насандаа доргилон төрсөн
Долоон их байрыг эвдэн төрсөн
Эрхийтэнд авталгүй
Эгэмтэнд дийлдэлгүй
Эрийн эрдэм төгссөн
Эрийн сайн Хан Харангуй гэж
Явав буюу гэнэ.
Алтай дүүрэн арван түмэн
Алаг бараан адуутай
Хангай дүүрэн хорин түмэн
Хонгор бараан адуутай



УГИЙН ТАЙЛБАР

Айхан
сайхан

Байр
цайз боомт

Өтөг
эр баавгай

Чон
улаан өнгийн хагас үнэт чулуу

Гунан
гурван нас

Дөнөн
дөрвөн нас

Дүнчүүр
тэрбум буюу зуун сая



Ав шувуунд унадаг
 Их Хар морьтой
 Айл зуур унадаг
 Бага Хар морьтой
 Хатуу дайсанд унадаг
 Хүлэг нь гэвэл
 Сойр сайхан дэлтэй
 Сувсан сайхан сүүлтэй
 Туулай сайхан зоотой
 Дугариг сайхан хүзүүтэй
 Тугал хар нүдтэй
 Голт сайхан биетэй
 Холч сайхан цээжтэй
 Хас эрдэнэ шүдтэй
 Хайлаар мөнгөн уруултай
 Хар болд туурайтай
 Хавиргандаа завсаргүй
 Харцагандаа үегүй
 Ерэн алд биетэй
 Есөн төө чихтэй
 Наян хүлгийн шинж бүрдсэн
 Нарийхан Чон хүрэн морьтой
 Гунах үхрийн арьсаар
 Гурамслан гөрсөн
 Дөнөн үхрийн арьсаар
 Дөрөмслөн гөрсөн
 Довцог хар ташууртай
 Гучин гурван хударга
 Хорин дөрвөн хөмөлдөртэй
 Дөчин дөрвөн оломтой
 Хүрэл мөнгөн хазаартай
 Долоон цагаан тохомтой
 Хөтлийн чинээ
 Дөш хар эмээлтэй
 Арын харгай санчиг болсон
 Алтан бөгжтэй
 Мөнгөн товруутай
 Харгай хар саадагтай
 Тасын өдийг
 Таслалгүй тавьсан
 Таван хар сөдтэй
 Гучин улаан зэв дүрсэн
 Ерэн тэхийн эврээр
 Элэглэж хийсэн
 Тэвхэнд нь
 Тэх марал зурсан

Бариулд нь
 Барс өтөг байгуулсан
 Мянган хүчит
 Заан цагаан нумтай
 Гучин алд иштэй
 Сумт улаан жадтай
 Мөнгөн болд мөртэй
 Мөсөн болд иртэй
 Есөн алд хар илдтэй
 Шил эрдэнэ шигтгээтэй
 Шижир алтан дуулгатай
 Далан давхар илтэстэй
 Далай цоохор хуягтай
 Гурван сая гурван бум
 Түмэн дүнчүүр албаттай
 Арын гөрөөсийг ард нь намнаж
 Өврийн гөрөөсийг өвөрт нь намнаж
 Өглөө үдшийн зоог болгон явдаг
 Эр агсанж буюу гэнэ...

Хэсэглэл 2

...Ах дүү хоёр мангасын яс үсийг үнс
 болгож орхиод
 Үет өвснөөс дээгүүр
 Үүлт тэнгэрээс доогуур
 Өлөн чоно мэт гишгүүлэн
 Сар нар гартал
 Цаг үе болтол
 Гүйлгээд явав буюу.
 Талд нь тавьж
 Тайгад нисгэж
 Ерэн есөн жилийн газрыг
 Ерэн есөн сар
 Ерэн есөн сарын газрыг
 Ерэн есөн хоногоор товчилж
 Агь Буурал хааны
 Их нутгийн захад
 Хүрэн ирвэл буюу
 Хоёр биеэ хувилгаж
 Хожгор заарт хөвүүн болов.
 Унасан хүлгээ
 Гурван хамуут даага болгон
 Хулсан нум дэрсэн сумтай
 Хоёр хожгор заарт бор
 Хөвүүн болон хувилаад
 Шав шав цохиж
 Хүр хүр давирагч болон явтал урдаас

нь түмэн цагаан тэмээ хариулсан Цал буурал өвгөн ирж уулзан асуув...Тэр харагдагч манай гэр билээ. Хоёр хүүхэд минь явдлын улс байна, очиж цай уугтун. Тэмээгээ цуглуулж, хойноос тань очъё гэж хэлээд өвгөн тэмээндээ явав.

...Шөнө өвгөний гэрт хэвтэж байтал их хожгор өвгөнөөс асуув гэнэ.

Танай хааны дагинын

Ид шид юу буй?

Сайн сайхан ямар хэвтэй буй

Гэж сурсанд хөгшин хэлэв

Манай дагинын ид шид болбол

Өнгөрсөн арван хоёр жилийн

Гайг таан айлддаг

Ирээдүй арван хоёр жилийн

Гайг угтан айлддаг

Хатсан модноос жимс ургуулан

Хуурай газраас ус гаргах

Үхсэн хүнийг босгох

Үгүйрсэн хүнийг баяжуулдаг

Сайн сайхан нь болбол

Хойшоо харж нойрсоход

Хойт зүгийн хүн

Гэгээн гэрэлд нь

Үүр цайж нар гарав гэж

Өрхөө татаж үнсээ гаргаж

Үхрээ сааж

Урагшаа харж нойрсоход нь

Урд зүгийн амьтан

Үүр цайж нар гарав гэж

Өрхөө татаж үнсээ гаргаж

Үхрээ саах

Гэр нэвт гэрэлтэй

Туурга нэвт туяатай

Тунгалаг улаан царайтай

Ийм дагина байна.

Тэнгэрийн хүү Эрхэм харын

Ид шид эр чадлыг сайн эс мэдэв

Үзэхэд сайн сайхан

Эр байна гэж хэлэн байв гэнэ.

Дагинынхаа ид шид сайн сайхныг сайтар хэлсэнд чинь баярлав гэж их хожгор арван алд алчуур дурданг өвгөнд шагнаж өгөв. Шөнө унтаж хэвтэж буюу. Гэнэт гэгээ оров. “Үүр цайв” гэж хоёр хожгор босч, “Морио барья” гэхэд өвгөн хэлэв гэнэ. “Эвий хүүхдүүд минь, үнэхээр үүр цайх биш байнам. Манай дагина наашаа харж нойрсоход гэгээ гэрэл нь ийм байдаг билээ. Та минь зүгээр унтаж, нойроо сайн хангаад явахгүй юу” гэв. “Эвий өвгөн өдий шүдээ унаж, үсээ цайтал үе гишүүгээ сулартал үүр шөнө ялгахгүй жигтэй өтөлсөн өвгөн билээ, чи” гэж бор хэвнэгээ өмсөөд, мордон явтал бас дахин харанхуй болон одоход “авхай адбиш гэрэлтэй билээ” гэж, хээр хэвтэж, үүр цайлгаад өглөөний шар нарнаар мордон гүйлгээд, Агь Буурал хааны өргөөний урдах уулан дээр гаран хамаг бүгдийг харуулдан ажиглав гэнэ...

Эрийн сайн Хан харангуй. Гар бичмэл эхүүдийг харьцуулан боловсруулж, оршил бичиж, тайлбар сэлт үйлдсэн Р.Нарантуяа, УБ., 1986 он

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Баатарлаг туульс:

- Домог зүйн дээд тэнгэр нарын эрх сүрийг үгүйсгэж, хүний хүч чадлыг батлан үзүүлж буй, монгол үндэстний магтах бахдах сэтгэлгээ, тоочин дүрслэх түүхэн туршлагын өвөрмөц нэгдэл болсон аялгуут аман яруу найргийг баатарлаг туульс гэнэ.

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Хэтрүүлэл:

- Юмс, үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж байдлыг ерийн байдлаас нь ихэсгэн давуулж дүрслэх уран дүрслэлийн ур маягийг хэтрүүлэл гэнэ.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Хэсэглэл 1-ийг уншина уу. Мэдэхгүй үг хэллэгийг сонгон тэмдэглэж, утгыг толь бичгээс лавлана уу.
2. Хан Харангуй баатрыг туульд хэрхэн магтан дүрсэлсэн байна вэ?
3. Хан Харангуйг магтсан дараах хэллэгийн утгыг хам сэдвийн хүрээнд тайлбарлана уу.

Үг хэллэг	Тайлбар
Эрхийтэнд авталгүй Эгэмтэнд дийлдэлгүй	
Долоон их байрыг эвдэн төрсөн	

4. Хан Харангуй баатрын хүлэг Чон хүрэн морины эрхэм сайн шинжийг хэрхэн дүрслэн шүлэглэсэн байна вэ?
5. Баатрын зэр зэвсэг, морины тоног хэрэгслийг хэрхэн магтан дүрсэлсэн бэ? Баатарлаг туульсын тоочин дүрслэх найруулгын онцлогийг тодорхойлно уу.
6. Хэсэглэл 2-ыг уншина уу. Туульсын баатар ерэн есөн жилийн тэртээ газраас ураглахаар мордож буй тухай туульсын энэхүү өгүүлэмж нь бидэнд юуг мэдээлж байна вэ?
7. Туульсад эмэгтэй хүний гоо үзэсгэлэн хэрхэн дүрсэлсэн байна вэ? Сэтгэлд нийцсэн дүрслэлийг эшлэн, тайлбарлана уу. Туульсад яагаад ингэж бодит байдлаас давуулан дүрсэлдэг талаар ярилцаж, энэхүү уран дүрслэлийн аргын үүргийг тодорхойлно уу.
8. Туульсын бичвэрээс бодит байдалд боломжгүй, хэтийдсэн дүрслэлийг сонгон авч, сэтгэгдлээ бичнэ үү.

	Эшлэл	Тайлбар
Туульсын баатрыг дүрслэхдээ		
Хүлэг морийг дүрслэхдээ		
Авхай дагиныг дүрслэхдээ		

ЭРИЙН САЙН ХАН ХАРАНГУЙ

Хэсэглэл 3

...Хаан зарлиг болов
Хоёр хүүхэд минь хоорондоо
Эрийн гурван наадмаар наадаж
Хэн дийлсэн тань
Миний авхайг автугай! гэв.
Хан Харангуй
Тэгвэл тэгнэ биз
Тэнгэрийн хүү Эрхэм хар чи хэл
Хэдий чинээ газраас
Морь тавих буй
Хэдий чинээ газраас
Бай харвах буй
Бөх хаана
Барилдах буй гэж
Асуун байв гэнэ.
Эрхэм хар хэлэв гэнэ.
Ес есөн сарын газраас
Морь уралдъя
Есөн сарын газраас
Бай харвах уу?
Хааны ордон дээр
Бөх барилдъя гэв.
Түүний чинь
Өлгийтэй хүүхдийн наадам
Өлөгчин нохойн хуцлага гэх буюу
Морийг ерэн есөн сарын газраас
Айхан тохой нутаг хүртэл
Үсэргэсээр одоод
Айхан тохой нутгаасаа
Нааш тавья
Нум сум харвахыг
Есөн сарын газар болно.
Хамгийн наад захад
Хонин чинээ цагаан чулуу тавья
Түүний цаана
Үхрийн чинээ хар чулуу тавья
Түүний цаана
Тавин хасаг түлээ тавья
Түүний цаана
Үхрийн сүүж хатгая
Түүний цаана
Үет цагаан өвс хатгая
Түүний цаана
Алтан тэвнэ хатгая

Хас хадыг нураая.
Хадыг хага харваж
Хасаг тэрэг явах
Зам гаргаад
Хааных хүртэл
Сум тэшүүлж
Хагас албатыг сүйд болгон
Түймэр шатаан харвая
Бөхийг ч мөн энд
Тавья гэж хэлэн байв гэнэ.
Тэнгэрийн хүү Эрхэм хар
Тэгэхийг тэгдэг байж гээд
Тэнгэрийн хүү Эрхэм хар
Өглөөний шар нарнаар
Мянга хүчит
Эртэгчин цоохор нумандаа
Эрдэнэт сумаа онилж татаад
Тэвхэн дэх
Тэх хуцыг мөргөлдүүлэн татаад
Бариул дахь
Бар өтгийг бариулдуулан татаад
Гичир дэх
Хэрээ галууг үмхэлдүүлэн татаад
Элгэн дэх
Элээ гардийг шүүрэлдүүлэн татаад
Ар дахь
Аргал угалзын толгойг
Авцалдуулан татаад
Эрхий хомхой хоёроос
Гунан бухын чинээ
Чавхийн улаан цусыг
Чивхартал татаад ирэхэд
Өлөн гэдэс эвхэлдээд
Өнчин сүвээ давхарлаад
Ирэхийн хэрд
Оройн улаан нарнаар
Сумны төмрөөс гал бадраад
Үнс утаа бургилдуулан
Татаад тавиад орхиход нь
Хонин чинээ
Цагаан чулууг ховх
Үхрийн чинээ
Хар чулууг огло аван
Тавин хасаг тэрэг түлээний
Тал дундуур сум нь
Тогтов буюу гэнэ...

Одоо миний ээлж гэж
 Хан Харангуй
 Мянган хүчит
 Заан цагаан нумны
 Хүний арьсан хөвчинд нь
 Хөтөл оньт хөдөө энт
 Хийвэр цагаан сумаа онилж
 Өглөөний шар нарнаар
 Ардаа татаж алдаа дүүргээд
 Өмнөө татаж дэлмээ дүүргээд
 Тэвхэн дэх тэх хуцыг мөргөлдүүлэн татаад
 Бариул дахь бар өтгийг барилдуулан татаад
 Гичир дэх хэрээ галуу хоёрын жигүүрийг
 Харгалдуулан татаад
 Эрхий хомхой хоёроосоо
 Дөнөн буурын чинээ
 Чавхийн улаан цусыг
 Чивхартал татаад ирэхэд
 Өлөн гэдэс эвхэлдээд
 Өнчин сүвээ давхарлаад
 Сумны ониноос
 Огторгуйн будан мэт
 Утаа бургиллаад
 Төмрөөс нь
 Таван эхт түймэр шатуулаад
 Оройн нарнаар
 Татаад тавиад орхиход нь
 Харвасан сум нь
 Хонин чинээ цагаан чулууг ховх
 Үхрийн чинээ хар чулууг огло аван
 Тавин хасаг тэрэг түлээг тасар аван
 Сүүжний нүхийг тасартал
 Үет цагаан өвсний
 Үеийг алдалгүй авч
 Алтан тэвний сэнжийг
 Сэтэртэл харваж
 Айлаар хүн
 Ачаагаар тэмээ явах
 Зам татуулан
 Цааш хар түймэр болон
 Тэшиж гараад
 Хааны нутагт нь орж
 Хагас албатыг сүйд хийн
 Хар түймэр тавьж
 Явав буюу гэнэ.

Улаадай мэргэн задын чулуу өвөртөлж, Чон хүрэн морийг барьж, унан хойноос
 нь улаа тавин нэхэж, хүрч ядан барьж, түймрийг унтрааж арайхан гэж гүйцэж,
 алтан цалмаа барин цаламдаж тогтоон барьж, сумыг дүүрч хүрч л ирэв гэнэ. Хан
 Харангуй “Нэгэн үеийн мөрий минийх болов” гэж дуудан байв л гэнэ...

ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ

ЗӨВЛӨМЖ

- Зохиолыг гүйлгэн унших явцдаа хос хосоороо ажиллан, баатруудын нэрийг бүртгэн гаргана уу. Баатрын нэрсийг цавуутай цаасан дээр тус тус бичээд, самбарт байрлуулж, хоорондын холбоо хамаарлыг сумаар холбон тэмдэглэж, баатруудын хэн нь бусадтайгаа хэрхэн холбогдож байгааг ажиглана уу.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Туульсад эр хүний эрдэм чадлыг хэрхэн тодорхойлж байна вэ? Баатарлаг туульсын энэхүү өгүүлэмжээс үндэслэн монголчуудын эрийн гурван наадмын үүслийн талаар таамаглан ярилцаарай.
2. Туульсад ураглах хуримлах ёсны ямар тусгал байна вэ?
3. Туульсын бичвэрээс эшлэл авч, Хан Харангуй баатрыг тодорхойлно уу.

	Эшлэл
Эрхэм сайн нэр ус	Эрийн сайн Хан Харангуй
Өргөн сайхан нутаг ус	
Өндөр дээд угсаа гарал	
Бие бодын эрхэм шинж	
Албат иргэд	
Мал хөрөнгө	
Хүлэг сайн морь	
Авах сайн авхай	
Тулалдах сайн баатар дайсан	

4. Хан Харангуй нь бусад баатартай хэрхэн холбогдож байгааг зураглан харуулна уу. Дүрүүдийн холбоо хамаарлын бүдүүвчээр гол ба туслах дүрийг тодруулна уу.
5. Гол баатрын зорилго тэмүүлэл, үзэл бодол, үйл хэрэгтэй нэгдэж, түүнийг дэмжиж байгаа туслах баатруудыг тодорхойлно уу. Мөн гол баатрын зорилго тэмүүлэл, үг хэл, үзэл бодол, үйл хэрэгтэй эсрэгцэн, түүнд саад хийж байгаа эсрэг баатрыг тодорхойлно уу.

Гол баатар	Туслах баатар	Эсрэг баатар
Хан Харангуй		Эрхэм хар....

6. Туульсын баатрын зан төрхийн онцлогийг харуулах жишээг бичвэрээс эшлэн авч тайлбарлана уу.

Баатар	Эшлэл	Тайлбар
Эгэл биш шинж		
Сорилго болзол		
Хам олныг дагуулах чанар		

7. Баатарлагийн цаг үе нь туульсын баатрын зан төрхийг бүрдүүлэхэд хэрхэн нөлөөлж буй талаар зохиолоос эшлэл авч тайлбарлана уу.



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

- Туульсын баатар нь эртний домог зүйгээс уламжлан хөгжсөн, хүний хувь заяаг эрхшээгч дээд тэнгэр нарын эрх сүрийг үгүйсгэж, хүний хүч чадлыг батлан үзүүлэхийг зорьсон аман зохиолын баатар юм. Тухайлбал, “Эрийн сайн Хан Харангуй” туулийн гол баатар Хан Харангуйг тэнгэртэй тэрсэлдэн, газартай гацалдан төрсөн баатар гэж үзүүлдэг.

8. Гол баатрын зорилго тэмүүлэл, үг хэл, үзэл бодлыг шинжилж, хийсэн үйлдлүүд нь хэрхэн үйл хэрэг болон өргөжиж буйг тодорхойлно уу.

Баатрууд	Үүрэг зорилго	Үг	Үйлдэл	Үйл хэрэг
Хан Харангуй				

9. Баатруудын зөрчил тэмцлийн өрнөл, төгсгөлийг таамаглан уншаарай.

ЭРИЙН САЙН ХАН ХАРАНГУЙ

Хэсэглэл 4

...Эрхэм хар “Нэгэн үеийн мөрий чиний болох юм байна. Та эндээ баахан хүлээж бай. Би морио аваад ирье” гэж дээд тэнгэрийн оронд очиж

Гучин гурван тэнгэрийн
Арслан амт
Заан шаргал морь
Зээрэн шилбэт
Зэс хошуутай
Ягч (шидтэн) цагаан хоёр эм
Салхинд үл гүйцэгдэх
Шар цоохор морь
Хуйд үл гүйцэтгэх
Хурдан цоохор морь
Мянган хий хүлэг
Энэ зургааг буулгаж ирэхэд

Хан Харангуйн морь цөөн гэж сайхан Толь гоо дагина өөрийн унадаг Жолоо бөхт Шаргал морийг сэлбэж өгөн байв гэнэ... Хан Харангуй хоёр морь зэхэж, олом жирмийг бэхэлж, морьдоо тавих болж. За, эндээс үсэргэсээр Айхан тохой нутгаас нааш сайхан жагсаж байгаад тавьтугай. Тавих цагт нь цаашаа битгий хар гэж Улаадай мэргэн дүүдээ гурав дахин сайтар захиад, Эрхэм харын морьттой нийлүүлэн,

Нэгэн дуу тэнгэрт
Нэгэн дуу газарт хадуулан
Нирхэртэл явуулаад
Орхив буюу гэнэ...
Хоёр талын хөлөөр
Хоногтоо амсхийн
Өдөртөө үсэргэн
Гүйлгэсээр явж
Хамгийн түрүүнд

Айхан тохой нутгийн захад
 Тэнгэрийн арслан амт
 Заан шаргал морь
 Чон хүрэн морь хоёр
 Зуузай холбон хүрэв.
 Түүний дараа
 Ягч цагаан хоёр эм
 Салхинд үл гүйцэтгэх
 Шар цоохор морь
 Хуйд үл гүйцэгдэх
 Хурдан цоохор морь
 Зуузай холбон хүрэв.
 Түүний удаа
 Их Хар морь
 Жолоо бөхт Шаргал морь хоёр
 Зуузай холбон хүрэв.
 Түүний удаа
 Мянган Хий хүлэг
 Эцэх нь эцэж
 Турах нь турж хүрэв гэнэ.
 Амьсгаагаа дарж байж одоо явъя гэж сайхан жагсаж байв л гэнэ...
 ...Хол уулыг ойртуулан гишгэж
 Уужим талыг алхуулан
 Амсхийлгүй явж
 Тэр угаараа
 Хатан болд туурайгаа
 Хааяа нэг
 Хар газарт хүргээд
 Хоёр хамраас нь
 Улаан суунаг татаад
 Газар тэнгэр
 Нэгэн болтол хурдлаад
 Арван таван сарын газарт гарахад нь
 Мянган хий хөлгийн
 Тоос явахыг үзэж
 Гүйцэж дайран гарахад
 Сүр залинд нь дарагдаж
 Бие биеэ дэрлэн хоцров.
 ...Чон хүрэн морь ч
 Өдөртөө нисдэг
 Өлөн цагаан жигүүрээ гаргаад
 Өмнө хойд хоёр хөл нь
 Эрүүтэйхэн толгойгоосоо
 Өвдөгцөөгөө өнгөрөөд
 Хоногтоо нисдэг
 Хонгор шар жигүүрээ гаргаад
 Дөш сайхан сайраа шидээд

Халдаггүй бие нь халаад
 Хааяа нэг хар хөлс нь чийхраад
 Дөшсөн сум мэт
 Дөлрөн хурдлаад явтал
 Эрхэм хар, Хан Харангуй хоёр
 Болзоотын Бор толгой дээрээ гарч,
 Миний морины тоос
 Чиний морины тоос гэж
 Булаалдан байв гэнэ.
 “Чон хүрэн морь
 Алтан дэлхийг догдлуулаад
 Алаг уулыг найгуулаад
 Ар өврийн чулууг шидлээд
 Сүн далайг цалгилуулаад
 Сүмбэр давхар хар уулыг сундлуулаад
 Амнаас нь арван анги гал цацран
 Хамраас нь хоёр анги утаа бургилан
 Дэл сүүл хоёроос нь
 Хорин анги улаан суунаг татан
 Дөрвөн талаас нь
 Дөрвөн эхт булаг урсан
 Огторгуйн улаан суунаг татаад
 Орон дэлхийд мандал хар
 Тоос татуулаад
 Түрүүлэн гарав ...
 ...Хан Харангуй

Хоёр үеийн мөрий миний болов! гэж дуудаж байхад Эрхэм хар хэлэв. “Болох нь ч болсон юм байна. Хан Харангуй та энд хүлээж бай. Би бөхөө аваад ирье” гээд дээд гучин гурван тэнгэрийн оронд хүрэн, надад сайн бөх хайрла гэж айлтгаад байвал, тэнгэр нар...

Дав дээрээ
 Далан тэмээ давхар хаядаг
 Дархан хар бөх
 Гучин тэмээ давхар чулууддаг
 Гунан хар бөх хоёрыг
 Авч оч гэж айлтгасанд
 Хоёр бөх аван
 Хүрээд ирэв гэнэ.

Тэрхэн биеэрээ бөхөө тавих гэж Дархан хар бөх Хан Харангуй хоёрыг зодог шуудаг өмсгөн тавиад орхив гэнэ. Хан Харангуй нь өдий төдийхөн авалдагчаа болж яваад, Дархан хар бөхийг үдийн газар дэлбэ хаяж орхив гэнэ...

(Хэсэглэн авав) Эрийн сайн Хан Харангуй. УБ., 1986 он

ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН БҮТЭЦ БА ҮЙЛ ЯВДЛЫН ДАРААЛЛЫГ ХҮҮРНЭЛИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Зохиолын үйл явдлын эхлэл, өрнөл, туйл, тайллын гол хэрэг явдлыг тодорхойлж, зохиолын өрнөлд хамаатай хэрэг явдлуудыг бүртгэнэ үү. Чингэхдээ зохиолын үйл явдлыг хэрхэн өрнүүлж байгааг ажиглаж, туульсын зохиолд үйл явдлыг өрнүүлэх ямар арга замууд байгааг тодруулна уу.

	Үйл явдлыг өрнүүлсэн нь
Үйл явдал нэмэх замаар	
Орчин нэмэх замаар	
Дүр дүрслэл нэмэх замаар	

2. Баатарлаг туулийн үйл явдлын гол зөрчлийг тодруулна уу. Тэмцэл тулалдаан хэн хэний хооронд голлон өрнөж байна вэ? Баатарлаг туульсын бичвэрээс зөрчлийг тодорхойлох баримтыг эшлэн бичнэ үү.

Тэмцэл тулаан	Эшлэл
Тэнгэр бурхад ба хүмүүсийн хоорондын зөрчил	
Хүмүүсийн хоорондын зөрчил	

3. Туульсын хэрэг явдлууд нь гол зөрчилтэй хэрхэн холбогдож, зохиолын утгыг тодруулж байгааг тодорхойлон бичнэ үү.
4. Зохиолын доторх өгүүлэгчийн хүүрнэл болоод баатрын хүүрнэл, харилцан яриа зэргийг шинжилж, зохиолоос жишээ татан, учир холбогдлыг тайлбарлана уу.
5. Баатарлаг туульсын бичвэрээс туульсын шинжийг тодорхойлох эшлэл баримтыг эх зохиолоос авч тайлбарлана уу.

Туульсын шинж	Эшлэл	Тайлбар
Хүүрнэн өгүүлэгчтэй		
Үйл явдалтай		

БҮТЭЭХ УРЛАН:

Дараах даалгааруудаас сонгон гүйцэтгэнэ үү.

- ▶ А. Туульсын бичвэрээс сэтгэлд нийцсэн хэсгийг сонгон цээжилж, туульчийг дуурайн, хайлах чадвараа хөгжүүлнэ үү.
- ▶ Б. Баатарлаг туульсын шүлэглэлээс суралцан, тоочин дүрсэлж зохионо уу.



НОМ УНШЛАГАД ХӨТЛӨХҮЙ



МОНГОЛЫН АРДЫН АМАН ЗОХИОЛЫН ДЭЭЖ

Эмхэтгэсэн: Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном
Редактор: Ц.Дамдинсүрэн
Эрхлэн гаргасан газар: ШУАХЗХ, УХГ
Эрхлэн гаргасан огноо: (1967) 1978



ЭРИЙН САЙН ХАН ХАРАНГУЙ

Гар бичмэл эхүүдийг харьцуулан
боловсруулж, оршил бичиж, тайлбар сэлт
үйлдсэн: Р.Нарантуяа
Редактор: Х.Сампилдэндэв
Эрхлэн гаргасан газар: АБЯ
Эрхлэн гаргасан огноо: 1986

ЗОХИОЛЫН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛИЙН ХЭРЭГЛЭЭГ СУДЛАХАД ТУСЛАХ НЬ

Зохиолын уран үг хэл	Уран дүрийн үгсийн сан	Дүр дүрслэлийн ур маяг	
		Үгийн утга шилжүүлэх ур маяг	Өгүүлбэр зүйн ур маяг
Баатрын хэл яриа Өгүүлэгчийн хэл яриа	• Үгсийн салаа утга • Ойролцоо нэр • Эсрэг нэр • Шинэ үг хэллэг • Хуучин үг хэллэг • Нутгийн аялгууны үгс • Мэргэжлийн үг хэллэг • Этгээд үг хэллэг • Бүдүүлэг үг хэллэг • Гадаад үг хэллэг	• Зүйрлэл • Адилтгал • Төлөөлөл • Хэтрүүлэл • Чимэг үг • Ёгтлол • Егөөдөл • Бэлгэдэл гэх мэт	• Давтал • Зэрэгцүүлэл • Хураангуйлал • Тонгоруулал • Тонгоруу зэрэгцүүлэл • Яруу асуулт • Яруу дуудал • Яруу хандал

Өөрийн үнэлгээ
(Мэдэрч сонсох чадвар)

1. Анхаарлаа төвлөрүүлэн бүрэн гүйцэд сонсох
2. Сонсох явцдаа үнэлгээ өгч, эргэцүүлэх
3. Сонсох явцдаа асуулт боловсруулах
4. Сонсонгоо тэмдэглэл хөтлөх
5. Сонссоныхоо дараа тэмдэглэл хөтлөх
6. Сонссоныхоо дараа тулгуур зураглал, бүдүүвч, томьёо, томьёолбор хийж тэмдэглэх
7. Сонсоод аливаа үзэл бодол үг яриаг хүлээцтэй цэгнэн хүлээж авах
8. Сонссон зүйлдээ тулгуурлан бусдын үзэл бодлыг дэмжих, няцаах, мэтгэлцэх
9. Сонссон яриа бүрээс суралцаж, өөрийн ярих чадвартаа тусган авч өөрийгөө хөгжүүлэх.

Сурагч та:

Өөрийнхөө сонсох чадварыг шалгаж үнэлэхдээ дараах дүрсүүдийг сонгоорой.

Үүнд:

Чаддаг байв



Улам хөгжүүлэв



Шинээр сурав



Үүнийг зохиол тус бүрээр гаргавал их сайн. Өөртөө өгсөн үнэлгээ тус бүрийг тоолоод бүх шалгуур асуултынхаа тоог 100% гэж харьцуулан тооцож үзээрэй.

Багшаараа хэрхэн хувилж тооцохыг заалгаад өөрийн сонсох чадварт аль болох шударга үнэлгээ өгч, хичээл дээр төдийгүй ямар ч үед анхаарлаа төвлөрүүлэн, бусдын үг яриаг тэвчээртэй хүлээцтэй сонсож, эргэцүүлэн ухаарч, сурах чадвараа улам ахиулаарай. Энэхүү сонсох чадвар бол сурагч таны хувьд эзэмшвэл зохих маш чухал чадвар юм шүү.

Дүгнэлт 1.
ЗОХИОЛЫН УРАН ҮГ ХЭЛ

Уран баримлыг гантигаар бүтээдгийн нэгэн адил уран зохиолыг үгсээр л бүтээж, үгийг сонгож бичдэг. Яруу найргийн үгийн утга хам сэдвээрээ тодорхойлогдоно. Зохиолын доторх үгс нь зөвхөн өөрийн утгыг илэрхийлээд зогсохгүй гарал нэг, дуудлага ижил, утга ойролцоо гээд янз бүрийн үгсийг, тэр ч бүү хэл огт байхгүй үгсийг ч санагдуулж, уншигч тэр бүгдийг хамтад нь мэдэрч байдаг. Тиймээс уран зохиол нь уран сайхны сэтгэлгээний түүх төдийгүй үг хэлний түүхийн салшгүй хэсэг юм.

Уран зохиол нь хэлний бүхий л баялаг, дүрслэх арга хэрэглүүр, боломжийг ашиглан бүтээх бөгөөд эргээд хэлнийхээ хөгжилд нөлөөлж, үгсийн санг баяжуулж байдаг.

Уран дүрийн үгсийн санд үгийн салаа утга, шилжсэн утга, ойролцоо нэр, эсрэг нэр, шинэ үг хэллэг, хуучин үг хэллэг, нутгийн аялгууны үгс, мэргэжлийн үг хэллэг, этгээд үг хэллэг, бүдүүлэг үг хэллэг, гадаад үг хэллэг зэрэг багтана.

Уран зохиолын хэл нь зохиолын **баатрын хэл, өгүүлэгчийн хэл** гэсэн хоёр хэлбэрээр илэрдэг. Зохиолын хэл нь уран зохиолын төрөл зүйлийн онцлогоос хамаарч, жүжгийн зохиолд зөвхөн баатруудын хэл яриагаар, туульсын зохиолд зохиолын баатрын хэл яриа болон өгүүлэгчийн хэл яриагаар, уянгын зохиолд энэ хоёрын нэгний үглэл яриагаар тус тус голлон байна.





II БҮЛЭГ

О.Магвандорж. "Эртний домог".
Тосон, зотон



ЗУРГААС ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

- ▶ Зургийг харах эхний мөчид таны нүдэнд ямар дүр зураг хамгийн тод туссан бэ?
- ▶ Зурагт юу юуг дүрслэн харуулсан байна вэ?
- ▶ Зургийг үзээд та нарт ямар сэтгэгдэл төрж байна вэ? Дараах зохиолуудыг уншихдаа монгол хэл, бичиг, соёлын үнэ цэнийг эргэцүүлээрэй.

Хоёрдугаар бүлэг. ШҮЛЭГ, НАЙРАГЛАЛ

2.1. Шүлэг

Б.Ринчен “Монгол хэл” шүлэг

С.Дулам “Хүмүүн бичиг” шүлэг

О.Дашбалбар “Өвөг дээдсээсээ бид эх орноо хүлээж авсан...” шүлэг

2.2. Найраглал

Есөн өрлөгтэй өнчин хөвүүний сэцэлсэн шастир

Б.Явуухулан “Тэхийн зогсоол” дууль найраглал

ЗОРИЛГО:

Энэ бүлгийг судалснаар та Монголын эртний болон орчин үеийн яруу найргийг уншиж, мэдэрч хүлээн авах, шүлэг найраглалын хэл, бүтэц, хэлбэрийг задлан шинжилж хариулах чадвараа хөгжүүлнэ.

2.1. ШҮЛЭГ

Яруу найраг гэдэг бол зөвхөн гоё үгс биш юм. Яруу найрагч нь өөрийн амьдарч буй түүхэн цаг үеийнхээ гэрч нь байж, хам олны эмзэглэл шаналанг өөрийн зүрх сэтгэлээрээ дамжуулан илэрхийлж, хувирган өөрчлөхүйд хөтлөх дуу хоолой нь болж, өөрийн улс үндэстэн хийгээд нийт хүн төрөлхтнийг уриалан сэнхрүүлэх үүрэг, хариуцлагыг өөртөө авсан байдаг.



Хишигийн Ууганхүү
Б.Ринчений хөрөг. Тосон
зотон. 70х58
С.Дуламын цуглуулгаас

Бямбын Ринчен
/1905-1977/

Сэлэнгэ аймгийн нутаг
“Бул Сарай” гэдэг газар
төржээ. 1923 онд уран
бүтээлээ эхэлж, “Үүрийн
туяа”, “Бэр цэцэг”, “Заан
Залуудай”, “Гүнж”, “Их
нүүдэл”, “Сандо амбан”
зэрэг ном хэвлүүлсэн
байна. 1946 онд Төрийн
шагнал хүртжээ.

Бичвэр 1

МОНГОЛ ХЭЛ

Чихинү чимэг болсон аялгуу сайхан монгол хэл
Чин зоригт өвгөд дээдсийн минь өв их эрдэнэ
Сонсох бүрий яруу баялгийг гайхан баясаж,
Сод их билигт түмэн юүгээн бишрэн магтмуу, би

Урьдын бэрх цагт улс монголын хэт заяаг
Уйтгарлан бодоход урам зоригийг мину сэргээсэн
Өөдлөн дэгжихийн төгс хувьтайд нь итгүүлсэн
Өрнөн мандахын шинж бүрдсэн өвгөдийн минь хэл

Мөрөн гол цутгалант ширгэшгүй их далай мэт
Мөнхөд үр ач нарын залгамжаар бадранхан дэлгэрч
Хөндий цээжинд орогч бүгдийг нэвтрүүлэх чадалт
Хөгжим мэт яруу баясгалант монгол хэл минь

Өсөх наснаас өтлөх нас хүртэл чам юугаан судлан
Өдөр бүр үгсийн эрдэнийг чинь баярлан түүнэм
Түмэн түмэн үеийн оюун билгийн үлэмж сангийн
үүдийг чинь

Түлхэх бүр сэтгэл сэргэн магнайн үрчлээ тэнийнэм
Түгшүүрт бэрхийг даван туулсан баатар түмний минь
Түвшнээ соёл эрдэнэ юүгээн мандуулахын гэгээн
улирал нээгдсэнд

Сэлбэлгүй сэцэн оюунтан, хэл юүгээн энхрийлэн
хөгжүүлье хэмээн

Сэтгэл урмас бадран бахдамуу, үсэн буурал өтгөс би

Хутаг өлзий бүрдсэн хувь заяат их түмний минь
Хурц авьяаст хөвүүд дүү нар, халуун элэгтэн хотлоор
Эгшиг сайхан монгол хэл юүгээн нэн хайрлан дээдэлж
Энхрийлэн бадруулахын бат зориг төгс юутай сайхан

Чихинү чимэг болсон аялгуу сайхан монгол хэл
Чин зоригт өвгөд дээдсийн минь өв их эрдэнэ
Сонсох бүрий яруу баялгийг гайхан баясаж
Сод их билигт түмэн юүгээн бишрэн магтмуу би

Монголын уран зохиолын дээжис. 2-р боть.
УБ., 1994 он. 204 дэх тал

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Зүйрлэл:

- Зүйрлэл нь нэг юмыг нөгөөтэй нь харьцуулах уран дүрслэлийн арга бөгөөд шиг, мэт, адил гэх мэт холбоосоор танигдаж байдаг.

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Найруулга:

- Тодорхой сэтгэгдэл төрүүлэхийн тулд бичвэрийн утгад нөлөөлөх (жишээ нь: үг, өгүүлбэр, дүрслэл) тогтсон аргыг найруулга гэнэ. Найруулга нь хувь хүний, тодорхой цаг үеийн бүтээлүүд, тодорхой төрөл болон бичвэрийн хэлбэрүүдийг ялгана.

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Шүлгийг анхааралтай унш. Шүлгийн эхний шатаас та өвөрмөц бичлэгтэй цөөнгүй үг олж харах болно. Сонгодог бичгийн хэлний найруулгаар бичсэн тэдгээр үгийн утгыг та шууд хүлээн авч чадаж байна уу?
2. Кирилл үсгээр “чихний” гэж бичих нь зөв хэдий ч яруу найрагч яагаад “чихинү” гэж бичсэн байна вэ? Яруу найрагч найруулгын энэ сонголтоороо ямар санааг илэрхийлэхийг зорьсон бэ?
3. Монгол ба кирилл үсгийн бичлэг дуудлага хоёрын хооронд ялгаа байна уу? Шүлгийн дөрөвдүгээр мөрийн “түмэн юүгээн”, “чам юугаан” гэсэн үгсийг монгол бичгээр бичээд, дуудан уншиж, эгшиг зохицох ёсыг ажиглаарай. Эдгээр үгийг яруу найрагч яагаад ингэж бичсэн гэж бодож байна вэ?
4. “Бишрэн магтмуу”, “бадран бахадмуу”, “түүнэм”, “тэнийнэм” гэсэн үйл үгсийн төгсгөлийг ажиглана уу. Эдгээр нь хэддүгээр биеийг зааж, хэнийг гэрчилж байна вэ?
5. Шүлэгт уран дүрслэлийн ямар хэрэглүүрийг хэрхэн ашигласан байна вэ? Шүлгээс уран дүрслэлийн жишээг түүж, хүснэгтийн эхний баганын нүднүүдэд жагсаан бичээрэй. Хүснэгтийн удаах багананд яруу найрагч уран дүрслэлийн ямар хэлбэрийг хэрэглэснийг тэмдэглэж, арын багананд илтгэж буй утгыг тайлан тайлбарлана уу.

Уран дүрслэл	Арга	Тайлбар
Далай мэт	Зүйрлэл	Монгол хэлний үгийн сан нэн баялаг болохыг илэрхийлсэн

6. Энэ шүлгийн бадаг бүрийн нэгээс хоёр ба гурваас дөрөвдүгээр мөрийн эхэнд ижил төстэй авиагаар холбоц бүтээсэн байна. Таны бодлоор энэхүү холбоцоор бүтээсэн дуу анирын сонголт чанар ямар үр нөлөөтэй байна вэ?
7. Шүлгийн шадуудаас монгол хэлний эгшиглэнт чанарыг баталж, эгшиг зохицлоор зохист санааг гаргаж буй үгсийг тэмдэглээд, шүлгийн утга болоод сонсогдох дуу анир хооронд нарийн холбоо байгаа эсэхийг мэдрэхийг оролдоно уу.

ШҮЛГИЙН УТГА, БҮТЦИЙГ СУДЛАХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

- Бадаг гэж холбоц хийгээд аялгын нэгэн хэмнэлд захирагдан, тодорхой утга төгссөн айзам буюу хэд хэдэн шадын нийлбэрийг хэлдэг.
- Шүлгийн нэг мөрийг шад гэнэ. Шүлгийн шадыг бичигт тэмдэглэсэн хэвлэлийн горимыг мөр гэнэ.

ЗӨВЛӨМЖ

- Судалгааны асуултууд нь голдуу хэрхэн, ямар арга замаар гэсэн асуух үгсийг хэрэглэдэг. Эдгээр үг нь таныг зохиолчийн үзэл санаагаа илэрхийлсэн арга зам руу төвлөрөхөд хөтөлнө.

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Энэ шүлэг нийт хэдэн бадгаас бүрдэж байна вэ? Бадаг бүр дэх шадын тоо ижил тэнцүү байна уу? Эсвэл адил бус байна уу?
2. Шүлгийн эхний бадгийн нэгээс хоёрдугаар мөр ямар гол утгыг илэрхийлж байна вэ? Энд өвөг дээдсийг дурсан сануулснаараа яруу найрагч уншигчдадаа юу хэлэх гэсэн юм бол?
3. Шүлгийн хоёр, гуравдугаар бадагт Монголын түүх соёлын талаар ямар мэдээлэл агуулж байгааг ярилцана уу.
4. Шүлгийн дөрөвдүгээр бадагт уянгын баатрын эгшиг сайхан монгол хэлээ судлан сурах хүсэл эрмэлзлийг хэрхэн илтгэж байна вэ?
5. Шүлгийн тав, зургаадугаар бадагт ямар шинэ дүр орж ирснээр ямар шинэ санаа нэмэгдэж байна вэ? Шүлэгт гарч буй дүрүүдийг бүртгээд, тэдгээр нь чухам аль цаг үеийг төлөөлж, шүлгийн санааг хэрхэн баяжуулж байгааг тайлбарлаарай.

Дүр	Цаг	Санаа
Чин зоригт өвөг дээдэс	Өнгөрсөн цагийг төлөөлж	Монгол хэл нь эртний түүхтэй хэл болохыг сануулж байна
Сод билигт түмэн		
Үр ач нар		
Баатар түмэн		
Сэцэн оюунтан		
Хөвүүд дүү нар		
Халуун элгэн хотол		

6. Шүлгийн утгыг гүнзгий ухаж ойлгохын тулд монгол хэлний хойч ирээдүй, хөгжил мандлын талаар шүлэгт ямар санаа туссаныг жишээ татан тайлбарлаад, энэ нь шүлгийн өнгө аяст хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлно уу.
7. Шүлгийн эхний бадгийг дахин унш. Уг бадгийг шүлгийн төгсгөлд мөн давтсан байна. Энэхүү давтлаараа яруу найрагч юуг илэрхийлэх гэсэн юм бол?
8. Яруу найрагч уг шүлэгтээ ямар утга санааг илэрхийлсэн талаар нэг цогцолбор бичнэ үү. Шүлгийн утга санааг илтгэж буй хамгийн гол шадыг эшилнэ үү.



Сэндэнжавын Дулам

Баянхонгор аймгийн
Баянбулаг сумын нутагт
төржээ. 1968 оноос
уран бүтээлээ эхэлж,
“Цагаан түрүү”, “Задын
чулуу”, “Зүүдний хэлмэр”,
“Сэнхрэл уянга” зэрэг
ном хэвлүүлжээ. 2005 онд
Монгол Улсын Шинжлэх
ухааны гавьяат зүтгэлтэн
цол хүртсэн байна.



ҮГИЙН ТАЙЛБАР

Уйтан

Уудам биш

Урь

Урин, цаг улирлын дулаан

Хөлгөн

Буддын гүн ухааны ном

Ботилох

Ном зохиолыг хэвлэх

Тэших

Тэмээний явдал



Бичвэр 2

ХҮМҮҮН БИЧИГ

Тэнгэр газар хоёрыг учруулж
Намираа хур орох мэт
Тэнүүн уйтан хоёрыг учирлаж
Морин хуур дарах мэт

Тэлмэн жороогийн удгал
Монгол бичгээрээ бичдэг сэн
Титэм, шүд, нуруу, шилбэтэй
Тэр чигээрээ хүн - бичиг минь

Харанхуй шөнийн цахилгаан цахихад
Хаялга цацлага нь зуралзах шиг болдог
Хаврын уриар цас ханзрахад
Хархан бийрээр таталгах шиг болдог

Халуун хошуут малын данс шиг
Халзан цагаан сүрэг минь бэлчдэг
Хөлгөн судрын мэргэн гарчиг шиг
Хөндлөн хөх уулс нь бидэртдэг
Удам залгасан нутгийнхаа хаанаас ч
Худам бичгийнхээ дүрсийг үгүйдэг

Төр улсынхаа тамганд сийлээстэй
Түмэн газрын хэрэмнээс ч дуулиантай
Түвшин мэргэдийн өвөрт хуйлаастай
Түүх бүтээлцэж явсан бичиг минь

Арвис эрдмийн ариун дээжийг
Арван ухааны номонд ботилж
Есөн эрдэнээр хувилган гэрэлтсэн
Ер бишийн хувь тавилантай

Нумын хөвч шиг бичиг минь үгүй бол
Нууц товчоогоо юугаар бичих вэ?
Гэрэлт хөшөөгөө юугаар сийлэх вэ?
Гэсэр, Жангараа юугаар хайлах вэ?

Мянган настай бичиг минь үгүй бол
Мяндсан баринтагт номуудаа яах вэ?
Мяралзан өнгөрөх олон зуунаар
Марталгүй ирсний учир нь юу вэ?

Өлмий дээрээ гишгэсэн хүн шиг
Өөдөө уруугаа тэшсэн бичиг минь
Ач үрсдээ ад үзэгдэх

Адал заяаг амссан бичиг минь

Догшин өвгөдийн түүхийг хайлсандаа
Дорнын өв соёлыг хадгалсандаа
Долоон бурхны домгийг хямгадсандаа
Дордож буурсан, доройтож буруутсан

Галын дөлөнд хөдөс шиг хунирч



ҮГИЙН ТАЙЛБАР

Хөдөс

Хуучирч муудсан нэхий

Өлөн дэрс

Хавар эрт ургах үет
ургамал

Унги

Ургамлын ил гарсан үндэс

Хамхуул

Үндэснээс салж хийсэх өвс



Гар сарвалзуулан шатаж байхдаа ч
Ганц хоёроороо үлдсэн тасархай нь
Гадаа хөдөө хийсч байхдаа ч
Өлгийтэй хойчдоо золгох сон гэхдээ
Өлөн дэрсний унгитай ороолдож
Өндөрхөн жалганд тогтох сон гэхдээ
Өргөст хамхуултай өнхөрч явсан
Түүхээ өмөөрөх зөн совинг нь
Түйрэн болгосон хэдэн хүн минь
Түймрийн өмнө ухаан нь хүчгүй
Түүдэг болсон хэдэн ном минь
Худал хэлдэггүй утга нь шударгуу
Хулсан үзэг шиг дүрс нь шударгуу
Хуучин гэдэг хоч нь л хуучирснаас
Хувь заяа нь огтхон ч хуучраагүй
Үсэг болгон нь эрдэнийн шинжтэй
Үе болгон нь эрдмийн шимтэй
Соёл мандлын буурал тэргүүн
Соёмбын өвөг таныгаа яах вэ?

1988 он Монголын уран зохиолын дээжис “93-р боть
С.Дулам. “Сэнхрэл уянга” УБ., 2004, 226 дахь тал

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Шүлгийг уншихад утга үл ойлгогдох танил бус үг хэллэг тохиолдож байна уу? Шүлгийн утгыг ойлгоход саад болж байгаа үгсийн утгыг хам сэдвийн хүрээнд нь таамаглаж, дараа нь толь бичгээс утгыг тодруулан мэдэж аваарай.

Танил бус үг хэллэг	Толь бичгийн утга	Эхийн хам утга
Тэнүүн уйтан	Тэнүүн- уудам, уйтан- давчуу, уудам биш гэсэн эсрэг утгатай үг.	Энэ шүлэгт хүний дотоод сэтгэлийн үймсэл долгислын хоёр туйлыг зааж байна.
Тэлмэн жороо		
Удгал /удгалах/		Жороо морины газраас хөндийрөн явах шиг айзамт хөдөлгөөнийг зааж байна
Түйрэн	Цөлжилт үүсгэх нарийн ширхэгт шар шороон шуурга.	
Бидэртэх		



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

- ▶ Адилтгал нь юмсыг харьцуулахдаа сул үг ашиглалгүйгээр нэг юм үнэхээр нөгөөтэйгөө адил болохыг хэлж байдаг.

Яруу асуулт:

- ▶ Уншигчдын анхаарлыг төвлөрүүлэн татах, уянгын баатрын ухаарал, сэтгэл хөдлөлийн эрчим, тэмүүллийг идэвхжүүлэх уран сайхны учир зорилгоор хэрэглэсэн өгүүлбэр зүйн ур маягийг яруу асуулт гэнэ.

ЗӨВЛӨМЖ

- ▶ Яруу найргийн уншлагын чухал зүйл бол зохиолыг унших үед уншигчийн мэдрэмжээр дамжин бүтээгддэг, уншигчийн оюун санаанд буусан дүр зураг буюу төсөөлөл юм. Тиймээс уншсан шүлгээ ой ухаандаа аль болох тодорхой дүрслэхийг хичээж, юуг үзэж, сонссон, ямар дүр зураг бууж байгааг ярилцах нь чухал.

2. Шүлгээс оноосон нэрийг түүж бичээд, шүлгийн санааг тодруулахад гүйцэтгэж буй үүргийг тодорхойлоорой
3. Шүлэгт үгсээр бүтээгдсэн дүр зургийг толгойдоо зураглан харахыг оролд. Зохиолчид эдгээр гайхалтай санааг дамжуулахын тулд ямар уран дүрслэлийг хэрэглэсэн байна вэ? Тодорхой үг хэллэгээр илэрхийлэгдсэн шүлгийн үр нөлөөг таньж мэдэхийн тулд шүлгээс сэтгэлд нийцсэн дүрслэлүүдийг сонгон бичнэ үү. Энэ шүлэгт монгол бичгээрээ бичихийг хэрхэн зурагласан байна вэ?

Эшлэл	Тайлбар

4. Би баатар юуг сонсож мэдэрч байна вэ? Нүдээ анин төсөөлнө үү. Яруу найрагчийн 1-р бадагтаа хэлээд байгаа морин хуур дарах мэт тэр айзмыг та төсөөлөн, олж сонсохыг хичээн оролд. Үүгээр дамжуулан яруу найрагч бидэнд чухам юуг мэдрүүлэхийг зорьсон юм бол? Намираа хур болоод морин хуурын айзмыг төсөөлөх замаар шүлгийн дотоод айзмыг мэдрэхийг оролдоорой.
5. Яруу найрагчийн харааны мэдрэхүйд хандан дүрсэлсэн дүрслэлүүд бидний ой тойнд ямар дүр зургийг буулгаж байна вэ? Шүлгийн 3-4 дэх бадгуудад юуг харуулахыг хүсэж байна вэ? Нүдээ аниад төсөөлнө үү. Яруу найрагчийн олж харсан тэр дүр зургийг та мөн олж харж чадна. Цахилгаан зуралзах болоод цас ханзрах үзэгдлээр дамжуулан яруу найрагч бидэнд чухам юуг мэдрүүлэхийг зорьсон байж болохыг эргэцүүлээрэй.
6. Шүлгийг уншаад дуусахад ямар мэдрэмж төрөв? Шүлгийн хамгийн эхний болон эцсийн шад ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?
7. Шүлэгт уран дүрслэлийн ямар хэрэглүүрийг хэрхэн хэрэглэсэн байна вэ? Зохиолоос эшлэл авч тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар

9. Шүлгийн 7-8 дахь бадгийн асуух өгүүлбэрүүд ямар учир зорилготой вэ? Шүлгийг төгсгөж буй асуух өгүүлбэр нь шүлгийн санааг тодруулахад хэрхэн нөлөөлж байна вэ?

ЗОХИОЛЫН УТГА САНААГ БҮРДҮҮЛЭХИЙН ТУЛД СЭДВИЙГ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛСНИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Шүлэг хэрхэн эхэлж, хэрхэн өрнөж, хэрхэн төгсөж байгааг ажиглаж, бүтцийг тодорхойлно уу.
2. Шүлгийг хувиран бэлтгэнэ үү. Шүлгийн бичвэрийн зүүн талын зайд тэмдэглэгээ хийж тайлбарлана уу. Тэмдэглэгээ хийхдээ шүлгийн тухайн хэсгийн агуулгыг дүгнэн бичих нь шүлгийн бүтцийг эргэн харахад дөхөмтэй болно.
3. Шүлгийн аялгуу эгшиг, айзам хэмнэл болон бадаглалын онцлогийг харуулж буй түлхүүр үг хэллэгийг бичвэрийн баруун талбарт зурж тэмдэглэн, товч тайлбар бичнэ үү.
4. Шүлэгт уншигчийн тайван биш байдалд аажмаар татан оруулж байгаа ямар мэдээлэл байна вэ? Шүлэгт Монголын түүхийн аль цаг үе туссан байна вэ? Яруу найрагч үүнийг энд онцлон хэлэхийн зорилго нь юу вэ? Эдгээр нь шүлгийн сэдэв агуулгад хэрхэн нөлөөлж байна вэ?
5. Шүлэгт эртний уран зохиолын дурсгалаас юу юуг цохон дурдсан байна вэ? Ийнхүү цохон нэрлэхийн учир зорилго юу вэ?
6. Яруу найрагч шүлгийн есдүгээр бадгаас эхлээд юуг мэдээлэхийг хүссэн юм бол?

ЗӨВЛӨМЖ

Яруу найргийг уншиж, хариулахдаа хоёр зүйлийг анхаарна. Таны эсээнд эдгээр асуулт тун чухал.

- Яруу найрагт юуг харуулсан байна вэ?
- Яруу найрагт хэрхэн харуулсан байна вэ?

7. Яруу найрагч чухам юуг үнэлж байна вэ? Би баатрын бахархал, итгэл үнэмшил нь чухам юу байна вэ?
8. Яруу найрагт дэвшүүлсэн асуудал юу вэ? Би баатар юуг үнэ цэнтэй хэмээн үзсэн нь хэнтэй юутай зөрчилдөж байна вэ? Шүлгийн шадаас эшлэл авч тайлбарлана уу.
9. Энэ шүлэгт би баатрын сэтгэл санааны байдал хэрхэн илэрсэн бэ? Энэ нь яруу найргийн өнгө аяст хэрхэн нөлөөлж байна вэ? Шүлгийн шадаас эшлэл авч тайлбарлана уу.

Сэтгэлийг бүтээх	Эшлэл	Тайлбар
Эмзэглэл, халаглал ба зовнил шаналан		
Догдлол ба тэмүүлэл		

10. Би баатрын сэтгэл санааны байдал болоод түүхэн цаг үе, нийгмийн нөхцөл байдлын талаарх таны төсөөлөл ямар байна вэ? Харилцан ярилцана уу.
11. Цаг үеийн алдаа хөнөөлийг таниулахын тулд яруу найрагч хүний сэтгэлийг хирдхийлгэх ямар үг хэллэгийг сонгон хэрэглэсэн байна вэ? Тэрхүү



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Далд санаа:

- Далд санаа гэж далд утгат үгс болон адилтгал, бэлгэдлийг ашиглаж, зохиогчийн санаагаа хэрхэн нуусныг хэлнэ. Шүлгийн далд санаа нь яруу найрагчийн сонгосон хам сэдэвтэй холбогдон илэрнэ.



ЗӨВЛӨМЖ

- Яруу найргийг задлан шинжилсний дараа та бүхэн энэ талаар судалгааны бичвэр бичиж эхэлнэ. Судалгааны бичвэр тань юуны өмнө зохиолчийн санаагаа илэрхийлж байгаа хэл ба бүтцэд төвлөрөх хэрэгтэй.

шимшрэлийг мэдрүүлж буй үг хэллэг, дүр дүрслэлийн доогуур зурж тэмдэглэнэ үү.

12. Сүүлийн 2 бадагт давтаж байгаа үгсийг түүж бичээд ажиглана уу. Та ямар өнгө аясыг мэдэрч байна вэ?
13. Шүлгийг дахин унш. Шүлгийн далд санаанд нөлөөлж байгаа уран дүрслэл ба яруу хэрэглүүрийн жишээг эшлэн авч, тайлбарлаарай.

Эшлэл	Далд утга
Титэм, шүд, нуруу, шилбэтэй Тэр чигээрээ хүн-бичиг минь	
Түүхээ өмөөрөх зөн совинг Түйрэн болгосон хэдэн хүн...	Үндэсний оюун санааны ой дурсамжийг арчин арилгах гэсэн тухайн цаг үеийн нөхцөл байдлыг цөлжилт үүсгэх нарийн ширхэгт шар шороон шуургатай адилтгасан байна.

14. Дараа нь яруу найрагт үгээр шууд илрүүлээгүй далд санааны талаар бод. Яруу найрагч далд санааг хэрхэн гаргасан талаар ярилц.
15. Уг шүлэгт дэвшүүлсэн асуудал болон даяаршлын үе дэх эх хэлний асуудлаар өөрийн байр суурийг илэрхийлнэ үү. Өөрийн үзэл бодлын үндэслэл, шалтгааныг танилцуулна уу.
16. Энэ шүлгийн талаарх таны сэтгэгдэл ямар байна вэ? Та өөрийн гаргаж байгаа үндэслэлийг батлах жишээг эш татахаа мартуузай.



Очирбатын Дашбалбар
/1957-1999/


Сүхбаатар аймгийн Наран сумын нутагт төржээ. Тэрээр “Оддын аялгуу”, “Гол ус намуухан урсана”, “Гэрэлт хайр”, “Зүүдний мөнгөн шувуу”, “Бурханы мэлмий”, “Цаг хугацааны гуниг буюу орон зай дахь дүрсүүд” зэрэг яруу найргийн ном хэвлүүлж, Монгол Улсын Төрийн соёрхол хүртжээ.



ҮГИЙН ТАЙЛБАР

Хунтайж

Хааны төрсөн хүү, Алтан ургийн том ноёдын цол



Бичвэр 3

ӨВӨГ ДЭЭДСЭЭСЭЭ БИД ЭХ ОРНОО
ХҮЛЭЭЖ АВСАН...

Өвөг дээдсээсээ бид эх орноо хүлээж авсан,
Үр ачдаа хүлээлгэж өгнө!

Туг,

Сүлд,

Тусгаар тогтнол,

Тулгын гурван чулуу

Тулсан голомтоо

Өвөг дээдсээсээ бид хүлээж авсан!

Үр ачдаа хүлээлгэж өгнө.

Алтай, Хангай, Говь, Талаа чулуу бүхэнтэй нь,

Өвс ногоо, шорооных нь ширхэг бүхэнтэй,

Алтан нар, мөнгөн сарыг тоолохын аргагүй од

мичидтэй нь

Хөвсгөл, Увс, Буйрыг усных нь дусал, загас бүхэнтэй нь

Хөөцөлдөн наадах долгисыг нь хүртэл

Өвөг дээдсээсээ бид хүлээж авсан,

Үр ачдаа хүлээлгэж өгнө!

Гал,

Ус,

Газар шороогоо

Гардаж авсны учир, бид

Ганц бус түм түмэн амиараа дүйж хамгаалсан!

Галдан бошигт, ван Магсаржав

Илдээ далайж босоогоороо нөгчсөн эрс,

Идэрхэн насандаа Монголоо аварсан Сүх

Ахиж олдохгүй эх орныхоо эс ширхэг бүхэнд

Алтан амь, хүсэл хайраа шингээсэн

Эх орон, хойч үеийнхээ төлөө

Энэ бие дээдсийн тангаргийг давтам.

Тужийн нарнаас эхэлсэн хувьсгалын түүх

Туган дээрх эртний бичээс, Сүхбаатарын гэрээстэй

Гучин ес, дөчин таван оны

Гуйвж дайваагүй ялалтын гэрчтэй

Эх орноо бид өвөг дээдсээсээ хүлээж авсан,

Үр ачдаа хүлээлгэж өгнө,

Соёмбот тугаа гурван зууны тэртээгээс бидэндээ

ирүүлсэн

Цогт хунтайжийг ч,

Сод ухаанаа Хөх судартаа үлдээж, хойч үедээ илгээсэн

Суу билигт Инжаннашийг ч

Өвөг дээдсээсээ бид хүлээж авсан,

Үр ачдаа хүлээлгэж өгнө!

Уулсыг өндөлзүүлж, ус голыг мэлмэлзүүлэх

Уяхан хоёр чавхдаст морин хуур, уртхан аялгуут
дуугаа
Уужим баянаараа хорвоо шигээр хорвоод тэнцсэн
Ухаант ардынхаа яруухан алдар МОНГОЛ нэрээ
Сансарт ниссэн гавьяа, атрыг хагалсан түүхтэйгээ
Сайхан бүхнийг нэмж бүтээсэнтэйгээ
Ураг элгэнээ улам олон болгож,
Ус нутгаа улам сайхан болгож,
Тэнгэрээ цэлмэг, нараа тунгалаг хүлээлгэж өгнө!
Өвөг дээдсээсээ хүлээж авсан эх орон шүү!
Үр ач минь ээ!

(О.Дашбалбар "Шидэт өртөнц" I боть, 2003 он)

ЗОХИОЛЫН УТГА САНААГ БҮРДҮҮЛЭХИЙН ТУЛД СЭДВИЙГ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛСНИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Шүлэг хэрхэн эхэлж байна вэ? Өвөг дээдсээсээ хүлээж авсан зүйлсийг бүртгэн тоочсон хэсгийг анхааралтай уншаад жагсаан бичнэ үү. Эдгээр нь юуг тодорхойлж байна вэ? Дэлгэрүүлэн тайлбарла. Үүнээс үүдээд улс үндэстний үнэ цэнт зүйлсийн талаар эргэцүүлэн ярилцаарай.
2. Шүлэгт ямар ямар түүхэн он цаг, газар усны нэр гарч байна вэ? Яруу найрагч эдгээрийг энд цохон нэрлэхийн учир юу вэ? Эдгээр нь шүлгийн утга санаатай хэрхэн холбогдож байна вэ?

Эшлэл	Тайлбар
Гучин есөн он	

3. Шүлэгт ямар ямар тодорхой хүний нэр ус гарч байна вэ? Энэ хүмүүс Монголын түүхийн аль үеийг төлөөлж, шүлгийн утга санаатай хэрхэн холбогдож байна вэ? Тайлбарлан бичнэ үү.

Эшлэл	Тайлбар
Галдан бошигт	

4. Шүлгээс би баатрын сэтгэл санааны байдлыг та хэрхэн мэдэрч байна вэ? Та нарын бодлоор, яруу найрагчийн зүрх сэтгэл чухам юунд зовниж байна вэ? Яруу найрагч чухам юуг үнэлж, юуг өмгөөлж, хамгаалж байна вэ?
5. Шүлэгт ямар өнгө аяс зонхилж байна вэ? Илт уриалах юм уу, ятган сэнхрүүлэх өнгө аяс байна уу?

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

- Иргэний яруу найраг нь сэдэв утгын хувьд ихэвчлэн хүн төрөлхтнийг зовоосон дайн, үхэл, мөхлийг ариутган эргэцүүлэх юм уу, оршин байгаа дэглэмийнхээ эсрэг тэмцэх, үндэсний үнэ цэнт зүйлээ хамгаалах үйлсэд чиглэж, жигшил зэвүүцэл, эсэргүүцэл, итгэл найдлагын сэтгэгдлийг бүтээх сонголттой байдаг.

6. Энэ шүлэг иргэний үүрэг ухамсрыг хэрхэн өдөөж байна вэ? Шүлэгт эхний шадыг хэдэн удаа давтсан байна вэ? Ийнхүү олон давтахын учир юу вэ?
7. Шүлгийн хэмнэлийг зөв мэдрэхийн тулд дуудан уншина уу. Шүлгийн хэм хэмнэл нь утга санаатайгаа хэрхэн нийцэж байна вэ?
8. Энэ шүлэгт өмнөх шүлгүүдээс ялгарах ямар онцлог байна вэ? Энэ шүлэг нь яруу найргийн ямар ангилал, зүйлчлэлд хамаарах вэ? Шүлгээс эшлэл авч, санаагаа батална уу.
9. Өнөөгийн монголын нийгмийн тулгамдсан асуудал юу байна вэ? Шүлгийн гол утга санаатай холбон хэлэлцэнэ үү.

ШҮЛЭГЛЭСЭН ЗОХИОЛЫН АЙЗАМ ХЭМНЭЛИЙГ ИЛРҮҮЛЭН УРАН УНШИХ

ЗӨВЛӨМЖ

- Шүлгийг уншихдаа том үсгээр эхэлсэн мөрийг өндөр дуугаар эхлэх ба мөр бүрийн эцэст түр зогсолт хийж уншина. Яруу найргийн уншлагаа илүү уран сайхан болгохын тулд өөртөө дуу хоолойн бичлэг хийж сонсох замаар алдаагаа илрүүлж ажиллавал тустай. Дуу хоолой тань чанга тод биш байвал чихэвч зүүж унших замаар дуу хоолойгоо чангаруулах арга байдгийг санаарай.

Задлан шинжлэх даалгавар

1. Шүлгийн яруу сайхан үг хэллэг, дүрслэлийг хэрхэн уран унших талаар төсөөлөн бодоорой.
2. Шүлгийн бадаг, шадуудыг уншихдаа хаана хоромхон зогсолт хийх, ямар үгийн аль үе дээр өргөлт өгч, хэрхэн дуудахаа бэлтгэнэ үү.
3. Шүлгийн айзам хэмнэлийг мэдрэн, сэтгэл хөдлөлтэй, чанга тод дуугаар уран унших бэлтгэл хийнэ үү.
4. Шүлгийн утга болоод сонсогдох эгшиглэл хоорондын нарийн холбоог илтгэн уншихыг хичээнэ үү.
5. Шүлгийг туршин уншсаны дараа хаана, ямар хэмнэлээр унших талаар хамтран ярилцаж, тэдгээр үг дээр тэмдэглэгээ хийгээрэй. Тэмдэглэгээний дагуу айзам хэмнэл үүсгэн, сэтгэл хөдлөлтэй, чанга дуугаар уран унших бэлтгэл хийж, жүжиглэх хөдөлгөөн болон хөгжимтэй хослуулах байдлаар өргөжүүлээрэй.
6. Яруу найрагчийн талаар улам ихийг таньж мэдэхийн тулд цахим ертөнцөөр аялж, бусад бүтээлтэй нь танилцарай.

БҮТЭЭХ УРЛАН:

Судалсан шүлгүүдээс сонгон цээжилж, урнаар уншина уу. Үүний тулд:

- Монгол хэлний эгшиглэнт чанарыг баталж, эгшиг зохицлоор зохист санааг гаргаж буй гол үгсийг онцлон тэмдэглээд, хэрхэн дуудан уншихаа төлөвлөнө үү.
- Шүлгийн утга болоод сонсогдох эгшиглэл хоорондын нарийн холбоог илтгэн уншихыг хичээнэ үү.

2.2. НАЙРАГЛАЛ

Монголын ард түмэн өөрсдийн түүхийг аман ба бичгийн хэлбэрээр хойч үедээ дамжуулсаар иржээ. Эртний уран зохиолын сор бүтээл болох «Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн сэцэлсэн шастир» зохиолд гарч буй үйл явдал нь Чингис хаан 50 насны сүүдэр зооглосон шарагчин хонин жил буюу 1211 онд Хэрлэн голын хөвөөнд болсон тухай түүхчид тэмдэглэсэн байдаг. Энэхүү зохиол нь Лувсанданзан гүүшийн “Алтан товч”, Рашпунцагийн “Болор эрх” зэрэг түүхэн сурвалжаар уламжлан иржээ.

УНШИХЫН ӨМНӨ

- ▶ “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн сэцэлсэн шастир” хэмээх зохиолын нэрийг сонсоод чамд ямар сэтгэгдэл төрөв? Зохиолд юун тухай өгүүлэх бол? Таамаглан бодоорой.
- ▶ Дараах түлхүүр үгсийг ашиглан, зохиолын үйл явдлыг таамагласнаа ярилцаарай. /Түлхүүр үгс: Архи, унд, дарс, өрлөг, түшмэд, чуулган, хаан, ээм, хор, цэнгэл, жаргал, сайн муу, буруу, зөв /



Чингис хааны хөрөг.
Тайванийн музей

Бичвэр 1

ЧИНГИСИЙН ЕСӨН ӨРЛӨГТЭЙ ӨНЧИН ХӨВГҮҮНИЙ СЭЦЭЛСЭН ШАСТИР

Хэсэглэл 1

Чингис хаан Хэрлэн мөрөнд нутаглаж бүхийд зуны тэргүүн сард түшмэддээ зарлиг болруун:

Манай Монголын тэжээсэн
Мал нь хэдэн зүйл буй боловч
Өст дайсан лугаа байлдахуй дор нөхрийн дээд
Үлдэх дайсныг даруй түргэн гүйцэгч
Үл алдагч хавт баатруудын жигүүр
Өсөх залуусын биеийн чимэг болсон
Эрдэнэт морины шим сүүний дээжийг
Эрхт тэнгэр, дэлхий дор өргөн тахиад
Үүнээс эхлэн сайтар тогтоож бүрүүн
Энэ Монгол Улсад хууль болгосугай! хэмээгээд
Есөн өрлөг, таван тайж тэргүүлэн
Ер таван өнгө, дөрвөн харь улсаа хурааж
Их хурим хийхүй дор

Суут Богдод Сүлдэсүний Сорхон шар хэлэв:
Дээд хаан эзэн минь айлдан соёрх!
Дэлхий их энэ хурал чуулганд



УГИЙН ТАЙЛБАР

Өрлөг

Цэрэг удирдан гавьяа
байгуулсан их жанжны цол

Сэцлэх

Оюун ухаанаа уралдуулах

Шастир

Түүхэн бичвэр

Үлдэх

Хөөх

Исэл

Сайн



Зарлиг

Улсын дээд эрхийг баригч
хүнээс гаргасан шийдвэр

Цулгуй

Амттан шимттэн ховор
хомс

Түшмэл

Төрийн албан хэргийг таслан
тогтооход оролцох эрх мэдэл
бүхий тушаалтан

Чуулган

Алив ажлыг зөвлөлдөхийн
тулд хуран чуулсан цуглаан

Тахих

Архи, цай тэргүүтний
дээжийг тэнгэр бурхандаа
өргөх зан үйл

Таван өнгө, дөрвөн харь улс

Хар төвөөд, шар сартуул,
цагаан солонгос, улаан хятад,
хөх монгол хэмээн таван
өнгөөр 5 улсыг, Монголоос
бусад 4 орныг харь улс хэмээн
нэрлэжээ.



Умд дарс үгүй болбоос
Үтэл цулгуй болмуй гэв

Заяат эзнээ Сорхон шар өгүүлбээс
Жалайрадай Гоо Мухулай угтаж аваад хэлэв:
Барилдсан үгсийг минь байлгадаг биш үү
Бардам дээрэнгүй сэтгэлийг төрүүлдэг биш үү
Чуулсан үгсийг минь цуцалдаг биш үү
Цугласан биеийг минь тэмцүүлдэг биш үү
Улигт муу умд дарсыг тэвчвээс
Үг минь бэх, бие минь исэл буй за гэв.

Цогт төрсөн Богдод Гоо Мухулай хэлбээс,
Зүрчидийн Чуу мэргэн угтаж аваад хэлэв:
Санасан үгсийг минь илрүүлдэг биш үү
Сайн муу хоёрыг минь мэдүүлдэг биш үү
Доторх үгсийг минь гаргадаг биш үү
Доор дээр хоёрыг минь ялгадаг биш үү
Эртнээс нааш рашаан биш үү
Энэ ертөнцөд жаргал биш үү
Үүнээс хойш дуртгал биш үү
Эдүгээ үүнийг тэвчвээс
Энэ хурим цулгуй болох зөв буюу гэв.

Ачит төрсөн эзнээ Чуу мэргэн айлдваас
Арулудын Хөлөг Боорч угтаж аваад хэлэв:
Аман дор орохдоо алтан шумуул мэт
Амнаас гарахдаа арслан заан боссон мэт
Хэлэнд амсахуй дор хэдгэнэ шумуул мэт
Хэлнээс гарахдаа хэдэр заан боссон мэт
Оюун билиг хоёрыг минь умартуулдаг биш үү
Олсон зөөсөн хоёрыг минь баруулдаг биш үү.
Биеийн сүлдийг минь бууруулдаг биш үү
Бэхлэн хэлэлцсэн үгийг минь умартуулдаг биш үү
Сархад дор бүү шимтэн согтёе л
Сайн муу хоёрыг ялган хэлэлцье л
Архин дор бүү амтшин согтёе л
Алив үйлээ хэлэлцэн тархъя л гэв.

Ухаант хаан эзнээ Хөлөг Боорч өгүүлбээс
Урианханы Зэлмэ угтаж аваад хэлэв:
Бор дарсны зориг буюу
Богд эзний ману засаг үгүй буюу
Хар архины дур бил үү
Хаан эзний ману цааз үгүй буюу
Умд дарсыг хураая л
Унага даага мэт цэнгэе л.
Урьд хожид согтёе л
Унатал бостол хэвтёе л

Архи дарсыг хураая л
 Ангир галуу мэт цэнгэе л
 Амраг сайхан нөхдөө аван жаргая л
 Алив хүслээ ханалцан тархъя л гэв.

Билигт төрсөн эзнээ Зэлмэ өгүүлбээс
 Бэсүдийн Зэв угтаж аваад хэлэв:
 Умд дарс үгүй болохул ураг үгүй буюу
 Учирсан энэ бие минь жаргал үгүй буюу
 Архи үгүй болохул амраг үгүй буюу
 Амраглан суугч энэ бие минь жаргал үгүй буюу
 Хар архийг тэвчье л
 Хаан эзнийхээ өмнө үнэхээр зүтгэе л
 Хас их төрийнхөө үйлийг зөвлөө л
 Харшлах дайсны үйлийг бэлдье л гэв

Онц төрсөн эзнээ Зэв өгүүлбээс
 Ойрадын Хар Хиру угтаж хэлэв:
 Хурсан бүгд ууваас жаргал биш үү
 Хол ойр сонсохул хүсэл биш үү
 Амлан ядах үгэнд чимэг нэмдэг биш үү
 Алалдах дайсанд зүрхийг минь хатаадаг биш үү
 Богд эзний өмнө
 Бор дарсыг хураагаад
 Бага их үгүй зэргээр ууж
 Баясгалант их хөөрийг үзье л гэв

Богд эзнээ Хар Хиру өгүүлбээс
 Борохул угтаж аваад хэлэв:
 Амраг нөхрөөс алгасуулдаг биш үү
 Алиа муу сэтгэлийг төрүүлдэг биш үү
 Ханилсан нөхрөөс хагацуулдаг биш үү
 Харгис дээрэнгүй сэтгэлийг төрүүлдэг биш үү
 Бор дарсны эрдэм нь ер чухаг буй за
 Бурчиж эвдэх гэм нь ер олон буй за гэв

Шилдэг дээд Богдод Борохул өгүүлбээс
 Шихихутаг угтаж аваад хэлэв:
 Хутагт төрсөн Богд эзний энэ хишгийг
 Хун, галуу мэт дуугаа нэгтгэж
 Хулан, чихтэй мэт зүсээ нийлүүлж
 Хурсан бүгд жаргалдан цэнгэе л
 Ачит төрсөн хаан эзний энэ хишгийг
 Ангир, галуу мэт дуугаа нэгтгэж
 Аргаль, марал мэт зүсээ нийлүүлж
 Амраг сайхан нөхдөө аван жаргая л гэв...

Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив.
 1959 он 39-42-р тал

ЗОХИОЛД ДЭВШҮҮЛСЭН АСУУДАЛ, ХАМ СЭДВИЙН ХҮРЭЭНД САНАА БОДЛОО ИЛЭРХИЙЛЭН БИЧИХ

Задлан шинжлэх даалгавар

Зохиолын дүрд хувилан, ангидаа мэтгэлцээн зохион байгуулаарай. Мэтгэлцээнд өөрийн үзэл бодлоо илэрхийлж, үг хэлж, нотлогч болон няцаагч тал болон оролцоорой.

Сэдэв: Архины хэрэглээ байх нь зөв үү? Буруу юу?

Хэрэглэгдэхүүн: Чингис хаан болон өрлөгүүдийн нэрсийг бичсэн малгай бэлтгэж өмсөх,

Нотлогч тал: Архийг хэрэглэх нь зөв гэж үзсэн өрлөгүүд буюу Сорхон шар, Чуу мэргэн, Зэлмэ, Хар Хиру;

Няцаагч тал: Архины хэрэглээг буруу гэж үзсэн өрлөгүүд буюу Мухулай, Боорч, Зэв, Борохул;

Зохион байгуулагч тал: Чандага сэцэн, Шихихутаг

Тэргүүн шүүгч : Чингис хаан, Дэд шүүгч : Өнчин хөвгүүн

Мэтгэлцээн зохион байгуулах аргачлал :

1. Ангиас 8 сурагч мэтгэлцээнд, 2 сурагч шүүгчээр, 2 сурагч зохион байгуулагч тал болон оролцох ба үлдсэн сурагчид үйл ажиллагааг ажиглан тэмдэглэл хөтөлж, мэтгэлцээний дараа багштайгаа дүгнэн ярилцаарай.
2. Мэтгэлцээн эхлэхээс өмнө дүр бүрийн нэрсийг бичсэн малгайг хүүхдүүд өөрсдийн гараар урлаж өмсөөрэй.
3. Мэтгэлцээнд оролцох 8 сурагч дөрөв дөрвөөрөө нотлогч ба няцаагч тал болон өрсөлдөөрэй.
4. Мэтгэлцээн эхлэхээс 20 минутын өмнө зохион байгуулагч тал өрсөлдөгч нарт мэтгэлцэх сэдэв, баримтлах зарчим зэргийг танилцуулна.
 - Харилцааны хувьд эелдэг, хүндэтгэлтэй харилцааг чухалчлаарай.
 - Бусдын үгийг хүлээцтэй сонсоорой.
5. Мэтгэлцээн эхлэхэд багууд тухайн дүрийнхээ үзэл бодлыг үндэслэл болгон өгүүлэх ба өөрсдийн шийдлийг танилцуулахдаа судалгааны үндэслэлтэй баримт материал ашиглаж болно.
6. Мэтгэлцээнд өөрийн үзэл бодлын үүднээс бус зөвхөн тухайн дүрийн өмнөөс шийдэл гаргаж, багаараа ярилцана. Өөрийн саналаа хамгаалахдаа итгэл үнэмшилтэй, үндэслэлтэйгээр жишээ татаарай. Үүний тулд өөрийн хувирсан дүрийн гадаад дотоод мөн чанар, үзэл бодол, дуу хоолойг түүхэн үүднээс маш сайн судалсан байх ёстой.
7. Шүүгчээр томилогдсон Чингис хаан, өнчин хөвгүүн хоёр мэтгэлцэгч талуудын нотолгоог нэг бүрчлэн сонсож тэмдэглэл хөтөлсний үндсэн дээр аль баг шийдэлтэй, илүү уялдаа холбоо бүхий үнэн зөв нотолгоо гаргасныг харгалзан ялсан багийг тодорхойлж, шүүгчийн хуудсан дээр тэмдэглэнэ.
8. Зохион байгуулагч талын үгсийг сонсоно. (Чандага сэцэн, Шихихутаг)
9. Эцсийн дүгнэлтийг тэргүүн ба дэд зэргийн шүүгчээр ажилласан сурагчид гаргаарай.

...Эзэн богд Чингис хаанаа
Эрхэт есөн өрлөг үг өчвөөс
Үүдэнд суусан өнчин хөвгүүн
Өндийж ирээд хэлэв:
Ихсийн зэрэгт орсон болоосой би
Ер үгээ хэлээсэй би
Сайдын зэрэгт орсон болоосой би
Санасан үгээ хэлээсэй би гэж байв.
Богд эзэн тэр үгийг сонсоод
Бодол үгүй өчүүхэн хөвгүүн юун өгүүлмүй чи гэв.
Тэр хөвгүүн хэлэв:
Эзэн богд минь гэгээн сүртэй аж л
Энэ хурсны дотор үг хэлэх нь бэрх аж л.
Хаан эзэн минь гэгээн сүртэй аж л
Хамаг хурсны дотор үг өгүүлэх нь бэрх аж л.
Ойн дор минь үг буй боловч
Онож хэлэх нь бэрх болов уу гэнэм би гэв.
Богд эзэн зарлиг болбай:
Үгтэй болбоос өч чи
Хошоотой болбоос холбо чи, гайгүй хэл гэв
Өв тэгш дээд эзний зарлигийг сонсоод
Өчүүхэн хөвгүүн баясаж
Өөрийн оюуны чинээгээр
Умд дарсны гэм, эрдэм хоёрыг хэлэв:
Балай их ууваас өвчин биш үү
Бага зэрэг ууваас жаргал биш үү
Бахархаж шунаваас эргүү биш үү
Балмад их согтвоос галзуу биш үү гэв
Үргэлж ууваас улиг биш үү
Өсөд үүнийг тэвчвээс билиг биш үү
Учиртай сайхан ууваас жаргал биш үү
Унатал их ууваас мунхаг биш үү
Хун галуу мэт цуглаад
Хурсан бүгд цэнгэлдэн жаргаасай
Худалч хүмүүний үгийг бүү ажиглан согтоосой та
Хутгалцах дайсан дор биеэ бүү тэвчээсэй
Цэн шувуу мэт цугларч
Сэцэд мэргэдээ аван жаргаасай
Чалчаа хүмүүний үгийг бүү ажиглан согтоосой та
Цавчилдах дайсан дор зэргээр ороосой
Ангир шувуу мэт амаар авалцаасай
Амраг сайн нөхдөө аван жаргаасай
Алиа хүмүүний үгийг бүү ажиглан согтоосой та
Алив хүслээ ханалцан цэнгээсэй
Алалдах дайсан дор нэг нэгнээ бүү орхилцоосой...гэв
Чингис хаанаа сэцэн хөвгүүн үг айлдваас
Чандага сэцэн ховшуур угтаж аваад өгүүлбэй:...

Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын дээж зуун билиг.
1959 он 39-42-р тал

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

► Уран зохиолын найруулгад дүрслэлийг уран яруу болгохын тулд үгийн утгыг шилжүүлэн хэрэглэхийг дүрслэх ур маяг гэнэ. Үүнд: адилтгал, төлөөлөл, тойруулал, ихэсгэл, багасгал, ёгтлол, егөөдөл, амьшуулал, хүншүүлэл, хэтрүүлэл зэрэг арга орно.

Задлан шинжлэх даалгавар

1. Хэсэглэл 1 ба 2-ыг уншина уу. Зохиолын эшлэл, уран дүрслэлийн арга хэрэглүүр болон тухайн эшлэлийг хэн хэлснийг асуултын тэмдэг тавьсан хэсгүүдэд нөхөж, хүснэгтийг гүйцээнэ үү.

	Зохиолоос авсан эшлэл	Уран дүрслэлийн ямар аргыг хэрэглэсэн бэ?	Хэлсэн эзэн нь хэн бэ?
1	Аманд орохдоо Алтан шумуул мэт...	Адилтгал	Боорч
2	Сайн муу хоёрыг минь мэдүүлдэг биш үү...	?	?
3	...Хулгана мэт биеийг чинь хугачнам би Хурсан бүгдэд инээдэм болгоном би гэв.	?	?
4	Хун галуу мэт дуугаа нэгтгэж Хулан тахь мэт зүсээ нийлүүлж Хурсан бүгд жаргалдан цэнгэе...	?	?

5	?	?	Зэв
---	---	---	-----

2. Хэсэглэл 3 дахь монгол бичгийн эхийг уншиж кирилл үсгээр хөрвүүлэн бичнэ үү.
3. Дараах үгсийн утгыг та нар юу гэж бодож байна вэ? Утгыг ярилцан тайлбарлаж бичээрэй.

№	Эшлэл	Далд утга
1	Өчүүхэн хүнийг өргөж хайрлахуул Өсдөггүй буюу Үргэдэг морийг өргөж тэжээхүл таргалдаггүй буюу	
3	Хамаг хурагсдад сэцэн үгүй гэж Хаан эзэнд чи үг айлтгах буюу	
4	Ихсийн зэрэгт орсон болоосой би Ер үгээ хэлээсэй би гэж байв	
5	Аманд орохдоо алтан шумуул мэт Амнаас гарахдаа арслан заан боссон мэт	
6	Үгтэй бол өч чи Хошоотой болбол холбо чи	

ЗОХИОЛЫН УТГА САНААГ БҮРДҮҮЛЭХИЙН ТУЛД СЭДВИЙГ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛСНИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Архины хэрэглээг хэн хэн юу гэж үзэв? Дараах хүснэгтийг гүйцээж бичээрэй.

№	Архийг хэрэглэх нь зөв гэж үзсэн өрлөгүүд	Архины хэрэглээг буруу гэж үзсэн өрлөгүүд
1		
2		
3		
4		
5		
	Хэн нь сархдыг тохируулж хэрэглэх ёстой гэж үзсэн бэ?	
6		

Хоёрдугаар бүлэг



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Шастир:

- Эртний түүхэн зохиолын нэгэн зүйлийг шастир гэнэ.

- “Есөн өрлөг” хэмээн есийн тоогоор онцлон нэрлэсний учир шалтгаан юу вэ ?
- Зохиолд эв найрамдалтай байхыг чухалчилсан санаа байна уу? Аль хэсэгт гарч байна вэ? Шад болон бадгийн доогуур зурж тэмдэглэнэ үү.
- Зэрэг зиндаа, анги давхаргын ялгаагүйгээр хүн бүр өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлдэг байх тэгш эрхийн зарчмыг харуулж байгаа хэсгийг эхээс олж, тайлбарлана уу.
- Зохиогч энэ түүхээр дамжуулан уншигчдад юуг хэлэхийг зорьсон бэ? Зохиолчийн хэлэх гэсэн санаа аль хэсэгт илүү тод илэрсэн бэ? Зохиолоос эш татан санаагаа батална уу.
- Архины гэм хороос гадна өөр ямар санааг чухалчлан хөндсөн бэ? Зохиолоос эш татан батална уу.
- Өнчин ядуу боловч сэцэн мэргэн ухаантай хөвгүүний тухай ардын аман зохиол болон өөр ямар зохиолд өгүүлсэн байдаг вэ?
- Чингис хаан өнчин хөвүүнд хэрхэн хандсан бэ? Өөрийгөө Чингис хааны оронд байгаагаар төсөөлөн ямар шийдвэр гаргах байснаа харилцан ярилцана уу.

ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Түүхэн дүр:

- Нийгмийн тодорхой түүхэн цаг үед амьдарч байсан, улс үндэстний бахархал болсон бодит хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааг уран зохиолд дүрслэн үзүүлснийг хэлнэ.

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Есөн өрлөгийг нэрлэнэ үү.
2. Арван нэгэн сэцдийн үг төгсөв хэмээхийн учир юу вэ?
3. Зохиолд гарч буй түүхэн дүрүүдийн зан төрх, үг үйлдэл, үйл хэргийг орчин нөхцөлтэй нь холбон ойлгохын тулд танилцуулга бэлтгэн, бусдадаа танилцуулаарай. Дүрийн танилцуулга бэлтгэхдээ 5-6 хүнтэй баг болж, дараах хүснэгтийн дагуу хамтарч ажиллаарай.

ШҮЛЭГ, НАЙРАГЛАЛ

№	Баг	Дүр	Юу хэлэв?	Сэтгэлийн ямар өнгө аясаар хандав ?	Ямар үйлдэл хийв?	Энэ үйл явдал ямар орчинд өрнөв?	Дүгнэлт: Би энэ дүрийн зан төрхийгийнхүү тодорхойлж байна. Яагаад гэвэл зохиолд бичсэн учраас ийнхүү тодорхойлж байна.
1	1-р баг	Чингис хаан					
		Сорхон шар					
2	2-р баг	Гоо Мухулай					
		Чуу мэргэн					
3	3-р баг	Боорч					
		Зэлмэ					
4	4-р баг	Зэв					
		Хар Хиру					
5	5-р баг	Борохул					
		Шихихутаг					

ЗОХИОЛЫН ОРЧИН НӨХЦӨЛ НЬ ДҮРИЙН ЗАН ТӨРХИЙГ ТОДОРХОЙЛОХОД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙГААГ ТАЙЛБАРЛАХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Нөхцөл байдал:

- Дүрүүдийн хоорондын харилцааны нөхцөл байдал, дүрүүдийг үзүүлсэн орон, цагийн нийгэм, түүх, соёлын онцлогийг хэлнэ.

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Зохиолын хэрэг явдал нь Монголын түүхийн аль цаг үед хамаарч байна вэ?
2. Зохиолын орчин нөхцөлийг эргэцүүлэн бодоорой.

Чингис хааны
амьдарч байсан цаг
үеийн нөхцөл байдал

► Түүхэн цаг үе
► Соёл ахуй
► Нийгмийн харилцаа

3. Үйл явдал өрнөж байгаа орчин, нөхцөл нь дүрүүдийн зан төрхийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахын тулд дараах асуултад хариулан бичээрэй.
 - Дүгнэлт хэсгийг нөхөхдөө санал нийлж байгаа хариултын өмнөх дугаарыг дугуйлан, зохиолоос эшлэл авч, өөрийн хариултаа батлаарай.

ЗӨВЛӨМЖ

- Баг тус бүр өөрийн багаас бэлтгэсэн танилцуулгаа бусдад хүргэж ярих илтгэгч нэг сурагчийг үлдээн, бусад нь мэдээлэл солилцохоор явна. Мэдээлэл авах сурагчид багуудыг тойрч явахад баг тус бүрийн илтгэгч сурагч өөрийн багийн танилцуулгыг бусдад ойлгомжтой байдлаар ярьж тайлбарлана.

А. Зохиолын үйл явдал хэдий үед болж байгаа вэ? /Хэзээ ? /

Б. Үйл явдал хаана, ямар орчинд өрнөж байгаа вэ? /Хаана ? /

В. Ямар үйл явдал өрнөж байна вэ? /Юу? /

Г. Уг үйл явдалд хэдэн хүн оролцсон бэ? /Хэдэн ?/

Д. Хүмүүсийн сэтгэл хөдлөл, сэтгэлзүй ямархуу байдалтай байсан бол? /Ямар ?/

Е. Тухайн орчинд дүрүүд үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх нөхцөл байдал бүрдсэн үү? /Орчин, нөхцөл /

Дүгнэлт: Миний бодлоор үйл явдал өрнөж байгаа орчин, нөхцөл нь дүрүүдийн зан төрхийг тодруулахад,
1. Маш их нөлөөлдөг гэж ойлголоо. Яагаад гэвэл зохиолд бичсэн учраас би ингэж дүгнэж байна.
2. Зарим үед харилцан хамаардаг гэж бодож байна. Яагаад гэвэл, зохиолд бичсэн учраас би ингэж дүгнэж байна.
3. Тодорхой нөлөө үзүүлэхгүй байх аа. Яагаад гэвэл....

ШҮЛЭГЛЭСЭН ЗОХИОЛЫН ШАД ХОЛБОЦ, АЙЗАМ ХЭМНЭЛИЙГ ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

Яруу найргийн зохиолын айзам хэмнэл, холбоцыг ажиглан, дүгнэлт гаргахын тулд дараах хүснэгтийг ашиглаарай. Өгөгдсөн жишээнээс гадна зохиолоос тохирох эшлэлийг өөрсдөө нэмж бичин, дүгнэлт гаргана уу.

№	Айзам хэмнэлийг бүрдүүлдэг зүйлс	Тохиромжтой жишээ, эшлэл	Дүгнэлт
1	Толгой холбоц		
2	Сүүл холбоц	...Эртнээс нааш рашаан биш үү Энэ ертөнцөд жаргал биш үү Үүнээс хойш дуртгал биш үү Эдүгээ үүнийг тэвчвээс Энэ хурим цулгуй болох...	
4	Яруу хэрэглүүр: Уран асуулт	Балай их ууваас өвчин биш үү Бага зэрэг ууваас жаргал биш үү ?	
5	Мөр бадгийн доторх үеийн тоог тэнцүүлсэн байдал	Амраг нөхрөөс алгасуулдаг биш үү Алиа муу сэтгэлийг төрүүлдэг биш үү Ханилсан нөхрөөс хагацуулдаг биш үү Харгис дээрэнгүй сэтгэлийг төрүүлдэг биш үү	

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Холбоц:

- ▶ Яруу найрагт ижил төсөөтэй авиагаар холбон, айзам хэмнэл бүрдүүлснийг холбоц гэнэ. Монгол шүлгийн холбоц нь гол төлөв үгийн эхлэл болон төгсгөлд сонсогдоно.

Уран давталт:

- ▶ Уран сайхны зорилгоор үг хэллэг, өгүүлбэр, мөр бадгийг давтах ур маяг.

ҮНЭЛГЭЭ

Хүүхдүүд ээ! Сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг ойлголт болон өөрийн идэвх оролцоог дараах асуултын хүрээнд дүгнэн, өөртөө үнэлгээ өгөөрэй!

Сэдэв: “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн сэцэлсэн шастир ” зохиолын сэдэв, утга санааг тодорхойлох, учир холбогдлыг шинжлэх

Даалгавар 1

Өрлөг бүрийн хэлсэн үгсийн утга санааг тайлан тайлбарлаж бичнэ үү.

Даалгавар 2

Архины гэм хорыг хэрхэн тусгасан бэ? Зохиолоос эшлэл авч батлаарай.

Даалгавар 4

Зохиолд архины гэм хороос гадна өөр ямар санааг чухалчлан хөндсөн бэ? Зохиолоос жишээ авч, тайлбарлаарай

Даалгавар 3

Зохиолд ямар асуудлыг дэвшүүлж, ямар утга санааг гаргасныг дүгнэж бичээрэй

Үнэлэх шалгуур	1-5 оноо
Зохиолд дэвшүүлсэн асуудлын талаар бодож эргэцүүлсэн үү?	
Ангийн мэтгэлцээнд оролцон өөрийнхөө үзэл бодлыг хамгаалан ярьж чадсан уу?	
Өөрийгөө зохиолын баатрын оронд байгаагаар төсөөлөн бодсон уу?	
Зохиолд архины гэм хороос гадна өөр санаа хөндсөн байгаа. Энэ талаар эргэцүүлэн бодсон уу?	
Найраглалаас өөрт таалагдсан хэсгээ цээжилж чадсан уу?	
Багаар ажиллах явцад нөхдийнхөө саналыг сонсон, хүндэтгэж, хүлээцтэй байж чадсан уу?	
Бусдыгаа ярьж байх үед зөв гэж үзсэн саналыг дэмжсэн үү?	
Багштай болон бусад сурагчтай санал зөрсөн тохиолдолд тодруулан асууж байсан уу?	
Зохиолоос жишээ баримт татан өөрийн үзэл бодлыг хамгаалж чадаж байгаа юу?	

Б.Явуухулан нь Монголын уран зохиолын хөгжилд “Дууль” хэмээх төрөл зүйлийг шинэ шатанд гаргаж хөгжүүлсэн ба 1969 онд бичсэн “Тэхийн зогсоол” дууль нь Монголын төдийгүй дэлхийн яруу найргийн шилдэг бүтээлд зүй ёсоор ордог.

УНШИХЫН ӨМНӨ

Дараах асуултын дагуу таамаглал хийж эргэцүүлэн бодоорой.

- ▶ “Тэхийн зогсоол” хэмээх нэрийг сонсоод чамд юу бодогдож байна вэ? Зохиолд юуны талаар өгүүлэх бол?
- ▶ Дараах түлхүүр үгсийг ашиглан таамаглал дэвшүүлээрэй. Түлхүүр үгс: Өвөлжөө, өвөл, харлаг, тэх, анчин, аав, эмээ, ээж, гурван гэр, оргил, бүргэд, зогсоол, нутаг, ус, амьтан, янгир, сүрэг, орчлон, уул, ёс, нүүдэл, үхэл, амьдрал



Бэгэгийн Явуухулан
/1929-1982/

Завхан аймгийн Алдархаан суманд төржээ. 1948 оноос уран бүтээлээ эхэлж, “Цэнхэр мандлын тэнгэр дор”, “Мөнгөн хазаарын чимээ”, “Хар ус нуурын шагшуурга”, “Хээр хоносон сар”, “Тэхийн зогсоол”, “Намрын мөнгөн өглөө”, зэрэг яруу найргийн ном хэвлүүлжээ. Шилдэг бүтээлээрээ 1967 онд Монгол Улсын Төрийн шагнал, 1979 онд Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртсэн байна.

ТЭХИЙН ЗОГСООЛ

Дууль

(Миний хайрт эцэг, нэрт анчин агсан Бэгз таны
гэгээн дурсгалд зориулав.)

Тээр жилийн тэр нэгэн өвлийн
Өнтэйг яана!
“Тэхийн зогсоол” гэдэг тэр оргилын
Өндрийг яана!
Хүрэн уулсын буйд мухар
Хүүш нэртэй
Хүрэхэд хол ч өвөлжихөд нөмөр
Хөх бууцтай.
Хүрэн уулсыг халуун намраар
Аав минь зорив.
Хүүшийн өвөлжөөнд гурван гэрээр
Айл өвөлжив.
Өвөлжөөг хүрээлсэн уулсын оргил
Бүгд өндөр
Өндрийн дундаас “Тэхийн зогсоол”
Бүүр ч өндөр!
Өвөлжөөнд буугаад аав хэсэг зуур
Ан хийв.
Өвөлд бэлдээд айлууд хэсэг зуур
Ажил хийв.
Өнтэй жилийн тэр нэгэн өвлийн
Дулаахныг хэлэх үү
Өвс цас тэгшхэн ууланд өвөлжихийн
Тухтайг хэлэх үү
Говийн ууланд жам ёсоороо
Хавар ирэв.



ҮГИЙН ТАЙЛБАР

Хүүш

Оройхон нар тусдаг, хад
болон уулын ар талын
сүүдэр газар

Буйд

Төвөөс алс зэлүүд газар

Мухар

Гарцгүй газар

Хөх бууц

Өнгө нь гандаж хөхөрсөн
өтөг бууц

Өнтэй жил

Өвс, цас элбэгтэй, зудгүй
дулаан жил

Харлаг

Хар алаг зүс

Тэх

Нас гүйцсэн эр янгир

Хонины ээлж

Хонь хариулах өдөр

Хишиг хүртэх

Ан хийж, ганзага мялаах

Ямаан ус

Газрын нэр

Идээлэх

Идэх



Гол бараадаж гурван гэрээрээ

Нүүх болов.

Нэгэн өглөө аав минь намайг

Гаднаас дуудав.

Нэг нүдний сунадаг дурангаа

Гарт бариулав

-“Тэхийн зогсоол” дээр юу байна?

Сайн хар! гэв.

Тэгж хэлснийхээ жаахан хойно

Санаа алдав.

Үзүүр нь гурвалжин, үүлэнд шүргэх

Оргил харагдав.

Үүрээ манан өндөрт эргэх

Бүргэд харагдав.

Дэргэдэх оргил нь илээд авахаар

Ойрхон байв.

Дээрх тэнгэр нь нүдэнд торохоор

Үүлгүй байв.

- “Тэхийн зогсоол” дээр хараагаа тогтоо! гэж

Аав минь хэлэв.

Тэрүүн дээр нэг амьтан бий, ол доо гэж

Ахин хэлэв.

Өвөлжин харагдаж, нүдэнд дассан

Оргил үзэгдэв.

Орой дээр нь эвэр нь сэрийсэн

Тэх харагдав.

Хангайн сайхан амьтныг үзээд

Би баясав.

- Харлаг тэх зогсож байна гээд

Бараг хашгирав.

Аав минь дуугүй, тамхиа сорсоор

Гэртээ оров.

Айлын хүмүүс янгирын сургаар

Манайд цуглав.

Цайгаа ч уухгүй аав минь тэгээд

Хэсэг суув.

Цаанаа л нэг гунигтай хоолой засаад

Ингэж ярив.

- Мөнгөн оройт уулсын хишгийг

Их хүртлээ.

Мөнхийн зогсоолдоо зогссон янгирыг

Анх үзлээ.

“Ямаан усанд” ноднин байсан

Тэх мөн байна.

Яах аргагүй зогсоолдоо зогссон

Тэх мөн байна.

Төрсний эцэст үхнэ гэдэг

Амьтны ёс оо!

Төрсөн нутгаа орхино оо гэдэг
 Амаргүй даваа!
 Янгир өтлөхөөрөө эврээ даахаа
 Больдог юм гэнэ лээ.
 Янгирын сүргээ гүйцэж чадахаа
 Байдаг юм гэнэ лээ.
 Эхээс төрсөн ууландаа эргэж
 Ирдэг юм гэнэ лээ.
 Эхээс унасан газраа олж
 Хэвтдэг юм гэнэ лээ.
 Насныхаа эцэст оргил өөд мацаж
 Гардаг юм гэнэ лээ
 Нартад түүнийг нь “Тэхийн зогсоол” гэж
 Нэрлэдэг юм гэнэ лээ.
 Өндөр оргил дээр олон хоног
 Зогсдог юм гэнэ лээ.
 Өнгөрүүлсэн амьдралаа эргэж нэг
 Хардаг юм гэнэ лээ.
 Умдаалдаг ариухан усаа үзэж нэг
 Баярладаг юм гэнэ лээ.
 Идээлдэг сайхан бэлчээрээ харж нэг
 Баясдаг юм гэнэ лээ.
 Ижил олон сүргээ эцсийн удаа
 Үздэг юм гэнэ лээ.
 Эх болсон нутгаа сүүлчийн удаа
 Хардаг юм гэнэ лээ.
 Өндөр оргилоос эвэр нь дийлээд
 Хальдаг юм гэнэ лээ.
 Өнгөт орчлонгоос нэг нь тэгээд
 Дутдаг юм гэнэ лээ.
 Аавын яриаг хүн бүхэн
 Дуугүй чагнав.
 Айлын эмээ янгирыг өрөвдөн
 Нулимс унагав.
 Тэрнээс хойш аав минь нэг л
 Зовууртай болов.
 Тэр өвөлжөөнөөс хэсэгтээ нэг л
 Нүүхээ байв.
 Гурван гэрийн хонины ээлж
 Дороо эргэнэ.
 Гуравхан хоногт манай ээлж
 Эргээд ирнэ.
 - Өндөр өөд хонио бүү бэлчээ гэж
 Аав минь захиана.
 Өглөө болгон л гаднаа сууж
 Оргил дурандана.
 Хүүшийн өвөлжөөнд чандманьлаж буусан
 Гурван айл!

Хүмүүсийн харааг өөртөө татсан
 Гурвалжин оргил!
 Цэнхэр тэнгэрт эвэр нь сэрийсэн
 Харлаг тэх!
 Чанх дээр нь өдөржин эргэх
 Хүрэн бүргэд!
 Ийм л зураг олон хоногоор
 Аавд минь харагдав.
 Энэ л зураг олон хоногоор
 Өвөлжөөнд суулгав.
 Нэгэн өглөө оргилыг дурандаад
 Аав орж ирэв.
 Нэг харахнаа баяртай мишээгээд
 Цайгаа ууж суув.
 - Яг л ёсоороо хальж дээ хөөрхий! гэж
 Аав минь ярив.
 -Яамай даа яамай, хөөрхий минь! гэж
 Ижий өрөвдөв.
 Маргааш өглөө нь гурван гэр маань
 Эрт ачаалав.
 Манарсан бууцнаас хүн мал маань
 Зэрэг хөдлөв.
 “Тэхийн зогсоол” оргилыг аав минь нэг
 Эргэж харав.
 Төрсөн нутаг минь! гэж эцэг минь нэг
 Өөртөө хэлэв.
 Тээр жилийн тэр нэгэн өвлийн
 Уртыг яана!
 “Тэхийн зогсоол” гэдэг тэр оргилын
 Өндрийг яана!

Б.ЯвуухуланТүүвэр зохиол. 1985.
 443-447 дахь тал



Завхан аймгийн Алдархаан сумын “Богдын гол” багийн нутаг дэвсгэрт
 орших Б.Явуухулангийн эцгийн өвөлжөө “Хүүш” хэмээх газар.
 Эх сурвалж: www.Zavkhan1.gov.mn

НАЙРАГЛАЛЫГ УНШИЖ, СОЁЛ ТҮҮХ, НИЙГМИЙН ХАМ СЭДВИЙН ХҮРЭЭНД МЭДЭРЧ ТУСГАН ХҮЛЭЭН АВАХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Найраглал:

- ▶ Нэг талаас туульсын зохиол адил баатрын хэрэг явдлыг хүүрнэн өгүүлэх атлаа нөгөө талаас гол баатрын юм уу өгүүлэгчийн бодол санаа, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх шүлэглэсэн зохиолын томоохон хэлбэрийг найраглал гэнэ.

ЗӨВЛӨМЖ

- ▶ 5-6 хүнтэй баг үүсгэн, уран унших дасгалыг хийгээрэй.
- ▶ Уран унших алхмыг сайтар уншиж, багаараа хэлэлцэн, сурагч бүр урнаар уншихад бэлтгээрэй.
- ▶ Шалгуур үзүүлэлтийн дагуу бие биеийнхээ уран уншсан байдлыг 1-5 оноогоор дүгнэж, нөхдөө урмын сайхан үгээр дэмжээрэй.

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

Б.Явуухулангийн “Тэхийн зогсоол” дууль найраглал нь уянга-туульсын хэв шинжтэй найраглал юм.

1. Хүснэгтийг гүйцээхдээ зэрэгцүүлэн тэмдэглэл хөтлөх аргыг хэрэглэж бичээрэй.

Хамгийн их сэтгэл хөдөлгөсөн эшлэл	Яагаад энэ хэсэг сэтгэлийг чинь хөдөлгөв?	Тухайн үг, өгүүлбэрийг уншаад төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ бичнэ үү.

2. Хүүхдүүд ээ! Найраглалын утга санааг улам гүнзгий мэдэрч ойлгохын тулд урнаар унших дадлага хийцгээе!

№	Үнэлгээний шалгуур	Үнэлгээ 1-5 оноо
1	Зохиолын утга агуулгыг нарийн мэдэрч, ойлгосон байдал	
2	Үйл явдлыг сэтгэлдээ төсөөлж зураглаж буй байдал	
3	Дүрийн зан төрх, сэтгэлзүйг мэдэрч, дууныхаа өнгийг өндөр нам болгон, үйл явдал бүрт өөрчлөн уншиж буй байдал	
4	Мөр, бадгийн тоог тооцоолон, үгийн тооноос шалтгаалан, амьсгалаа хуваарилж буй байдал	
5	Үгийн өргөлтийг тооцоолж, цэг, таслал дээр зогсоц аван, мэдэрч уншиж буй байдал	
6	Өгүүлэгч болон баатрын үг хэллэгийг ялгаж уншиж буй байдал	
7	Өөртөө итгэлтэй байдал	

“Тэхийн зогсоол” дуулийг уншсан Ш.Гүрбазарын бичлэгийг сонсож, өөрсдийн уран унших чадварыг сайжруулаарай
Эх сурвалж: <https://www.youtube.com/watch?v=Z9fM3UVDA0>

ЗОХИОЛЫН ОРЧИН НӨХЦӨЛ БАЙДАЛ НЬ ДҮРИЙГ ТОДРУУЛАХАД НӨЛӨӨЛЖ БУЙГ ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Зохиолын үйл явдал өрнөж буй орчин нөхцөлийн тухай ойлголтоо дараах асуултад хариулах явцдаа бататгаарай.

Асуултад хариулахдаа эхлээд бие дааж хариулж бичсэний дараа хосын аргаар найзтайгаа саналаа солилцож, ярилцаарай.

- Хэзээ, хаана, ямар орчин нөхцөлд, хэдүүл өвөлжив?
- Хаанахын ууланд жам ёсоороо хавар ирэв?
- Хэдийд, хаана юу юу харагдав?
- Хаана, ямар нөхцөл байдал бий болов?
- Аль зүг рүү хонио бэлчээхээ болив?
- Ямархуу өвөл болов?
- Ямар орчин хамгийн содон байв?
- Яагаад айлууд нүүхгүй удав?

2. Цаг хугацааны хоёр өөр нөхцөлд дүрийн зан төрх хэрхэн өөрчлөгдөж байна вэ? Чи юу гэж бодож байна вэ? Дүрийг тодорхойлж, учрыг тайлбарлана уу.

Дүр	Зан төрх	Тэхийг харснаас хойш хэрхэн өөрчлөгдөв?
Аав	Нүүх суух шийдвэр гаргадаг	
Би	Аавынхаа үгэнд ордог	
Эжий		
Айлын эмээ	Уяхан	
Тэх	Амьтны амьдралын жамыг туулсан	
Бүргэд	Аливаа зүйлийг олж харж чаддаг	

3. Цаг хугацааны хоёр өөр нөхцөлд дүрийн зан төрхийн өөрчлөлт хэрхэн илэрдгийг гүйцээн бичээрэй !

Цаг хугацаа, орчин нөхцөл нь дүрийн зан төрхийг өөрчилдөг ажээ. Тухайн өөрчлөлт нь баатрын царай төрх,зэргээр илэрч байна. Жишээ нь:...

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Ахиулал:

- Үг хэлээр хүний сэтгэлийн хөдөлгөөн, үйлийн явц өрнөлийг багаас их рүү, энгийнээс нарийн руу эрчимжүүлэн ахиулж илэрхийлэх давталтын өвөрмөц хэлбэрийг хэлнэ.

ЗӨВЛӨМЖ

- Хам сэдвээс утгыг таамаглан тайлбарлахад хэцүү болон толь бичиг байхгүй нөхцөлд бичвэр бүрийн ард жагсаан бичсэн үгсийн тайлбарыг ашиглана уу.

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Зохиолыг уншихад утгыг нь мэдэхгүй үг тохиолдож байна уу? Хүснэгтийг гүйцээж бичээрэй.

Утгыг нь огт мэдэхгүй үг	Тайлбар
Өнтэй	
Буйд	
Хүүш	
Бууц	
Хам сэдвийн хүрээнд утга нь тодрох хэллэг	Тайлбар
Өвс цас тэгшхэн	
Гол бараадах	
Чандманьлаж буух	
Хонины ээлж	

2. Янгир ямааны эр эм болон үр төлийг хэрхэн нэрлэдэг талаар мэдлэг, мэдээллээ бататгаарай.

Ерөнхий нэр	Өөр нэр	Эр	Эм	Үр төл
Ямаан гөрөөс	Цагаан шил тэх-Хамгийн хөгшин том тэх	Тэх	Янгир Багзаг тэх-шүдлэн	Өнөх-Төл ишиг нь Хүнэн тэх-8 настай

3. Зохиолын эшлэлийг дүрслэх ур маягтай зөв харгалзуулаарай.

Зохиолоос авсан эшлэл	Дүрслэх ур маягийн нэршил
1.Өвөлжөөг хүрээлсэн уулсын оргил Бүгд өндөр Өндрийн дундаас тэхийн зогсоол Бүүр ч өндөр	А. Хэтрүүлэл
2. Үзүүр нь гурвалжин үүлэнд шүргэх Оргил харагдав	Б. Төлөөлөл
3.Мөнгөн оройт уулсын хишгийг Их хүртлээ	В. Ахиулал
4.Нартад түүнийг нь "Тэхийн зогсоол" гэж Нэрлэдэг юм гэнэ лээ	Г. Хүншүүлэл
5.Өнгөрүүлсэн амьдралаа эргэж нэг Хардаг юм гэнэ лээ	Д. Адилтгал

ШҮЛЭГЛЭСЭН ЗОХИОЛЫН ШАД, ХОЛБОЦ, АЙЗАМ ХЭМНЭЛИЙГ ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Уянгын баатар:

- Уянгын зохиолд бодол санаа, сэтгэл хөдлөл, мэдрэмж зэрэг дотоод ертөнцийг илэрхийлж буй дүрийг уянгын баатар гэнэ. Яруу найрагт их төлөв нэгдүгээр биеэс санаагаа илэрхийлдэг тул “би баатар” гэж нэрлэх нь бий.

- Уянгын найраглалыг яруу сонсголонтой, айзам хэмнэлтэй болгож байгаа зүйл юу байгааг ажиглан, хүснэгтийг гүйцээн бичээрэй!

№	Айзам хэмнэлийг бүрдүүлдэг зүйлс	Жишээ	Тайлбар
1	Толгой холбоц		?
2	Сүүл холбоц		1 ба 3 дугаар мөрөнд “яана” гэсэн үгээр, 2 ба 4 дүгээр мөрөнд харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр /өвлийн, оргилын/ сүүл холбосон нь найраглалыг яруу сонсголонтой, айзам хэмнэлтэй болгожээ.
3	Ахиулал		
4	Уран давталт		?
5	Мөр бадгийн доторх үгийн үеийн тоог тэнцүүлсэн байдал		?
6			

БҮТЭЭХ УРЛАН:


Дараах даалгавраас сонгон гүйцэтгэнэ үү.

- А. Унших: Найраглалаас сэтгэлд нийцсэн хэсгийг цээжлэн, уран яруу уншихад бэлтгэж ирээрэй.
- Б. Бичих: Аавын дүрийн талаар төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн эсээ бичээрэй. Санаагаа илүү тод гаргахын тулд дараах үгсийг ашиглаарай. (Ашиглах үгс: Миний бодлоор, сэтгэгдэл, төрөх, мэдрэмж, сэтгэл зүрх, хорвоо, жам ёс, амьтан, санагдах, уужим, догдлох, хайрлах, ухаарах, монгол, заншил, сэтгэлгээ, анчин, байгаль дэлхий, өрөөч, зөөлөн, холч ухаан, сэтгэл санаа, түгшүүр, ухаан бодол, дасан зохицох, уламжлал)

ҮНЭЛГЭЭ

- Сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг ойлголтоо шалгахдаа дараах асуулт даалгаврыг гүйцэтгэн багшдаа шалгуулж, үнэлүүлээрэй!
 - Зохиол хаана болж байна вэ?
 - Тэхийн халил хүүгийн сэтгэлд гунигтай дурсамж үлдээсэн эсэхийг тааварлан бичнэ үү.
 - Харлаг тэхийн зогсолт, аавын сэтгэлзүйн байдал хоёр хэрхэн холбогдож байна вэ?
 - Хүн байгалийн хүйн холбоо, жам ёс ижилхэн юм гэдгийг аль мөр бадгуудад илүү тод дүрсэлсэн бэ?
 - Янгир өтлөхөөрөө хийж чаддаггүй үйлийг жагсаан бичнэ үү.
 - Өвгөн анчин зогсоолдоо зогссон тэхийг харалгүй нүүдэл хийсэн бол дууль цаашаа хэрхэн өрнөх байсан бэ? Чи юу гэж бодож байна? Таамаглан бичээрэй.
 - Өтөлсөн янгир яагаад эврээ даахаа больдог вэ? Амьтан судлалын талаарх сонирхолтой мэдээллүүдийг цуглуулан, энэ талаар судлаарай.
 - Өвгөн анчин оргил дээр зогсож буй янгирыг агнаагүйн учир юу вэ? Ан агнах ёс заншлын талаар ярилцаарай.
 - Би баатрын оронд тэхийн зогсож байгааг харсан бол өдөр бүр ямар тэмдэглэл бичих байсан бэ? Гурван гэрийн хүмүүсийн сэтгэлзүйн байдалтай холбон бичээрэй.
- Бүдүүвчийг ажиглан, бидний үзсэн хоёр найраглал аль хэсэгт хамаарахыг дүгнэн бичээрэй.

ШҮЛЭГ, НАЙРАГЛАЛ



- Дараах асуултад хариулан өөрийн үнэлгээ хийгээрэй.

№	Үнэлгээний шалгуур	Хариулт
1	Бидний сурсан зүйлээс хамгийн чухал нь юу байв?	
2	Сэдвийн хүрээнд ямар ямар шинэ зүйлийг мэдэж авсан бэ?	
3	Бидний сурсан зүйлсээс юу нь хамгийн гайхалтай байв?	
4	Сэдвийн хүрээнд тодорхой биш зүйл юу байв?	
5	Бидний судалсан зүйлээс юу нь хамгийн хэцүү байв?	
6	Хичээлүүдээс хамгийн сонирхолтой нь аль хичээл байв?	
7	Өөр юуг илүү их гүнзгийрүүлж мэдмээр байв ?	

Алжаал тайлах дасгал :


Үгийн сүлжээ бөглөн, оюуны дасгал хийгээрэй. Бөглөх явцдаа эх зохиолд орсон зарим үгийн утгын тайлбарыг мэдэж аваарай.

ХӨНДЛӨНГӨӨР

1. Ээжийн ээж
2. Өвөлжөөний нэр
3. Сүм хийд, суваргын оройд байдаг өлзий мөрийг бэлгэдсэн гурван дусал бүхий тэмдэг
4. Нутаг сонгож, нэг газраас нөгөөд шилжин явах үйл явц
5. Нэгэн зүйлийн зэрлэг ямаа
6. Янгир ямааны эр нь

БОСООГООР

1. Ан гөрөө хийдэг хүн
2. Нутагладаг газартаа зохицсон бор хүрэн өнгөтэй, хүч чадал ихтэй, хурдан шаламгай хөдөлгөөнтэй, том биетэй, махчин шувуу
3. Амьтны аймгийн хэсэг бүлэг
4. Нэгэн өрх гэр, бүл
5. “Үүрд”, “эгнэгт” гэсэнтэй ижил утгатай үгийг харьяалахын тийн ялгалаар хувиргасан хэлбэр
6. Амьтны орогнох оромж





НОМ УНШЛАГАД ХӨТЛӨХҮЙ



МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН ДЭЭЖИС Найман боть. II боть

Хэвлэлд бэлтгэсэн: Д.Төрбат нар

Редактор: Л.Түдэв

Эрхлэн гаргасан огноо: 1994



Б.ЯВУУХУЛАН. ТҮҮВЭР ЗОХИОЛ

Эмхэтгэсэн Ж.Адъяа, Я.Баатар

Редактор Д.Цэнд

Эрхлэн гаргасан огноо: 1985

ШҮЛЭГ, НАЙРАГЛАЛ

ЯРУУ НАЙРГИЙГ МЭДЭРЧ ХҮЛЭЭН АВАХАД ТУСЛАХ НЬ

Алхам	Аргачлал
1. Анхааралтай унш.	Дуудан унших буюу толгойдоо төсөөлөх замаар үгсийн сонголонг чанарыг төсөөл. Анхаарлаа төвлөрүүлээрэй.
2. Танил бус үгийг хар.	Толь бичиг хэрэглэж заншаарай.
3. Зүүлт тайлбар хий.	Яруу найраг дахь санаанууд болоод түлхүүр үгсэд санал-тайлбар хий.
4. Хураангуй товчлол бич.	Яруу найргийн хэсэг бүлэг юм уу, бадаг бүрээр юу тохиолдсоныг хураангуйлан бичнэ үү. • Юу тохиолдсон бэ? • Хүн, газар орон, эд юмс болоод хэрэг явдлыг юу гэж дүрсэлсэн бэ? • Яруу найрагт ямар сэтгэл хөдлөл, мэдрэмж байна вэ? • Яруу найрагт ямар санаанууд байна вэ? • Яруу найргийг хэнээс хэнд зориулсан байна вэ?
5. Яруу найргийн далд санааг тодруул.	Эргэцүүлнэ үү: Шүлгийн сэтгэл хөдлөлийн мэдрэмж болон санаанууд нь юу байв?

Өөрийн үнэлгээ
(Мэдэрч унших чадвар)

1. Анхаарлаа төвлөрүүлэн унших
2. Унших явцдаа гол хэсэг, чухал үг зэргийг ялгаж, салгах
3. Унших явцдаа өөрт хэрэгтэй санаа, үг өгүүлбэрийг тэмдэглэн авах
4. Унших явцдаа янз бүрийн тулгуур зураглал, томъёо, томъёолбор ашиглан тэмдэглэх
5. Уншсаныхаа дараа тулгуур зураглал, томъёо, томъёолбор ашиглан тэмдэглэх
6. Төлөвлөгөө гарган тэмдэглэх
7. Төлөвлөгөөнийхөө дагуу сэргээн санах
8. Бусдад уран тод, зөв унших
9. Жүжиглэлтэй уран унших
10. Номын сан, номын худалдаа зэргээс өөрт хэрэгтэй чухал номыг зөв сонгож унших
11. Ном сайн уншдаг нөхдөөсөө суралцах

Сурагч та:

Өөрийнхөө унших чадварыг шалгаж үнэлэхдээ дараах дүрсүүдийг сонгоорой.

Үүнд:

Чаддаг байв



Улам хөгжүүлэв



Шинээр сурав



Үүнийг зохиол тус бүрээр гаргавал нэн сайн. Өөртөө өгсөн үнэлгээгээ тус бүрийг тоолоод, нийт шалгуур асуултынхаа тоог 100% гэж харьцуулан тооцож үзээрэй.

Өөрийн унших чадварт аль болох шударга үнэлгээ өгч чадвал хойшдын суралцах үйл ажиллагааны тань чухал тулгуур болсон унших чадвараа ахиулах, улам бататгах, шинээр сурах зүйлийн тухайд ихээхэн тус болно шүү!

Дүгнэлт 2.
УРАН ЗОХИОЛЫН ТӨРӨЛ, ЗҮЙЛ

Үгийн урлаг болох уран зохиол нь эрт цагаас амаар зохиогдон, амаар уламжлан хөгжиж байснаа хүн төрөлхтөн бичиг үсэгтэй болсноор бичгийн уран зохиол үүсч хөгжсөн билээ. Монгол **аман зохиолыг** аман яруу найраг, хүүрнэн өгүүлэх аман зохиол, жүжиг наадмын аман зохиол гэж гурван төрөлд ангилж судалдаг. Бид энэ удаад аялгуут аман яруу найргийн зүйлсээс **ерөөл, магтаал, баатарлаг тууль**, хүүрнэн өгүүлэх аман зохиолоос хошин шог **үлгэртэй** танилцаж байна.

Уран зохиол нь үгээр илрэхдээ нэг бол бодит юмс үзэгдлийг дүрслэн үзүүлдэг, нэг бол зохиолчийн бодол санааг илэрхийлдэг, эсвэл харилцааны хэрэглүүр болж байдаг. Иймээс уран зохиолыг туульсын зохиол, уянгын зохиол, жүжгийн зохиол гэж үндсэн гурван төрөлд ангилдаг. **Туульсын зохиол** бол тодорхой баатруудыг дүрсэлж, үйл явдлыг хүүрнэн өгүүлдэг. Туульсын том хэлбэрийн зохиолоос бид **баатарлаг туульс**, дунд хэлбэрийн зохиолоос **найраглал**, тууж жижиг хэлбэрийн зохиолоос **өгүүллэгтэй** танилцаж байна. **Уянгын зохиол** бол хүмүүний сэтгэл санааны байдлыг гол төлөв шүлэглэн гаргадаг. Уянгын зохиолоос хамгийн төгс боловсорсон авианы байгууламж бүхий нь **шүлэг** юм.

III БҮЛЭГ



Монгол Улсын Үндэсний Номын сан.
Улаанбаатар хот

Гуравдугаар бүлэг. ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖ

3.1. Өгүүллэг

Д.Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэг

Ж.Барамсай “Цүнхтэй инээд” хошин өгүүллэг

3.2. Тууж

П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг ба Борзооны явдал” тууж

Дүгнэлт

ЗОРИЛГО:

Энэ бүлгийг судалснаар та монголын орчин үеийн өгүүллэг, туужийн бичвэрийг уншиж, тусган хүлээж авах, сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн бичих чадвараа хөгжүүлнэ.

3.1. ӨГҮҮЛЛЭГ

УНШИХЫН ӨМНӨ

- Дараах зохиолын нэр гарчгаас үндэслэн зохиолын хэрэг явдлыг таамаглан уншина уу.



Донровын Намдаг
/1911-1984/

Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт төржээ. 1934 оноос уран бүтээлээ эхэлж, “Алим”, “Их хурим”, “Цаг төрийн үймээн”, “Шарай голын гурван хаан”, “Сүрэг чоно” зэрэг олон ном хэвлүүлжээ. 1962, 1983 онд Төрийн шагнал, 1971 онд Урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.

Бичвэр 1

ҮРЭГДСЭНИЙГ ХҮЛЭЭГЧ

(Өгүүллэг)

1939 оны намар говь нутагт суудлын ногоон машинтай цэргийн нэг дарга Нямаа өвгөн гэгчийнхийг эрэн сурсаар очив. Тэрээр Халх голын байлдаанд байлдсан нэг бага даргын тухай яваа боловч очсон тэр айлдаа баяр баясгаланг өгч чадсангүй.

Гэрийн баруун хоймор өргөн нүүртэй шанааны үс буурал, янхигар цээжтэй, тавь эргэм настай Жамьян гэгч гүнээ санаа алдаж, “Ээ хөөрхий эхээс бид гурван хүү төрсөн юм сан” гэж нүднээсээ ганц боловч нулимс унагахгүйг хичээн шүд зуув. Цааш өгүүлэхдээ Жамьян: “Дундах маань тээр жил... одоо бага дүү маань...улс орныхоо төлөө баатарлаг байлдаж байгаад гавьяа байгуулсан боловч нэгэнт амь бие үрэгдсэнээс хойш үлдсэн бидэнд ямар баяр баясгалан байх билээ дээ” гээд нулимсаа барьж эс чадан асгаруулж гарав.

Доодтойд суугаа минчгэр хүрэн царайтай цээжин бие нь дан хөх даалимбан тэрлэгтээ багтаж ядсан бүдүүн авгай, “Ээ тийм эвий минь, энэ хорвоо гэдэг чинь ер яасан хэцүү” гэж өгүүлэнгүүтээ говь нутгийн халуун хуурай агаарт гандан борлохынхоо зэрэгцээгээр сааль сүүндээ зөөлөрсөн гараа нүүрэндээ аваачин енгэнэв.

Нөгөөтэй нь үнсийг нь хаясан том тулганы хажууд ээжийнхээ дээлийн үлдцээр хийсэн өмднөөс өөр хувцасгүй борхон ходоодтой лантгар жаал аав ээжий хоёрынхоо уй гашуу болж байгааг гайхан нүд бүлтэлзүүлэн ширтэнэ. Түүний дээдтэй Нямаа өвгөн наян насныхаа найрыг гурван жилийн өмнө их хүүгээрээ хийлгэсэн бөгөөд амь үрэгдсэн баатар эрийн хойноос хамгийн гашуудах ёстой хүн мөн байлаа. Гэвч чих баахан хатуу, нүдний хараа муу аж. Анх муу мэдээ авчрагчийг орж ирэхэд хүү минь ороод ирэв үү гэсэн байдлаар нэг сайн харж аваад, ихэвчлэн нүд анин, уруул хөдөлгөж суудаг хэвдээ орсон байв. Тэгээд эцэст нь өвгөн эмэгтэй хүний гэнэт дуу алдан енгэнэхийг сонсоод, нүд нээн энэ тэрийг ажив.

Гэлээ ч хүү бэр хоёрын нүүрний хувиралт уйлах, инээхийн чухам алин дээр байгааг ялгаварлаж үл чадан:



УГИЙН ТАЙЛБАР

Нүд аних
Үхэх

Ам нээх
Үг хэлэх



- Ээ хүүхдүүд, та нар минь юу болов, юун тухай хөөрөлдөн инээдэм шуугиан болно вэ? гэж асуусанд цөм дуугаа хураан чимээгүй болов.

Үнэндээ өвгөн урьд өмнө уг ярианд ийнхүү хөндлөнгөөс орж байсан удаагүй билээ. Иймд эр эм хоёр, “Аав бидний яриаг дуулчхав уу? Аль зөн совингоороо тааварлаж байна уу?” гэж шивнэлцэн, юу гэж хэлэхээ олохгүй сандарцаав. Үнэндээ эл гунигт явдлыг мэдэхийг чин сэтгэлээсээ эмээнэ. Учир нь гэвэл, өвгөн хэдэн сарын өмнө тэр хүүгээ цэрэгт мордсоор даруй таван жил болов бус уу? Энд би үхэх маань өнөө маргаашгүй болсноор барахгүй хэдэн жилээр хожимдож байна. Өөрт минь амьд явах яршиг болж гүйцэв. Ганцхан хоргодох маань чи. Чамтай уулзалгүй нүд анивал сүнс минь хоргодон, зуурдын зовлон эдлэх тул арга буюу түүнээс айн амин судас нь цохилж байна. Иймд чи энэ жил заавал ир. Сэтгэлийг минь амраа. Сүнснийг минь хоргодох юмгүй болго гэж өгүүлэн захиа бичүүлж явуулсан юмсан. Үүнийг нь одоо Жамьян ам нээн дурдмагц эхнэр нь нэмэн нэмэн давтаж үүдэн хоймор суугаа даргын зүрхийг шимшрүүлэв.

Гэтэл өвгөний сэтгэлд ямар нэгэн сэжиг төрөв бололтой, гал нь барагдаж гадуураа цэнхэр хүрээ тогтсон улбар нүдээ цавчлан хүн бүрийг нарийвчлан ажиглан:

- Үгүй та нар юугаа ярилцана вэ? Юунд миний асуусныг тоохгүй байна вэ? гэж гоморхсонд Жамьян өөрийн эрхгүй босон дэргэд нь очиж чихэнд нь ам тулган:

- Аав минь, энэ жил дүү маань ирж чадахгүй гэнэ гэв. Үүнд өвгөн ихэд цочин:

- Яагаад тэр билээ? гэж өөдөөс нь ширтэв.

- Халх голын байлдаанд гарамгай байлдаж баатар болж, тушаал дэвшсэн гэнэ. Тэгээд ажил их, энэ жил ирж чадахгүй болоод энэ даргыг нааш явуулж шүү дээ гэсэнд өвгөн “Ээ” гэж бахдан инээмсэглэснээ:

- Үгүй ээ тэгээд хэзээ ирэх юм бэ? гэж царай хувиргав.

- Хойтон өдийд ирнэ гэж хэлүүлж шүү дээ гэсэнд өвгөн царай үрчийлгэн бодолхийлоод:

- Нэг жил гэдэг надад урт хугацаа. Би амьд байж чадах уу? гэж өөртөө асуулт тавиад, ингэхэд чухам өнөөдөр аль сарын хэдэн бэ? гэхэд

- Намрын дунд сарын арван таван гэж Жамьян хариулав. Энэ нь бол худлаа. Амандаа орсныг өгүүлсэн нь тэр байлаа.

- Өвгөн намрын дунд сарын арван таван гэж давтаад:

- За яах вэ, би тэсье гэх нь хажуугийн хүмүүст үхэх амьдрах хоёрыг өөрийн санааны хэрэгт боддог байх нь ээ гэсэн мэт бодогдуулав. Тэр мөртөө бас “Хүүд минь хойтон өдийд ирнэ гэснээрээ заавал ирэхийг хэлүүлье” гэлээ.

Тэр нэгэн өдрөөс эхлэн Нямаа өвгөн өдөр нэг бүрийг алдахгүй тоолох болсон бөгөөд, орж ирсэн бүхэнд: “Миний бага хүү баатар. Бас тушаал дэвшсэн, их дарга болсон. Энэ жил ажлын завдалгүй, аргагүйн эрхэнд нааш ирж чадахгүй юм гэнэ” гэж баяр бахдал болгон ярина. Их хүү бэр хоёр нь өвгөнийг аль болохоор аятай таатай байлгахыг хичээнэ. Тийнхүү ярих бүрт өрөвдөх зүрх шимширнэ. Гэлээ ч нэгэнт хуурснаа буцах нөхцөл алга. Харин ч улмаар итгүүлбэл дээр гэж үзэх тул “Ээ тийм, энэ жилдээ ирэхгүй, хойтон ирнэ” гэж өвгөний чихэнд дуулдахуйц чанга өгүүлээд дараа нь уг явдлыг нам дуугаар нэг нэггүй ярин халаглана.

Иймд тэр явдал орчны хүмүүст дорхноо тарсан учир тодорхой болов. Энэ үед хүмүүс өнгөрсөн тэр эрийн аль сайн сайхан талыг нь санан дурсахынхаа зэрэгцээгээр амьд мэндэд тооцон хүлээгч хөөрхий өвгөнийг мөн мундахгүй өрөвдөн шогширно. Гэвч юм бүхэн хуучирч хүч тэнхлээ алддаг гэдэг. Тэр ёсоор хүмүүсийн өрөвдөн шогшрох аяндаа замхарсан төдийгүй өтлөн зөнөгсдийн жишээ инээдэмт үзэгдэл болон яригдах тийш хандав.

Гэтэл өвгөн өнөөх хоосон итгэлд гүнээ автагдсан хэвээр, “Төрийн их дайнд орж баатар болох нь ер, жирийн хүний хэрэг биш шүү дээ” гэж бодох тусам сэтгэл нь сэргэх бөгөөд тэгээд хүнгүй ганцаараа байлаа ч гэсэн ам нээн ярихаас өөр аргагүй байдаг аж. Түүнийхээ дээр бас үлгэр домгийн баатруудыг үнэнхүү хэрэг дээр тодорсон түүхийн гайхамшигт хүмүүсийн явдлуудтай хутгалдуулан нэмэн нэмэн ярьж, шоолон тохуурхах маягаар хэлэлцэгчдийн яриаг улам дэврээнэ.

Эрүүл мэнд нь гэвэл бас ч доройтсон зүйлгүй. Өглөө босох нь эртсэж, шөнө унтах нь оройтсоноор барахгүй малын захад шилбүүр барин, “Хаая, хүүе” хашхиран зогсох дуртай болсон нь өвгөн санаа сэтгэл сэргэснийхээ хэрээр бие махбод нь сайжирсан байлаа.

Үүнд хүү бэр хоёр нь нэг талаар баярлаж байвч нөгөө талаар нэгэнт хууран мэхэлснээ мэдэгдчих вий гэж ямагт гэмшиж болгоомжилно. Гэлээ ч энэ ертөнцөд элэгдэн хуучирдаггүй юм даанч байдаггүй шигээ тэдний болгоомжлол ч аяндаа сулрах тийш хандав.

Ямагт ээлжлэх өдөр шөнийн урсгалыг саатуулагч хэн байдаг билээ. Хүн амьтан аль ч өөрцгүй амьдрахын хойноос ийн тийн зүтгэж байх зуур тоот сар дэс дараалан өнгөрч, ээлжит улирал аяндаа ирэх тул нэг мэдэхэд мөн л намар, намрын уур орж ирсэн байв. Энэ зуур өдөр хоногийг хэн чухам нэг нэгээр нь тоолж байна гэвэл гагцхүү үл эргэн ирэгчийг хүлээгч өвгөн! Тэрээр босох суух хоёртоо тамирдах атал айраг бүлэхэд бүх хүч тэнхлээ өгөх болж эхлэхийнхээ зэрэгцээгээр тогоотой сүү рүү өнгийн, өрөм загсаж аль хэр байгааг талын зэрэглээг ажих мэт гараа магнайдаа аваачин саравчлан ширтэнэ. Энэ бол түүний хувийн нь тооллоор намрын дунд сарын арван таван ойртсон шинж тэмдэг мөн.

Энэ үед хүү бэр хоёр нь дахин яаж аргалахаа аль хэдийн бодож амжсан байлаа. Нэг өдөр Жамьян, малын эрэлд явахыгаа өвгөнд аймгийн төв орж, дүүгийнхээ хэзээ ирэхийг сураглана гэж өгүүлэн гарав. Тэгээд эргэж ирэхдээ, “Дүү одоо холын хол сургууль хийж агаараар нисэх онгоц жолоодон сурч байгаа гэнээ” гэсэнд өвгөн “Хэ” гэж дуу алдан баярлав. Энэ нисэх онгоц жолоодох нь яавч ерийн хүний хэрэг биш гэж боддогийнхоо хувьд хүүгээ мөн ер бусын хүнд аваачин бахархсан нь тэр байлаа. Дараа нь Жамьян “Ингээд дүү маань энэ жилдээ бас ирж чадахгүй болж шүү дээ” гэсэнд өвгөн: “Пээ” гэж дуу алдан бараг муужрахад хүрч, хураасан амьсгалаа арайхийн эргүүлэн авч, “Тэгээд хэзээ ирэх нь вэ?” гэж асуухад нь Жамьян “Хойтон” гэж өгүүлэнгүүтээ, “Явуулсан захидал нь энэ” гэж сургуулийн хүүхдийн дэвтрийн тасархай гаргав. Тэгээд унших нь мөн хуурамч бөгөөд санан сэтгэх талаар хүүхэд шиг болсныг нь хэрхэн даримдуулахаа чадамгай боловсруулсан аж. Иймд өвгөн үг нэг бүр дээр инээмсэглээд, эцэст нь “Энхрий хайрт аав минь, хойтон намрын эхэн сарын нэгэнд очно. Тэр болтол энх тунх сайн сууж байхыг хичээж үз” гэсэнд өвгөн “Хэ” гэж дуу алдан баярлав. Энэ нь чухамдаа дунд сар биш эхэн сар, тэр мөртөө нэгэнд гэсэн нь тийм ч холын хугацаа биш шиг бодогдсоных байлаа.

- За яамай, тэр болтол аав чинь амьд мэнд байж чадна гэж хариу захиа явуул гэлээ. Жамьян хэдийгээр хөнгөн хийсвэр хүн биш боловч эцгээ эвтэйхнээр мэхэлж чадсанаа бусдад багахан дурсахгүй байж хараахан чадаагүй учир орчны хүмүүс өвгөнийг мөн л өрөвдөх дооглох хоёрыг хослуулан шагшиж хэлэлцэж гарлаа. Тэр дундаас намрын сайхан тарган дулааныг архи эргүүлэн өнгөрүүлэгч зарим нэгэн саваагүй этгээдийн зориуд сонжин сонирхохоор очиход өвгөн өөртөө бахдан сэтгэл хөдөлснийгээ илчлэхгүй байж үл чадна.

- Баатар хүү маань одоо нисэх онгоц жолоодохыг сурч байгаа шүү гэж хэлээд дараа нь үлгэр домогт гардаг хангарди хэмээх шувууг өнөө цагийн нисэх онгоцтой зүйрлүүлэн ярьж, улмаар элэг доог боллоо.

Өвгөн ахин нэг жилийг эсэн мэнд давлаа. Өөрийнхөө тооллоор зуны сүүл сар юу

юугүй шувтрахад эгээ л ноднингийнх шигээ айраг бүлэх ба тогоотой сүүний өрөм загсаалт руу анхаарах болов. Гэтэл түүнийг нь онцлон анхаарах хүн алга. Орчны хүмүүс элдвээр сонирхон хэлцэлдэх нь аль хэдийн өнгөрсний адил дэргэд нь халамжлагч хүү бэр хоёртоо мөн төдийлөн онцлогдохгүй болсон байлаа. Жамьян дэргэд нь эхнэртэйгээ хэрхэх тухай дүнгэр дүнгэр хэлэлцээд чихэнд нь очиж:

- Аав минь та тайван байж үз. Энэ жилдээ дүү мөн ирэхгүй байж мэднэ гэсэн өвгөн цочин:

- Яагаад гэж нүүрийг нь ширтэв. Хариуд нь Жамьян:

- Ер нь хүний үйл хэрэгт ямар нэгэн саад учрахыг хэн байг гэх вэ гээд цааш нь бас хэдэн үг хэлэх гэтэл өвгөн:

- Заавал ирнэ гэж уцаарлан буруу харав. Ингэснээрээ өвгөн Жамьянг дахин үг хэлүүлээгүй бөгөөд өөрөө ч дуугарсангүй. Сэтгэл нь хүү ирнэ, заавал ирнэ гэхийнхээ дээр ирэхгүй байж мэднэ гэж хэлсэн их хүүдээ гомдон байж ядна.

Тэр өдөртөө өвгөн нэг ч үг дуугарсангүй, ямагт санаа алдан газар ширтэв. Хүү бэр хоёр нь хэрхэх билээ гэж нэг үе тэвдсэнээ, “За яах вэ, ингэж байгаад аяндаа тайвшрах биз. Юу ч атугай одоогоор аргадахаа байя” гэж хэлэлцэв.

Тэр шөнө өвгөн огт унтаагүй ч байж мэднэ. Өглөө эрт аргагүй босож гэрийн хаяанд хөмрөн хаясан хэмхэрхий араг дээр сандайлан тэнгэрийн хаяа ширтэн суужээ. Энэ өдөр бол өөрийн тооллын намрын эхэн сарын шинийн нэгний өдөр мөн бөгөөд өнөөдөр хүү ирнэ, заавал ирнэ гэж бат итгэх аж. Бэрийнхээ үнээ малаа сааж дуусаад, “Орж цай уухгүй юу” гэснийг уцаарлан хөөв. Аягүй бол хүүгээ иртэл хэлэн дээрээ юу ч тавихгүй гэж бодсон байж мэднэ.

Бэр нь сандран гэртээ орсон боловч нөхөртэйгөө “За яах вэ, ингэж байгаад аяндаа тайвшрах биз” гэж ярилцав.

Өвгөн суусаар л байв. “Хүү ирнэ, заавал ирнэ. Хүү минь надтай хамгийн түрүүнд золгоно, хүү минь надтайгаа золгоод тэврэн авч араг дээрээс босгон гэрт оруулна” гэж бодно. Тэгээд бас гэртээ ороод их хүү бэр хоёртоо гомдсон гомдлоо нэг мөсөн гаргах гэж хэлэх үгээ бэлтгэнэ. Нар дээш хөөрч, халуун элчээрээ төөнөж эхлэхэд хүүгээ өдөр дундын үеэр ирэх нь гэж бодов. Үд өнгөрөн нар баруунаа хэлтийхэд хүүгээ орой ирнэ гэж бодов. Бодвоос ч ирэх нь өглөө, өдөр дундуур ч биш, орой л байх гарцаагүй аж.

Үдшийн бүрэнхий болов. Өвгөний тэнхэл аль хэдийн алдарсан учир тэнгэрийн хаяа ширтэхийнхээ оронд эрүү өвдөг нийлүүлэн атирсан байлаа. Гэтэл хүү бэр хоёр ингэж байгаад аяндаа тайвшрах биз гэж бодохын оронд тунирхаж байна гэж үзээд, хоорондоо “Аргадахгүй байх юм шүү” гэж хэлэлцэн гэдийх аж.

Шөнө тээр орой өвгөн гэртээ орон, харанхуй дундуур тэмтчин байж орондоо орон хэвтэв. Хүү минь ирнэ, заавал ирнэ гэдэг итгэл нь хэвээр, чихний сонор муугаа мартан, чагнан хэвтэж байхад нөгөөтэй нь хүү бэр хоёр сэтгэл тавин “Аав үнэхээр зөнөжээ. Зөнөх зөнөхдөө бүр буруугаар шүү. Ийм болсон хүнийг чинь одоо чухам яавал таарах байна даа байз” гэж хэлэлцсээр нам гүм унтав.

Гэнэт өвгөний чихэнд хүнгэнэх их авиа сонсогдсонд хүү минь ирэв гэж яаран босон харайв. Энэ бол зүүд. Өдрийн энгээр хоол ундгүй суусандаа хийрхэж, чих нь дүнгэнэснийх тэр. Зүүд цааш үргэлжлэхдээ, өвгөний гэрээс гарахад шөнө биш өдөр байх бөгөөд эрээн тарлан үүлэн дундуур аварга том шувуу шунгинан бууж ирснийг өвгөн нисэх онгоц мөн гэж бодов. Тэгээд тэр шувуун онгоцноос хүүгээ бууж ирэхийг ажихад төрх байдал хэвээр байвч өнгө зүс маш тунгалаг, өмссөн хувцаснаас нь хүртэл гилбэгээн өнгө гялалзана. Үүнд өвгөний баярласан нь маш их, хүн болсоор тийн баярлаж үзсэнгүй бөгөөд ингээд зүүд ч дуусав. Амьсгаа нь хураагдсан аж.

1962 он. Монголын сонгомол өгүүллэг. УБ., 2005, 29-33 дахь тал

ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ

Д.Намдагийн “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгт Халх голын дайнд гэр бүлийн гишүүнээ алдсан нэгэн гэр бүлийнхнийг үзүүлэхдээ хэзээ ч үл ирэх хүүгээ өдөр хоногийг тоолон хүлээх өвгөн эцгийн дүрийг бүтээсэн байна. Зохиолч дүрийг хэрхэн бүтээж, амилуулж байгааг задлан шинжилцгээе.

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Дүр:

- Зохиолын өгүүллэгдэхүүний гол зангилааг тээж явдаг төлөөлөл хүнийг дүр гэнэ. Уншигчийн зүгээс дүрийг ёс суртахуун, зан төрхийн шинж болоод шийдвэр гаргах оролцоогоор нь гол дүр, сөрөг дүр, туслах дүр гэж ялгадаг.

ЗӨВЛӨМЖ

- Зохиолч дүрээ амьдруулахын тулд янз бүрийн аргыг хэрэглэдэг. Өгүүллэгийг уншиж, дараах асуултад хариулснаар та үүнийг олж мэдэх болно.
- Дүрүүд юу хийж байна вэ?
- Дүрүүд юу бодож, мэдэрч байна вэ?
- Дүрүүд юу ярьж хэлж байна вэ?
- Бусад дүр түүний талаар юу гэж ярьж байна вэ?

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Өгүүллэгт ямар ямар дүр гарч байна вэ? Холбоо хамаарлыг зураглан үзүүлж, тайлбарлана уу.

Дүрүүд	Холбоо хамаарал
Нямаа өвгөн	
Жамьян	Нямаа өвгөний том хүү, гэрийн эзэн
.....	
.....	

2. Зохиолч дүрүүдээ хэрхэн хөрөглөн дүрсэлснийг ажигла. Зохиолч уран дүрслэлийн ямар хэрэглүүрийг ашигласан байна вэ? Зохиолоос эшлэл авч, тайлбарлаарай.

Дүрүүд	Эшлэл	Тайлбар
Жамьян		
Жамьяны эхнэр		
Жаал		
Нямаа өвгөн		
Цэргийн дарга		

3. Нямаа өвгөний хийж байгаа үйлдлийг ажигла. Нямаа өвгөний үйлдлийг үзүүлэхдээ зохиолчийн сонгосон үгсийн уншигчид хүрэх нөлөөллийг тайлбарла.

Эшлэл	Уншигчид үзүүлэх нөлөө

4. Нямаа өвгөний хэлж байгаа үгс, бодож байгаа бодлыг ажигла. Нямаа өвгөний хэл яриаг үзүүлэхдээ зохиолчийн сонгосон үгсийн уншигчид хүрэх нөлөөллийг тайлбарла.
5. Нямаа өвгөний хүсэл зорилго юу вэ? Түүний хүсэлд хэн, юу саад болж, хэрхэн зөрчилдөж байна вэ? Д.Нямаа өвгөний дүрийг бүтээсэн зохиолчийн зорилгыг тайлбарла.



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

- *Зохиолын гол дүр нь үзэл бодол, үйл хэрэг, эрхэм нандин чанараараа дагуулж, асуудлын шийдлийг гаргаж буй давуу хүчин юм. Эсрэг дүр гэдэг нь гол дүртэй бүхий л талаараа зөрчилдөж буй хүн буюу сөрөг хүч юм. Харин туслах дүр нь гол дүрийн үзэл бодол, үйл хэргийг дэмжин оролцож байдаг.*

ЗӨВЛӨМЖ

- *Та дүрийн өмнөөс үзэл бодол, мэдрэмжээ илэрхийлэн бичихдээ “би” гэсэн төлөөний үгийг хэрэглэнэ.*
- *Та шинэ дүр, хэрэг явдлыг оруулж болохгүй.*

6. Нямаа өвгөний хүүгээ хүлээх хүлээлт, итгэл найдвараас та юуг ойлгож ухаарсан бэ? Таныг энэхүү ухааралд хөтлөхөд нөлөөлж байгаа гол үг хэллэг, бичил дүрслэлийг зохиолоос эшлэн авч тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар

7. Нямаа өвгөний талаар хүмүүс хэрхэн бодож, бас хэлж байна вэ?
8. Жамьян болоод түүний эхнэрийн хэлж байгаа, бодож байгаа үг өгүүлбэрийг ялгаж бичээд, тэдний талаар төрсөн анхны сэтгэгдлээ гурван өгүүлбэрээр илэрхийлэн бич. Өөрийн үзэл бодлыг дэмжихдээ өгүүллэгээс эшлэл авч нотлоорой.
9. Дараах асуултад төвлөрөн, үзэл бодлоо илэрхийлж бичнэ үү. Хүү бэр хоёр нь яагаад Нямаа өвгөнөөс үнэнийг нуусан бэ? Үнэнийг нуух нь асуудлыг шийдвэрлэх арга мөн үү? Эсвэл энэ нь тухайн нөхцөлд аавынхаа сэтгэл санааг амар байлгах гэсэн энэрэнгүй арга гэж ойлгох нь зөв үү?
10. Зохиолын төгсгөлд буй хүү бэр хоёрын яриаг дахин унш. Тэдний ярьж хэлж буй байдал болоод дуу хоолойны өнгийг төсөөл. Тэдний талаарх сэтгэгдлээ илэрхийлэн бичнэ үү. Өмнө тодруулсан хэсгээсээ нотлох эшлэлийг авч хэрэглээрэй. Эшлэл авахдаа хашилт тэмдгийг хэрэглээрэй. Жишээ нь: “Аав үнэхээр зөнөжээ. Зөнөх зөнөхдөө бүр буруугаар шүү. Ийм болсон хүнийг чинь одоо чухам яавал таарах байна даа байз” гэж хэлэлцсээр нам гүм унтав.
11. Та “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгийн Нямаа өвгөний оронд байсан бол яах байсан бэ? Та дүрийн өмнөөс үзэл бодол, мэдрэмжээ илэрхийлэн бичээрэй.

12. Энэ өгүүллэгт үзүүлсэн шиг явдал бодит амьдрал дээр тохиолдох боломжтой юу?
13. Уг өгүүллэг нь өндөр настай хүнд тохиолдож болох эрсдэлийг хэрхэн дамжуулж байна вэ? Хүү бэр хоёр нь өвгөнд хий горьдлого төрүүлж, жилийн жилд хүү нь ирнэ хэмээн худал хэлж байгаа нь зөв буруу эсэх талаар асуудал дэвшүүлэн мэтгэлцэж, өөрийн үзэл бодлоо илэрхийлээрэй. Эх зохиолоос эшлэл авч, хариултаа дэмжээрэй.

ЗОХИОЛЫН ОРЧИН, НӨХЦӨЛ НЬ ДҮРИЙГ ТОДРУУЛАХАД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БУЙГ ТАЙЛБАРЛАХ

Хэзээ ч үл ирэх хүүтэйгээ уулзахыг хүсэн, өдөр хоногийг тоолон хүлээх өндөр настай өвгөн эцгийн дүрийг тодруулахын тулд зохиолч орон цаг, эрхлэх аж ахуй, соёлын орчинг хэрхэн тохируулж, уур амьсгал бүрдүүлснийг судалцааю.

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Орчин:

- Орчин гэж зохиолд гарч буй цаг ба орныг хэлнэ. Орчин нь дүрийг тодруулахад чухал үүрэгтэй. Дүрийн тухай мэдээллийг орчны дүрслэлээр дамжуулж өгөхөөс гадна хүрээлэн буй орчин, нөхцөл байдал гол зөрчлийг тодруулах нь бий.

ЗӨВЛӨМЖ

- Орныг судлахдаа зохиолд үзүүлсэн орон нь бодит тодорхой газар орон байна уу, аль эсвэл ерөнхий нэгэн орон байна уу, зохиолч орныг дүрслэхийн тулд ямар түлхүүр үгс болоод дүрслэлийг ашигласан байна вэ гэдгийг нарийн анхаарч судлаарай.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Зохиолд үзүүлж буй цаг нь бодит тодорхой түүхэн цаг байна уу? Аль эсвэл ерөнхий эрт нэгэн цаг байна уу?
2. Үзүүлсэн орон нь бодит тодорхой газар орон байна уу? Аль эсвэл ерөнхий нэгэн орон байна уу?
3. 1939 он Монгол Улсын түүхэнд болсон ямар хэрэг явдлыг сануулж байна вэ? Зохиолч энэ орон цагийг сонгон авсан учир зорилго нь юу вэ? Эдгээр нь зохиолын дүрийг бүтээхэд хэр нөлөөтэй байна вэ?

	Эшлэл	Тайлбар
Орон		
Цаг		

4. Зохиолч орныг дүрслэхийн тулд ямар түлхүүр үгс болоод дүрслэлийг ашигласан байна вэ?
5. Дүрүүд нь орчинтойгоо хэрхэн харилцаж байна вэ?
6. Зохиолч дүрүүдээ орчинтой нь хэрхэн холбон үзүүлсэн бэ? Жамьяны гэрийн доторх орчныг зохиолч нарийн дүрслэн үзүүлэхийн гол зорилго юу вэ?

Эшлэл	Тайлбар
Гэрийн баруун хоймор ...	
Доодтойд нь суугаа ...	
Нөгөөтэй нь үнсийг нь хаясан тулганы хажууд ...	
Түүний дээдтэй ...	

7. Уг өгүүллэгт цаг улирлыг хэрхэн тусган үзүүлсэн байна вэ? Зохиолч намрын улирлын шинж тэмдгийг эрхлэх аж ахуйтай холбон хэрхэн гаргасныг хүснэгтэд жагсаан бичээд зорилгыг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар

8. Зохиолч Нямаа өвгөний дүрийг бүтээхдээ ямар нөхцөл байдлын дунд үзүүлсэн бэ? Түүний хүсэл зорилготой эсрэгцэж, түүнд саад болж буй ямар хүчин зүйлс байна вэ?

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

ЗӨВЛӨМЖ

► Цагийг судлахдаа зохиолд үзүүлж буй цаг нь бодит тодорхой түүхэн цаг байна уу, аль эсвэл ерөнхий эрт нэгэн цаг байна уу гэдгийг анхаарч, цаашилбал, цаг нь дүр бүтээхэд хэрхэн харилцан нөлөөлж байгааг судална. Зохиолд дүрслэгдэж буй цаг, одоогийн таны амьдарч буй цаг хоёрын хооронд хэр хол хугацаа байгааг харьцуулаарай.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Нөхцөл байдлыг хурцатган үзүүлэхийн тулд зохиолч бичил дүрслэлийг хэрхэн ашигласан бэ? Зохиолоос эшлэн тайлбарлана уу

Эшлэл	Тайлбар
"... уйлах инээхийн алин дээр байгааг ялгаварлаж үл чадан ..."	

2. Зохиолд Нямаа өвгөнийг чих хатуу, хараа муу гэж үзүүлсэн ч тогоотой сүүний өрөм загсахыг ажиглан шинжих өвгөний үйлдлээр зохиолч бидэнд юуг таниулж байна вэ?
3. Нямаа өвгөний сэтгэл санаа ямар байна вэ? Зохиолч Нямаа өвгөний сэтгэл санааны байдлыг бидэнд дамжуулахдаа үхлийн тухай ямар ямар үг хэллэгийг хэрхэн илэрхийлснийг түүж бичээд, үхлийн талаарх монгол хүний үзэл төсөөллийг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
"зуурдын зовлон эдлэх"	
"сүнс минь хоргодох"	

4. Зохиолд эхлэхэд Нямаа өвгөний сэтгэл санааны байдал харьцангуй тайван байгаагаар үзүүлж байсан бол зохиолын өгүүлэгдэхүүний аль үеэс зохиолч дахин хойшлуулшгүй шахааж шаардсан нөхцөл байдлыг бүтээсэн бэ?
5. Төгсгөлийн мөрүүдийг дахин унш. Нямаа өвгөний сэтгэл санааны байдал болоод хүмүүсийн харилцаа хандлагыг та хэрхэн тодорхойлох вэ? Хариултаа дэмжихийн тулд эшлэл аваарай.
6. Нямаа өвгөний хоосон горьдлого, хүлээлт болоод үхлээс ирж буй уур амьсгалыг дамжуулахдаа зохиолч ямар арга замыг сонгосон бэ? Өөрийн үзэл бодлыг дэмжихийн тулд эшлэл авч, тайлбарла.
7. Зохиолч Нямаа өвгөний амьдралын сүүлчийн өдрийн сэтгэл санааны байдлыг бидэнд дамжуулахдаа нарны цагийг хэрхэн сонгон хэрэглэсэн байна вэ? Холбогдох үг хэллэгийг түүж бичээд, утгыг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
нар хөөрч	
үд өнгөрөн	

ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН БҮТЭЦ БА ҮЙЛ ЯВДЛЫН ДАРААЛЛЫГ ХҮҮРНЭЛИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ТАЙЛБАРЛАХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Хүүрнэн өгүүлэгч:

- *Хүүрнэн өгүүлэгч гэдэг бол өгүүллэг, тууж дахь түүхийг ярьж буй хүн юм. Гуравдугаар биеийн хүүрнэн өгүүлэгч нь бүхий л дүрүүдийн хэлж, бодож, хийж байгаа бүхнийг мэдэн дамжуулж байдаг.*

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Зохиолд ямар хэрэг явдлыг өгүүлж байна вэ? Зохиолын хэрэг явдал хэрхэн эхэлж, хэрхэн өрнөөд, хэрхэн төгссөн бэ? Тоймлон ярина уу.
 2. Хүүхдүүд бичвэр дээр хос хосоор ажиллан, өгүүлэгдэхүүний задлал хийж, зохиолоос зангилаа болон туйл хэсгийг олж тодруулна уу.
 3. Өгүүллэгт хүүрнэн өгүүлэгч нь хэн байна вэ? Тэр хэддүгээр биеэс өгүүлж байна вэ?
 4. Нямаа өвгөнд бусад хүн хэрхэн хандаж байгааг харуулсан хүүрнэн өгүүлэгчийн үгийг зохиолоос сонгон тэмдэглэнэ үү.
 5. Та “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгийн Нямаа өвгөний дуу хоолойг сонсож, мэдэрч байна уу? Чингэхдээ тухайн дүрээр дамжуулж, зохиолчийн хэлэхийг хүссэн үг, дуу хоолойг батлахыг хичээгээрэй.
6. Дээрх дасгалыг хариулж дууссаны дараа жижиг бүлгээр ажиллаж, сурагч бүр өөрсдийн хариултаа уншиж, дүрийн дуу хоолойг илэрхийлээрэй. Бусад нь энэ хариулт хэр амжилттай болсон талаар дүгнэж, санал бодлоо солилцоорой.
 7. Зохиолч зохиолдоо өгүүлэгчийн хүүрнэлээс гадна бусад зохиомжийн нэгжийг хэрхэн ашигласныг ажигла. Өгүүллэгт захидал ямар үүргээр орсон байна вэ? Аавын хүүдээ бичүүлсэн захидлыг зохиолоос сийрүүлэн бичээд, захидлаар дамжуулан өгч буй мэдээллийн цаг хугацааг ажигла.
 8. Өгүүллэгт зүүд ямар үүргээр орсон байна вэ? Уг зүүдний бүтэц болоод хэлний хэрэглээг шинжилж, нэг цогцолбор бич. Энэхүү зүүд нь зохиолын санааг төгсгөхөд хэрхэн тусалж байгааг тайлбарла.
 9. Асуултад хариулахдаа зохиолын хам сэдэв хийгээд зохиолчийн амьдарч байсан нийгэм цаг үеийг судалж, дэмжих нотолгоог авч бичээрэй.
 10. Бусад уншсан зохиол, үзсэн жүжиг, кинонд хоёр өөр цаг хугацааг хэрхэн үзүүлдэг талаар ярилцана уу.

Өмнө уншсан Д.Намдагийн “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгийн хэрэг явдал 1939 оны намар Монголын говь нутгийн нэгэн малчин айлын гэрт болж өнгөрдөг бол Ж.Барамсайн “Цүнхтэй инээд” хошин өгүүллэгийн хэрэг явдал дунд сургуулийн орчинд өрнөн, өсвөр насны хүүхдийн дуу хоолойг дамжуулдаг.

УНШИХЫН ӨМНӨ

- ▶ Хүүхдүүд ээ, та нар ирээдүйд ямар мэргэжилтэй болохыг хүсэж байна вэ? Энэ мэргэжлийг сонгоход танд ямар зүйл нөлөөлсөн бэ? Магадгүй, уншсан зохиол, үзсэн кино, хайртай жүжигчин, дуучин чинь нөлөөлсөн байж болно. Энэ тухайгаа ангийн нөхөдтэйгөө хуваалцана уу..
- ▶ Дараах өгүүллэгт нэгэн бяцхан хүүгийн мэргэжлээ сонгосон тухай, түүнд тохиолдсон зарим нэг бэрхшээлийн тухай өгүүлнэ.

ЦҮНХТЭЙ ИНЭЭД (Өгүүллэг)



Жаргалын Барамсай
/1950-1996/

1950 онд Архангай аймгийн Их тамир суманд төржээ. 1970 оноос уран бүтээлээ эхэлж, “Хэцүү урилга”, “Хөшиг нээвэл нууц задарна”, “Санал гомдлын дэвтэр”, “Цүнхтэй инээд”, “Биегүй сүүдэр” зэрэг ном хэвлүүлсэн байна.

Инээдмийн өдөр 4 сарын 1-нд манай ангийнхан шог зураач Цайдам гуайтай уулзалт зохиож элгээ хөштөл инээлээ. Тэр өөрийн зурсан зургуудыг үзүүлээ. Түүний “Муур зуучихсан тарган хулгана”, “Эмээдээ тусалж байгаа нь энэ” гээд эрх ач хүү нь шээзгий дотор нь ороод зогсчихсон мөртөө бас шээзгий үүрч, эмээ нь тэр лүү нь аргал хийж байгаа, бас морьдоо атаршуулж алдчихаад араас нь хонь унаад явж байгаа уурга чирсэн хүний тухай олон зурагнууд үзэж бахаа ханатал инээж авлаа. Тэр зураач самбар дээр янз бүрийн шог зураг зурж биднээр таалгаж, тайлбар хэлүүлсэн билээ. Түүнээс гадна тэр “Шог зураг бол муу муухай, шударга бус үйлийг шүүмжилж доог тохуу болгодог төдийгүй бүр дайны эсрэг тэмцэлд ч хурц зэвсэг болдог тухай зөндөө ярьсан юм. Дайны эсрэг хурц зэвсэг шүү! Энэ үг л намайг бөөн бодолд унагаж, хөл бөмбөг тоглох, бөглөөдөх хоёроос болиулсан юм. Би буудаж чадахгүй, танк барьж, онгоц жолоодож ямар чадах биш. Чадлаа ч гэсэн дээ, аюултай юм чинь. Харин дайсны эсрэг шог зураг зураад л ангидаа сууж байна биз!? Гэхдээ дайсны эсрэг яаж зурдаг юм бол!? Дайснууд тэр шог зургаас нь айдаг байх шүү?

- Нэг өдөр манай бүлэг “Чи ямар мэргэжилтэй болох вэ?” гэсэн бүлгийн ажил зохиолоо. Манай ангийнхан цөм л эмч, багш, инженер, дарга, телевизорын засварчин, бөхийн засуул, онгоцны жолооч, жүжигчин гээд бүх л мэргэжлийн хүн болох юм байх аа!? Харин намайг босгоод асуухаар нь

- Би шог зураач болно гэтэл хүүхдүүд нирхийтэл инээлдэв.

- Яагаад тэр билээ? Шог зураач гэдэг мэргэжил биш юм болов уу? Миний нүүр чинэрч, ичсэндээ чихээ хүртэл улайсан байх.

- Оо яа яа! Шог зураач гэнэ шүү!? Гараад өгчээ... Ха ха ха гэж Бордох доогтойёо хөхрөв. Бүлгийн ахлагч Наранцэцэг эгч тэдний шуугианыг намжаагаад:

- Та нар юунд Хонгорыгоо шоолоо вэ? Шог зураач гэдэг чинь сайхан мэргэжил шүү дээ. Магадгүй Хонгорын цүнхэн дотор бидний дутагдлыг шоглосон инээдтэй зурагнууд байгаа ч юм бил үү? гэсэн юм.

Үүнээс хойш манай ангийнхан намайг “Шог зураач, цүнхэн доторх инээднээсээ гаргаач” гэж зовоодог боллоо. Тэгэх тусам нь би заавал шог зураач болно доо гэж боддог байлаа...

Тун гайхалтай. Маргааш нь 2-р цагийн хичээл дээр анхны шог зургаа зурлаа. Үүнийг зурах болсон нь учиртай. Бордох Алимааг тоогоо хуулуулсангүй гээд гар руу нь үзгээрээ хатгаж уйлуулснаас болсон хэрэг. Би том үзэг барьсан урт гар, тууз зангидсан охины толгой руу хатгаж байгаагаар зураад,

Охины толгой руу хатгадаг

Онгиороо Бордох энэ байна

Хүүхдийн тархи руу чичдэг

Хөөрүү Бордох энэ мөн

гэж бичээд хажуугийнхаа ширээний Баяраад үзүүлтэл завсарлагааны хонх дуугарлаа. Багшийг гарангуут Баяраа огло харайн,

- Хараач ээ, хүүхдүүд ээ! Манай шог зураач, Бордохыг ингэж матарласан байна гээд самбарын өмнө гарч дэвтрийг үзүүлэв. Манай ангийнхан тэр дороо л шавчихлаа.

- Онгиороо Бордох яг байна,

Хөөрүү Бордох дүрээрээ байна...

гэж шуугицгаав. Бордох Баяраагийн гараас зургийг булааж нэг базаж шидчихээд, над дээр үсрэн ирж, “Чи муу намайг ингэж доромжлоод байхдаа яадаг юм бэ?” гэж уурласнаа “Ёо” гэтэл эгэм рүү дэлслээ. Ингэж би анх шог зураг хүний уур хүргэдгийг мэдлээ. Хонх дуугарч, дараагийн хичээл орлоо. Бордох намайг гар зангидан занаж байхад Алимаа над руу эрхийгээ гозойлгон инээмсэглэж байлаа.

Дараагийн шог зураг маань их түүхтэй. Би түүнийг оройнхоо хоолыг идсэний дараа зурсан хэрэг. Ээж аав хоёрыг салхинд гарсан хойгуур 10-р ангид сурдаг миний ах нуугаад тамхи татаж гарлаа. Би түүнийг нь мэдчихээд, “Дээл толгой дээгүүрээ нөмөрсөн мөртөө ганцхан тамхи цухуйж, утаа нь энэ тэрүүгээр савсаж байгаа зураг зурлаа. Тэгээд дор нь “Энэ дээлэн доор манай ах Элбэг хичээлээ давтаж байгаа юм” гэж бичээд яг дуустал мөрөн дээгүүр ахын гар орж ирээд шүүрээд авлаа.

- Аа мөн! Чи хичээлээ давтахгүй бас ийм балай юм зурж байдаг вий гээд миний чихийг халуу оргитол мушгив. Тэр миний зургийг хумьж авахад нь би,

- Зураг өгөхгүй бол аавд хэлнэ дээ, тамхи татсаныг чинь гэвэл ах,

- Хэл л дээ. Чамайг тэгвэл загасанд дагуулж хамт явна байгаа гэх нь тэр. Загасанд явах ч гоё шүү. Ялангуяа хээр усны зах дээр шөнө гал түлж суух бүр сайхан... Гэхдээ өөрөө зурсан хайран зургаа алдах гэдэг даанч дэмий санагдав. Бид хоёрыг маргаж байтал аав ээж хоёр орж ирлээ. Ах таг дуугүй болов. Аав миний зурсан зургийг авч үзэх хооронд ах гараад явчихлаа.

- Хараач Дарьсүрэн! Хүү чинь ахыгаа шоглоод зурчхаж. Манай Элбэг тамхи татаад байгаа юм байна шүү?! Би бас хар аваад байсан юм аа гэж ээжийг дуудлаа. Ээж ирж үзээд,

- Болж миний хүү! Цаад ахыгаа бүр сайн шоглож зураарай гэсэн юм. Анх би шог зураг хүнийг баярлуулдгийг ингэж мэдсэн юм.

Би урам ороод зав л гарвал шог зураг зурж байдаг болов. Нэг удаа ...завсарлагаанаар цонхоор харж байтал хоёр гуравдугаар ангийн л бололтой хоёр жаал сургуулийн хашааны гадна жижигхэн тугал ноолоод, нэг нь мордчихсон, нөгөөх нь сүүлнээс нь чаргуулдсан харагдлаа. Би түүнийг санаандгүй зурмаар санагдав. Тэгээд багшийн орхисон шохойг аваад самбар дээр зурж байлаа. Цүнх үүрсэн жаал тугал унаад нэг нь сүүлнээс нь нөгөөх нь эврээс нь чаргуулдсанаар зурж байтал багш ороод ирж. Би мэдсэнгүй. Ангийн багш намайг, “Чи хэнийг доромжилж байна? Завсарлагаанаар ч зүгээр байж чадахгүй, яасан гар нь өтсөн амьтан бэ? Энэ үхэр чинь хэн юм бэ?” гэлээ. Би “үхэр биш гадаа байгаа тугал” гэвэл багш, “Чи наашаа хүрээд ир!” гээд дагуулаад гарлаа. Би багш нарын конторт орлоо. Олон багш сууж байна.

Ангийн багш “Чи энэ янз бүрийн юм зурдгаа болих уу, үгүй юү? Гадаах төмөр хаалган дээр хэн нохой зурсан бэ? Чи биз?” гэж асуув. Би “Үгүй, би биш” гэж үнэнээ хэлэв. Гэтэл зургийн багш хажуунаас “Хн! Энэ Хонгор бид хоёрын юм зурах ч гайгүй хэвтэнэ ээ. Саяны улирлаар миний хичээл дээр дөнгөн данган гурав гарсан юм чинь” гэвэл манай багш “Энэ, муу юманд их адтай хүн байгаа юм, дахиад чи тэгж хүн доромжлоод үзээрэй. Хөдөлмөр хүмүүжлийн сургуульд явуулах юм шүү” гэв. Юу гэнээ? Муу юманд адтай гэв үү? Цайдам ах шог зургийг муу муухай шударга бус зүйлийг доог тохуу болгож олон түмэнд жигшүүлдэг гэсэн биш билүү? Ийнхүү бодож байтал багш “Чи явж ангийн дарга дээрээ оч. Ханын сонины толгой зурж өг” гээд намайг гаргалаа. Үнэндээ би зүгээр зурагт тааруу л даа. Ямар сайн даа л зургийн хичээл дээр “Баяр болж байгааг зур” гэхэд нь чүү чамай дунд авах вэ дээ. Хүүхдүүд цөм улаан туг, өнгө өнгийн цэцэг зурж байшин барилга дээр чимэглэл хийснийг дүрсэлсэн байхад би хэдэн согтуу хүн зурсан хэрэг. Баяр болохоор архи уусан хүн зөндөө олон болчихдог юм чинь. Би баяраар нэг ч хүн битгий архи уугаасай л гэж бодож зурсан юм шүү дээ. Ханын сонины толгой гаргая гэвэл ч гаргана л даа. Даанч би сонирхдоггүй юм.



Багш аа! Аав минь гадаад явах гэж байгаа тул миний зургийн хичээлийн даалгаврыг бүтэн нэг сараар өгнө үү.



Баясгалан өөрөө дунд сурдаг мөртөө хаалган дээрээ “Онц сурлагатан” гэж бичив.



?

Дөрөвдүгээр ангиа төгсгөхөд би зуун шог зурагтай боллоо. Ёстой ганц ч хүнд үзүүлээгүй дээ. Аягүй бол нэг нь “Чи хэнийг доромжлоов, намайг уу?” гээд булааж аваад ураад хаячихна. Би тэднийгээ гэртээ ч орхидоггүй. Цүнхэндээ хийгээд явж байх цаанаа л нэг сайхан. Зуны амралтаараа шог зураач Цайдам ахыг олж уулзаж танилцаад цүнхээ уудалж зурагнуудаа үзүүлнэ. Тэр ах миний зургуудыг лав урахгүй. Харин би та нарт хэдхэн зураг зүгээр сонирхуулах уу? Хар даа?

Өө, би хөөрөөд та нарт зөндөө зураг үзүүлчихлээ. Надад дайснуудыг шоглосон зураг бий л дээ. Гэхдээ жинхэнэ шог зураач ахад үзүүлнэ. Одоо бол шог зураач болоогүй байгаа шүү дээ. Харин дайснууд айгаад дайн гаргана гэж ярьдгаа больтол шог зураг зурдаг жинхэнэ Шог зураач болохдоо нэг болно доо.

1985 он

УНШСАН ЗОХИОЛЫН СЭДЭВ, ГОЛ САНАА, ДҮРЭЭС ТӨРСӨН МЭДРЭМЖ СЭТГЭГДЛЭЭ БИЧ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Хошин шог зохиол:

- Нийгмийн ахуй ба хүмүүсийн амьдрал зан харилцаанд байгаа гэм хор, доголдол дутагдлыг инээдэмтэй, шог аясаар шүүмжлэн үзүүлсэн зохиолыг хошин шог зохиол гэнэ.

ЗӨВЛӨМЖ

- Сэтгэгдэл мэдрэмжийн хариултад эшлэл зүүлт оруулахгүй. Учир нь, энэ нь таны илэрхийлэх гэж байгаа дуу хоолойны урсгалд төвөг учруулна. Сэтгэгдэл мэдрэмжийн хариултын бичвэрт дэмжлэг болж орох зүйлс нь тухайн дүрийн түгээмэл хэрэглэдэг үг хэллэг юм уу зохиолоос авсан мэдээлэл байж болно.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Сургуулийн орчны талаарх таны төсөөлөл ямар байна вэ? Сэтгэгдлээ илэрхийлэн нэгэн цогцолбор бич. Хариултаа дэмжихийн тулд дүрслэл ашигла.
2. Хонгорын дүрийг зохиолч хэрхэн үзүүлсэн бэ?
3. Бордох, Алимаа нарын дүрийг хэрхэн үзүүлсэн бэ?
4. Хонгорын гэр бүлийн орчинд түүнийг хэрхэн ойлгож байсан талаар шинжлэн хоёр цогцолбор бичээрэй.
5. Багш нарын дүрийг хэрхэн үзүүлсэн бэ? Зохиолын төгсгөлийг таамаглахад хэрхэн тусалж байна вэ? Хонгорын хэлсэн үг, бодсон бодлыг авч үзээрэй.
6. Хонгор хүүгийн хүсэл зорилгод саад болж буй ямар хүчин зүйлс байна вэ? Зохиолын бичвэрээс мэдээллийг цуглуулан, нэгтгэн дүгнэнэ үү.
7. Хонгорын зурсан зургуудыг сонирхоорой. Сэтгэлд нийцсэн нэгэн зургийг сонгож, зургийн дүрслэлийг үгээр илэрхийлэн бичихдээ өгүүллэгийн эхэнд Цайдам гуайн зургуудыг Хонгор бидэнд хэрхэн дүрслэн өгүүлж байсныг эргэж санан, түүнээс суралцаарай.
8. Өгүүллэг хэрхэн төгссөн бэ? Хонгор хүү өөрийн зорилгодоо үнэнч үлдэж чадсан уу? Энэ өгүүллэг хэний дуу хоолойг илэрхийлж байна вэ? Дуу хоолойг илтгэх түлхүүр үг хэллэгийг эшлэн, уншигчид хүрэх нөлөөг тайлбарлаарай. Өгүүллэгийн дүр дүрслэлээс эш татан нэг цогцолбор бичнэ үү.
9. Зохиолын дүрийн талаар төрсөн сэтгэгдлээ илэрхийлэн бичнэ үү.
10. Хонгорын оронд та байсан бол яах вэ? Таны сонголтыг бусад үл хүндэтгэх үед та хэрхэх байсан бэ? Дүрийн өмнөөс сэтгэдэл мэдрэмжээ илэрхийлэн бичнэ үү.

3.2. ТУУЖ



ЗУРГААС ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

- ▶ Туужийн нэр болон номын чимэг зураг нь зохиолын хэрэг явдал хийгээд дүрийн талаар бидэнд юуг мэдээлж байна вэ?
- ▶ Зохиолд ямар дүрүүд гарч, ямар хэрэг явдал өрнөж болохыг урьдчилан таамаглаж уншаарай.



Пэрнлэйн Лувсанцэрэн
/1933-1972/

Баянхонгор аймгийн Баянбулаг суманд төржээ. 1962 оноос уран бүтээлээ эхэлж, “Нар шингээгүй”, “Усны эргүүлэг буюу Борзооны явдал”, “Оддын дор”, “Хаврын шувуу” ном хэвлүүлжээ.



ҮГИЙН ТАЙЛБАР

Хошлон

Хоёроор зэрэгцүүлэн оёсон
эрчтэй дээс

Шургааг

Огтолж бэлтгэсэн уулын
нарийн мод

Дун

Сээр нуруугүй амьтны
бие хамгаалах хатуу бүрхүүл
гэрийг засч хийсэн үлээх
хөгжмийн зэмсэг

УСНЫ ЭРГҮҮЛЭГ БУЮУ БОРЗООНЫ ЯВДАЛ (Тууж)

Хэсэглэл 1

Үүсгэл бүлэг

1944 он миний санаанд гүн шингэжээ.

Сүүлийн хичээл дуусаж завсарлагааны хонх дуугарав.

Хичээл тармагц гадуур байрны хүүхдүүд гэр гэр лүүгээ явцгаана. Дотуур байрныхан ялгарч үлдээд, хичээл хийдэг намхан цагаан байшингийн ойролцоох их элсэн дээр цуглан тоглоцгооно.

Барилдана. Хөөцөлдөнө. Цүнхтэй номоороо бие биесийг цохиж үймэн хашхиралдана.

Хичээл тарсны дараах энэ шуугианд би эхлээд их дурлаж, хэнээс ч дутуугүй ноцолдож үймүүлдэг байснаа хожим нь яагаад ч юм, нэг л залхуутай санагдаж, зүгээр халуун элсэн дээр суух дуртай болов. Хичээл хийдэг байшингаас гарч ирээд, гутлаа тайлан хөл дээрээ халуун элс овоолж, наранд суух тун сайхан.

Энэ өдөр яльгүй салхитай ч тэнгэр цэлмэг, нарны илч хурц хэвээрээ, магнай халаан төөнөсөөр байлаа.

- Урьд шөнө манай гэрийн хошлонг хутгаар тас огтолчихсон байна билээ гэж миний хажууд суусан Нямжав гэдэг эмэгтэй хүүхэд ярив.

- Гэрийн хошлон огтолж байна гэнээ? гэж би лавлан асуугаад, Нямжавын царай өөд харахад, тэр их л уйдсан янзтай хажуугаараа хоёр гардаж элс атгаад, хөл рүүгээ ус шиг урсгаж суув.

Нямжав шиг ийм жаахан хүүхэд ийм лут уйтгартай царай гаргаж суухыг ерөөсөө үзсэнгүй тул их л шохоорхож,

- Чи их айгаа юу гэж би асуув.
- Айлгүй яахав.
- Юунаас нь айх юм бэ?

- Шөнө гэрээс гартал хутга барьчихсан хүн зогсож байвал...!
- Чи их зориггүй юм. Би бол тэр муу Борзооныг чинь дор нь нам цохино гэж би хэлэв. Яагаад ийм үг хэлснээ би одоо болтол мэддэггүй. Намайг бүүр бага байхад манай нутагт Борзоон гэж нэг хүн байсан. Түүний нэр гэнэт санаанд ороод би ингэж хэлчхэв.

Нямжав, миний үгийг сонсоод, гайхсан бололтой над руу харж:

- Борзоон гэж юу байдаг юм бэ? гэж асуув.
- Чи Борзооныг үзээгүй юу? Яагаав, хөл нүцгэн явдаг нэг хүн. Үс нь их ургачихсан. Бас хөлийнхөө уландаа үстэй. Уландаа үстэй юм болохоор ямар ч хурдан мориор хөөхөд гүйцэгддэггүй юм. Чи юу гэж санана. Манай сургуулийн хашаа шиг ийм шургааган хашаан дээгүүр чинь авиралгүй үсрээд давдаг хүн байхгүй юу? Борзооныг чи гэрийн хошлон огтолдог гэж санаж байна уу? Тийм биш! Зүгээр шүдээрээ л тас хэзчихдаг юм. Ган шүдтэй гэж амьтан ярьдаг юм.

- Тэгээд тэр чинь хаана байдаг юм?
- Гэр байхгүй ээ! Энэ баруун булгийн хойд хадан дотор өдөр нь унтчихаад, шөнө нь аймгийн төвөөр явдаг юм.
- Ямар аймаар юм бэ!

- Айх юм байхгүй. Хурдан л болохоос биш өөр айх юм байхгүй. Зэр зэвсэг хэрэглэхгүй, хэрэглэхийг ч мэдэхгүй. Тийм болохоор чи шөнө гарч яваад дайралдвал чулуугаар л цохчих хэрэгтэй.

- Байж үхье дээ, чи минь! Өөдөөс бариад авбал яах юм бэ? Ёстой аймаар юм байна. Өнөө шөнө би лав тэр Борзооныг чинь зүүдэлнэ байх. Бүр айчихлаа.

Нямжавтай миний ингэж дэмий ярьж байгаа маань хоолны дун дуугарахыг хүлээж цаг нөгчөөж суугаа хэрэг. Би огт худал яриагаар Нямжавыг сонирхуулж чадсандаа бахархаж улам цаашлуулан:

- Энэ аймгийн төвийн Борзоон яахав, харин дүү нь манай суманд байдаг юм. Махчин болчихсон юм гэж ярилаа.

Нямжавын сонирхож байгаа гэдэг учиргүй. Эмэгтэй хүүхэд ийм гэнэн. Намайг бүр үнэн яриад байна гэж санаж байгаа бололтой.

- Махчин гэж юу юм бэ?

- Хүний мах иддэг хүн. Би нэг удаа бараагийг нь харсан. Манай нутагт Хөшиг гэж уул байдаг юм. Тэр уулын өвөрт хүн нутаглуулдаг юм. Тэнд л хүний хүүр эрээд



явж байна билээ. Саарал дээлтэй явж байхаар нь би махчин байна гэж таниад, ааваараа буудуулчихсан. Тэгсэн чинь яасан гэж санана? Бууны сум биендээ хүргэлгүй өөдөөс нь шүүрч аваад, буцаагаад бидэн рүү шидэж сүйдлэх шахсан.

Буудаж болохгүй юм байна гэж мэдчихээд аав бид хоёр мориороо хөөсөн чинь том том жалга гуун дээгүүр шувт харайгаад л зугтаасан. Гүйцэгдэхийн аргагүй юм билээ. Заримдаа утасны модны хэртэй газар нисээд бууж байгаа харагдсан шүү. Жаахан далавчтай юм даг уу, гэж би санаж явсан.

- Ээ мөн хачин юм даа. Одоо тэр амьд яваа бол уу?

Номын чимэг зургийг С.Төгс-оюун

- Ах нь амьд байхыг бодоход дүү нь амьд л яваа байлгүй.

Манай сумаас ч яваад өгсөн л дөө. Ноднин Хүрээмаралд явна гэж нэг дуулдсан. Одоо танай суманд л яваа байх гэж амьтан ярьдаг юм.

Чи гэр лүүгээ захиа бичвэл саарал хувцастай махчин манай сумаар явж байна уу? гэж сураглаарай. Одоо яг танай сумд л явах учиртай.

Бид хоёрыг ярилцаж дуусаагүй байтал хоолны дун дуугарав. Хоолны дун дуугараагүй бол би хөдөө байхдаа хөгшдөөс сонссон өч төчнөөн юм ярих байв. Ер нь яриад байвал надад сонссон юм их бий. Зарим нь аймаар, зарим нь хүн огт үнэмшмээргүй өч төчнөөн юм бий. Жишээ нь: Би галзуу чонын тухай зөндөө ярьж чадах байв. Намайг бага байхад манай нутагт галзуу чоно тун элбэг байсан юм. Хаврын сард хаанаас ч хамаагүй галзуу чоно гүйж ирээд хүн мал, юу дайралдсантайгаа ноцолдоно. Тэр ч байтугай нэг шөнө манай гэрт орж ирэх шахсан. Тэр шөнө аав гэртээ байгаагүй бол манайд чоно орж ирээд, биднийг хааш ч гаргалгүй баллах байсан даг. Харин аав гэртээ байсны ачаар бидэнд гэм болоогүй. Хаяа сөхөгдөж, ханын шийрэн доогуур чонын хоншоор орж ирээд, сэнгэнэтэл шиншлэхээр нь аав сүх барьж очоод хамрыг нь бараг хавтгай болтол цохичихсон. Чонын хар хамрыг модоор цохичихсон ч үхдэг гэж хөдөөнийхөн ярьдаг. Худлаа. Хамраа хавтгай болтол цохиулчихсан тэр галзуу чоно үхэх нь байтугай, уур нь хүрч, манай гэрийн баруун урд хатавчны туургыг салбартал урж хаячхаад явчихсан (...)

(...) Борзоон амилж эхлэв.

Анх байр хуваарилахад манай сумын арван найман хүүхдийг нэг гэрт суулгав. Бид сургуулийн аж ахуйн агуулахаас нь нэг нэг гудас хөнжил, хоёр хоёр цагаан даавуу, бас дэрний уут авлаа. Энэ шөнө бид унтахын өмнө нэг хэргийг тун их маргаж байж шийдлээ. Шөнө унтахдаа толгойгоо хаяа руу харуулах уу, голомт руу харуулах уу гэж бид маргасан юм. Баахан маргаж байгаад цөм хаяа руугаа хөлөө жийж унтахаар шийдлээ. Ингэж унтах бидэнд үнэхээр тохиромжтой болж, орондоо ороод ярилцаж шуугилдаж байхад, бидний толгой хоорондоо ойр аятайхан байдагт байв.

Гэтэл нэг шөнө том Жамсрангийн гутлыг хаяагаар хулгай аваад явчихжээ. Тэгээд тэр өдөр хичээлдээ гуталгүй суугаад үдэш нь надад ярихдаа :

- Миний гутлыг Борзоон л аваад явчихлаа. Уг нь хөл нүцгэн явдаг амьтан гэсэн. Одоо гуталтай болчлоо. Даарсан юм байх даа гэв. Би бүр мэл гайхаж :

- Борзоон гэж хэн бэ? гэж асуув.

- Энэ аймагт Борзоон гэж нэг лут хулгайч бий гэнэ.

- Хэн чамд тэгж ярьж байна?

- Хүүхдүүд. Зарим нь үзсэн байна билээ. Манай сургуулийн хашаан дотор нэг шөнө бүр чармай нүцгэн гүйж явсан гэнэ.

- Худлаа байлгүй. Аягүй бол Мягмарыг л нэг нь хараа биз.

- Хаанаас. Мягмараас бүр хамаагүй өндөр. Хөлийнхөө уланд үстэй хүн байдаг юм гэнэ.

- Борзоон гэдэг нэртэйг нь чи яаж мэдсэн юм бэ?

- Эндхийн хүүхдүүд бүр сайн мэдэх юм. Мандалын Бибиш надад ярьсан.

- Худлаа даа. Би л тоглоомоор Нямжавт ярьж байсан юм.

Намайг ингэж хэлэхэд Жамсран огт тоосонгүй. (...)

ЗОХИОЛЫН УТГА САНААГ БҮРДҮҮЛЭХИЙН ТУЛД СЭДВИЙГ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛСНИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ

П.Лувсанцэрэнгийн энэ туужид 1940-өөд оны үеийн Монгол орны хөдөөгийн сургуулийн сурагчдын амьдрал байдлыг үзүүлжээ. Зохиолч зохиолын орчин, нөхцөлийг утга сэдэвтэйгээ хэрхэн холбон хөгжүүлснийг задлан шинжилцгээе.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Тууж:

- Гол баатрын амьдралын мөчлөг үеийг өгүүлж, цаг хугацааны орчил харьцаагаараа баатрын дүрийн өсөлтийг гаргадаг туульсын зохиолын томоохон зүйлийг тууж гэнэ.

ЗӨВЛӨМЖ

- Сэдэв утгын хамаарлыг гаргаарай. Үүнээс далд утгыг нь тайлбарлах юм шүү.
- Орчин нөхцөл нь зохиолын утгыг бүрдүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг анзаараарай.

1. Сургуулийн орчныг дүрслэхдээ зохиолч ямар үгс ашигласан байна вэ? Тэдгээр үгийг тодруулна уу. Сургуулийн орчныг таниулахын тулд ямар нэгэн бодит зүйлсийг дүрсэлсэн байна уу? Эх зохиолын дүрслэлээс эшлэл авч тайлбарлана уу.

Түлхүүр үгс	Тайлбар
Намхан цагаан байшин	
Завсарлагааны хонх дуугарах	Сургуулийн орчны анир чимээг таниулахын тулд завсарлагааны хонхны чимээг сонгосон байна.
Хоолны дун дуугарах	
Дотуур байрныхан	

2. Зохиолч яагаад 1944 оныг онцолж нэрлэсэн бэ? Орон цаг нь зохиолын сэдэвтэй хэрхэн холбогдож байна вэ?

	Эшлэл	Тайлбар
Цаг	1944 он	
Орон		
Нөхцөл байдал		Дайны үеийн ховор хомс нөхцөл байдал

3. Зохиолч яагаад эхний бүлэгтээ Хашбат Нямжав хоёрын харилцан яриагаар дамжуулан “Борзоон” гэдэг уран сэтгэмжийн дүрийг бүтээсэн бэ? Зохиолын удаах бүлэгт энэхүү гэнэн яриа хэрхэн цуу яриа болж өргөссөн бэ?
4. Орчин, нөхцөл байдлыг тодруулахын тулд зохиолч ямар орос үгийг хэрэглэсэн байна вэ?

Эшлэл	Тайлбар
савтай ширнээлээ дандаа атгаж суудаг ...	
отряд	
тактик	
коор (корево)	

5. Зохиолд дайны үеийн ховор хомс байдлыг дотуур байранд амьдран суралцаж байгаа хүүхдүүдийн гэр орон аав ээжээсээ хол байгаа ахуй нөхцөлтэй

хэрхэн хослуулан үзүүлсэн байна вэ? Зохиолоос эшлэл авч тайлбарлана уу.

6. Нөхцөл байдлыг хурцатгахын тулд зохиолч ямар аргуудыг ашигласан байна вэ? Хамгийн чухал гэж үзэж байгаа хоёроос гурван жишээ сонгон тайлбарлана уу.

Эшлэл	Уран дүрслэл	Тайлбар
Усны эргүүлэг	Адилтгал	
Борзоон		Зохиолч “Дайны хажуугаар дажин” гэсэн мэргэн үгийн санааг баяжуулж, дайныг “Борзоон”-той адилтгаж, дайны эсрэг тэмцлийг нэгэн сургуулийн орчинд үүссэн хулгай, худлыг илчлэх багш сурагчдын ухамсарт үйл хэргээр үзүүлсэн байна.

7. Дайны үеийн ховор хомс нөхцөл байдлын дундах хүний мөн чанарыг зохиолч хэрхэн үзүүлсэн бэ?

Хэсэглэл 2

П.Лувсанцэрэн “УСНЫ ЭРГҮҮЛЭГ БА БОРЗООНЫ ЯВДАЛ” туужаас
(Үргэлжлэл)

Борзоон уршиг тарьж эхлэв

Анх Нямжавт ярьсан миний дэмий яриа сургууль даяар тарж “Борзоон” гэж нэг амьтан үүслээ гэж би бат итгэж байлаа. Гэтэл хүн бүхэн, Борзооны тухай бүр үнэмшмээр юм яриад байхаар би өөрөө ч заримдаа итгэх шахаад байв. Гэвч хараахан гүйцэд итгээгүй, миний дэмий ярианаас л ийм хэрэг гарлаа, хамаг бурууг нь би боллоо, гэж дотроо гэмшсээр явлаа. Гэтэл яван явсаар Борзоон бидэнд ч гай тарьж эхэллээ.

Нэг өдөр хичээл тараад, байрандаа орох гэж явтал:

- Сэмбэн та хоёрыг захирлын өрөөнд дуудаж байна гэсэн хэл ирлээ.

Би ямар хэрэг хийснээ эхлээд бодлоо. Захирал дуудахыг бодоход заавал нэг сүрхий хэрэг дэгдсэн байж таарна. Аягүй бол Бибиш, Хорлоо хоёр шиг шийтгүүлнэ байх гэж бодлоо. Тэр хоёрын шийтгүүлж байхыг би нүдээрээ үзсэн юм. Чухам ямар хэргээр тэд гийгүүлснийг мэдэхгүй.

Сэмбэн бид хоёр дулаан дээл өмсөөд, захирлын өрөөнд орж ирлээ. Тэнд Цэвэгдорж багш, Ядам багш хоёр байв.

Бид хоёр ороод зуухны хажууд номхон зогслоо. Цэвэгдорж багш суудлаасаа босож миний өмнө ирээд

- Чи томоотой царайлсан, бас нэг хачин нөхөр өө дөө! Наашаа хар! гэв.

- Наад нөхөр чинь сургуульд ирсэн анхны өдрөөс тар нь танигдсан юм аа! гэж Ядам багш хажуунаас нь хэлэв.

Яагаад Ядам багш намайг ингэж хэлж байгааг би мэдэж байлаа.

Энэ бол сургуульд ирсний маргааш өглөө болсон хэрэг. Би тэгэхэд өглөө бүрээр дуунаар яаралтай босож, хоолны дун дуугармагц гал тогооны байшингийн ард очиж жагсдаг журамтай байсныг мэдээгүй байсан юм. Тиймээс яаралгүйхэн босож нүүр гараа угаагаад, хоолны дун дуугарахад мөн яаралгүй явсаар очиж, жагсаалын эцэст орж зогссон билээ.

Ядам багш энэ өдөр жижүүртэй байсан тул жагсаалын өмнө дун барьж зогсоод, хоолонд хамгийн сүүлд ирсэн намайг их л анхааралтай ажиглаж байлаа. Уг нь би хоолны дун дуугармагц, турж үхэх гэж байгаа амьтан шиг гал зуух руу яаран гүйх

ичгэвтэр юм уу даа гэж дотроо бодож явсан юм.

- Та нар талхаар шидэлцсэн үү? гэж асуухад нь би түрүүлж,
- Тэгсээн багш аа гэв.

Ядам багш бидний царайг хэсүүлж хараад:

- Танай Баянбулагийнхан сахилгагүй байна. Талхаар шидэлцэнэ гэнээ!! Та нарын үдийн хоолыг хаслаа. Дахиад талхаар шидэлцвэл хатуу ярина шүү. Дайны цаг байна, одоо дайны хуулиар л ярина. Ялангуяа чи нөхөр... гээд бид нар рүү харснаа:

- Нэр чинь хэн билээ гэв.

- Хашбат! гэтэл

- Нөхөр Хашбат өглөө жагсаалд хожигдоод, бас талхаар шидэлцэнэ гэнээ! гэв. Багшийн үгийг сонсмогц энэ өнгөрсөн явдал миний санаанд зурсхийн бодогдоод өнгөрөв.

- Чи Бууцагааныхны цагаан бүрээсийг яах санаатай урсан бэ? гэж Цэвэгдорж багш надаас асуулаа.

- Би ураагүй багш аа.

- Тэгээд хэн урсан юм?

Цэвэгдорж багшийг ингэж асуухад, Сэмбэн хажуунаас:

- Наадах чинь ураагүй байх аа, багш аа! гэж хэлэв.

Ядам багш ч Сэмбэнг дагуулан гарав.

Цэвэгдорж багш бид хоёр л үлдлээ. Надад маш аймшигтай санагдана. Цэвэгдорж багш надтай цаг гаруй ярив.

“Борзоон гэж огт байхгүй. Би тоглоомоор Нямжавт дэмий юм ярьсан маань сургуулиар тарж ийм хэрэг боллоо. Миний буруу. Би ямар ч хулгай хийгээгүй. Гэрийн бүрээс ч ураагүй” гэж би бүх явдлыг нарийвчлан ярив. Цэвэгдорж багш нэг ч үг дуугаралгүй миний яриаг чагнаж аваад:

- Чиний ярьж байгаа цөм үнэн гэв.

Миний дотор онгойх шиг санагдлаа. Гэтэл Цэвэгдорж багш дэргэдээ сандал тавьж намайг суулгаад:

- Чиний ярьж байгаа цөм үнэн. Одоо чи сургуулийн байранд хэн хулгай хийж, гэрийн бүрээс урж, хошлон огтолж байгааг надад хэлж өг дөө. Чи өөрөө хулгай хийдэггүй чинь үнэн. Би чамд итгэж байна.

- Би мэдэхгүй.

- Чамаас өөр сайн мэдэх хүн байхгүй шүү дээ.

- Би мэдэхгүй багш аа!

- Яагаад?

- Би үг хэлж чадсангүй. Гэтэл Цэвэгдорж багш:

- Чи бүгдийг мэдэх ёстой.

- Яагаад?

- Учрыг нь би чамд ярья! Уг нь чи өөрөө ярих ёстой байсан юм даа. Яахав би ярья. Чи сонс. Сурагчдын хоол хувцас хулгайлдаг, тэгээд ч зогсохгүй сургуулийн шинэ гэрүүдийн цагаан бүрээсийг хүртэл урж, аминдаа ашигладаг тийм хүмүүс манай сургууль дотор бий. Үнэн үү? гэв.

- Үнэн!

- За тийм. Үнэн. Тэр үл бүтэх этгээдийг чи сайн мэднэ. Үнэн үү?

- Худлаа. Би мэдэхгүй багш аа!

- Чи худлаа ярьж байна. Чи сайн мэднэ.
- Мэдэхгүй, багш аа.
- Сайн сонс чи! Чи бүгдийг сайн мэднэ. Мэдэхээр барахгүй тэр үл бүтэх этгээд чиний дотно хүн байгаа: Тэр хүн гэмт хэрэг хийгээд баригдахгүй байхын тулд... чи сонсож байна уу? Баригдахгүйн тулд гэж... бас өөрийгөө нуухын тулд, хүүхдүүдийг айлгахын тулд, “Борзоон” гэж нэг аймшигтай хүн байдаг гэсэн цуурхал тараахыг чамд даалгасан байна.

Чи тэр даалгавар ёсоор Нямжавт тийм юм зохиож ярьсан. Нямжав ч цааш нь тараасан. Нэгэнт тийм цуурхал тарсан болохоор хүүхдүүд юм л алга болбол “Борзоон авсан” гэж ярьдаг болсон. Гэрийн бүрээс урсан ч “Борзоон урсан” гэдэг л болсон.

Борзоон гэдэгт чинь хууртаад хүүхдүүд жинхэнэ хулгайчийг барих гэж бодохоо ч больсон. Ингэж “Борзоон” гэдэг нэрээр халхавч хийгээд нэг нөхөр манай сургуулийг санаа амар сүйтгэж байна. Тэр хулгайчид санаа амар хулгай дээрэм хийж явах бүх бололцоо, үүд хаалгыг нь чи ингэж нээж өгсөн...

- Үгүй ээ, багш аа. Тийм юм байхгүй.
- Дуугүй бай, нөхөр минь! Чи Борзооныг зүгээр нэг хүн ч биш, хөлийнхөө уланд үстэй, ямар ч хурдан моринд гүйцэгддэггүй гэхчлэн ярьсан чинь хүүхдүүдийг айлгахад бүр ч сайн шалтаг болсон. Энэ бүхнийг чи өөрөө ч зохиож яриагүй. Цаад хүн чинь ингэж яриарай гэж чамд зааж өгсөн. Ийм л байна. Чи тэр хулгайчийг л авчирч аль! Чамтай өөр юм ярихгүй гэв.

Надад хэлэх үг олдсонгүй. Баахан дуугүй сууж байгаад

- Би мэдэхгүй ээ, багш аа гэж дахин нэг хэллээ.
- Мэдэх л болно доо чи. Хэлэх л болно доо чи! гэж хэлээд Цэвэгдорж багш ширээн дээрээ ном дэлгэн юм бичиж эхэллээ!

Намайг хайхрахаа болилоо. Би харанхуй болтол суув. Цэвэгдорж багш шүүгээ уудлан, лаа гаргаж асуугаад, над руу нэг харж:

- Чи хэлэх болоогүй л байна уу? гэв.
- Надад хэлэх юм алга, багш аа.
- Хэлэх л болно доо чи. Яахав сууж л бай.

Ингээд асаасан лаагаа өмнөө тавьж дахин юм бичиж эхэллээ.

Оройн хоолны дун дуугарч хүүхдүүд хоолондоо орлоо.

Хоол идээд дууслаа. Нэг хэсэг хүүхэд хашаан дотор хашхиралдан шуугина. Галч нар түлээгээ хагалаад дууслаа. Энэ бүхнийг би чимээгээр нь таамаглан мэдэж суув.

Харанхуй боллоо. Бодвол одод гараа байх. Хүүхдүүдийн чимээ намдаж, ноход шуугилдана. Тоононы өөд харахад хав харанхуй. Гадаа их л хүйтэрч байгаа янзтай, гэрт суухад ч бие жихүүцэж байлаа.

- Чи гурав хоногийн дотор хэлнэ үү? Шоронд сууна уу? гэж Цэвэгдорж багш над руу харснаа босоод ирлээ. Тэгээд намайг дуугарч амжаагүй байтал, доошоо тонгойж шүүгээний нүдийг уудлав. Авдарны түлхүүр эрж байх бололтой.

- Багш аа гурав хоног бодъё гэж би хэлэв. (...)

(Хэсэглэн авав) П.Лувсанцэрэн. Усны эргүүлэг буюу Борзооны явдал. УБ.,

ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН БҮТЭЦ БА ҮЙЛ ЯВДЛЫН ДАРААЛЛЫГ ХҮҮРНЭЛИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ТАЙЛБАРЛАХ

П.Лувсанцэрэнгийн “Усны эргүүлэг ба Борзооны явдал” тууж нь нэгдүгээр биеийн хүүрнэлийг ашигладаг. Энэ тохиолдолд хэрэг явдал нь дэлхийн хоёрдугаар дайны үеийн Монголын хөдөөгийн сургуулийн амьдрал, сурагч насны гэнэн томоогүй үеийн хэрэг явдлаа дурсан хүүрнэх байдлаар үзүүлдэг. “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгт өндөр настны дуу хоолой зонхилж байсан бол “Усны эргүүлэг ба Борзооны явдал” туужид өсвөр насны хүүхдийн дуу хоолой зонхилно.



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

► Нэгдүгээр биеэс хүүрнэн өгүүлэгч нь өгүүллэг, туужийн доторх идэвхтэй дүр юм. Бүх хэрэг явдлыг бид түүний нүдээр хардаг. Нэгдүгээр биеийн хүүрнэгчид бусад дүр болоод хэрэг явдлын талаарх бидний бодлыг замчлахын тулд идэвхтэй дүрийн үүрэгтэй байдаг.

ЗӨВЛӨМЖ

Нэгдүгээр биеэс хүүрнэн өгүүлэгчийн үүргийг ойлгоход дараах асуултууд тусална.

- Тэр бусад дүртэй яаж холбогдож байна вэ?
- Хэн ба юуг тэд батлан сайшааж, эсвэл эсэргүүцэн буруушааж байна вэ?
- Тэр ямар мэдээллийг дэлгэж чадах вэ?

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Өгүүллэгт хүүрнэн өгүүлэгч нь хэн байна вэ? Тэр хэддүгээр биеэс өгүүлж байна вэ?
2. Хүүрнэн өгүүлж буй дүрийн хэл яриаг сайтар тунгаа. Ямар сэтгэгдэл төрж байна вэ? Таны үзэл бодлыг дэмжиж буй хэсгийг бичвэрээс эшилнэ үү.
3. Хашбатын хэлсэн үгийг тодруулагчаар тодруулж, түүний ярьж хэлж буй дуу хоолойны өнгийг төсөөл. Мөн Нямжавын хариу үйлдлийг харуулж байгаа хэсгийг өөр өнгөөр тодруулна уу.
4. Туужаас Борзооныг дүрсэлсэн хэсгийг хувилж аваад уран дүрслэл, яруу асуулт, хэтрүүллийн жишээг тодруулна уу. Туужийн хэсэглэлд байгаа уран дүрслэл уншигчид хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлана уу.
5. Туужийн эхний хэсэглэлийг уншаад хүүрнэн өгүүлэгчийн талаар ямар сэтгэгдэл төрсөн бэ? Хашбатын талаарх анхны сэтгэгдлээ хоёр өгүүлбэрээр илэрхийлж бичнэ үү. Бичихдээ өнгөөр тодруулсан хэсгүүдээсээ эшлэл авч нотлоорой. Эшлэл авахдаа эшлэлийн хашилт тэмдгийг хэрэглээрэй. Жишээ нь: “...Тэр уулын өвөрт хүн нутаглуулдаг юм. Тэнд л хүний хүүр эрээд явж байна билээ. Саарал дээлтэй явж байхаар нь би махчин байна гэж таниад...” гэхчлэн гурван цэг тавьж хашилтад бичээрэй.
6. Хүүрнэл зохиолын утга санаа нь хүүрнэн өгүүлэгчээр дамжиж гарч ирдэг. Зохиолын энэ хэсгээс Хашбатын үзэл бодлыг дамжуулсан хэсгийг дахин унш.
7. Түүхийг үнэмшилтэй өгүүлэх үүднээс хэрэглэсэн харилцан ярианы үүргийг тодорхойл.
8. Дүрүүдийн хооронд өрнөж буй харилцан яриаг зохиолд хэрхэн ялгаж тэмдэглэсэн байна вэ? Дүрүүдийн харилцан яриаг өнгөөр ялган тэмдэглээд, тэдний өмнөөс төлөөлөн уншина уу. Энэхүү дасгал нь дүрийн дуу хоолойны өнгийг



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Дуу хоолой:

- ▶ Зохиогчийн зүгээс уран зохиолын бичвэрээр дамжуулан өөрийн үгээ илгээж буй арга, хүүрнэлийн тулгуур ойлголтыг дуу хоолой гэнэ.

мэдрэхэд тань тусална.

9. Энэ туужийн зохиогч харилцан яриаг хэрхэн хэрэглэсэн бэ? 200 үгэнд багтаан асуултад хариулж бичихдээ бичвэрээс эшлэл авахаа мартуузай.
10. Шийтгэгдэж буй хоёр хүүхдийн тухайд та нар юу хэлэх вэ? Тэдэнд ямар байгаа бол? Энэ явдалд чухам хэн, юу буруутай вэ?
11. Зохиолын баатруудын юуг магтаж сайшаамаар байна вэ? Юуг шүүмжилмээр байна вэ? Хамгийн үнэмшилтэй гэсэн нотолгоонуудаа бичнэ үү.

П.Лувсанцэрэн “УСНЫ ЭРГҮҮЛЭГ БА БОРЗООНЫ ЯВДАЛ” туужаас

Хэсэглэл 3

(...) Борзоон дахин уршиг тарив.

Би анхандаа “Борзоон гэдэг хүн байхгүй, миний ярианаас л гарсан юм” гэж бодож байснаа олон хүүхэд яриад байхаар “Борзоон” гэж энэ аймагт үнэхээр нэг хүн байгаа юм болов уу гэж эргэлзэж байсан юм. Гэтэл Цэвэгдорж багшийн ярианаас хойш, энд “Борзоон” гэдэг хүн байхгүй, харин Борзооны нэрийг барьсан нэг этгээд заавал байгаа гэж баттай боддог боллоо. Тэр хүнийг гурав хоногийн дотор олж өгнө гэж Цэвэгдорж багшид ам алдсанаас хойш, миний сэтгэлд тэр хүнээс өөр бодогдох юмгүй боллоо.

“Ямархуу зүс царайтай, ямар янзын амьтан хаана яваа бол? Муу цусыг яг хулгай хийж байхад нь палхийтэл барьж аваад шүүхэд өгөх юм сан...” гэж хорсон бодож, бодох тоолондоо уур хүрч явав. Сүүлдээ бүр хичээл дээр сууж байхад хүртэл бодогдоод байдаг боллоо.

Нэг өдөр Жанцан багшийн хичээл дээр бүр их бодов. Жанцан багш тоо заадаг юм. Би үнэнээ хэлэхэд тооны хичээлд сайн л даа. Гэрийн ажил хийлгүй ирж, эсхүл тоо буруу бодож, Жанцан багшийг уурлуулж байсан удаа огт байхгүй.

...Урьд өдөр нь Борзооны уршгаар Цэвэгдорж багшид байцаагдсанаас би анх удаа гэрийн даалгавар хийлгүй ирж, түүндээ бантаад Жанцан багшийн нүүр лүү ч харж чадахгүй суулаа. Ашгүй Жанцан багш гэрийн ажлыг энэ өдөр нийтэд нь шалгалгүй, хүүхдүүдийг нэг нэгээр нь босгож, самбарт тоо бодуулж байлаа. Тэр



хооронд нь би Борзооныг баривчлах тухайгаа бодож суув.

- Хашбат гэж Жанцан багшийн дуу гэнэт тасхийв. Юу асууж байгааг ойлгоогүй ч гэсэн босож, номхон зогслоо.

Нэгэнт гэрийн ажил хийгээгүй ирсэн болохоор би ч гомдсонгүй дотроо “Борзоонд” уур хүрч суулаа. Борзооны уршгаар би анх удаагаа ингэж тооны хичээл дээр муу дүн авлаа.

Борзооныг баривчлах отряд

Энэ орой бид манаанд гарахаар хэлэлцэж тохирлоо. Манааны ажлыг удирдуулахаар Сэмбэнг сонголоо.

- За бидний яриа бол цэргийн нууц. Тийм болохоор хүнд сонсгохгүй. Одоо харуул гаргаж, гадаа үүдэнд зогсооно Намжил харуулд гар.. гэж Сэмбэн зааварлав.

- Намжил дээлээ өмсөөд, харуулд гарч гадаа үүдэнд зогсов.

- Зохион байгуулалт сайтай байх хэрэгтэй. Бид өөрсдийгөө “Борзооныг баривчлах отряд” гэж нэрлэнэ. Би бол отрядын дарга. Миний орлогч Хашбат. Намжилсамбуу бол холбоочин, Бэгзжав, Дашпунцаг хоёр их буучин, бусад нь байлдагчид... Нөхөр орлогч та сургуулийн хашааны зургийг хурдан зураад ир. Бид тактик хийнэ гэв.

Би дэвтрийн гол цаасан дээр сургуулийн хашаа, гэрийг тоймлон зурав. Бүгдээрээ энэ зургийг лааны гэрэлд дэлгэн тавиад, отрядын дарга хүн хүнд үүрэг өглөө.

- Холбоочин Намжилсамбуу, их буучин Бэгзжав, Дашпунцаг нар байрандаа үлдэнэ. Гэхдээ унтаж болохгүй, бэлэн хувцастайгаа чимээ чагнаад байж бай. Сургуулийн хашааны баруун хойд булангаас зүүн үзүүр хүртэлх зайг Гомбо, бага Жамсран, Банзрагч гурав хариуцаж манана, дарга нь Банзрагч. Сургуулийн хашааны урд хэсэг, хичээлийн байр орчныг Намжил, Лодойсамбуу хоёр даана. Манааны байр нь хичээлийн байрны урд талын хонхор. Гал зуухны орчмыг Лийсэн манана. Лийсэнгийн байр бол гал тогооны хойд талын хураалттай түлээ. Хашааны зүүн талын овоолсон тоосгонуудын тэнд хамгийн сэжигтэй, ширүүн байлдаан болж магадгүй газар. Тэнд Хашбат бид хоёр гарна. Үлдсэн бусад таван нөхөд байрандаа зүгээр унтана. Гэхдээ холбоочноор хэл ирээд, яаралтай дуудвал түргэн босож байлдаанд орно Манаанд гарах нөхөд манаанд гарч байгаагаа хэнд ч мэдэгдэж болохгүй. Хүүхдүүд унтаад гүйцэхээр барагцаалбал 11 цагийн үед ганц ганцаараа сэмхэн гарч, манааныхаа байрыг эзэлнэ. Дэргэдээ чулуун “зэвсэг” бэлдэж авах хэрэгтэй. Өнөө шөнө сар байхгүй. Чимээ маш сайн чагнана. Борзоон явж байгаа сэжиг мэдэгдвэл өөртөө аль болох ойр байгаа манаанд мэдэгдээд, хоёул юм уу, гурвуул гэнэт дайрах хэрэгтэй. Эсэргүүцэхгүй бууж өгвөл гарыг нь ард нь хүлээд, надад хүргэж ирнэ. Эсэргүүцэх юм бол цусныхаа эцсийнхээ дуслыг хүртэл тэмцэхийн хамт тун дийлмээргүй бол “Туслаарай” гэж чанга хашхирна.

- Бид хэдэн цаг хүртэл манах юм бэ?

- Үүр цайтал манана. Үүр цайтал суугаад, Борзооныг барихгүй бол маргааш

дахиад манана. Бүрэн ялалтад хүрсэн цагт л бид амарна... гэж отрядын дарга заавар өглөө.

...Сэмбэн бид хоёр чимээгүй нэлээд ажиглалаа. Сургуулийн баруун талаар байдаг айлуудын ноход дуу дуугаа авалцан хуцаж, бас нэлээд ойрхон морь тургих чимээ гарч, эмийн сангийн байшингийн хана бүдэгхэн цайрч харагдана. Гэтэл хоёр эмэгтэй хүүхэд ярилцсаар гарч ирээд хоорондоо:

- Анхнаасаа л чи надтай нэг ширээнд суухгүй.
- Харин тэгдэг л байж
- Миний хажууд суудаг тэр дэнжгэр чинь их сахилгагүй.
- Би савтай ширнээлээ дандаа атгаж суудаг шүү... Тэгэхгүй бол дүрчих гээд байдаг юм. Ховдог дүрнэ гэдэг нь. Үзэгнийхээ үзүүрийг хугартал ч хамаагүй дүрнэ гээч.

Ингэж ярилцаад хоёул буцаж, байр луугаа явлаа. Энэ хоёрыг буцаж ороод, арваад минут хэртэй болсны бас хоёр хүүхэд гарч ирэв.

Тэр хоёр хашааны хаалгаар гарч ирээд, ганц ч үг солилгүй хэдэн алхам явснаа зогсож хоорондоо шивнэлдэв. Эрэгтэй хүүхдүүд бололтой. Хоёул жаахан шивнэлдсэнээ, хүүхдүүдийн замаас зайлж, урагшаа хэд алхаад, Сэмбэн бид хоёрын зүүхэн талд ирж, хэсэг тоосгоны ёроолд суув...

- Юм идэж байх шиг байна гэж Сэмбэн надад шивнээд, гараа миний мөрөн дээр тавин, тэр хоёрыг хөдөлгөөнгүй ширтэв.
- Энэ хоёр ч “Борзоон мөн дөг шүү. Том Борзоон уу, бага Борзоон уу, одоо мэдэгдэнэ ээ” гэж Сэмбэн мөн шивнэн хэллээ.

Борзоон ийм байдаг юм бий” гэж би дотроо баяртай бодож:

- Одоо дайраад орвол яадаг юм бэ? гэж Сэмбэнгээс асуухад
- Болоогүй хонгор минь. Болохгүй гэж толгойгоо сэгсрэв.

Би Борзоонуудыг шалавхан барих гэхээс тун яараад байлаа.


- Юм нууж байна гэж Сэмбэнд хэллээ.

Тэр хоёр шалавхан нэг юм тоосгоор дарчхаад, босож хашааны хаалга руу цувралдан алхацгаахад:

- Би явлаа. Энэ хоёрыг дагана. Чи тэр тоосгон дотор нуусан юмыг аваад, байрандаа шалавхан оч гэсээр Сэмбэн босож тэр хоёрын хойноос дагав.

Би тоосгон дотроос жижиг даавуун ууттай ааруул олоод, олзондоо их л баярлаж, байрандаа инээд алдан чичирсээр орж ирэхэд манайхан цөм ирсэн байлаа.

“Борзооныг баривчлах отрядын” анхны шөнө ингэж талаар өнгөрөөгүй нь бидний урмыг сэргээв. Манай отрядын баривчилж ирсэн хоёр “Борзооныг” маргааш нь оройн тоо бүртгэлийн дараа сурагчдын жагсаалын урд хөтлөн үзүүлж, шийтгэсэн билээ...



ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН БҮТЭЦ БА ҮЙЛ ЯВДЛЫН ДАРААЛЛЫГ ХҮҮРНЭЛИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ТАЙЛБАРЛАХ

Өгүүллэгт гол дүрийн амьдралд тохиолдсон дан хэрэг явдлыг үзүүлдэг бол туужид цуврал хэд хэдэн хэрэг явдлыг үзүүлдэг. Хүүрнэл зохиолын зохиолчид үзүүлж буй хэрэг явдлаа дараалалд оруулахдаа юу болж өнгөрснийг цаг хугацааны дарааллын дагуу дараалах юм уу, эсвэл алгасах, товчлох зэрэг олон аргаар өөр дараалалд байрлуулдаг. Уг туужид зохиолч хэрэг явдлыг хэрхэн дарааллаж, үйл явдлыг хэрхэн өрнүүлж үзүүлснийг судалцаая.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Зохиолд ямар хэрэг явдлыг өгүүлж байна вэ? Зохиолын хэрэг явдал хэрхэн эхэлж, хэрхэн өрнөөд, хэрхэн төгссөн бэ? Тоймлон ярина уу.
2. Зохиолын бичвэр дээр хосоор ажиллан, өгүүлэгдэхүүний задлал хийж, зохиолоос зангилаа болон туйл хэсгийг олж тодруулна уу.
3. Эхлэл хэсэгт зохиолч сургуулийн амьдралын талаар ямар мэдээллийг хэрхэн өгсөн хийгээд цуу яриаг хэрхэн эхлүүлсэн талаар хоёр өгүүлбэрээр хариулж бич.
4. Зохиолч хэрэг явдлыг цаг хугацааны дарааллын дагуу үзүүлсэн байна уу, эсвэл цаг хугацааны дарааллыг өөрчилсөн байна уу? Зохиолч хоёр өөр цаг хугацааны хэрэг явдлыг бичихийн тулд зохиолч ямар арга хэрэглэсэн байна вэ?
5. Өгүүллэгт болж буй хэрэг явдлыг товчлон, зохиолчийн бичсэн дарааллын дагуу жагсаана уу. Зарим сурагч үйл явдлын дарааллыг харуулсан зураг зурж, зарим нь өгүүллэгийн үйл явдлыг цаг хугацааны дарааллын дагуу бичихийг оролдоно уу. Энэ дасгал нь өгүүлэгдэхүүнийг хэрхэн зохион байгуулсан арга замыг ойлгоход тань тусална.
6. Зохиолын өгүүлэгдэхүүн нь ямар ямар санаатай хэрхэн холбогдож байна вэ? Тэдгээр санаа нь сэдвүүдтэйгээ хэрхэн холбогдож байна вэ?
7. Зохиолч туужийнхаа дотор Хашбатын яриагаар Борзоон хэмээх нэгэн дүрийг оруулж ирэх замаар хэрэг явдлыг эхлүүлсэн нь сэдэвтэйгээ хэрхэн холбогдож байна вэ?
8. Зохиолч үндсэн сэдвээ хэрхэн гаргаж ирсэн бэ? Өгүүлэгдэхүүн нь утга санааны ямар илэрхийллүүдтэй холбогдож, тэдгээр утгын илэрхийллүүд нь сэдэвтэйгээ хэрхэн холбогдож байна вэ? Энэ тууж нь ямар үзэлд суурилсан байна вэ?

Өгүүлэгдэхүүн	Сэдэв

9. Зохиолч зохиолын үйл явдлыг хэрхэн өрнүүлж байна вэ? Шинэ дүр нэмэх аргаар үйл явдлыг өрнүүлж байна уу? Аль эсвэл орон, цагийг өөрчлөх аргаар өрнүүлж байна уу? Зохиолоос жишээ татан батална уу.
10. Дайны хор хохирлын талаар өөрийн үзэл бодлоо үндэслэлтэй илэрхийлж, үнэлж дүгнэн бичээрэй.

Хэсэглэл 4

Том Борзоон баригдав.

...Цоодол багш дэргэдээ байсан мухар сандлыг над руу ойртуулаад:

- Өнөө шөнө манаанд гарна даа. Борзооныг чи барина. Чадах уу? гэж асуулаа.
- Чадна аа багш аа гэж би зогсоогоороо хариуллаа.
- Хүүхдүүдэд ярьж хэлсний хэрэггүй. Хэдэн хүүхэд гараад, нэг шөнө нэг цаг хүртэл манаа хийнэ. Харин дулаан хувцсаа өмсөх хэрэгтэй. Чухам ямар янзтэй манахыг энэ хүн нарийн хэлж өгнө гээд Цоодол багш үл таних хүн рүү заав.

Би яг авсан зааврынхаа ёсоор Сэмбэнгээс түрүүлж байрнаасаа сэм гараад, сургуулийн гал зуухны байшингийн урдах хоёр том бөөрөнхий модны хооронд орж, түрүүлгээ харан хэвтлээ.

...Тэгээд дотор овоо уужрах шиг болж, цээжээ өндийлгөж ирээд чимээ чагнаж байтал, сургуулийн баруун хаалганы тэнд бололтой гэнэт шүгэл тасхийлээ. Ахиулаад чагнаж байтал шүгэл дахин дуугараад хүмүүс шуугилдаж эхэллээ. Би босож тэр зүг рүү хар хурдаараа гүйв. Очоод үзтэл Сэмбэн бид хоёроос гадна зөндөө олон хүн манаа хийж байсан юм санж. “Том Борзооныг” барьж аваад, урдаа туучихсан шуугилдаж байлаа.

Өч төчнөөн хоног бодож, санаархаж, манаа хийж яваад “Том Борзооныг” яг барихад өөрөө оролцож чадаагүйдээ миний урам хугарч, бас тэр зэрэгцээд сууж байснаа бодохоос уур хүрч, түүнийг бүр нам цохиод унагачихмаар байв. Би орондоо ороод нэг хэсэг уйллаа. Хор хөдөлсөндөө уйлсан юм.

Бас л Борзооны гай

“Энэ Борзооны гай дуусах цаг арайхийж нэг ирлээ дээ” гэж бодсон чинь бас байдаггүй. Горьдсон сэтгэлийн гарз болов. Нэг юмыг одоо л нэг дуусна байх гэж дэндүү горьдоод байхаар дуусдаггүй юм байна гэж мэдээд, би эмнэлэгт ирсэн хойноо “Борзооны гай дуусах яагаа ч үгүй” гэж дотроо бодож, бодсондоо бат итгэж байгаа. Том Борзооныг баривчилсан маргааш өглөө нь би хэвтрээсээ босож чадсангүй. Надад өвчин туссанаас болж л тэр шөнийн манаан дээр тэгж их нойр хүрч бие чичрээд байсан юм санж.

Манай сургуулиас олон хүүхэд өвдөж эмнэлэгт хэвтжээ...Байр хүрэлцээгүйгээс болж, янз бүрийн өвчтэй хүүхдийг нэг байранд хутгалдуулж, нэгний нь өвчин нөгөөдөө түргэн халдаж байлаа. Анх намайг эмнэлэгт ирэхэд “Цусан суулгатай” хүүхэд гэж эмч нар хоорондоо ярьдаг байснаа “коор” гэж нэг шинэ нэр яригдах болж, миний бүх бие улаан гувруу татан туурлаа....Тэр үед миний байдлыг харвал, эцэж турахын туйлд хүрч, арьс маань улаан цоохор болтлоо туурч, бас хоёр нүдний зовхи хавдсаны улмаас хааяа юм харах хэрэг болбол нүднийхээ зовхийг хоёр гараараа дээш доош нь салган татаж хардаг, хүн аймаар амьтан болоод, биеэ харахаас хүн байтугай би өөрөө айдаг байв.Надтай хамт тусгаарлагдсан гурван хүүхэд ч мөн надаас доор уу гэхээс биш, дээр юм байхгүй. Манай гэрт эмч, сувилагчаас өөр хүн эс орно.

...Шөнө нэг сэрэхнээ цагаан халаадтай хоёр хүн “Ганцаараа ч гэсэн хамаагүй

сургуульдаа үлдэхэд яадаг юм бэ?” гэсэн янзтай уйлахгүй байдаг бяцхан охин Одонг даавуугаар бүтээгээд дамжлан гарч харагдав.

...Эрүүл байсан цагийн юм бүхэн сайхан байжээ. Хэдхэн хоногийн өмнө л бид өглөө босохоос амиа гартал шахам айдаг байсан. Түүнийг одоо бодоход бүр тоглоом шиг санагдаж, багшийгаа юунд тэгж унь бариулж гүйлгэдэг байв даа гэж би харамсан бодлоо.

...Энэ гэрт ялгаж оруулснаас хойш манай хоёр багш л цагаан халаад өмсөж, нэг орж ирснээс өөр хэн ч биднийг эргэсэнгүй....“Аав минь юм уу, ээж минь нэг хүрээд ирж чаддаггүй л юм байх даа” гэж надад ч гэсэн бодогдлоо. Үнэндээ яаж ч ирэхэв дээ. Манай нутаг чинь зургаан өртөө газрын цаана байгаа. Бас миний өвчтэй байгааг ч мэдээгүй. “Нэг нь ирмээр байна” гэсэн миний захидлыг аваад, “муу хүү минь гэрээ санаж” гэж л бодоо байх...

Борзооны сураг тасрав.

Хот хөдөө аль ч газар намар оройхон болоод, хүйтэн салхи хохилзон үлээж байхад хүн, хүн байтугай мал хүртэл сэтгэлийн тав алддаг болов уу гэмээр байдаг. Яг л тийм нэг өдөр үдээс хойхно Галсандорж бид хоёр хамаг дулаан хувцсаа өмсөж, малгайгаа хүртэл бүчлээд, хоёр жижигхэн чавганц юм уу, хүүхдээ саяхан гаргасан хоёр жаахан хүүхэн шиг хэлбэр байдалтай улс эмнэлгээс гарцгаав...Элдвийг бодож байснаа би:

- Нөгөө том Борзоон юу болсон бэ? гэж асуулаа.
- Том Борзоон ялд орсон гэнэ билээ. Довдонг баривчлаад л бид гэнэт хулгай алга болчих юм шиг санаад байсан чинь ер нь жижиг Борзоон олон байх шиг байна аа. Хүүхдүүд энд тэндгүй л жаал зугаа идэх юмаа борзоондуулчихлаа гэж ярьж байх юм. Борзоонддог хүн ч олон байх шиг байна гэж Сэмбэн ярив.
- Манаа хийж Борзоон барьдгаа больсон уу?
- Манаа хийгээд байхаар том дорвитой Борзоон ч алга болж л дээ. Харин жижиг хулгана шиг Борзоон л олон байна. Тийм юмны чинь манаа хийгээд яаж барихав. Бидний дотор л байна. Одоо манаа хийхээ ч байсан.
- Мартсанаас, анх манаа хийхэд чи тэр боорцог, хортой харандааг хаанаас олж биднийг шагнасан бэ? гэж би Сэмбэнгээс асуулаа.
- Түүний чинь Цоодол багш өгсөн юм. Та нарыг манаанд гаргах бүх ажлыг Цоодол багш надад зааж өгдөг байсан. Тэр ч байтугай өөрсдийгөө “Борзооныг баривчлах отряд” гэж нэрлэхийг ч би Цоодол багшаас асууж зөвшөөрүүлсэн юм шүү дээ, хонгор минь.
- “Цэргийн нууц” гэдэг чинь тийм нарийн байдаг юм гэж Сэмбэн надад гайхуулан ярьснаа,
- Одоо дорвитойхон Борзоон байхгүй болчихоод, манаанд гаръя гэсэн ч Цоодол багш дэмжихээ больсон гэж харамссан янзтай ярив.

Энэ ярианаас үзэхэд, анх эхэлж миний худал ярианаас үүссэн Борзоон (миний худал ярианаас үүссэн гэж би эргэлзээгүй мэдэж байна) сурагч тасарч, миний сэтгэл амрах цаг арайхийж иржээ.

- Чи хулгайчид бололцоо олгох гэж санаатайгаар цуурхал тараасан. Чи тэр хулгайчаа одоо олж өг! гэж Цэвэгдорж багш хэзээ л байцааж шалах бол гэдгээс

би ямагт айж явсан. Тэр айдас одоо ч дуусаагүй байж мэдэх юм. Тиймээс Борзоон гэдэг үг чихэнд дуулдмагц миний уур хүрч явдаг байсан. Одоо ч уур хүрч байна...

Төгсгөл бүлэг

Чойдог багш над руу хараад:

- ...Та нар муу л юм бол “Борзоон” гэж ярих дуртай улс. Жинхэнэ том Борзоон чинь дайн л байгаа юм гэснээ,
- Усны эргүүлэг гэж юу байдгийг та нар мэдэх үү? гэж гэнэт асуув.

Бид онох онохгүй хариулт хэлж, хоорондоо цэц булаалдах шахаж шуугилдав. Би бол “цүнхээл” гэж мэдэхээс биш “эргүүлэг” гэж мэдэхгүй учир:

- Манай нутагт л тийм юм байхгүй гэж хэллээ.
- Жижиг гол усанд байдаггүй юм гэж хэлээд Чойдог багш маань цааш ярилаа.
- Зүгээр тунгалагхан урсаж байсан голын ус зарим газар урсаж чадахгүй тогтчихоод шавар элстэй элдэв бохир хутгалдаж, эргэлддэг газрыг усны эргүүлэг гэдэг юм. Манай сургууль энэ намар нэг хэсэгтээ тэр бохир эргүүлгэд орчихсон юм шиг өлсгөлөн, хулгай зэлгий, өвчин зовлонтой хутгалдаж бужигналаа. Одооноос аюулт эргүүлэгнээс гарах гэж байна. Дайн дуусаж, сургууль эмнэлэг, юм бүхэн тохижиж, тэр булингартай эргүүлэгнээс бүрмөсөн гарах цаг мөдхөн ирнэ. Тэр цагт та нар жаргана. Том голд эргүүлэг заавал байдаг юм... гэв.


(товчлон аваа) П.Лувсанцэрэн. Усны эргүүлэг буюу Борзооны явдал. УБ., 1972 он

ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ

Өгүүллэгт цөөн хэдэн дүр гардаг бол туужид олон арван дүр гарна. Туужийн зохиогч дүрээ амьдруулахын тулд хэрэглэж буй аргуудыг танин мэдэхийн тулд туужийг бүрэн эхээр уншаарай.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Ямар ямар дүр гарч байна вэ? Жагсаан бичээд, дүрүүдийн холбоо хамаарлыг бүрдүүвчээр үзүүлнэ үү.



2. Хашбатын хэлж байгаа үг, бодож байгаа бодол, хийж байгаа үйлдлийг ялгаж бичээд, түүний талаар төрсөн анхны сэтгэгдлээ илэрхийлэн бич. Өөрийн үзэл бодлыг дэмжихдээ өгүүллэгээс эшлэл авч нотлоорой.

Дүр	Бодол	Үг	Үйлдэл
Хашбат			Худал хэлсэн
	Буруутан нь би боллоо	... миний буруу...	Гэмшсэн
	...хулгайчийг барьж шүүхэд өгөх юм сан...		Үнэнээ хүлээсэн
			Хулгайчийг барихаар амласан
			Хулгайчийг барих манаанд гарсан

3. Хашбатын талаар бусад дүр юу гэж бодож, юу гэж ярьж байна вэ?

Хэн	Хашбатын тухай
Цэвэгдорж багш	"Чиний ярьж байгаа цөм үнэн... би чамд итгэж байна"

ЗӨВЛӨМЖ

► Туульсын үйл явдалд дүрүүд хоорондоо хэрхэн холбогдож байгааг зураглан үзүүлэх замаар гол дүр, туслах дүр, сөрөг дүрийг ялган таних буюу дүрүүдийн холбоо хамаарлыг тайлбарлана. Гол дүрийн зорилго тэмүүлэл, үг хэл, бодол санаа, үйлдлийг шинжлэх замаар дүрийн өсөлт, өөрчлөлтийг тодорхойлно.

4. Хашбатыг багш нар буруутгаж байна уу? Та нар Хашбатын оронд өөрийгөө тавиад төсөөлнө үү. Та түүний дуу хоолойг сонсож, мэдэрч байна уу?
5. Зохиолч Хашбатын дүрээр дамжуулж, юуг хэлэхийг хүссэн юм бол? Хүүрнэн өгүүлэгчийн дуу хоолойг баталж бичээрэй.
6. Энэ хэрэг явдлаас Хашбат юуг ойлгож ухаарсан бэ? Зохиолчийн сонгон хэрэглэсэн үг хэллэг, бичил дүрслэлийн нөлөөг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар

7. Зохиолын эхэнд байсан Хашбат зохиолын төгсгөлд хэрхэн өөрчлөгдсөн бэ? Дүрийн өсөлтийг тодорхойлно уу. Уг дүрийн талаарх сэтгэгдлээ илэрхийлэн бичнэ үү. Өмнө тодруулсан хэсгээсээ нотлох эшлэлийг авч хэрэглээрэй. Эшлэл авахдаа эшлэлийн хашилт тэмдгийг хэрэглээрэй.



НОМ УНШЛАГАД ХӨТЛӨХҮЙ




УСНЫ ЭРГҮҮЛЭГ БА БОРЗООНЫ ЯВДАЛ

Зохиогч: П.Лувсанцэрэн

Эрхлэн гаргасан газар: Артсофт ХХК

Огноо: 2013



МОНГОЛЫН ӨГҮҮЛЛЭГ ТУУЖИЙН ДЭЭЖ-1

Эмхэтгэсэн: Д.Батбаяр, Л.Дашням

Редактор: У.Бямбаням, Д.Нямдорж

Эрхлэн гаргасан газар: "Монсудар"
хэвлэлийн газар

Эрхлэн гаргасан огноо: 2015

ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖ

ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХЭД ТУСЛАХ НЬ

Хүүрнэл зохиолын бичвэрийг задлан шинжлэх нь зохиолд янз бүрийн үүрэг зорилгоор хэрэглэгдэж байгаа бүрэлдэхүүн хэсгүүдийг бүхэл дунд нь задлан шинжлэх мөртлөө уялдаа холбоонд нь авч үзэх оюуны үйлдэл юм. Чингэхдээ уран сайхны мэдрэмжтэй салшгүй холбон үзэх шаардлагатай бөгөөд чухам энэ шинж нь уран зохиолын судлан шинжлэх аргын онцлог болно.

Бүрэлдэхүүн хэсгүүд	Товч	Мэдлэг бүтээхэд туслах асуултууд
Өгүүлэгдэхүүн	Зохиолд үзүүлж байгаа хэрэг явдлын учир зүйн дараалал юм.	Зохиолыг хэрхэн эхэлсэн бэ? Өгүүлэгдэхүүнээ хэрхэн хөгжүүлсэн бэ? Үндсэн сэдвээ хэрхэн гаргасан бэ?
Орчин	Орчин нь зохиолын хэрэг явдал болж буй орон болоод цагийн хамаатай ойлголт юм.	Дүрүүдээ яаж оруулж ирэн, яаж хөгжүүлсэн бэ? Орчныг яаж тохируулсан бэ? Уур амьсгалыг яаж дамжуулсан бэ?
Дүр	Дүр гэдэг нь зохиолын өгүүлэгдэхүүний гол зангилааг тээж явдаг хүн, түүний төлөөлөл юм.	Нэг ба гуравдугаар биеийн хүүрнэгчийг хэрхэн хэрэглэсэн бэ? Хэрэг явдлыг хэрхэн дараалсан бэ? Зохиолыг хэрхэн төгсгөсөн бэ?
Сэдэв	Сэдэв гэдэг нь зохиолд дэвшүүлсэн үзэл баримтлал буюу шууд өгүүлсэн утга санаатай холбогдоно.	Зохиолч зохиолын үйл явдлыг хэрхэн өрнүүлж байна вэ? Шинэ дүр нэмэх аргаар үйл явдлыг өрнүүлж байна уу? Аль эсвэл орон, цагийг өөрчлөх аргаар өрнүүлж байна уу?

Өөрийн үнэлгээ

(Эх зохиолын тэмдэглэл хөтлөх чадвар)

- Тулгуур зураглал, бүдүүвч, загвар зэргийг ашиглан, өөртөө зориулж зөв сайн товчилсон
- Тулгуур зураглал, янз бүрийн тэмдэглэгээ үл ашиглан өөрийн ойлгосноор товчилж тэмдэглэсэн
- Гол төлөв номын үг үсгийн дагууд нь хуулах хандлагатай, товчилж тэмдэглэсэн
- Өөрөө уншиж тэмдэглээгүй, нөхдийнхөө эх зохиолын тэмдэглэлээс хуулсан боловч хойшдоо өөрөө уншиж тэмдэглэл хөтөлж сурахаар төлөвлөж байгаа

№	Зохиогч	Зохиолын нэр	Өөрийн үнэлгээ			
			1	2	3	4
1						
2						

гэх зэргээр өөрийгөө шалгаж үнэлээрэй!

Сурагч та:

1. Эх зохиолоо үнэхээр гүйцэд уншиж, тэмдэглэлийг сайн хийжээ. Энэ бол чиний өөрийнхөө чадварыг хөгжүүлэхийн төлөө хийсэн маш чухал алхам шүү.
2. Тэмдэглэлийг хөтлөхдөө цаг заваа хэмнэхээс гадна мэдлэгээ эмхлэж цэгцлэх, зохиолоос чухал санаа, хэрэгтэй үг хэллэгийг тэмдэглэж авахыг хойшид чухалчлахыг зөвлөө.
3. Энэ тохиолдолд өөртөө санаа тавьж, бие даан сурах арга барилаа улам хөгжүүлэхийг хүсье.
4. Аливаа эх зохиолыг уншиж тэмдэглэхдээ зөвхөн багшид үзүүлж шалгуулан, дүн авахын тулд биш, харин өөртөө зориулан чин сэтгэлээсээ хандан хийж сураарай.

Дүгнэлт 3:

ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН

Аливаа зохиол бүтээлийн үйл явдал тодорхой шалтгаанаас үүдэн өрнөж, баатруудын нь хоорондын зөрчил хурцдан хурцадсаар оргилдоо хүрээд эргэж тайлагдах явцыг зохиолын өгүүлэгдэхүүн гэдэг. Зохиолын өгүүлэгдэхүүнд зохиолд гарч байгаа баатруудын хоорондын харьцаа хийгээд **зөрчил** чухал үүрэгтэй.

Зохиолын өгүүлэгдэхүүний нэгжийг ямар нэг үйл хөдөлгөөн гэж үзэж болох бөгөөд туульсын зохиолд **зангилаа, өрнөл, туйл, тайлал** заавал байдаг.

- Зохиолын үйл явдал өрнөх шалтгаан болж байгааг нь зохиолын **зангилаа** гэнэ.
- Зангилаанаас хойш үйл явдлын **өрнөл** болно.
- Өрнөл нь тодорхой нэгэн үед хүрээд зөрчлийнхөө оргилд хүрэхийг **туйл** гэнэ.
- Зөрчлийн туйл цаашдаа хэрхэн шийдэгдсэнийг **тайлал** гэнэ.

Эртний уран зохиолд зохиолын баатруудын үйл явдал нь гол байдаг бол орчин үеийн уран зохиолд дүрийн зан төрх нь эрхэм чухал байдаг. Өөрөөр хэлбэл, дүрүүдийн хэлэх үг, үйлдэх үйлдэл нь ялгарч байдаг гэсэн үг.

IV

БҮЛЭГ



Дөрөвдүгээр бүлэг. ХОШИН ЖҮЖИГ

4.1. Хошин шог үлгэр

Бадарчны үлгэрээс


Далан худалчийн үлгэрээс

4.2. Хошин жүжиг

Ч.Ойдов “Далан худалч” жүжгээс

ЗОРИЛГО:

Энэ бүлгийг судалснаар та монголын хошин үлгэр болон хошин жүжгийн бичвэрийг уншиж, хошигнол бүтээх аргад суралцана.



4.1. ХОШИН ШОГ ҮЛГЭР

Зальтай, ухаантай, газар газар явж, хал үзэж, дол цохисон бадарчингуудад тохиолдсон ортой, оргүй явдлаас эх авч, бадарчны үлгэрүүд зохиогддог. Бадарчны тухай эдгээр үлгэр нь Далан худалч Бэлэн Сэнгийн адал явдалт үлгэрүүдтэй нэгдэн хөгжжээ.

БАДАРЧНЫ ҮЛГЭРЭЭС

Бичвэр 1

ДАРХАН НОЁНТОЙ ЦЭЦ БУЛААЛДСАН НЬ



ҮГИЙН ТАЙЛБАР

Жишүүл

Бэлтгэл хангагч

Хув

Чих, бариулгүй тогоо


Дархан

1. Төмрөөр эд хийдэг уран хүн

2. Алба татвар төлөхгүй эрх дарх олгосон цол

Хиа

Засаг ноёд, хэргэм зэрэгтнийг даган үйлчилж явах доод тушаалтан, бараа бологч



Баадай их замд орж явсаар үдийн халуун болоход ихэд ядарсан тул замын хажууд түүдэг гал ноцоогоод, хув хар тогоондоо ус дүүргэн, цай буцалгаж суутал ноёны жишүүл бололтой нэг хиа хүрч ирээд:

- Ай муу бадарчин аа! Энэ замаар манай Дархан ноён морилж яваа тул бушуухан зам зайл хө гэсэнд Баадай:

- Танай ноён хэр зэргийн дархан бэ? гэж асуусанд нөгөө хиа уур нь хүрсэн бололтой:

- Ямар ч байсан эзэн хаанаас Дархан цол шагнагдсан юм даа хөө! Чи яах нь вэ? гэсэнд Баадай:

- Танай ноён тийм дориун дархан юм бол түүгээр чинь муу хар тогоогоо хадуулья даа! гэсэнд хиа уурлан:

- Муу тэнэг минь олон үг донгосолгүй зам зайл!:

- Хөөе тэнэг ээ! Чамайг зайл гэж байна гээд таягаараа замыг нүдсэнд хиа тэсгэлгүй уурлан:

- За чи гайгүй ингээд л новширч бай. Ноёнд айлтгаад толгойг чинь авхуулна даа гээд буцан харайлгасанд Баадай:

- Хөөе, танай тэр ноён чинь толгойгүй юм уу? Миний муу зэнтгэр толгой таарахгүй биз дээ гэж айлтгаарай л даа хэмээн хойноос нь хашхирчээ.

Удсангүй ноёнтон бараа бологчдоо дагуулан хүрч ирэхэд Баадай зам дээр нь хөндлөн гулд суугаад том хар аягандаа цай дүүргэн суусанд ноёнтон гайхан хараад

- “Үүний аягыг хараач та нар, худаг шиг” гэж доромжлон хэлсэнд Баадай

- Энэ ноёны худаг нь миний аяга шиг байгаа юм чинь адуу нь зурам шиг юм байдаг байх даа гэжээ...

(Монгол ардын хошин шог үлгэр. ШУАХЗХ., УБ., 1984, 60-61 дэх тал)

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Үг хэлний хошигнол:

Хошигнол нь хэлний тусгай хэрэглээгээр үүсч бий болдог. Үүнд хэлний зүйг зориудаар гажуудуулсан үг хэллэг ба үгийн тоглоом зэрэг орно. Жишээ нь: Бадарчны үлгэр дэх

► ...Зам зайл гэхэд
“Замаа чамайг зайл
гэж байна” гэх буюу
“ноёнд ам гарлаа”
гэхэд “ноёнд ам
гараа юу? Хуучин
амных нь хаана
гараа вэ?” гэх мэт.

Задлан шинжлэх асуулт, даалгавар:

1. “Дархан” гэдэг үгийн утгыг тайлбарлана уу.
 -
 -
 -
2. Үлгэрт “дархан” гэдэг үг орсноороо зохиолын утга санааг тодруулахад хэрхэн нөлөөлж байна вэ?
3. “Зам зайл”, “Толгой авах” зэрэг хэллэгийг хэрхэн ойлгож байгаагаа бичээд, Баадай эдгээр хэллэгийг хэрхэн гуйвуулсныг тайлбарлаарай.
4. “Айлтгаарай”, “Морилох” зэрэг үгсийн найруулгын зэргийг тодорхойлоод, ерийн найруулгын үгээр солино уу.
5. Хиагийн зан чанарыг ямар үгсээр илэрхийлсэн байна вэ? Дээрэнгүй зан чанар ямар үр дагавар авчирч байна вэ? Чиний эргэн тойронд ийм явдал тохиолдож байсан уу?
6. Баадай хаана, юу хийгээд сууж байв? Энэ нь дархан ноёны явах замд саад болох уу?
7. Баадай, хиа хоёрын яриаг инээдэмтэй болгож байгаа гол зүйл нь юу байна вэ?
8. Өнөөгийн нийгэмд энэхүү ноёны жишүүл хятай адил төсөөтэй ажил үүргийн хуваарь байна уу? Харьцуулан ярилцана уу.
9. Баадайн анхны байсан орчинг дараагийнхтай харьцуулж яагаад ингэх болсон шалтгааныг тайлбарлаарай.
10. “Аяга нь худаг шиг” гэсний хариуд хэлсэн “Худаг нь аяга шиг” гэснээс уран дүрслэлийн ямар хэв маяг харагдаж байна вэ?
11. Ноёны доромжлолд дургүйлхсэнээ лавшруулан хэлсэн эшлэлийг бичээд, найруулга зүйн ямар хэв маяг болохыг тодорхойлоорой.
12. Ноёнтонг мад тавиулсан байдлаар харилцан яриа нэмж, үлгэрийг цааш үргэлжлүүлэн зохиогоорой.

ДАЛАН ХУДАЛЧИЙН ҮЛГЭРЭЭС...

Монгол ардын хошин шог үлгэрийн хамгийн нөлөө бүхий баатар нь Далан худалч юм. Далан худалч нь хаад ноёдын эсрэг хурц оюун билгээрээ тэмцэж чадсан ардын баатрын дүр юм.

УНШИХЫН ӨМНӨ

► Далан гэсэн үг орсон хэлц үг олж, утгыг нь тайлбарлаарай.

-Далан**давхар**.....

-Далан

-Далан

-Далан

-Далан

-Далан

Бичвэр 1

ЧУЛУУН ХАХУУЛЬ



ҮГИЙН ТАЙЛБАР

Ембүү

Алт мөнгийг тусгай хэвд цутган хийсэн нэг зүйлийн цул зоос

Зарга

Харилцан заалдаж тэмцсэн тэмцэл

Ганзага

Эмээлийн хавтасны өмнө хойдод бэхлэн унжуулсан нарийн сур

Жинс

Манжийн үед төр, шашны хэргэмтнүүдийн малгайн оройд зэрэг хэргэмийн ялгаагаар хаддаг байсан эрдэнийн чулуу, сампин

Отго

Ноёд түшмэдийн зэрэг хэргэм, цол тушаалыг ялгасан ёслолын малгайд зүүдэг тогосын өд

Гувчуур

Биет зүйлээр авдаг албан татвар

Хэлтрүүлэх

Аюул зовлонгоос ангижруулах, зайлуулах



Манай танил Маамуу чавганц надтай уулзаад ийн өгүүлрүүн:

- Магсар тайж манай охиныг хүүдээ авч өгнө гэхээр нь “Мангуу тэнэг хүүтэй чинь хүүхнээ суулгаж, мал болгодог хүн хэн байх вэ дээ” гээд хэлчихсэн чинь Магсар тайж өс хонзон өвөрлөж, хошууны өмнөөс Даашинхүүгийн өрд төлөх таван жороо морийг тавин лангийн ембүүтэй гаргаж төл гэлээ. Хэрэв төлж эс чадвал охиноо хүүд минь өгөөд, оронд нь түүнийгээ аргалуулж болно гэж намайг тулгасан юм. Би түүнийг чинь төлж чадахгүй гэж хошуу ноёнд зарга мэдүүлэх гэсэн чинь ноёнд нь атгуулдаг юмгүй болоод заргаа алдах гээд байна, яадаг билээ Сэнгээ минь гэж хэлэв. Түүнийг сонсоод би газраас хэсэг цагаан чулуу авч цаасанд боож, өвөртлөөд хошуу ноёныд нь очив.

Тавдан засгийн хошууны
Тамга захирагч ноён гуай
Танхай бардам зантай
Хууз хар сахалтай
Хулганан онигор нүдтэй
Хээл хахуульд дуртай
Хэнгэрэг бүдүүн гэдэстэй
Хэнхэг сүржин яриатай
Шунахай хар сэтгэлтэй

Шуламсын хувилгаан цолтой ийм нэгэн хүн байсан юм. Би шууд яваад ноёны өргөөнд ортол Тавдан засаг ноёнтон ийн өгүүлрүүн:

- Харц хүн байтлаа хамаагүй юунд ноёныд орж ирэв хө! Түшмэдэд айлтгаад хадаг бичиг барьж бараалхдаг ёсыг чи муу нохой дур мэдэн зөрчинө гэнээ! гэж ирээд л тасхийж гарав.

- Жа ноёнтон минь! гээд л дуугартал,

- Жа, жа гэнэ ээ чи. Жавжаар чинь шүлс бурахаас

өөр юу байна чамд, гар хө! гээд л ташуураа барихын хамт би гарч явлаа.

Гадаа гарч ганзаганаасаа дээлээ гаргаж өмсөөд, хүрэн жинс, хүж отго зүүгээд, түшмэд дээр нь очиж:

- Баян Сэнгээ гэгч бараалхахаар ирснийг айлтгах ажаамуу гэж дамжуултал ноёнтон гуай бушуу оруул гэж айлдсан ажээ. Би ноёныд дахин орохдоо ийн өгүүлрүүн:

- Ноёнтон амгалан айлдаж байна уу? Лагшин чинь тунгалаг уу? гэж нахилзан мэндлээд
- Эрхэм ноёнтон соёрхоно уу? Би танай хошууны Цэ баяны хүү, Дайчин вангийн Да ноёны хүргэн, Шанзавын яамны түшмэл, их шавийн Сэнгээ гэгч байна. Та намайг танихгүй байж ч магадгүй, эрхэм ноёнтонг эрдэмтэй, ухаантай, энэрэнгүй сэтгэлтэй гэж манай Шанзавын яамныхан ярилцдаг юм. Тэгээд би танд бараалхан ирж, далимд нь нэг өчүүхэн бага зүйл мэдүүлэхээр ирсэн юм сан гэхэд:

- Ээ лам гурван эрдэнэ минь! Шанзавын яамны түшмэл минь дээшээ морил, дээшээ морил гээд л бөндөгнөж гарлаа.

- Манай эгч Маамуу эмгэн танай хошуунд байдаг юм. Тэгээд би эгчдээ золгохоор ирээд танд бас золгоё гэж ирсэн юм гэхэд,

- Ээ! сахиус минь! Маамуу чавганц чинь таны эгч юм бий. Мөн ч ухаантай, уужим сэтгэлтэй эмгэн шүү. Түшмэд гуай зоогло, зоогло! гэж байна.

- Эрхэм ноёнтонд айлтгалтай ирсэн юм сан. Таныг эрхбиш бүтээж өгөх болов уу гэж горьдож байнам гээд, өнөөх цаасанд боодолтой чулуугаа хадагтай хамт барьтал ноёнтон ихэд баярлан инээмсэглэж,

- Болно! Болно! Бүтээж өгье! Танай хадам эцэг Да ноён даанч сайн хүн шүү дээ гэж хэлээд л нахилзаж гарлаа.

- Манай эгч Маамуу чавганц танай хошуунд амьдардаг юм аа. Тэгээд түүнд таван жороо морь, тавин лангийн мөнгөтэй гувчуур оноосон юм байхаа! Тэгтэл тэр эмгэнд жороо морь байтугай тараг идэх үнээгүй юмсан. Ингэхлээр та үүнийг нэг хэлтрүүлж өршөөнө үү? гэсэнд ноёнтон сонсоод:

- Болно! Болно гэж хэлээд, түшмэдээ дуудаж ийн өгүүлрүүн:

- Магсарын отгийн Маамуу чавганцад оногдсон таван жороо морь, тавин лангийн мөнгийг зүй бус оногдуулсан учир бүрмөсөн тайлсугай гэсэн зарлиг хийж өг! гэж тушаав.

- Ухаантай хүн гэдэг бас өөр юм даа, ноёнтон минь! Танай Магсар тайж чинь сүрхий бялдууч хүн юм байна шүү гэхэд

- Ээ! Их түшмэл минь өршөөгөөрэй! Тэр золиг тийм тэнэг хүн байгаа юм. Очиж очиж эрхэм түшмэлийн эгчид алба оноож байхыг нь харав уу. Чамайг даа! Би нэг чадъя даа гээд л салгалж, савсганаж гарав. Удсангүй түшмэл нь надад өнөөх зарлигийн бичгийг гардуулан барив. Тэгээд би явахаар болж,

- Эрхэм ноёнтон танд тун их баярлав. Ухаантай хүн гэдэг ийм байдаг юм байна. Манай Шанзавын яамныхан таныг магтдаг нь аргагүй юм байна гэж хэлэхэд:

- Эрхэм түшмэд минь, Да ноёны хүргэн минь өршөөгөөрэй. Таныг би хэзээ ч мартахгүй гэж нахилзан нахилзсаар намайг үдэж мордуулав.

Би тэндээс явж хувцсаа тайлж ганзагалаад, хуучин хувцсаа өмсөөд, Маамуу чавганцад өнөөх зарлигийг өгөөд, үүнээс хойш ямар ч гувчуур төлөхөө байсан гэж хэлэв. Би ч буцав.

Орой нь нөгөө ноёнтон нөгөө цаасанд боодолтой юмаа аваад “Лав зуун лан байсан байх аа” гээд задалтал хоёр хэсэг цагаан чулуу байхыг үзээд

- Манай Да ноёны хүргэн арай ингэхээр хүн бишсэн гэж хэлээд, амаа барихад хажуунаас нь түшмэд нь:

- Сайн мөнгө заримдаа чулуу болчихдог ёсон байдаг гэнэ билээ! Хээл хахуульд хэт шунавал хээрийн чулуу ч үмхэж болно шүү ноёнтон минь! гэж хэлсэн гэдэг.

(Монгол ардын хошин шог үлгэр. ШУАХЗХ., УБ., 1984, 79-81 дэх тал)

ҮЛГЭРИЙН УТГА САНААГ БҮРДҮҮЛЭХИЙН ТУЛД СЭДВИЙГ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛСНИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ

ЗӨВЛӨМЖ

► Хүүхдүүд ээ!
“Дараагийн хүнийг
ярианд урих арга”-
ыг хэрэглэж, задлан
шинжлэх даалгаврыг
ажиллаарай. Багш
эхний асуултыг
аль нэг багийн нэг
сурагчид тавина.
Асуултад хариулсан
сурагч мөн л аль
нэг багийн хэн нэг
сурагчид асуултаа
тавьж, хариултаа
аваарай.

Задлан шинжлэх асуулт даалгавар

1. Мөнгө, татвар, засаг захиргаа, зэрэг дэвийн утга бүхий үгсийг түүж бичээд, түүхийг тодруулаарай.
2. Зохиолоос засаг захиргаа, зэрэг дэвийн утга бүхий үгсийг түүж бичээд түүхийг тодруулаарай.
3. Маамуу чавганцад оногдуулсан алба зүй ёсных байсан уу? Өнөөгийн нийгмийн алба татварын талаар хоёр жишээ гаргаж харьцуулна уу.
4. Маамуу чавганцын охиныг хүүтэйгээ гэрлүүлэхийн тулд Магсар тайж ямар арга хэрэглэсэн бэ? Иймэрхүү оролдлого мөнгөтэй, эрх мэдэлтэй хүнд хэвийн зүйл үү?
5. Баячуул болоод хүчтэний эрх мэдэлтэй шууд тулгарахгүйн тулд Сэнгээ ямар арга замыг сонгосон бэ?
6. Бэлэн Сэнгийн чулуун хахуулийн хохирогч нь хэн бэ? Нийгмийн аль хүрээллийг хамрах вэ?
7. Болсон үйл явдал хийгээд түшмэдийн үг ноётонд зан суртахууны ямар сургамж болов?
8. Далан худалчийн үлгэрт хошуу ноёны дүрийг шог хошин болгоход ямар арга хэрэглэсэн бэ?
9. Далан худалчийн дүрийг эерэг болгоход ямар арга хэрэглэснийг ажиглаарай.
10. Тавдан засаг ноёны үнэн нүүр царайг илчлэхэд тусалж байгаа дүрийг тодруулаад өнөөгийн нийгэм дэх түшмэдийн дүрийг төсөөлөөрэй.

Бичвэр 2

УДГАН МОДОНД ХҮЛҮҮЛЖ, УЖИГ ӨВЧНӨӨ ЭДГЭЭСЭН НЬ

...Заяа муут далан худалч

Заргаа алдсан бэлэн Сэнгээ

Захын модонд хүлээтэй үлдэж

Задгай хээр байхдаа гээд дуулж байтал Далай ван ноёны шадар түшмэл салга Батмөнх гуай сайвар морио унасаар ирэхэд нь

...Ба ноён минь өршөөгөөрэй. Барлаг зарц би чинь ууц нурууны ужиг өвчинд баригдаад, удаан жил хэвтэрт байсан хүн юм сан.Эм дом элдэв дээдээр аргалаад эдгээгүй юм сан. ...Энэ удган модноос хүлүүлбэл эмгэг хууч чинь эдгэнэ гэлээ. Тэгээд модноос хүлүүлсэн чинь хоногийн дотор эдгэж сайхан болоод “Хорвоогийн сайныг үзлээ” баярлаж сууна даа...

Батбаатар Х. Монгол ардын үлгэр.,УБ., 2006., 408 дахь тал/

УЛИАСТАЙН АМБАНД ҮЛГЭР ЯРИВ

Тээр жил могой жилийн шинийн нэгэнд Дархан чин ван “Ванжил” агсны нэрийн өмнөөс Улиастай хотын амбанд сар шинийн мэнд хүргэхээр миний бие зарагдан явж билээ.

...Амбан ноёнтон намайг “Амттай сайхан үлгэр ярьж өг, ам дүүрэн инээцгээе, бахтай сайхан үлгэр ярьж өг, багалзуураа хөштөл инээцгээе” гэж шахалзуулав.

- За тэгвэл амбан ноён унтахгүй, уурлахгүй бол би үлгэрээ ярьа л даа. Далан худалч болсон хойно дандаа худал юм ярина гэдгийг амбан та соёрхоно биз гэхэд дандаа худал тусмаа л сайн гэж хэлэв.

Өгүүлэх нь:

Эрт урьдын нэгэн цагт би

Эзэн хааныг ширээнд суугаагүй байхад

Дайван хааныг балчир байхад

Далай ламыг банди байхад

Өөрийн аавыг гараагүй байхад

Өвгөн аавын тэмээг хариулаад

Өргөн говьд тэнэж явлаа... гээд үлгэрээ эхэлтэл

- Эцгийн чинь тархи, юуны чинь өөрийн аавыг гараагүй байхад өвгөн аавын тэмээг хариулах вэ? гэж амбан хэлэв.

Өөрийн гүрнийг тогтоогүй байхад

Өвгөн Манжийн хаанд алба залгадаг

Өчүүхэн монгол орныг зүйрлэвэл

Өөрийн аавыг гараагүй байхад

Өвгөн аавын тэмээг хариулахтай адил юм гэж монголчууд бид ярьдаг юм аа, амбан минь гэхэд:

- Тийм ч байж болно, үгүй ч байж болно, цааш нь ярь гэв.

Өвгөн аавын өндөр хүрэгч ингэ

Өглөө нь шилрээд орой нь ботголов.

Тэгэхээр нь эхийг нь унаад

Ботгыг нь дүүрээд явах гэсэн даасангүй.

Тэгэхээр нь би ботгыг нь унаад

Эхийг нь дүүрээд явсан чинь

Дэнхэн данхан гээд явахчаан боллоо гэтэл,

- Ээ элэнцэг чинь...Эх нь даагаагүй юмыг ботго нь даагаад явна гэнээ хө гэж амбан дуу алдав.

Эрхэм дээд амбан минь ээ!

Энэ чинь аргагүй шүү дээ

Өчүүхэн бага халх монгол

Өдий төдий сая хүн амтай


Манж Чин улсын

Албыг залгуулж, аяыг дагуулж

Аль дутсаныг нь хангаж байгааг

Зүйрлэн үзвэл ботгыг нь унаад

Эхийг нь дүүрээд явахтай адил хэрэг биш үү? гэхэд:



Амбан

Манжийн төрөөс Монголд суулгаж байсан төлөөний сайд, элчин сайд

- Цааш нь ярь гэв.

За тэгээд эхийг нь дүүрээд, ботгыг нь унаад
Дэнж дээгүүр явсан чинь дэнж бас даасангүй
Тэгэхээр нь дэрсэн толгой дээгүүр явсан чинь
Дэгэн догон гээд явахчаан боллоо гэхэд:

- Далан худалч аа, арай дэндэж байгаа юм биш үү?
Дэнж даагаагүй юмыг дэрсэн толгой даана гэнэ ээ гэхэд:
- Тийм ээ, амбан минь дэндэж байгаа юм...

(Монгол ардын хошин шог үлгэр. ШУАХЗХ., УБ.,
1984, 83-85 дахь тал)

ҮЛГЭРИЙН ХОШИГНОЛ БҮТЭЭХ АРГЫГ СУДЛАХ



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Учир зүйн хошигнол:

- Учир зүйн дарааллыг зориуд эвдэх нь хошигнол үүсгэж байгаа нэг хэлбэр юм. Жишээ нь: Далан худалчийн үлгэрт “Ботгыг нь дүүрээд эхийг нь унаад явтал даасангүй. Харин эхийг нь дүүрээд ботгыг нь унаад явтал дажгүй даалаа” гэх мэтээр гардаг.

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. “Хэзээ”, “хэдийд?” гэсэн асуултад хариулагдах цаг хугацааны утгатай үгсийг эхээс олж бичээрэй.
2. Амбаны хэлж байгаа “Эцгийн чинь тархи”, “элэнцэг чинь” гэх мэт үгс ямар утгатай вэ? Ямар үгсийн санд хамаарах вэ? Амбаны хэлсэн дээрх үгс нь түүний талаар бидэнд ямар мэдээлэл өгч байна вэ?
3. Бичвэрүүдээс Далан худалчийн дүрийг тодруулахад онцгой үүрэгтэй хэсгүүдийг ол.
4. Сэнгээгийн амбанд үлгэр ярихдаа ашигласан үг хэл, хэллэгүүдийг тодруулаад хэр уран сайхны үнэ цэнтэйг тодорхойлоорой.
5. Үлгэр дэх тонгоруу дүрслэл Далан худалчийн дүрийг эерэг, сөрөг болгоход нөлөөлж байгааг дүгнээрэй.
6. Амбаныг Сэнгээгийн ярьсан үлгэрийг тасалдуулах бүрт адилтгалаар гарч ирж байгаа ямар санаа байна вэ?
7. “Арай дэндэж байгаа юм биш үү?” гэж амбаны дуу алдахад Сэнгээгийн хэлсэн “дэндэж байгаа юм...” гэсэн хариулыг та нар хэрхэн ойлгож байна вэ? Энэ нь зохиолын санааг хэрхэн тодруулж байна вэ.
8. Өнөө үед баячуул болоод хүчтэний эрх мэдэлтэй тулгарвал Далан худалчийн адил заль ухаан хэрэглэх шаардлагатай юу?
9. Иргэд хоорондын сайн сайхан харилцааг буй болгохын тулд таны бодлоор ямар үнэт зүйлийг хөгжүүлэх хэрэгтэй вэ?

ҮНЭЛГЭЭ

Өөрийгөө үнэлэх даалгавар:

30 онооны дасгал бүхий өөрийгөө үнэлэх даалгаврыг гүйцэтгээд, ардын хошин үлгэрийн онцлог, хошигнол бүтээх аргуудын талаарх ойлголтоо бататгацгаая.

1. “Улиастайн амбанд үлгэр яриу” үлгэр дэх нөхцөл байдлын хошигнолыг олж тайлбарлаарай. (2 оноо)
2. Сэнгээгийн хэлсэн дүрслэлийг дараах бүдүүвчийн дагуу тонгоргоно уу. (2 оноо)

... Танхай бардам зантай	Зан нь танхай
Хууз хар сахалтай	
Хулганан онигор нүдтэй	
Хээл хахуульд дуртай	
Хэнгэрэг бүдүүн гэдэстэй	
Хэнхэг сүржин яриатай	
Шунахай хар сэтгэлтэй	
Шуламсын хувилгаан цолтой	

3. Үнэн бөгөөд хатуу үг хэлсэн түшмэдийн үг ноётонд хэрхэн туссан бол... Таамаглал бичээрэй. (2 оноо)
4. Сэнгээгийн хэлсэн дүрслэлийн тусламжтайгаар түшмэлийн хөрөг дүрийг тодруул. (2 оноо)
5. Түшмэл Сэнгээ хоёрын ярианд гарч байгаа биеийн төлөөний үгийг олж, харилцан солигдох үндсийг тайлбарлана уу. (3 оноо)
6. Ба ноёны “Сэнгээ баян”-ы сүр хүч, алдар нэрээс нь сүрдсэн байдлыг үлгэрт ямар үг, үйлдлээр илэрхийлсэн байна вэ? (2 оноо)
7. Сэнгээгийн дээлээ сольж ирэхээс өмнөх ба дээлээ сольсны дараа түшмэлийн гаргасан ая занг харьцуулахад чамд ямар мэдрэмж төрж байна вэ? (2 оноо)
8. Амбаны “ам дүүрэн инээх, багалзуураа хөштөл инээх” хүслийг нь боогдуулсан Далан худалчийн үг хошигнол бүтээх ямар арга вэ? (3 оноо)
9. Дээрх гурван үлгэрт гарч байгаа дүрүүдийн зан төрхийн хошигнолыг жишээгээр баталж гаргацгаая. (4 оноо)

Дүрүүд	Алиалж марзганаж хошигнол бий болгож байгаа	Гэнэн тэнгээрээ хүний инээдийг хүргэж байгаа
Баадай		
Ба ноён		
Бадарчин		
Амбан		
Хиа		
Далан худалч		

10. “Дархан ноёнтон цэц булаалдсан нь” үлгэрийн орчныг өөрчлөн, үйл явдлыг өрнүүлэн бичээрэй. (4 оноо)

4.2. ХОШИН ЖҮЖИГ

“Далан худалч” болон Бадарчны үлгэрийн уламжлалаас сэдэв авч бичсэн Ч.Ойдовын “Далан худалч” хэмээх 3 бүлэг, 5 үзэгдэлт хошин жүжиг нь монголын жүжгийн зохиолын санд шинэ үзэгдэл болсон юм.



Чойжамцын Ойдов
/1917-1963/

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутагт төржээ. Тэрээр “Ардын элч” кино болон “Алиа Тогмид” хүүхэлдэйн жүжиг “Жаргалыг хүссэн Мөнхөө”, “Зам”, “Далан худалч” зэрэг 30 гаруй жүжиг бичжээ. 1947 онд Төрийн шагнал хүртсэн байна.

ДАЛАН ХУДАЛЧ

(Хошин жүжиг)

Тоглогчид нь:

Сэнгээ- Далан худалч
Алимаа- залуу сайхан
хүүхэн (Гэлэг өвгөний
төрсөн охин)

Хятад-баян худалдаачин
Пагма – Хүрээний авгай
Гэлэг- хуурч өвгөн
Давст-Гэлэгийн хүү
(багадаа төөрсөн)
Галдан – доод түшмэл

Жалбуу – лам

Намнан – цагдаа
Лам- Жалбуугийн
дагалдан

Бат-залуу хүү (ядуу)
Тунгалаг- Батын сэтгэлт
хүүхэн
Малгайч- худалдаачин
Бичээч- хятдын зарц
Баян- Амбаны
туршуулын хүн

Хэсэглэл 1

НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

Хүрээ зах зээлийн газар хятад маягийн томхон дэлгүүрийн үүдэнд хөл үймээн ихтэй ажээ. Хэсэг дуудварын худалдаачид цуглараад наймаа хийж байна. Тайзны баруун талд том асар хаалга харагдана. Хятад дэлгүүр хаалттай байв.

Давст: Холбоолжийн улаан давс, Холбоолжийн улаан давс аваад байгаарай.

Малгайч: Хилэн малгай, эсгий малгай, тоорцог, лоовууз аль дуртайгаа аваарай, Хүүе малгай ав.

Жалбуу: (Хэдэн ламтай уулзаж) Одоо заавал олдоно. Багш ламтан сая сор залахдаа Далан Худалчийг барьж авах гэж их даатгал хийсэн гэнэ.

... Бат: Олон түмэн юм хайрла! (Малгайчид ойртож) Юм хайрла!

Малгайч: (Ширүүнээр) юм байхгүй.

Бат: (Давстад очиж) Юм хайрла!

Давст: Ганцхан давс л байна шүү дээ.

Бат: Давс ч гэсэн яах вэ дээ, бас л хэрэгтэй шүү дээ.

Давст: Тэгвэл май май, ав ав. (*Том шанагаар хийж өгнө*).

Бат: (*Хүүдий тосч*) Арван цагаан буян чинь дэлгэрч яв, ах дүү нар олондоо хүндлэгдэж яв даа.

Давст: Нэмүүлнэ үү, дахиад авах уу?

Бат: Болно болно, энэ их давсаар яах вэ, давс амттай гэвч дангаар идэж болдоггүй, чихэр амттай гэвч жингээр идэж болдоггүй шүү.

Давст: (*Инээж*) Мэргэн зүйр үг байна даа.

(*Бат нэг юм харснаа яаран нуугдав*).

... Галдан: За хө, чи хэрэг чирэгдэл гарвал над дээр ирж байгаарай. (*Батыг харж*) Энэ муу мал шадар ноёны морины үнийг төлсөн үү?

Намнан: Үгүй. Тэгээд би сая олж аваад явж байна. Төлөх юм байхгүй гэнэ.

Галдан: Ясанд нь хүртэл банзад тэгвэл цөм өр гардаг юм.

Сэнгээ: Энэ муу амьтан хэчнээн өртэй юм бэ?

Галдан: Жороо морь төлөх учиртай юм, тавин лан мөнгө ч болно.

Сэнгээ: Тавин ланг нь би төлье, та суллах уу?

Галдан: Үгүй, та үнэн хэлж байна уу?

Сэнгээ: Үнэн, үнэн.

Галдан: Энэ ч уг нь ажлын хүчтэй залуу хүн шүү.

Сэнгээ: Ажил хийлгэе гэсэн хүн заавал мөнгө гарздаж худалдаж авахаар энэ зэргийн юмыг зах дээрээс ганцхан шөнийн хоолоор хөлслөхөд бишгүй нэг олдоно шүү дээ. Хүрээгээр дүүрэн ажилгүй ядуучууд байна. Би зүгээр багш ламтан маань таалал төгсчөөд... Хөөрхий багш маань амьддаа их нүгэл хийж явсан юм гэнэ. Тэгээд зовлонт амьтнуудыг аварч, буян хийж яваа юм.

Галдан: За яах вэ, өгчихье, харин наадхыгаа хүрээнд байлгаж болохгүй шүү.

Сэнгээ: Мэдлээ, мэдлээ. Би үүнийг чинь аваад хөдөө гарна, май мөнгөө.

Наадхыгаа сулла.

Галдан: (*Намнанд*) Сулла. (*Мөнгийг авч*) Энэ чинь арай хуурамч юм биш биз дээ.

Сэнгээ: Хаанаас даа үз л дээ.

Галдан: Лав тавин лан мөн биз дээ.

Сэнгээ: Дэнслээд хар л даа

Галдан: За за, яах вэ, боллоо.

Сэнгээ: (*Батад*) Яв тэнд намайг хүлээж бай.

... Зарц: Манжийн төрийг муулсан тэрслүү боол бэлэн Сэнгээг барьж өгсөн хүнд нэг зуун лан мөнгө шагнаана аа. (*тийм зарлал наагаад одоход Намнан ирэв.*)

Намнан: Хувилгаан багшийгаа хувалз гэсэн хушуу ноёныгоо бирд гэсэн нүгэлт боол Майрамд Майрай гэгдэх Майжгий Лувсан, Сайрамд Сарай гэгдэх сайжгий Самбууг барьж өгсөн хүнд нэг зуун тавин лан мөнгө шагнаана. (*явав*)

Ойдов "Жүжгүүд" УБ, 1957, 194-195 дугаар тал

ЗОХИОЛЧИЙН ҮГ СОНГОЛТ, УРАН ДҮРСЛЭЛ /ЁГТЛОЛ, ЕГӨӨДӨЛ/ -ИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ДАЛД УТГЫГ ТАЙЛАН ТАЙЛБАРЛАХ

Ч.Ойдовын “Далан худалч” жүжгийн уран хурц хэллэг, найруулга нь манай жүжгийн зохиолын харилцан яриа боловсруулалтын бодит жишээ болсон билээ. Үүнийг задлан шинжилцгээе.

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Жүжгийн бичвэр:

- Тайзан дээр унших буюу тоглож үзүүлэхэд зориулсан бүтээлийг жүжиг гэнэ. Жүжгийн бичвэрт хэл яриа, горим гэсэн хоёр гол бүтэц байдаг.

Хэл яриа:

- Жүжигчдийн тайзан дээр ярьж хэлэх ёстой дүрүүдийн үг яриа

Горим:

- Жүжигчдийн тайзан дээр хэлж ярих ёсгүй зохиогчийн зүгээс үзэгдэл бүлгийг хуваах, жүжигчний хувцас чимэглэл, үйл хөдөлгөөн, дуу аялга, дохио зангаа зэргийг тодруулж заасан тэмдэглэл.

Задлан шинжлэх асуулт даалгавар:

1. Жүжгийн бичвэрээс утгыг мэдэхгүй үг хэллэгийг авч утгыг тайлбарлана уу.

Үг хэллэг	Тайлбар
Сор залах	Бурханы шашинтай дайсагнагчтай тэмцэн няцаагч догшдыг магтах, тарнийн хүчээр муу муухайг шингээж, цамын үед галд хаяж устган, муу муухайгаас салж буй санааг илэрхийлдэг шашны зан үйл.
Дуудвар	
Лан	Хүндийн хэмжээ, нэг лан нь арван цэнтэй тэнцдэг (37,3 грамм/)
Бирд	

2. Дээрх бичвэрийг жүжгийн зохиол болохыг та нар юугаар нь таньж байна вэ?
3. Тайзан дээр болж байгаа орон зай, цаг хугацааг чухам ямар хэллэгүүдээр илэрхийлж байна вэ?
4. Зохиолч хэрэг явдал болж байгаа орчны мэдээллийг хэрхэн өгсөн бэ? Эшлэл татаж тайлбарлана уу.
5. “Түүнд хэлээд яадаг юм бэ? (Хажуу тийш) Энэ золиг надаас түрүүлж очоод хэлчих вий дээ...” гэсэн эшлэл дэх налуу үсгээр бичсэн үг ямар үүрэгтэй орсон гэж бодож байна вэ?
6. Жүжгийн зохиолын хэсэглэлд (Үзэгчдэд) гэж бичсэн нь зохиолд ямар үүрэгтэй гэж та нар бодож байна вэ?
7. Жүжгийн зохиолын хэсэглэлд үг хэлний хошигнолыг хэрэглэсэн жишээ байна уу?
8. Жүжгийн хэсэглэл дэх харилцан яриа нь дүрийн зан төрхийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлаарай.

Хэсэглэл 2

ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ
(Сэнгээ бачимдан орж ирэв.)

...Алимаа: Та манайд ирэх хүн мөн гэж үү?

Сэнгээ: Тийм ээ, би.

Алимаа: Би таныг хөгшин настай хятад худалдаачин гэж бодсон.... Би таныг цонхоороо олон удаа харсан. Олон гуйлгачинд юм өгч байхыг чинь харсан. Өрөвдмөөр ялтныг худалдаж авч байхыг чинь харсан. Юм үүрсэн хоёр хүнд тусалж байхыг чинь харж, өчүүхэн ч болов зовлонгоо мартаж, элгээ хөштөл инээсэн.

...Сэнгээ: Би таны учрыг одоо л гадарлаж байна. Би бас өөрөө зовлонд учраад явна. (цонхоор харж) Харав уу? Энэ олон улс намайг эрж яваа юм. Намайг нуу. Би чамд заавал тусална. Чамайг хятад худалдаачинтай суулгах гэсэн биз.... Эхээсээ гуй. Сайн гуй. Уйлж унжиж байгаад гуй. Энэ сайхан залуу насаа эрэмдэг зэрэмдэг болсон хөгшин хятадтай өнгөрүүлэхээр үхсэн нь дээр гээд уйл.

Алимаа: Энэ гуйлт надад тусгүй. Энэ авгайн сэтгэлийг яасан ч хөдөлгөхгүй. Энэ бол миний эх биш. Та миний зовлонг бүрэн мэддэг ч болоосой.

(Бат, Тунгалаг хоёр ирэв.)

Тунгалаг: Таныг эрээд айл бүрийг нэгжиж байна шүү.

Сэнгээ: Тэр яах вэ? Би энд байна. Энэ хүүхдэд та хоёр тус бол. Хөдөө гадаа хаашаа ч явсан дагаад яв. Тэгээд чухам юу болж байгааг нь надад мэдэгдэж бай. Бас хуурч өвгөн, давс худалдагч хоёрт хэл. Найран дээр дууч, хуурч болоод очигдоно....

(Бат, Тунгалаг хоёр явав.)

Сэнгээ: Хэрвээ эс зөвшөөрвөл (чихэнд нь шивнэж) Одоохон ирлээ. Чи сэжиг битгий мэдэгд. Унтагч болоод сууж бай.

(Өөрөө бурхны ширээн доор нуугдав.)

(Алимаа унтагч болно.Пагма, Хятад хоёр ирэв.)

Пагма: Хүү минь унтаж байна уу? Сэр сэр.

... Алимаа: Хэрвээ бурхан мэргэдээс болно гэвэл би дуртай таны гэргий болно.

Пагма: Заавал гэсэр бурхан энэ тэр гэж яах вэ? Манай бурхан ч гэсэн гэсэрээс дутахгүй. Ээжийнх нь олон үе шүтэж ирсэн бурхан байгаа юм. ...

(Гурвуулаа мөргөнө.)

Пагма: Бурхан сахиус минь. Үр болох хоёр хүүхдэд минь өрх гэр болоход нь өлзий соёрхлоо хайрлаж, өнөө орой нэг тэмдэг хайрла.

Бурхан: Зуны дунд сарын шинийн таванд олдошгүй сайн өдөр бий. Тэр өдөр хүрээнд биш, хөдөө гэртээ гэрлүүлбэл буян хишиг, өлзий хутаг оршино.

Хятад: Ай, Энэ юу байна.

Пагма: Аа, амилсан сахиус минь! Зарлигийн чинь ёсоор больё.

Хятад: (бурханд учиргүй мөргөж) Бурхан чиний зарлигаар больё. (Алимаад)Бурхан, хүүхэн чиний үгээр больё. Бид хоёрын чухам заяа түлхэж аюулаас ингэж зайлуулж байна. Чи миний заяаны амраг мөн байжээ. Бид хоёр яасан ч удаан төөрсөөр одоо нэг уулзав.

...Галдан: Салга гэдэг чинь юу гэсэн үг вэ?

Давст: Утгасан давсаа осолдож асгахдаа өөрийгөө "салгалсан үхээр" гэхсэн юм даа.

Баян: Тэгээд гурван тэмээгээр нь торгохоос нааш миний гомдол тасрахгүй дээ.

Галдан: Тэмээ нь хаана байгаа юм бэ?

Намнан: Тэнд гурван ижилхэн цагаан халзан тэмээ бий.

Сэнгээ: Хүүе тэнд чинь бас миний гурван тэмээ бий шүү. Харин цагаан халзан биш, улаан халзан. Гайгүй будлиантахгүй биз. (Галданд) Багш ламтан минь зүс нийлүүлж авсан их хайртай тэмээнүүд юм. Тэгээд таалал төгссөнөөс нь хойш богдод барьчихсан юм. Энэ хүн чинь богдын тэмээчин шүү дээ. Задарсан хар тархи.

Баян: - Цагаан халзан тэмээнүүдийг яах вэ?

Сэнгээ: (Чангаар) Цагаан халзан биш ээ, улаан халзан тэмээнүүд байгаа юм. Улаан халзан, улаан халзан (Чихэнд нь хэлж байгаа болж хашхирна.)

Баян: Цагаан халзан бол би авна, улаан халзан бол чи ав.

Сэнгээ: Тэг тэг. Тийм шив дээ ноёнтоон.

Галдан: Тэг тэг .

Баян: - Алив үзье. (Бүгдээрээ очиж үзэе)

...Сэнгээ: Намайг далан худалч, худалч л гэдэг юм. Үнэндээ надад худал хэлсэн үг байхгүй, үнэн хэлдэг болохоор миний дайснууд тэгж байгаа юм. Харин би сая бол худал хэлсэн. Хувилгаан багшийн таалал төгссөн гэж, чиний цагаан халзан тэмээг улаан халзан гэж. Тэгсэн чинь ашгүй Батын тусламжаар таны тэмээ улаан халзан болчихсон байж шүү. (унээцгээнэ)

... Бат: Сэнгээ гуай улаан халзан тэмээ гэж чангаар хашхирч байхыг сонсоод надад хэлж байгаа үг гэдгийг мэдсэн л дээ. Тэгээд би тийм болгочихсон юм.

... Давст: Үгүй ээ. Сэнгээ гуай таны энэ их олон нэр Майрамд Майрай, Майжгий Лувсан, Сайрамд Сарай, Сайжгий Самбуу, Бэтэг Түндэв, Бэлэн Сэнгээ, Далан худалч, үгүй энэ нэр чинь бүгдээрээ таных гэж үү.

Сэнгээ: Бүгдээрээ минийх.

Давст: - (унээж) Би бүгдээрээ ондоо ондоо хүн юм байж гэж бодож байсан юм, яасан олон нэр вэ?

Сэнгээ: Юуны олон байх вэ, малын нэг муу баас хүртэл олон нэртэй байхад хүний хүү надад энэ зэрэг нэр олон биш ээ.

Давст: За байз малын баас чинь ямар ямар олон нэртэй билээ.

Сэнгээ: Учиргүй олон шүү дээ, өтгөн гарвал нэг янз, шингэн гарвал нэг янз, хатуугаараа аргал, түлэхээрээ түлээ, түлэгдсэн хойноо үнс.

Давст: (унээж) Та үнэн хэлж байна. Гэвч өөрийгөө аргал хорголтой зүйрлүүлж арай болохгүй.

Сэнгээ: Яагаад аргал чинь дулаан илчээрээ хэнийг ч ялгаагүй баясгана. Би аргал шиг мөртөө олон түмэндээ тустай хүн болох сон гэж боддог юм...

ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН БҮТЭЦ БА ЖҮЖГИЙН ҮЗЭГДЛИЙГ ТАЙЛБАРЛАХ

ЗӨВЛӨМЖ


*Дөрвөн баг болоорой.
Өмнө судалсан жүжгээс
нэг нэг үзэгдлийг
сонгон тайзан дээр
тавих бэлтгэл хий.
Тайзан дээр тавих
сонголт хийхэд
туслахын тулд юуны
өмнө эхлээд жүжгийг
маш анхааралтай
унших ёстой. Энэ нь
найруулагч хийгээд
жүжигчний хамгийн
анхны ажил юм.*

*Зохиогчийн тэмдэглэл
горим ба эх бичвэрээс
бид чухам юуг илрүүлж
болох вэ? Дараах
асуултад хариулна уу.*

- *Таны баатруудын дууны өнгө ямар байх вэ?*
- *Ямар дохио зангаа голчлох вэ?*
- *Хувцас нь ямар байх вэ? Чимэг зүүсгэл нь ямар байх вэ? Танд ямар нэгэн нэмэлт жижиг хэрэгсэл шаардлагатай юу?*
- *Ингээд дүрүүдээ хувааж аваад ангид тоглохын өмнө бэлтгэл хийж үгээ цээжилнэ үү.*

Задлан шинжлэх асуулт даалгавар:

1. Зохиол хэрхэн эхэлж байна вэ? Эхлэл хэсэгт гарч буй дүрүүдийг бичвэр тус бүрээр тоочно уу.
2. Хэн хэний хэлсэн үг, хийсэн үйлдлээс зөрчил үүсэж байна вэ? Үүнийг юу гэдэг вэ?
3. Зохиолын хэрэг явдал хэрхэн өрнөж байна вэ?
4. Бичвэр 2-ыг уншина уу. Өвгөн хуурч, давс худалдагч хоёрын дүрийг ямар зорилгоор оруулж ирсэн бэ? Нэрсийг нь бичиж хэнтэй холбоотой дүр болохыг тайлбарлана уу.
5. “Хэрвээ бурхан мэргэдээс болно гэвэл би дуртай таны гэргий болно” гэсэн Алимаагийн үг хэнийг юу хийлгэхэд хүргэсэн бэ?
6. Хурим болох газрыг “Бурхан” хаана гэж товлосон бэ? Энэ нь өгүүлэгдэхүүний бүтцийн аль хэсэгт нь байна вэ?
7. Бичвэр 3 дахь зөрчлийн эхлэл, шийдэл нь дүрийн үг ба үйлдлийн алинаар илэрч байна вэ?
8. Гэнэн тэнэгээрээ бусдын инээдийг хүргэж буй дүрүүдийг тоочоод, энэ нь өгүүлэгдэхүүний бүтцийн аль хэсэгт хамаарч буйг тодорхойлоорой.
9. “Сэнгээ гуай улаан халзан тэмээ гэж хаширч байхыг сонсоод надад хэлж байгаа үг гэдгийг мэдсэн л дээ” гэсэн Батын үг зөрчлийг шийдэхэд хэрхэн нөлөөлсөн бэ?
10. Хоёр бичвэр дэх хүний санаанд оромгүй гэнэтийн үйлдлийг хошигнол бүтээх ямар аргаар илэрхийлсэн бэ?
11. Дараах бүдүүвчийг хэрэглэн, тодорхойлолт бүтээгээрэй.



ДАЛАН ХУДАЛЧ
ДӨРӨВДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

Балар их ой байна. Сэнгээг шуудайд хийж өндөр модноос дүүжилжээ. Түүний зөвхөн толгой нь цухуйна. Дэргэд нь Галдан, Жалбуу нар байна.

Галдан: Ингээд үхэхийн муугаар тарчилж үх муу хог.

Жалбуу: Ингээд амар сайхандаа жаргаарай. *(Явцгаав)*...

Баян ирэв. Нэлээд согтуу явна.

Баян: Энд хүн дуулаад байсан биш үү, хаачдаг юм бэ?

Сэнгээ: Тэнгэр газар хоёрын хооронд мөн ч сайхан байна даа.

Баян: Юу гэнээ, та хаана байна,

Сэнгээ: Би энд байна даа.

Баян: Үгүй энэ чинь хүний дуу гараад байх, өөрөө хаана байгаа юм бэ?

Сэнгээ: Таны дээр, та тэнгэр өөд харвал намайг харна.

Баян: *(харж)* Үгүй ер нь энэ чинь яаж маяглаж байгаа хүн бэ?

Сэнгээ: Би маяглаагүй, биеэ эмнэж байгаа хүн

Баян: Ийм эмнэлэг байдаг юм гэж үү? *(инээж)* Та чинь хэн гэгч вэ?

Сэнгээ: Би бэтэг Түндэв гэдэг байна. Сүүдэр саа өвчнөөр олон жил өвдөж зовсон хүн юм сан. Эм дом, гүрэм ном олон зүйлээр аргалуулаад ер эдгээгүй

юм. Тэгээд нэг бурхан хүн энэ хайрхан модонд ингэж дүүжлүүлбэл зүгээр болно гэсэн юм. Ашгүй зүгээр болчих шиг боллоо.

Баян: Хүн бас сонин юм даа. Энэ хүн нээрээ эдгэж үү, үгүй юу, хүлээж байгаад үзье. Би ч гэсэн энэ өвчнөөсөө салчихвал аштай юу, үгүй хүн гуай та одоо болсон байлгүй дээ, буу л даа.

Сэнгээ: Та юунд ингэж яараад байгаа юм бэ?

Баян: Би ч гэсэн тан шиг өвчтэй юм, тэгээд нэг үзээд авъя гэж бодож байна.

Сэнгээ: Ээ за за, би бас л байзнамаар байна даа.

Баян: Би ч эдгэнэ гэдэгт ердөө итгэхгүй байна. Үгүй ер нь энэ хүн эдгэсэн болов уу үзэх юм сан.

Сэнгээ: Хүрээ амбан бас салга юм гэв үү?

Баян: Тийм ээ, бас салга.

Сэнгээ: Зайлуул, түүнд хэлэх юм сан, энд ийм аятай тустай мод байдаг гэж.

Баян: Түүнд хэлээд яадаг юм бэ? *(Хажуу тийш)* Энэ солиг надаас түрүүлж очоод хэлчих вий дээ.

Сэнгээ: Хэлэлгүй яах вэ, үгүй тэгээд эдгэсэн хойноо ийм тустай, ачтай юм зааж өгсөн хүнд баярлана даа.

Баян: Үгүй тэр чинь салгалдаггүй юм гэнэ лээ

Сэнгээ: Та сая салга өвчтэй гэж хэлсэн биш үү?

Баян: Тэр чинь ондоо хүн, амбан биш.

Сэнгээ: Аа тийм үү, бие бас сайхан болж байна даа.

Баян: Та одоо бас л болоогүй байна уу?

Сэнгээ: Болоогүй л байна.

Баян: Яасан уддаг юм бэ?

Сэнгээ: Та тун яараад байна уу даа.

Баян: Нээрэн яараад байна шүү.

Сэнгээ: За за, тэгвэл одоо намайг буулга. *(Баян буулгав)*

Сэнгээ нүүр амаа мурийлгаж атируулаад танигдахгүй байна...

Баян: *(Шуудайн боодлыг тайлж)* Таны нүүр ам чинь яагаад эдгэдэггүй юм бэ?
 Сэнгээ: Энэ бол төрөлхийн юм. Энэ хайрхан мод зуурдын өвчнийг анагааж чаддаг юм.
 Баян: Заавал ингэж гар хөлийг чинь хүлж хийдэг юм уу?
 Сэнгээ: Тэгэлгүй яах вэ? Энэ хүлэг, шуудай, цөм адистай юм.
 Баян: Бас хачин юм даа. *(Шуудайнаас гаргав)* Үгүй та чинь хэн билээ. Нэг л үзсэн хүн шиг
 Сэнгээ: Би бэтэг Түндэв, Та намайг үзсэн байлгүй дээ.
 Баян: Аа муу зальт Далан худалч биш үү чи...
 ...Сэнгээ: Хүний үнэргүй амьтан чи яах гэж тэдэнд хүн барьж өгдөг байсан бэ? *(улам зодно)*
 Баян: Ёо ёо болиоч намайг зодохоо *(уйлна)* Тэр ноён амбан чинь өдрийн гурван хүнийг барьж өгч бай, энэ хүрээгээр дүүрэн сэжигтэй боолчууд байна гээд амар заяа үзүүлдэггүй юм...
 Сэнгээ: Тэр олон хүнийг хилсээр зодуулж, алуулсны өшөөг би одоо авна даа...
(Баяныг шуудайд хийж өөрийнхөө орноос дүүжлэв)

Ойдов Ч. Жүжгүүд. Уб., 1957 он

Хэсэглэл 5

ТАВДУГААР ҮЗЭГДЭЛ *(Хятад, Пагма хоёр ирэв)*

Пагма: Зайл чи. Бушуухан манайхаас зайл.
 Сэнгээ: Энэ хэрэгт Пагма гуай та ч бас холбогдоно. Би үнэнийг хэлнэ.
 Хятад: Тийм тийм. Пагма бас хийсэн.
 Пагма: Надад яагаад хамаа байдаг юм бэ?
 Сэнгээ: Хэргийн уурхай нь тан дээр байна. Та яагаад ял эдэлбэл зохих хүнийг нууж дарж байгаад, сүүлд нь худалдах гэсэн юм бэ? Энэ хэргээс чинь болоод Богд гэгээний ойр ураг, ойрхон ураг нь шүү сайн бод. Бас Амбан яамны далд туршуулын хүн энэ хоёрын амь үрэгдсэн байхад холбогдох хүн бүрийн толгойг авна даа, харж байгаарай.
 Пагма: Гэгээн минь нээрэн тэгнэ дээ. Би бас оргох хэрэг үү? Бүсгүй хүн богино жолоотой. Ганц би хаашаа явах вэ?
 Хятад: Ай, Сэнгээ бид хоёр танил бол танил, нөхөр бол нөхөр, хоршоо бол хоршоо, чи надад арга зааж аль, би одоо яах вэ?
 Сэнгээ: Ганц мод гал болдоггүй, ганц хүн айл болдоггүй. Чи Пагмыг аваад яв. Замаасаа ганц илжиг худалдаж аваад, Пагматай яваад байхад та хоёрыг хэн ч сэжиглэхгүй. Нэг ядарсан луухаан авгайтайгаа явна гээд л явуулаад байна.
 Хятад: Тэр ч бас мөн ухаан байна. Хэрэв Пагма надтай явахгүй бол...
 Сэнгээ: Пагма гуай та Далайтай яв, та хоёр лав таарна. Тийм үү Далай.
 Хятад: Би бодвол таарна.
 Пагма: Юу таарна гэж?
 Хятад: Хамт явахад, тэгээд амь зуухад.
 Пагма: Тэгвэл ч би дуртай л даа.
 Хятад: Нээрээ дуртай юу?
 Сэнгээ: Тэрнийг асууж яах нь вэ зайлуул, бас зовно шүү дээ. За за, эртхэн далд орж үз, одоо үүгээр чинь өнөө элч нар давхиад ирнэ шүү.
 Хятад: За явъя, Пагма аа
 Пагма: Хаашаа явах билээ?
 Хятад: Харсан зүг тийшээ явъя

Пагма: Хүрээ сэмхэн ороод, ядаж жаал жуул юмаа авах сан даа.

Хятад: Юм юу хийнэ? Амь хэрэгтэй. Надад бас хэд гурван лан мөнгө байна. Энэ лав илжиг хүрнэ. Явъя явъя.

Пагма: Бурхан минь ингээд л явъя даа.

Хятад: Явъя явъя. Сэнгээ би чамд дандаа буян санаж явна.

Пагма: Би ч гэсэн.

Хятад: Яах вэ дээ. Ядарсан надад Пагма ч яах вэ. (Явав) ...

Ч.Ойдов "Жүжгүүд" УБ, 1957, 234-236 дэх тал

ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ



ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Нөхцөл байдлын хошигнол:

- Энэ нь зохиогчийн бодож олсон өдөл, сэдэл хатгаасын дундах нөхцөл байдлыг үүсгэдэг. Жишээ нь: Хээл хахуульд хэт шунаад хээрийн чулуу атгаж мад тавиулах гэх мэт.

Зан төрхийн хошигнол:

- Дүрүүдийн зан төрх нь хошигнол үүсгэх үндэс болдог. Зарим дүр нь алиалж марзганаж бусдыг инээлгэдэг бол зарим нь гэнэн тэнэгээрээ хүний инээдийг хүргэж байдаг.

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Жүжигт ямар ямар дүр гарч байна вэ? Хэн нь хэнтэйгээ хэрхэн холбогдож байгааг бүдүүвчээр харуулаарай.
2. Хэн нь гол, хэн нь туслах, хэн нь сөрөг дүр болж байна вэ? Яагаад?
3. Сэнгээгийн үйл хэрэг, үзэл бодлыг дэмжиж байгаа болон түүнийг эсэргүүцэж байгаа дүрүүдийг ялгаж бичнэ үү.
4. Сэнгээг өөрөөр хэн гэж нэрлэж байна вэ? Түүний энэ олон нэр нь зан чанарын ямар нэг онцлогийг илэрхийлж байна уу?
5. "Удган модонд хүлүүлж, ужиг өвчнөө эдгээсэн нь" үлгэрийн дүр, өгүүлэмжтэй холбоотой хэрэг явдлыг бичнэ үү.
6. Та нарын бодлоор энэ жүжигт чухам хэнийг элэглэн шоолж байна вэ?
7. Баяны дүрээр дамжуулан хүний зан чанарын ямар онцлог шинжийг зохиолч шоглон үзүүлсэн бэ?
8. Бэлэн Сэнгээ буюу Далан худалчийн ямар зан чанар та нарын сэтгэлд хамгийн их хүрч байна вэ?
9. Уламжлалт ёсоор жүжгийн дүр нь зан төрх, сэтгэл зүй, бие бялдар, нийгмийн шинжүүдээрээ тод ялгарч байдаг гэвэл Далан худалчийн дүр эдгээрийн алианаар нь ялгарах вэ?
10. Далан худалчийн дүрээс дотоод болон гадаад зөрчлийн аль нь илүү харагдах вэ?
11. Далан худалчид тохиолдсон саад бэрхшээл нь түүний ямар үнэт зүйлийг илрүүлж байсан бэ?

12. “Ядарсан надад Пагма ч яах вэ” гэсэн Хятад буюу Далайн үг түүний зан суртахууны ямар байдлыг тодруулж байна вэ?
13. Энэ хоёр дүр хийгээд Бэлэн Сэнгээгийн хооронд зан чанарын ямар эсрэгцэл байна гэж та хүлээн авч байна вэ?
14. Далан худалчийн худал яриаг уншигч яагаад зөвтгөн хүлээж авдаг вэ?
15. Далан худалчийн үгээр зохиолч бидэнд ямар санааг хэлэхийг хүсэж байна вэ?
16. Сэнгээгийн Хятад (Далай)-д өгсөн зөвлөгөөтэй чиний санал нийлж байна уу? Пагма, Хятад (Далай) хоёрын хувь заяаг өөрөөр эргүүлэх шийдэл олж бичээрэй.

17. Сэнгээгийн “Би ард түмний хүсэл юм” гэж хэлсний учрыг тайлбарлахдаа зохиолоос баримт авч ашиглаарай.

Хэсэглэл 6

ТАВДУГААР ҮЗЭГДЭЛ

(Бат, Гэлэг нар ирэв.)

Сэнгээ: Гэлэг гуай, та хааччихав аа?

Бат: Гэлэг гуайг эд нар хүлчхээд хаячихсан байсныг сая би олж суллалаа шүү. Өнөөдүүл хааччихсан бэ?

Сэнгээ: Цөмийг нь учрыг олсон. (Гэрийн үүдийг нээж) Одоо таны амьдрал энэ гэрийн үүд шиг нээлттэй.

Алимаа: Аав аа! Эд таныг алчхаагүй юу.

Тунгалаг: Бат минь, Бат минь. Чи яасан удав аа. Намайг Галдан сүйд хийх шахсан шүү.

Сэнгээ: Гэлэг гуай, Алимаа чинь таны охин байсан юм уу. Тийм ч байж магадгүй. Би ч бас бодож байсан юм шүү.

(Давст цагдаа хувцастай ирэв.)

Давст: Хаа байна тэр Галдан, Жалбуу нар

Сэнгээ: Таны цагдаа хувцасны хэрэг одоо өнгөрсөн. Чи аав дүү хоёрыгоо эрж яваа бил үү. Аав чинь энэ, дүү чинь энэ.

Гэлэг: Юу гэн ээ.

Алимаа: Нээрээ мөн гэж үү?

Давст: Намайг Дамдин гэдэг.

Алимаа: Ах аа! (Үнсэлдэнэ.)

Гэлэг: Ингээд төөрсөн төрөл уулзаж элэг бүтэн болдог цаг байдаг юм аа (Сэнгээд) Сайн хүн чиний ачаар бид уулзлаа.

Давст: Сэнгээ чи надад их тус боллоо. Аав дүү нартай минь уулзуулж өглөө. Би гэдэг хүн хэчнээн зовов. Есөн наснаасаа хойш аав дүү хоёрыгоо бодсоор, санасаар, эрсээр яваад, өнөөдөр санаандаа хүрч байна.

Алимаа: Би ноёны гэрт нохой шиг тэжээгдэж өслөө аав аа! Сүүлд нь боолын боол, босгоны шороо гэгч боллоо. Ухаан алдталаа согтсон агь ноёныг гэр оронтой нь шатаачхаад, сайн санаатай өвгөний хүчээр оргочихсон юм. Тэгээд хэчнээн зовлон үзсэн гэж санана.

Сэнгээ: За та нар минь төөрсөн төрлүүд уулзлаа. Бат, Тунгалаг та хоёр ч гараасаа хөтлөлц. Бат гэдэг нэр шигээ бат бөх, Тунгалаг гэдэг нэр шигээ тунгалаг ариун амьдраарай. Далан худалч цэнхэр хөх огторгуй дээвэртэй цэлгэр уудам газраар гэрээ хийгээд цэнхэр хөх тэнгэрээр хөнжлөө хийгээд л олон түмэнтэйгээ уулзаж учирч явъя. Намайг хаана, хэн хүсэж байна вэ? Би тэнд байх дуртай. Тэгэхээр би ард түмний хүсэл юм. (Үзэгчдэд) Бидний энэ үе Монголын ард түмний түүхийн харанхуй үе байсан юм. Бид ингэж аймаар, инээмээр амьдарч байсан юм. Үүнийг үзэхгүй манай сайхан ирээдүй хойч үеийн хүмүүс Далан худалчийн явдлаар инээж цэнгэ, шүүмжилж бод.

ЗОХИОЛЫН УТГА САНААГ БҮРДҮҮЛЭХИЙН ТУЛД СЭДВИЙГ ХЭРХЭН ӨРГӨЖҮҮЛСНИЙГ ЗАДЛАН ШИНЖЛЭХ

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Хошин жүжиг:

- Нийгэм, хүмүүсийн аж төрөл, ажил үйлс, зан суртахууны харилцаанаас үүсэлтэй шүүмжлэлт өнгө аяс, хөгжилтэй хошин өгүүлэмж бүхий жүжгийн зохиолын нэг зүйлийг хошин жүжиг гэнэ.

Ойдов Ч. Жүжгүүд. Уб., 1957, 200 дахь тал

Задлан шинжлэх, даалгаврууд

1. Жүжигт хэдий үеийн үйл явдал гарч байна вэ? Үүнийг юунаас мэдэж болох вэ?
2. Жүжгийн дээрх бичвэрт дэвшүүлсэн асуудал нь юу вэ?
3. Нийгэм түүхийн ямар нөхцөл байдлыг харуулсан бэ? Энэ нь жүжгийн үйл явдлаар илэрч байна уу? Эсвэл дүрийн үгээр илэрч байна уу?
4. Бичвэр 3-т өгүүлсэн давс худалдагч, хуурч өвгөн хоёрын хувь заяаны шийдэл /Бичвэр 6/ ямар утгыг илэрхийлж байна вэ?
5. "Цөмийг нь учрыг олсон Одоо таны амьдрал энэ гэрийн үүд шиг нээлттэй." гэж хэлсэн Сэнгээгийн үгээр ямар утгыг илэрхийлж байна вэ?
6. Сэнгээгийн хэлснээр ард түмний аймаар болон инээмээр амьдрал нь юу болохыг жүжгийн хэсэглэлүүдээс эшлэл авч дүгнээрэй.
7. "Далан худалч" жүжгийн далд утга нь юу вэ? "Оюуны довтолгооны арга"-аар хувилбарууд гаргаад, хамгийн оновчтойг сонгон, үзэл бодлоо нэгтгээрэй.

Илэрхийлэх урлан:

Дараах даалгавраас сонгон гүйцэтгээрэй.

А. Зохиож бичих

"Худал хэлээд инээдэмт байдалд орсон минь" сэдвээр хошигнол бүтээх аргаас суралцан эх зохиож бичээрэй.

Б. Дүрд тоглох

Дээр бичсэн эхийг жүжгийн бичвэрт оруулан тоглолт хийгээрэй. Дараах шалгуур үзүүлэлтээр өөрийн болон багийн тоглолтыг дүгнээд, шилдэг тоглогчоо шалгаруулаарай.

Сонгосон Үзэгдэл	Дүрийн хэл яриаг эзэмшсэн байдал	Дүрийн онцлогийг гаргасан байдал	Хошин өнгө аясыг гаргаж байгаа байдал	Дуу хоолойны өнгө аяс	Нүүр царайны хувирал, дохио зангаа
Бичвэр-1					
Бичвэр-2					
Бичвэр-3					
Бичвэр-4					

Ч.Ойдовын “Далан худалч” жүжгийг бүрэн эхээр нь уншиж дууссан гэж бодож байна. Гурван бүлэгт, таван үзэгдэлт энэ жүжгийг уншиж дуусаад доорх асуулт даалгавраар өөрийгөө сориорой. Нийт 25 онооны дасгал даалгавар байгаа шүү, хүүхдүүд ээ!

1. Жүжгийн хэсэглэлүүдэд гарч байгаа өвөрмөц дүрүүдийг тоочоод яагаад ингэж нэрлэсний учрыг тайлбарлаарай. /2 оноо/
2. Яагаад эерэг ба сөрөг дүр гэж үзэж байгаагаа тайлбарлаарай. /2 оноо/
3. Гол дүрийн хүслийг боогдуулж, бодсон санаснаа хэрэгжүүлэхэд саад болж байгаа шалтгаан нь юу вэ? Яагаад гэдгийг тайлбарлаарай. /2 оноо/
4. Сэнгээгийн эргэн тойрон дахь орчноос нийгмийн амьдралын ямар дүр зургийг олж харж байна вэ? 2-3 дүр зураг гаргаж жишээгээр батална уу. /2 оноо/
5. Дүрүүдийн үг, үйлдлийг шинжилж, сэтгэлийн ямар өнгө аяс гаргаж байгааг тайлбарлахдаа дараах хүснэгтийг ашиглаарай. /2 оноо/

	Инээж шоолмоор	Жигшиж зэвүүцмээр	Хөхиүлэн дэмжмээр	Өрөвдөж энэрмээр	Бахархан дуураймаар
Үг					
Үйлдэл					

6. Ямар дүрүүдийн харилцаа нь зохиолын утга санааг илүү тодруулж байна вэ? /2 оноо/
7. Шашин болон түүхийн хам сэдэв хэрхэн илэрч байгааг баримтаар нотлоорой. /3 оноо/
8. Зусарч зулгуйч, дээрэнгүй, бусдыг аялдан дагалдагч зэрэг зан чанарыг илэрхийлэхдээ ямар үг хэллэг хэрэглэсэн байгааг дүгнэж ярилцаарай. /3 оноо/
9. Сэнгээгийн “Малын баас чинь учиргүй олон нэртэй. Өтгөн гарвал нэг янз, шингэн гарвал нэг янз, хатуугаараа аргал, түлэхээрээ түлш, түлэгдсэн хойноо үнс” гэсэн өгүүлбэрийн бүтэц, агуулгын онцлогийг ажигла. Мөн тухайн сонгосон зүйлийнхээ олон янзаар хувирдаг байдлыг харгалзан өгүүлбэрийг хувиргаж бичээрэй. Үлгэрлэвэл: Тараг, шалгалт гэх мэт. /4 оноо/

Сонгосон зүйл	Хувирал өөрчлөлт	Нэршил
Тараг	Бүрсэн даруйд	Элэг
	Исээд ирэхээрээ	Ундаа
	Нэрэхээр	Архи
	Буцалгаад шүүхээр	Аарц
	Зүсээд хатаахаар	Ааруул

10. Үлгэрийн хэрэг явдалтай “Далан худалч” жүжгийн хэрэг явдлыг харьцуулж уламжлал шинэчлэлийг дараах зүйлийн хүрээнд тодорхойлно уу. /3 оноо/ Үүнд:
 - Төрөл зүйлийн хувьд,
 - Сэдвийн хувьд,
 - Агуулгын хувьд,
 - Дүрийн хувьд хэрхэн шинэчлэгдсэн бэ?



НОМ УНШЛАГАД ХӨТЛӨХҮЙ



ДАЛАН ХУДАЛЧ БЭЛЭН СЭНГЭ

Эмхэтгэсэн: Д.Сүрьеэ

Редактор: Ч.Бямбажав

Эрхлэн гаргасан газар: Алтайн хөгжил
сонины үйлдвэр

Эрхлэн гаргасан огноо: Алтай хот 1969



ЖҮЖГҮҮД

Зохиогч: Ч.Ойдов

Редактор: В.Одгийв

Эрхлэн гаргасан газар: Улсын
хэвлэлийн газар

Эрхлэн гаргасан огноо: 1969

ХОШИГНОЛ

ХОШИГНОЛ БҮТЭЭХ АРГАД СУРАЛЦАХ НЬ

1. Нөхцөл байдлын хошигнол	Энэ нь зохиогчийн бодож олсон өдөл, сэдэл хатгаасын дундах нөхцөл байдлыг үүсгэдэг. Жишээ нь: Хээл хахуульд хэт шунаад хээрийн чулуу атгаж мад тавиулах гэх мэт.
2. Зан төрхийн хошигнол	Дүрүүдийн зан төрх нь хошигнол үүсгэх үндэс болдог. Зарим дүр нь алиалж марзганаж бусдыг инээлгэдэг бол зарим нь гэнэн тэнэгээрээ хүний инээдийг хүргэж байдаг.
3. Учир зүйн хошигнол	Учир зүйн дарааллыг зориуд эвдэх нь хошигнол үүсгэж байгаа нэг хэлбэр юм. Далан худалчийн үлгэрт "Ботгыг нь дүүрээд эхийг нь унаад явтал даасангүй. Харин эхийг нь дүүрээд ботгыг нь унаад явтал даажгүй даалаа" гэх мэтээр гардаг.
4. Үг хэлний хошигнол	Хошигнол нь хэлний тусгай хэрэглээгээр үүсч бий болдог. Үүнд; хэлний зүйг зориудаар гажуудуулсан үг хэллэг ба үгийн тоглоом зэрэг орно. Жишээ нь: Бадарчны үлгэр дэх "Зам зайл" гэхэд "Замаа чамайг зайл гэж байна" гэх буюу "Ноёнд ам гарлаа" гэхэд "Ноёнд ам гараа юу? Хуучин амных нь хаана гараа вэ?" гэх мэт.

Өөрийн үнэлгээ
(Уран унших, ярих чадвар)

№	Шалгуурууд (чадвар эв дүй)	Авах оноо	Авсан оноо
1.	Сонсогчдын анхаарлыг татаж, яриагаа эхлэх	3	
2.	Зохиолын тухай товч мэдээлэх	3	
3.	Зохиолын дүрүүдийн тухай товч мэдээлэх	3	
4.	Дууны өндөр нам, чанга сул, ярианы хурдыг тохируулах	3	
5.	Зохиолын үг хэллэг, дүрслэлээс эш татан ярих	3	
6.	Зохиолын сэтгэл хөдөлгөх өнгө аясыг хадгалж ярих чадвар, эв дүй	3	
7.	Чухал, гол хэсгийг сонгож ярих	3	
8.	Зохиолыг зөв, дэс дараалалтай бүрэн дамжуулан ярих	3	
9.	Зохиолыг ярьж төгсгөх, нэгтгэн дүгнэх	3	
10.	Зохиолыг ярьж дуусмагц сонсогчдоор яриа өрнүүлэх, асуултад хариулах	3	
Нийт үнэлгээ		100%	

Д/д	Зохиолч	Зохиолын нэр	Өөрийн үнэлгээ
-	-	-	-
-	-	-	-
-	-	-	-

Сурагч та:

Уран сайхан ярих, унших чадвараа энэхүү хүснэгтээр шалгахдаа асуулт бүр дээр үнэлгээг шударгаар зөв өгч, өөрийгөө сорьж чадвал хойшдын суралцах үйл ажиллагаанд тань эергээр нөлөөлөх болно шүү.

Дүгнэлт 4:
ЗОХИОЛЫН СЭДЭВ УТГЫН НЭГДЭЛ

Зохиолд дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэж, уран дүгнэлтэд хүрснийг зохиолын утга гэнэ. Уран зохиолын төрлүүд нь утгыг илэрхийлэх онцлогоороо ялгаатай. Уянгын зохиолд хүний сэтгэл санааны байдлыг дүрслэх замаар утгыг илэрхийлдэг бол туульсын болон жүжгийн зохиолд дүрийг бүтээх замаар утгыг илэрхийлнэ. Хошин шог зохиолд бол зохиогч өөрийнхөө цаг үеийн гэм дутагдал хийгээд хувь хүмүүсийн зан суртахууныг шүүмжлэн үзүүлдэг.

- **Сэдэв:** Ихэс дээдэс, баяд ноёдын эрх мэдлийн эсрэг тэмцэхийн тулд зохиолын баатрууд нь ард түмнийг төлөөлсөн заль мэхт, ухаалаг баатрыг гаргаад, ухаан бол биеийн хар хүчийг, тэнэг мунхгийг ялан дийлж байгааг үзүүлдэг. Жишээ нь: Далан худалчийн захирагч ноён хийгээд амбаныг чадсан явдал нь тэнэг мунхгийг саруул ухаан ялж буйг харуулж байна.
- **Утга санаа:** Бадарчны явган шог, Далан худалчийн үлгэр зэрэг нь хүнийг инээлгэхийн зэрэгцээ шүүмжлэх, амьдралын сөрөг талыг илчлэн шоолох, эзэд албатын хоорондох өрсөлдөөнийг харуулах, эрх мэдлээ хортойгоор ашиглагч дээдэс болон ядуусыг хууран мэхлэгч баячуудыг илчлэх нэгэн санаа зорилготой юм.

V

БҮЛЭГ



Тавдугаар бүлэг. ГАДААДЫН УРАН ЗОХИОЛ

5.1. Эртний Грекийн домог, туульс

5.2. Дорно дахины шидэт үлгэр

ЗОРИЛГО:

Энэ бүлгийг судалснаар та дэлхийн сонгодог уран зохиолоос монгол орчуулгаар уншиж, бие даасан уншлагаа хөгжүүлнэ.



5.1 ЭРТНИЙ ГРЕКИЙН ДОМОГ ТУУЛЬС

Эртний Грекчүүд олон тэнгэрийн домгоос эхлээд Тройн дайн, Аргонавтууд, Эдип хаан зэргийн тухай цуврал домгуудыг бүтээжээ. Грекийн домог ёсоор, Олимп уулан дээрх тэнгэрүүд ертөнцийг захирч, хүний амьдрал ч тэнгэрүүдийн хүсэл тааллаар болж байдаг. Грекийн домог хожим уран зохиол хөгжих үндэс суурь болсон төдийгүй үндсэн сэдэв нь болж байжээ.

Грекийн домгийн гол дүрүүдээс танилцуулъя...

Афродита: Хайр дурлал, гоо сайхны тэнгэр. Зарим домогт Зевсийн охин гэж гардаг ч зарим домогт далайн дундаас мэндэлсэн гэж гардаг. Тройн талд тусалдаг. Афродитад далайн тэнгэр, дайны тэнгэр хоёр дурладаг.

Полифем: Циклоп бол далайн тэнгэр Посейдоны хүү, аварга том биетэй, ганц нүдэт махчин. Бас Полифем ч гэдэг.

Эол: Салхины тэнгэр. Эол Одиссейг ивээн замд нь таарах бүх салхийг тулманд хийж өгсөн ч Одиссейн нөхөд нь тулманд эрдэнэс байна гэж бодоод задалснаар салхинд туугдан төөрдөг.

Дионис: Үр шим, ургацын тэнгэр, усан үзмийн дарсны тэнгэр. Вакс гэсэн давхар нэртэй. Дионисийг Зевсийн хавирганаас төрсөн гэдэг. Энэ тэнгэрийн тахилын ёсноос эмгэнэлт жүжиг үүссэн гэдэг.

Арес: Дайны тэнгэр. “Илиада” туульд дайныг буруутгаж, Зевс дайны тэнгэр Аресийг зэмлэж буйгаар гардаг.

Гефест: Ур дархны тэнгэр бөгөөд Афродитагийн нөхөр. Гефест бол тэнгэр бурхдын дунд хамгийн үзэмжгүй тэнгэр гэнэ. Грекийн хамгийн хүчирхэг баатар Ахиллд хуяг бамбай хийж өгдөг.

Кентавр: Уул модонд амьдардаг хүн морь хоёрын заримдаг төрхтэй догшин ширүүн амьтан. Зевс тэнгэрийн зарлигаар Герагийн дүрст орсон үүл болоод Эксион хоёроос төрсөн. Кентавруудыг далайн тэнгэр Посейдон ивээдэг. Кентавруудыг Геракл баатраас урд өмнө хэн ч дийлж байгаагүй гэдэг.

Минотавр: Минотавр бол хүн бух хоёрын заримдаг төрхт амьтан. Эх нь нарны бурхан охин, харин эцэг нь Крит арлын бух юм. Энэ бухыг Посейдон тэнгэрийн хувилгаан гэж үздэг. Минотавр нь аймшигтай догшин амьтан тул түүнийг уран Дедалын барьсан газар доорх төөрдөг байшинд хийж, жил бүр Афины иргэдээс долоон бүсгүй, долоон залуугаар тахил өргөдөг заншилтай байжээ. Энэ их золгүй явдлыг устгахын тулд Афины Ханхүү Тесей тахилд өргөх долоон залуугийн тоонд орж очиж Минотаврыг алж чадсан бөгөөд хэн ч эргэж гардаггүй төөрдөг байшингаас Миносын хааны охин Ариаднагийн өгсөн түүдэг утсыг дагаж явсаар агуйгаас гарсан гэж домогт гардаг.

Сфинкс: Сфинкс бол эмэгтэй хүний цээжтэй, арслангийн биетэй, шувууны далавчтай амьтан. Түүнийг Лера тэнгэр Фив хот руу хүмүүсийг шийтгүүлэхээр явуулжээ. Сфинкс Фив хотын ууланд байрлаад, хажуугаараа явсан хүмүүсийг барьж, оньсого таалгаад, оньсогыг таагаагүй хүмүүсийг барьж алдаг байв. Харин Эдип хаан оньсогыг таасанд Сфинкс маш их уурлан ангал руу үсэрч үхсэн домогтой.

Сирена: Сирена бол уран сайхан дуу хоолойгоороо далайчдыг мэхлэн аваачиж, барьж иддэг хүн шувуу хоёрын заримдаг төрхтэй махчин шуламс. Сиренийн эцэг нь Ахило хэмээх ширүүн гол, эх нь урлагийн тэнгэр Муза. Тэрээр эцгийнхээ догшин зан авирыг, эхийнхээ сайхан дуу хоолойтой өвлөж авсан юм. Одиссей Ясон зэрэг баатар эрс өөрсдийнхөө тэвчээрийг шалгах гэж хадан арлын хажуугаар өнгөрч байсан домогтой. Сиренийн хоолойг биширсэн Аргоноп тэсэлгүй усанд харайсанд түүнийг Афродита аварч байсан домогтой.

Цирце: Цирце бол Нарны тэнгэр Гелиосын охин бөгөөд ид шидээр бусдыг эрхэндээ оруулагч шулам дагина. Кирка ч гэж нэрлэдэг.

Харин та нарынхаар домог зүйн эдгээр дүр Одиссей зохиолд ямар үүрэг гүйцэтгэх бол...



Зевсийн хөрөг баримал. Санкт-Петербург. Эрмитаж

ЗЕВС: Грекийн домогт ертөнцийн бүх тэнгэр, нар болон хүмүүсийн хаан нь Зевс тэнгэр бөгөөд аянга цахилгаанаас аваад бүх зүйл түүний эрхшээлд байдаг. Одиссейд хэрхэн туслах бол...



Герагийн хөрөг баримал

ГЕРА: Гера бол гэр бүлийн тэнгэр бөгөөд Зевсийн эхнэр. Домогт Зевс Ио охиныг сонирхсон тул Гера түүнийг үхэр дүртэй болгосон. Гера Одиссейд хэрхэн туслах бол...



Афины хөрөг баримал. Пушкины дүрслэх урлагийн музей

АФИНА: Зевсийн охин. Домогт гардгаар эцгийнхээ толгойноос унасан гэдэг. Мэргэн сэцэн, эрдэм билиг, оюун ухааны тэнгэр гэж үздэг. Одиссейд хэрхэн туслах бол...




Аполлоны хөрөг баримал

АПОЛЛОН: Зевсийн хүү. Грекийн домог үлгэрт гардаг тэнгэр. Түүнийг гэрэл гэгээ, урлаг, уран сайхан, нум сумны тэнгэр гэж шүтдэг байв. Одиссейд хэрхэн туслах бол.....



Посейдоны хөрөг баримал. Копенгагены музей

ПОСЕЙДОН: Далайн тэнгэр бөгөөд Зевсийн дүү. Өөрөөр Айд ч гэдэг. Одиссей баатар хүүгийнх нь нүдийг сохолсон учраас Зевсийн эсрэг байдаг гэнэ. Одиссейд




Хермесийн хөрөг баримал. Ватиканы музей

ХЕРМЕС: Тэнгэр нарын элч, мал сүрэг, худалдаа арилжааны тэнгэр гэгддэг. Одиссейд

УНШИХЫН ӨМНӨ

- ▶ Үхлийн оронд амьдаараа хэн ч очиж байсан удаагүй. Үхлийн тэр орноос амьд хүн хэзээ ч эргэж ирж байсан түүхгүй. Гагцхүү л ухаант Одиссей л амьдаараа очоод амьдаараа буцаж ирсэн гэдэг. (“Хомерийн туульс” УБ, 1974, 95-р тал)
- ▶ Зохиолоос эш татсан дээрх хэсгийг уншаад Одиссейн тухай та юуг төсөөлж байна вэ?
- ▶ Одиссей ямар адал явдалтай учирч, түүнийг хэрхэн давах бол...
- ▶ Эрийн сайн Хан Харангуй, Жангар зэрэг баатруудтай эн зэрэгцэх болов уу?
- ▶ Түүнд хэн, юу туслах бол...

ХОМЕР



“Илиада”, “Одиссей” хоёр их туульсыг “Бага Азийн сохор дууч” хэмээн алдаршсан Хомер зохиосон гэдэг домогтой. Энэ туульс нь Тройн дайны тухай цуврал домгоос сэдэвлэн зохиогджээ. Бага Азийн Трой буюу Илион хотыг ахайчууд /грекүүд/ байлдан эзлэх гэж арван жил дайтсан домогтой. Трой хотын хааны хүү Парис Грекийн Менелай хааны хатан сайхан Еленаг хулгайлан авсан учир энэ дайн үүссэн гэдэг. Дайн арван жил үргэлжилж, хэн нь ч дийлж чадахгүй байхад аргат Одиссей модон морь бүтээн, тройчуудыг мэхэлж ялдаг. “Илиада” туульд энэ дайны ес дэх жилийн тавин нэгэн өдрийн үйл явдлыг өгүүлдэг.

Тройн дайны дараа Одиссей тэргүүтэй Грекийн дайчид эх нутаг Итактаа буцах замдаа мөн арван жил төөрч, элдэв бэрхшээл, адал явдалтай учирснаас “Одиссей” туульд гэртээ харихын өмнөх дөч хоногийн үйл явдлыг өгүүлдэг.

Эх зохиолыг бүрэн эхээр нь уншицгаая.

ОДИССЕЙ

(Их туульс)

ОДИССЕЙ ИТАК ОРОХ ЗАМДАА

...Одиссей тэргүүтэй баатрууд ариун Илион хотыг үнсэн товрог болгоод төрөлх Итак нутагтаа буцах замдаа түмэн зүйлийн зовлон зүдрэл гай гамшиг, адал явдалтай учран бие сэтгэл бэрхтэй зовжээ. Эцэст Олимпын тэнгэр нар түүнийг өршөөн, дээд тэнгэр Зевсийн охин Атене Палладын эцгээсээ гуйсан ёсоор, Одиссейг нутагт нь буцаахаар тогтжээ. Харин хүү Полифемийнх нь нүдийг сохолсонд өширхсөн далайн тэнгэр Посейдон Одиссейг хаана ч явсан мөшгөн заналхийлж байжээ...

“Хомерийн туульс” УБ, 1974, 57-р тал

...Лянхуа идэштэнээс зугтан хөвсөөр нэгэн эзгүй арал дээр ирсэн нь махчин циклопчуудын арал байлаа. Циклопчууд нь хууль ёс гэдгийг мэдэхгүй, тодорхой захиргаагүй зэрлэг хүмүүс бөгөөд хадны агуйд суудаг ажээ. ...

Маргааш нь би хэдэн нөхдийн хамтаар онгоцондоо суун, эргийн дагуу хөвсөөр том хадан агуйн харалдаа ирж зогсон, хамгийн чадалтай, зоригтой арван хоёр баатраа бас нэлээд дарс, хүнсний юмтай авч, агуй руу орлоо.

Циклоп агуйдаа байсангүй. Хонь ямаагаа хариулах гээд явсан бололтой. Эзний байхгүйг далимдуулан, агуйн доторхыг сайтар шинжилж үзвэл, хулсан сагсаар дүүрэн бяслаг, бас хувин, тогоогоор бялхам сүү, тараг байлаа. Мөн агуйн дотроо тусгай пүнзэрхүү юм бариад олон хурга ишиг хашжээ. Нөхөд маань бяслагнаас нь сайтар базааж, хурга ишигнийх нь торниун, сайнаас шилж аваад, алга болцгооё гэсэн боловч эз нь хатгасан юм байлгүй циклопыг өөрийг нь хармаар санагдаад байхаар нь явахаас татгалзав.

Гэнэт гадаа хонь ямаа майлалдан, газар доргим нүсэр хөлийн чимээ дуулдан, удалгүй агуйн амаар багтаж ядсан том хүн орж ирлээ. Тэр хоол ундаа болгохоор гуалингийн чинээтэй түлээ тэвэрч ирснээ агуйн аман дээр хаячхаад, хонио эр эмээр нь ялган, тусгай хашаанд оруулаад, хорин мориор ч татаад хүч хүрэхээргүй тийм том чулуугаар агуйгаа таглав. Дараа нь хонь ямаагаа саан, хурга ишгийг нь хөхүүлээд, оройныхоо хоолыг хийх гэж байгаа бололтой галаа түллээ. Энэ бүхнийг айж чичирсээр харж суусан бид агуйн мухарт шигдсээр л байлаа.

Галын гэрэлд тэр аварга хүнийг сайтар харцгаалаа. Ямааныхаа арьсаар биеэ хагас дутуу халхалсан энэ хүн магнай дээрээ ганц том нүдтэйг нь үзээд манайхны айдас хүрэн, өөрийн эрхгүй дуу алдах чимээнээр циклоп шатаж байгаа цучил авч, дээш өргөн, агуйг гэрэлтүүлж, бидний олж хараад, ...тэр дороо улайрсан араатан мэт үсчин ирээд, хурга шүүрсэн бүргэд адил хөөрхий хоёр нөхрийг минь гуалин шиг бүдүүн савраараа сарвалзуулан барьж аваад, толгойгоор нь агуй руу гуядан, тархийг нь савируулан огтчин шарж идэв. Хүний махаар хооллолцоод, цадсан байртай тэрийн хэвтээд, төдөлгүй унтаад өгөв.

Би идүүлсэн хоёр нөхрөө бодохоос уур буцлан, энэ махчинг дүрж алья гэж шийдээд, ирт мэсээ хуйнаас нь сугалан, уушиг зүрхнийх нь тус газраар сүлбэж орхих гэснээ агуйн амыг тагласан том хадыг хараад, хэрэв Полифемийг алчихвал бид тэр чулууг ч хөдөлгөж чадахгүй, энэ агуйд өлбөрч үхэхээс өөр замгүй болохыг хараад, урамгүйхэн буцаж далд хийлээ. Шөнийн турш бидний нойр огтхон ч хүрсэнгүй. Цөм яаж энэ махчнаас мэнд хоёр яс салах тухай бодсоор үүр цайлгалаа.



УГИЙН ТАЙЛБАР

Пүнз

Төл мал хаших дулаан хороо

Гуалин

Мөчир нахиаг нь шулж зассан
бүдүүн урт мод

Цучил

Нэг үзүүр нь шатаад нөгөө
үзүүр нь шатаагүй үлдсэн

Сэтэр

Хив хадаг уяж, онголж
дархалсан мал



Махчин Полифем өглөө босоод, дахин хоёр нөхрөөр маань хооллочхоод, агуйгаасаа хонь ямаагаа гаргаж, өнөөх том чулуугаараа биднийг гаднаас таглаж орхиод, хонио хариулахаар исгэрэн одов. Бид хэрхэн эндээс амь мэнд гарах арга сүвэгчлэхийг оролдовч арга олсонгүй.

Агуйн доторхыг сайтар тойруулж харвал нэг том тостой модыг хана түшүүлэн тавьсан байхыг олж үзэв. Тэр даруй мэргэн арга олж, өнөөх модноос гурван тохойг хэмжиж аваад, өрөөсөн үзүүрийг нь бүр шовхолж зороод, агуйн нэг буланд нуув. Үдэш Циклоп хоньдоо туусаар хүрч ирээд, хурга ишгээ эхэд нь хөхүүлэн, саахыг нь саагаад, бас л хоёр нөхрийг минь шүүрэн авч, мөнөөх аюултай хуургаа хийж идэв. Би тэгэхэд нь аяганд дарснаасаа хийж, Циклопод зориглон дөхөж очоод:

- Полифем чи, хүний махан хүнснийхээ дээрээс үүнийг уучих. Бид зориуд чамд өгөхөөр авчирсан билээ. Чи гийчин болгоныг ингээд байвал хэн энд ирэх билээ гэхэд тэр дарсыг маань дор нь хөнтөрч орхиод, бүр амтанд нь орон, аягаа өгч:

- Дахиад нэг хийчих. Бас өөрийнхөө алдар нэрийг танилцуулна уу? Би чамд зохих бэлэг өгөмз. Циклопчууд бид амтат жимс хураадаг юм. Харин чиний энэ дарс ёстой дээдсийн ундаа буй заа гэв. Би яаравчлан аягалж өгөв. Циклоп хэд дараагаар ууж орхив. Төдөлгүй энэ гайхамшигт дарс махчны дотор гэдэс, толгой тархийг нь үймүүлэн донслуулж эхлэхэд би түүнд тал засангуйгаар:

- Циклоп чи ёсыг дагаж надад бэлэг өгөхөөр алдрыг минь асуув уу? Эцэг эхийн минь хайрласан нэр гэвэл Хэнчбиш гэдэг билээ. Эдүгээ нөхөд минь тэгж дууддаг билээ хэмээхэд тэр махчин бах нь ханасан байртай зэвүүнээр инээн, согтож ээдэрсэн дуугаар:

- Эрхэмсэг Хэнчбиш таныг би хамгийн сүүлд шарж иднэ. Миний чамд өгөх бэлэг тэр болог. Эхлээд нөхдийг чинь залгиж дуусна гэв. Циклоп газар хэвтэн архины халуунд шатах шахан цааш нааш хөлбөрөн байснаа төдөлгүй зэрлэг араатны архирах адил чангаар хурхирч эхлэхэд сая бидний дотор жаал онгойлоо. Миний өгсөн дохиогоор зориуд дөрвөн нөхөр минь өнөөх нуусан



Якоб Жордан. "Одиссей Полифемийн агуйд" XVII зуун.

модыг авч ирэхэд шовх үзүүрийг нь галд хийн, шатах янз ороод ирэхийнх нь үед галаас гарган, унтаж байгаа махчинд дөхөж очлоо. Бид хүчээ нийлүүлж байгаад, Полифемийн ганц нүд рүү өнөөх улайссан шовх үзүүрээр нь лав гэгчийн цоргиход түүний хөмсөг өмрөн, хар хүрэн цус годгодон гарч байлаа. Циклоп босон харайж, амь тэмцэн цовхчиход бид

тал тал тийшээ бут үсрэн зайлав. Махчин цусаа садруулсаар, агуй дэлбэртэл ёолон хашхирч, галзуу мэт үсчин, бусад циклоп нь хүрч ирээд, агуйных нь гаднаас хашхиран:

- Полифем чи юунд бидний амтат нойрыг маань сэрээн, шөнө дундуур гуагчин дуудав. Хонь малыг чинь ямар нэгэн амьтан хулгай хийв үү? Эсвэл амь биеийг чинь бүрэлгэх гээд байна уу? Ов мэх, хүч чадлын чухам алинаар нь хэн зовоож байна. Юу болоов? Хэн бэ? Хэл! гэгцгээхэд Полифем зэрлэг муухайгаар чарлан:

- Хэнчбиш, Хэнчбиш намайг хүчээр биш, залиар алж байна. Би л тэнэгтээ Хэнчбишид чадууллаа гэхэд цаадуул нь Полифемийн тэнэг, утгагүй хариултад уур нь хүрч:

Хэн ч биш юм бол чи юунд бархирсан юм. Өвчин туссан бол Зевст мөргө. Бид яаж тусалж чадах билээ гэж хэлээд явцгаав.

Өглөө боллоо. Полифем ёолж гасалсаар агуйн амыг тагласан том хадыг түлхэж зайлуулаад, зальт муу оргодлууд та нар миний гараас мултарна байх аа гэсэн байртай агуйны аманд зогсоод, хонио цувруулан, нурууг нь сайтар илж үзээд, гаргаж байв. Тэр даруй миний санаанд нэг мэргэн арга орж ирсэнд би хамгийн сахлаг ноостой хоньдыг нь гурав гурваар нь холбоод, дундах хонины өвчүүн доор нь нөхдөө нэг нэгээр нь зүүгээд явуулав. Би сүүлд нь Полифемийн хамгийн хайртай сэтэртэй том хонийг нь барьж аваад, гэдсэн дороос нь зүүгдэв. Тэр хонь биеэр томын дээр хэдэн жил хяргаагүй учир маш сахлаг ажээ. Түүний мяндаслаг сахлаг ноос нь намайг бүрхэн халхалж байлаа...

Бид циклопын хамаг хонь, ямааг нь хөөн, онгоцон дээрээ ирэхэд ард хоцорсон нөхдийн маань санаа амарч, юу болсныг нь шалгаахад би үг дуугүй хоньдыг ачин шалавхан эндээс зайлахыг тушаав. Тэд ч миний үгийг даган хөдөллөө....

Бид чимээгүйхэн сэлүүрдсээр дахин эргээс нэлээд холдсоны хойно нөхөд маань хэчнээн гуйж хорьсон ч би тэсэлгүй:

- Хэн чамайг харах нүдгүй болгосныг хэрэв сонирхон хүн асуувал Итак орны хаан Лаэрт баатрын хүү, хот балгадыг ч атгандаа оруулагч Одиссей сохолсон гээрэй гэж хашхирахад:

- Ээ чааваас. Даанч яав даа. Урьд алдарт нэгэн төлөгч хэзээ нэгэн цагт Одиссей баатарт харах нүдээ алдах юм байна чи гэж мэргэлсэн нь нээрээ онолоо шүү. Одиссей баатар гэхээр хэнд ч дийлдэхгүй хүдэр сайхан эр байх юм гэж санасан чинь ийм өчүүхэн хүний оронцог, өөдгүй шавж шиг юм байсан юм уу гээд, хорсож өшсөндөө эцэг Посейдон тэнгэрийг дуудан залбирч, бидний аялах замд саад хийн, амь насыг нь сүйтгэхийг гуйн мөргөж байлаа...

“Хомерийн туульс” УБ, 1974, 80-85 дахь тал



ҮГИЙН ТАЙЛБАР

Амбан шар

Нас гүйцсэн том шар

Тулам

*Битүүгээр өвчиж авсан
арьсаар хийсэн сав*



ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ

Задлан шинжлэх асуулт даалгаврууд

1. Зохиолд ямар дүрүүд гарч байна вэ? Тэнгэр нар болон дүрүүдийн холбоо хамаарлыг бүдүүвчээр үзүүлнэ үү.
2. Циклопыг өөрөөр юу гэж нэрлэж байна вэ? Түүнтэй ойролцоо дүр төрхтэй ямар дүр байдаг вэ? Хооронд нь жишиж харьцуулаарай.
3. Хүний ажил үйл, зан чанарыг Циклопоос харж болох уу?

Хүний ажил үйл	Хүний зан чанар
...	...
...	...

4. Циклопын ер бусын гэдгийг батлах баримт нь аль вэ? Ийм ер бусын дүрийг юу гэж нэрлэдэг вэ?
 -
 -
5. Циклопын ер бусын гэдгийн эсрэг Одиссейн ямар зан чанарыг сэргүүлэн тавьж болох вэ?
6. Одиссей болон түүний нөхдийн зан чанарыг тодруулахад нөлөөлсөн орчин нь юу байсан бэ?

Сониучхан	...
Айдас хүргэм	...
Уурласан	...
Арга сүвэгчлүүлсэн	...

7. Одиссейн нөхөдтэйгөө санал зөрөлдсөн зүйл нь юу вэ? Тэр нь дүрүүдийн зөрчлийг хэрхэн хурцатгасан бэ?
8. Одиссей өөрийнхөө нэрийг Хэнчбиш гэсний учрыг тайлбарлана уу.
9. “Долоо хэмжиж нэг огтол” гэсэн хэлцэд тохирох баримтыг бичээрэй.
10. Аргат Одиссей гэдгээ хэрхэн харуулсан бэ? Түүний үйлдлийг ямар хэлцээр илэрхийлж болох вэ?
 -
 -
11. Одиссейн ямар зан чанарыг энэ бичвэрээс илүү тод харж байна вэ?
12. Полифемийн хувьд Одиссейн талаарх төсөөлөл ямар байв? Төсөөллийг Одиссей хэрхэн өөрчилсөн бэ?
13. Бичвэрийн энэ хэсгээс грекчүүдийн ахуй амьдралын ямар хэв маяг харагдаж байна вэ? Жишээгээр батлаарай.

Бид явсаар нэгэн хөвөгч арал дээр ирсэн нь салхины эзэн Эолын арал ажээ. Энэ арал эргэн тойрон элгэн хадаар хүрээлэгдсэн бөгөөд орд харш нь ч бөх гэгчийн зэс хэрэмтэй байв. Тэнд Эол тэнгэр эхнэр, зургаан хүү, зургаан охиныхоо хамт, буянаа эдлэн, цаг ямагт тансаг найранд умбан, баян чинээлэг амьдардаг ажээ. Тэрээр биднийг найрсгаар угтан авч, бүтэн нэг сар архи дарс, хоол хүнсээр дайлан, аян замын адал явдал, дайн тулаан, Трой хотын сонин хачныг шохоорхож, дэс дараагаар нь яриулсан билээ.

Ингээд би нэгэн өдөр хэрэг зоригоо илэн далангүй яриад, эх нутагт минь буцааж өгөхийг хүсэв. Эол тэнгэр миний гуйсныг зөвшөөрөн, биднийг үдэж гаргахдаа надад бэлэг болгон, амбан шарын ширээр хийсэн туламтай юмыг их л нандигнан өглөө. Туламныхаа амыг ер бусын мөнгөлөг эдээр бат гэгч нь боожээ. Энэ тулманд бидний замд дайралдах бүх салхийг хийгээд нямбайлан боосон нь тэр ажээ. Эол тэнгэр зөвхөн өрнөөс үлээх Зефир салхийг дураар нь үлдээсэн учир, тэр салхи бидний онгоцыг туун, бид ч айх эмээх юмгүй эсэн мэнд хөвж явлаа.

Эол тэнгэр тэр туламтай юмыг эх нутагтаа очихоос өмнө задалж хэрхэвч болохгүй гэж хатуу зөвлөсөн юм.

... Олон хоног нойр хоолгүй явсан би, эх нутгийнхаа барааг хараад, сэтгэл уужран, улам яаравч, нэг талаар санаа амран алжаасан бие минь тавигдахад өөрийн эрхгүй амтат нойронд дарагдан түр дуг хийв.

Намайг унтаж байх зуур сониучхан нөхөд маань тэр тулманд үнэт эрдэнэ бий биз гэж бодоод чухам юу байгааг нь үзэхээр болжээ. Салхины тэнгэр Эол зөвхөн надад туламтай юм гардуулсанд нөхөд маань атаархал төрж сэмхэн хуйвалдаад, тулмыг задалжээ. Гэтэл тэдний бодсончлон алт мөнгө дотроос нь гарсангүй, харин хүйтэн салхи исгэрэн шуугьж, хоромхон зуур далай тэнгэр хоёр нийлэх адил болж, эргэн тойрон юу ч үзэгдэхгүй, дан ганц хүчит давалгаа оволзон, онгоцыг зомгол мэт шидлэн, далайн хар салхи ширүүсэн ульж эхлэхэд, болчимгүй юм хийсэн нөхөд маань хий самгардан, ухаанаа гартал айжээ.

Би тэр чигээрээ сэргэж, чухам юм болсныг мэдмэгц харих тавилангүйдээ урам гутран, хөөсрөх давалгаа руу үсрэн орж, үхэхийг завдсан авч, болиод толгой дээгүүрээ нөмрөгөө нөмрөн, онгоцны голд унав. Тийнхүү хэвтэх завсар галзуу шуурга биднийг шидлэн хөөсөөр Эолын арал дээр дахин авчирчээ. Би нөхдөөсөө хоёрыг нь авч, Эолын ордонд хамт очив. Биднийг гэнэт ороод очиход Эол учиргүй гайхан:

- Үгүй, энэ чинь Одиссей юу? Ямар хорон санаат чамайг саатуулан, энд буцааж авчрав? Чамайг нутагт чинь эсэн мэнд хүргэхийн тулд бид чадах бүхнээ хийсэн биш үү? гэж дуу алдахад түүнийг аргадсан дуугаар би ингэж хэлэв.

- Гайтай нойр намайг унтуулж, нөхдийн маань болчимгүй шунаг сэтгэл ийм золгүй явдалд хүргэв. Эрхэм нөхөр минь дахин туслаач. Танаас өөр хэн үүнийг гүйцэтгэж чадах билээ.

Миний үгэнд уярсангүй, харин ч омог нь шатан:

- Зайлцгаа, азгүй муусайн золигнууд! Одоохон миний арлаас тонилцгоо! Мөнх тэнгэрт ад үзэгдсэн юмнуудыг би өршөөхгүй. Явцгаа! гэж ууртайгаар зандран хөөв. Гашуун нулимсаа асгаруулсаар тэндээс аргагүй гарсан билээ, би.

“Хомерийн туульс” УБ, 1974, 85-87 дахь тал

ЗОХИОЛЫН ОРЧИН НӨХЦӨЛ БАЙДАЛ НЬ ДҮРИЙГ ТОДРУУЛАХАД НӨЛӨӨЛЖ БУЙГ ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Эол арлынхны амьдардаг орчныг юу гэж дүрсэлсэн бэ?
2. Энэ арлынхны амьдралын хэв маягийг Циклопын амьдралын хэв маягтай харьцуулна уу.
3. Эолынхны амьдралын хэв маяг, орчин нөхцөл нь зохиолын утгыг илэрхийлэхэд хэрхэн нөлөөлж байна вэ?
4. Амбан шарын ширээр хийсэн туламтай зүйлийг зохиолд дүрсэлсэн нь дүрийн зан төрхийг тодруулахад ямар үүрэгтэй гэж бодож байна вэ?
5. Одиссейн нөхдийн гаргасан үйлдэл нөхцөл байдлыг хэрхэн эргүүлсэн бэ? Энэ нь Эол болоод Одиссейн ямар зан чанарыг тодруулсан бэ?
6. Бичвэрээс таныг баярлуулж, гуниглуулж, бухимдуулж байгаа хэсгийг тэмдэглээд, хүний зан чанарын ямар ямар асуудлыг хөндсөн гэж үзэж байгаагаа тайлбарлаарай.
7. Одиссейн сэтгэл санааны байдал ямар болсон хийгээд юунд илүү итгэж байгааг дүгнээрэй.
8. Туламтай зүйлийг нөхөд нь задлаагүй бол хэрэг явдал хэрхэн үргэлжлэх бол... үүнийг түлхүүр болгоод утгыг дэлгэрүүлэн зохиож бичнэ үү.

Илэрхийлэх урлан: Бичих

9. Өмнө бүлэгт бид “Далан худалч” жүжгийг уншиж, задлан шинжилсэн билээ. “Одиссей салхины тэнгэрийнд ирсэн нь” гэсэн бичвэрийг жүжгийн хэлбэрт оруулан бичээрэй. Ингэхдээ харилцан яриа, горим, хажуу тийш, үзэгчдэд хандах зэргийг оруулж илэрхийлэхээ мартуузай.

Илэрхийлэх урлан: Дүрд тоглох

10. Бичсэн жүжгээрээ дүрийн тоглолт хийж үзүүлцгээе.

Бид явсаар Эй гэдэг арал дээр иржээ. Тэнд Гелиос тэнгэрийн охин шидэт Цирце амьдардаг аж.

...Цирцегийн ордонд ойртож очиход, тэдний гадуур омогт арслан, ховдог чоно зэрэг араатнууд гүйлдэн, өөдөөс нь тосон ирж, урж хазахын оронд сүүлээ шарвагнуулан эрхэлж байжээ. Тэдгээр араатныг Цирце шидэт зүйлээр номхроон, эрхэндээ оруулсан нь тэр болой.

Тэдний зарим нь хэл амаа долоон зовлонгоо тоочих мэт гаслан, зарим нь тэдний хормойноос нь зуун, цааш явуулахгүй гэсэн шиг гэдрэг чангаахад Эврилохийн дотор муу ёр зөгнөсний тэмдэг биш байгаа гэж бодогдоно. Тэд явсаар ордонд тулж очвол эмэгтэй хүний намуухан дуулах сонсогдоход яах вэ гэсэн байртай тээнэгэлзэн, жаал зогссоноо дуучин бүсгүйг гарч ирээч гэж дууджээ. Намуухан дуулах ая тасалдан хаалга чахарч, хурмастын дагина биз гэхээр гоолиг бүсгүй гарч ирэв. Бүсгүйн гарч ирэхийг үзсэн араатнууд ухаан жолоогүй тал тал тийшээ бут үсрэн нуугдав. Юундаа энэ хүүхнээс тэгж айгаа юм бол? Найрсаг дуугаар «орооч» гэж уриад, уярам сайхан мишээхэд хөөрхий нөхөд маань эр хүний харгүй сэтгэлээр итгэн хүүхний араас орцгоожээ. Гагцхүү Эврилох юу ч болж мэднэ гэж хаширлаад, сэмээрхэн хоцорч, хаалганы ард нуугдан, үг чагнахад, хүүхэн нөхдийг нь амтат дарсаар дайлан, бүгдээрээ алиалан хөгжилдөх дуу сонсогдож байснаа удалгүй өнөөх эмийн үл ойлгогдох зандарсан үг дуулдаж, огт хүнгүй юм шиг таг чимээгүй боллоо. Хэчнээн чагनावч анир алга. Харин гахай шуухитнах дуулджээ....

...Зовлонт нөхдөө хэрхэн аврах аргаа бодон бодон явтал замдаа нэг сайхан залуу эртэй учирлаа. Тэр залуу эелдгээр мишээн, толгой дохиод, миний хаачих гэж явааг таан, шидэт эмийн аюулаас хэрхэн өөрийгөө хамгаалах болон яаж аврах аргыг зааж, хар үндэстэй сүүн цагаан дэлбээтэй хачин янзын цэцгийг надад өгч:

- Май үүнийг ав. Мөнх бурхад энэ цэцгийг «Моли гэдэг юм. Энэ цаг ямагт гартаа барьж яв. Тэгвэл Цирце гэгч эмийн ид шидэнд чи дийлэгдэхгүй. Хороо тэр амтат дарсанд шидэт ус хольж, чамд өгнө. Түүнийг чи уугаад, гахай болж хувирна. Гэвч энэ цэцэг чамайг гахай болохоос аварна. Дараа нь чи тэр эмийг сүрдүүлэн айлгаснаар нөхдөө аварч чадна гэж хэлээд алга болов. Энэ залуу Зевсийн элч Хермес бурханы хувилсан дүр байжээ....

... -Өршөө амийг минь! Чи хаа газрын хэн гэгч вэ? Үүнээс өмнө миний шидэт ундааны аюулаас хэн ч амь гарч чадаж байсан удаагүй билээ. Би чамайг мэдэж байна. Чи арга ухаант Одиссей байх. Одиссей баатар хэзээ нэгэн цагт үүгээр дайрч өнгөрнө гэж, тэнгэр надад аль эрт айлдсан юм. Одоо би чиний өмөг нөхөр чинь больё. Сэлмээ хуйнд нь далд хийчих! хэмээн гуйлаа. Би түүний үгэнд орж, сэлмээ далд хийсэнгүй....

Бид тэр арлаас гарз хохиролгүй явж чадсангүй. Явахынхаа урьд орой зөндөө найрласан тул бидний хамгийн бага Эльпенор гэгч залуу согтоод, нам гүм, сэрүүхэн газар унтахаар байшингийн орой дээр гарч хэвтсэн билээ. Өглөө нь бидний шуугилдан бужигнах чимээгээр сэрээд, дээвэр дээр унтсанаа мартан хоцорчихно гэж бодоод нойрмогоороо санд мэнд босон харайтал, хөл алдан байшин дээрээс унаж хэмхэрч үхлээ. Сайн нөхрөө алдсандаа гашуудан нэлээд уйлав. Замд гарах болж, бүх юмаа зэхэж янзлаад, онгоцондоо суутал Цирце хоёр хар хонь хөтөлж авчраад, харанхуй Айдад хүрсэн хойноо тахил өргө гэж өгөв. Хонийг ачаад хөдөллөө. Шидэт эмийн илгээсэн Борей салхи биднийг Айд орон руу тууж явлаа.

ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН БҮТЭЦ БА ҮЙЛ ЯВДЛЫН ДАРААЛЛЫГ ХҮҮРНЭЛИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

1. Тэд хаана ирсэн бэ?
2. Ордны эргэн тойрон дахь ямар байдлаас зөрчил үүсгэсэн бэ?
3. Үйл явдал хэрхэн өрнөсөн бэ?
4. Моли цэцэг өгсөн нь нөхцөл байдлыг хэрхэн эргүүлэв?
5. Цирце хувилгаан дагина яагаад бууж өгсөн бэ?
6. Хийсэн үйлдлүүдээс нь хараад Цирцег ямар зан чанартай гэж тодорхойлж болох вэ?
7. Эврилохын дүрээр зохиолч юу хэлэхийг хүссэн бэ? Энэ нь өгүүлэгдэхүүний бүтцийн аль хэсэгт хамаарах вэ?
8. Унших үед зохиолын аль хэсэг нь таатай сэтгэл төрүүлсэн бэ? Мөн таагүй сэтгэл төрүүлсэн зүйл байсан уу? Яагаад?
9. Зевсийн элч Хермес бурхны хувилсан дүрийг ямар зорилгоор оруулж ирсэн бэ? Энэ нь үйл явдлын өрнөлтөд хэрхэн нөлөөлөх вэ?
10. Хермес бурхны хувилсан дүр Одиссейтэй нүүр тулах бүрт зохиолын хэрэг явдал хаашаа эргэж байна вэ?
11. Цирцегийн Одиссейд бууж өгсөн өгүүлэмжид тохирох хэлц үг бичнэ үү?
12. “*Чи арга ухаант Одиссей байх. Одиссей баатар хэзээ нэгэн цагт үүгээр дайрч өнгөрнө гэж тэнгэр надад аль эрт айлдсан юм*” гэсэн Цирцегийн үгээс ямар дүгнэлт хийж болох вэ? Өөр ямар бүлэгт ийм өгүүлэмж гардаг вэ?
13. Энэ хэсэглэлд гарч буй салхийг Эол тэнгэрийн өгсөн туламтай салхитай харьцуулж хэрэг явдлын эргэлтэд хэрхэн нөлөөлж буйг харьцуулан тайлбарлаарай.

Илэрхийлэх урлан: Илтгэл бичих

“Зорилготой хүнийг ямагт аз түшдэг” сэдвээр зохиолоос эшлэл татаж, илтгэл бэлтгээрэй. Дараах алхмыг анзаарч хараарай.

- Хүн тодорхой зорилготой амьдардаг.
- Тохиолдох саад бэрхшээл маш олон.
- Аз дайрах үе ч бас гарна. Тэр үед ямар мэдрэмж төрсөн бэ? Ямар сэтгэгдэлтэй байсан бэ?
- Нэгэнт дайрсан аз тохиолыг алдахгүй барьж аваад, ашигтайгаар эргүүлэх нь чухал.

... Үүр дөнгөж гэгээрэхтэй зэрэг би нөхдөө сэрээж, юм хүмээ ачаад замд гарлаа. Өглөөний сэрүүн салхи зөөлнөөр үлээж, бидний онгоцыг тууна. Шидэт Цирцегийн арал тэртээ ард бүдгэрэн бүдгэрсээр далд орлоо.

Гэнэт салхи зогсов. Алсад хэсэгхэн зурвас газар харагдсан нь өнөөх шидэт Сиренийн арал байлаа. Миний сэтгэл сэртхийн, айдас төрсөн боловч Цирценийн зааж өгснөөр нөхдөдөө хандан:

- Найзууд аа! Бид Сиренийн аралд дөхөж явна. Бид тэр арлын хажуугаар өнгөрөх ёстой. Сиренүүд хажуугаараа өнгөрөгч онгоцыг үзэнгүүт уран сайхан эгшгээр уянгат дууг аялан, далайчдын сэтгэлийг татан бишрүүлдэг ажээ. Тэдний дуулах дуунд уярсан далайчид онгоцоо өөрийн эрхгүй энэ арлын зүг залж, тэдний дуулахыг тавтай сонсон амрахаар онгоцноосоо буудаг байна. Тэгэхэд Сиренүүд довтлон барьж иддэг гэнэ. Тэдний хөнөөлт уран дуунд хууртагдалгүй гарсан хүн үгүй гэнэ. Гэвч та нар минь эмээсний хэрэггүй. Би та нарын чихийг зөөлөн лаваар сайтар бөглөө. Намайг бөх гэгчийн татлагаар онгоцны шорогт хөдөлгөөнгүйгээр хүлэгтүн. Хэрвээ би тэдний дуулахыг чагнахаад тавьж өгөөч гэж дохиогоор шаардах бол даруй гар хөлийг дахин бэхэлж уяад, татлагыг чангалсугай гээд, лав авч бүгдийнх нь чихийг юу ч дуулахгүй болтол нь бөглөхөд, тэд нар намайг өчүүхэн ч хөдөлгөхгүйгээр баглаж орхив.

Өнөө арлын дэргэд ирэхэд, эм хүний толгойтой махчин шувуунууд нисэн ирж, зүрх сэтгэл хоногшим урнаар:



Д. У. Уотерхаус, Одиссей ба сиренүүд, 1891

- Ахайчуудын алдар цуу болсон баатар эр Одиссей чи алив наашаа ирээч.

Онгоцтойгоо хүрээд ирээч. Уянгалан эгшиглэх дууг минь сонсооч. Уран нарийн дуунд минь уярдаггүй хүн үгүй билээ. Урам орж сэргэсэн тэд ихийг мэдээд буцдаг билээ. Грекчүүд та нарын

гашуун зовлонг мэдэж байна гэж дуулахад нь зовлон жаргалаа хуваалцсан дотно найзын минь дуу мэт санагдан сэтгэл уярч, нүднээс нулимс бөмбөрөн, арал дээр очихыг нөхдөөсөө гуйн, хүлээсээсээ мултрахыг хичээн, галзуурсан мэт зүтгэвч олсон татлага хаашаа ч хөдөлгөхгүй байлаа. Харин ч миний түрүүчийн хэлснийг санаад, Перимед, Эврилох хоёр бас нэг олс авчирч, намайг бүр сайн хүлэв. Сиренүүдийн арал бидний ард далд орж, тэдний дуу сонсогдохгүй болсон хойно бид онгоцоо зогсоон, хүлээсээ тайлж чихнийхээ бөглөөсийг авцгаав.

Нэг аюулыг мэнд шүү гэтлээд, цаашаа явж байтал гэнэт их нүргээнт чимээ сонстон, утаа шиг юм суунаглах үзэгдэв. Энэ бол Харибда мөн гэж би таалаа. Нөхөд минь, би ч тэр чимээнээс ухаан алдталаа айцгаан, сэлүүрээ алдан онгоцны голд бөөгнөрч, онгоц маань зогслоо. Би тэгэхэд нь нөхдөө зоригжуулан:

- Найзууд аа! Бид их ч зовж, олон аюулыг туулсан биш үү гэв....

“*Хомерын туульс*” Орчуулсан Ц.Цэдэндамба УБ., 1974, хэсэглэн авав.

ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ

Задлан шинжлэх асуулт, даалгаврууд

- Одиссейн дүрийг монгол ардын баатарлаг туулийн дүр болох Эрийн сайн Хан Харангуйтай харьцуулаарай. Ижил болон ялгаатай талыг Веннийн бүдүүвчээр гаргаж харуулаарай.
- Одиссейд тохиолдсон хэрэг явдлууд нь бусад дүрийг тодорхойлоход хэрхэн нөлөөлж байгааг дараах ажлын хуудсаар илэрхийлээрэй.

Бүлгийн нэр	Хэрэг явдал	Дүрийг тодорхойлоход хэрхэн нөлөөлж байгаа баримт
Одиссей Полифемийн агуйд		"...Энэ бүхнийг айж чичирсээр харж суусан бид агуйн мухарт шигдсээр л байлаа..."
Одиссей салхины тэнгэрийнд	"Эол тэнгэр зөвхөн өрнөөс үлээх Зефир салхийг дураар нь үлдээсэн учир, тэр салхи бидний онгоцыг туун..."	
Одиссей Цирце дагинынд		
Сиренийн аралд		

- Одиссей болон түүний нөхдөд ямар аюул тулгарч, түүнийг хэрхэн гэтэлснийг хүснэгтээр харьцуулаарай.

Одиссейн очсон газрууд	Учирсан ид шидтэн	Учирсан аюул занал	Гэтэлсэн арга зам
Одиссей Полифемийн агуйд			
Одиссей салхины тэнгэрийнд ирсэн нь			
Цирце хувилгаан дагина			
Сиренийн арал дээр			

4. Одиссейн дүрийг сонгож аваад дүгнэлт хийгээрэй. Ингэхдээ дараах дарааллын дагуу ажиллаарай.

- Түүний зорилго нь юу байсан вэ?
- Сонгосон арга зам нь зөв үү?
- Үр дүн нь юу байсан бэ?
- Хэрэв түүний оронд чи байсан бол яах бол...
- Дүрээ тодорхойлбол...

Илэрхийлэх урлан.

А. Эсээ бичих

“Хэрвээ би Одиссейн оронд байсан бол...” сэдвээр эх зохиохдоо өөдрөг үзэл бодлыг дэмжсэн эшлэл баримт ашиглахаа мартав аа.

Б. Илтгэл бичих

“ОДИССЕЙ БОЛ ХАМГИЙН ...” /тэсвэр хатуужилтай, хянамгай, арга ухаантай, сайн бодож төлөвлөдөг, аливаад эрс шийдэмгий хүн/ сэдвээр илтгэл бичихдээ эв зетэй байдлыг дэмжсэн эшлэл баримт ашиглахаа мартав аа.

Бэлтгэсэн илтгэлээ нөхдөдөө сонирхуулаарай.

5.2. ДОРНО ДАХИНЫ ШИДЭТ ҮЛГЭР

Грекийн алдарт их тууль “Одиссей” зохиолыг бид бүрэн эхээр нь уншиж, хүний оюун ухааны үнэ цэнийг илүү баталсан билээ. Энэ удаад бид Төвөд, Монголд эрт үеэс дэлгэрч, аман зохиол мэт яригдсаар ирсэн Энэтхэгээс гаралтай “Шидэт хүүрийн үлгэр”-ийг уншина.

УНШИХЫН ӨМНӨ

- ▶ Энэ үлгэрийн нэр та нарт ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?
- ▶ Үлгэрт юун тухай гарах бол? Таамаглаарай.



Үлгэрт өгүүлэх нь, Бурханы шашны зүрхэн тольт их багш Нагаржуна, нэгэн ханхүүг шавиа болгон, Сайн амгалан явдалт хаан хэмээх нэрлэв. Энэ үед Энэтхэгийн өмнө зүгт нэгэн их хүүрийн газар шидэт хүүр байдаг юмсанж. Тэр хүүрийг үүрээд, үг алдалгүй Цогт ууланд авчирч чадвал замбуутивийн хүн нэгэн мянган насыг наслах учир ерөөлтэй байв.

Нагаржуна Ханхүүг хүүрийг авчруулахаар явуулна. Ханхүү хүүрийг үүрэн ирэх замд шидэт хүүр ер бусын үлгэр түүх хүүрнэн ярьсаар түүнийг үг алдуулах бөгөөд тэр бүртээ торноос мултран эргэж одно. Ханхүү Сайн амгалант явдалт 25 дахь удаагийнхаа явалтаар хүүрт үг алдалгүй авчирч, буяныг үйлдэх ажээ.

А
Я

ҮГИЙН ТАЙЛБАР

Замбуутив

Буддын шашны сударт өгүүлдэг дөрвөн тивийн нэг, хүний ертөнцийн нэр

Хутагтын улс

Энэтхэг орны хүндэтгэлт нэр

Хүүрэгэнэ

Тагтааны нэгэн зүйлийн нэр

Расванар

Хутагтын орны хуврагууд

Лавай

Далайн дунгийн хүндэтгэлт нэр, цагаан өнгийн бэлгэднэ

Нэгэн бээр

1,5-2км зай

Хууль өгүүлэх

Сургамж баримтлал болгон үлгэр, үг өгүүлэх

Гэхих

Сэгсрэх

ШИДЭТ ХҮҮРИЙН ҮЛГЭР

Хэсэглэл 1

Хутагтны улс дахь дунд газар ах дүү долоон илбэч хүн буй ажгуу. Түүн лүгээ хол бус нэгэн бээрийн газар одвоос нэгэн агуу хүчин төгссөн хааныд ах дүү хоёр буйгаас ах нь илбэчний илбэ сурахаар одож долоон он болтол заалгаваас илбэчний илбийн оньсыг үнэхээр эс сурчээ. Нэгэн цагт дүү нь ахдаа хүнс хүргэж очихдоо хаалганых нь завсраар шагайж үзээд, илбийн оньсыг сурсан тул ахдаа хүнсээ үл өгөн, хоёул орд харшдаа харив. Тэндээс дүү нь өгүүлрүүн:

- Илбэчин илбэ сурсныг минь мэдэх болуузай. Бидний хороонд нэгэн сайн морь буй. Чи түүнийг хөдөлгөөд, долоон илбэчний зүгт бүү яв, өөр оронд очоод худалдаж, эд агуурс авчиртугай хэмээн өгүүлээд өөрөө тэр моринд хувилав. Ах нь дүүгийнхээ үгээр болж

- Би долоон он болтол илбэ эс сурав. Дүү минь ийм сайн морь олжээ. Үүнийг унахгүй байж яаж болох вэ хэмээн сэтгээд унав. Унах болоод илбийн авьяасаар морио залж эс чадаад, илбэчний гадна хүрэв. Тэндээс зугтааваас үл гарна. Мөнхүү энэ илбэчинд худалдсугай хэмээн бодоод,

- Миний дүү ийм нэгэн сайн морь олсон бүлгээ. Та үзнэ үү хэмээн асуусанд тэдгээр илбэчин илбийн морин гэдгийг мэджээ. Энэ мэтээр илбийг бүгдээрээ сурваас бид бусдаас ялгаагүй болоод, илбээр гайхамшигт үл болох тул үүнийг алсугай хэмээн сэтгэж, тэр морийг худалдан авч, үнийг хүссэнээр нь өгч авав. Тэндээс илбэчин тэр морийг харанхуй хашаанд уяад, алахын цагтаа цусыг нь арвин байлгахын тулд зарим нь толгой, дэл, сүүлийн хойноос, зарим нь гуянаас бариад, алдуурахааргүй болгож, мөрний тэртээд хөтөлж одоход, тэр морь нь сэтгэрүүн:

- Аяа, ах минь эс чадав. Одоо эдний гарт оров. Хувилан орох аливаа нэгэн амьтан ирээсэй гэж хүстэл усанд нэгэн загас умбаж ирэхийг үзээд, түүнд хувилав. Долоон илбэчин долоон цахлай болоод хөөв. Барих дөхсөнд огторгуйд нэгэн хүүргэнэ нисч ирэхийг үзээд, дүү нь түүнд хувилав. Илбэчид долоон харцагай болж, уул голгүй үлдэн хөөж, хүрэхийн цагт өмнө зүгт Бэдийн орны Цогт уулын Амирлуулагч нэрт хүлэмж хадны дотор Нагаржуна багш сууж байхуйд өвөрт нь орж шунгав. Долоон харцгай хүлэмжийн хаднаа хүрч ирээд, долоон расванар болон хувилав. Багш гэгээндээ “энэ хүүргэнийг долоон харцгай үлдэн хөөхийн шалтгаан юун билээ” хэмээн сэтгээд асууруун:

- Хүүргэнэ ээ, энэ мэт айн зүдсэний чинь учир юу вэ? хэмээн асуусанд тэр урьдын учир шалтгаанаа нарийн тоочиж өчөөд, одоо хүлэмжийн гадна долоон расванар ирсэн буй. Тэд багшийн өмнө ирээд, багшийн барьсан эрихийг гуйна. Тэр цагт би эрихний толгойд хувилж орно. Багш эрихээ соёрхохдоо толгойг нь амандаа үмхээд, эрихээ цацаж орхи хэмээн өчив.

Тийнхүү долоон расванар ирээд, багшийн эрихийг гуйсанд багш толгойг нь амандаа үмхээд, эрихийг гадагш цацлахад сац нэгэн эгшинд хорхой болон хувирав. Долоон расванар долоон тахиа болоод, тэдгээр хорхойг цөмийг цөлбөж идэв. Тэгээд багш даруй амнаасаа эрихний толгойг гаргасанд хүн болон хувилаад, бэрээ барьж, долоон тахиаг тоншиж алав. Алуулмагцаа долоон хүний үхдэл болон хувирсанд багш сэтгэл нь машид зовоод:

- Би ганц чиний амийг аврахын тулд энэ долуулын амийг үхүүлсэн нь маш сайн бус хэмээн зарлиг болсонд тэр хүн өгүүлрүүн:

- Би нэгэн хааны хөвгүүн бөлгөө. Багш ганц миний амийг аврахын тул эдгээр бусдыг үхүүлсэн нүглийг арилгахын тулд аливаа зарлигийг чинь илт магтан дагасугай хэмээн өчив. Багш зарлиг болруун:

- Тийм болбоос сэрүүн ойт үхээрийн газарт шидэт хүүр хэмээгч бэлхүүснээсээ дээш алтаар бүтсэн, доргош зэсээр бүтсэн, тэргүүндээ лавай үс нэрт нэгэн бүлгээ. Түүнийг чи хатуужин авч чадах уу? Хэрэв чадваас би түүгээр алтан бүтээвэл энэ замбуутивийн хүн мянган насыг наслах ерийн нэгэн гайхамшигт шид болмуй хэмээн зарлиг болсонд, тэр хүн “тэгье” хэмээн ам алдав.

Миний явах зам болон үйлдэх арга, авч явах хүнс тэргүүтнийг зааж өгч соёрхтугай. Зарлигаар чинь больё хэмээн өчсөнд, багш зарлиг болруун:

- Тийм бөгөөс эндээс нэгэн бээрийн газар одвоос маш харанхуй модтой, аюух мэт хавцал голд маш их үхдэлүүдээр дүүрсэн байгаа. Чамайг очиход тэдгээр үхдэлүүд

бүгдээрээ босч ирнэ. Тэдний ихэнх үхдэлд “Хала хала суухаа” хэмээн тарнидсан арвай сацаж орхи. Түүнээс цаахан нэгэн голд өчүүхэн хүүр олон буй. Тэдгээр өчүүхэн үхдэлүүдэд “Холо холо суухаа” хэмээн сац. Түүнээс цаахан нялхсын үхдэлүүдэд “Ри ри, чи вид” хэмээн сац. Тэдгээрийн дундаас Шидэт хүүр цааш буруулан зугтаж, Амари нэрт модонд авиран гарч сууна. Тэр цагт чи цагаан саран нэрт сүхээрээ модны ёзоорыг цавчихын дүр үзүүлвээс Шидэт хүүр бууж ирнэ. Тэгэхлээр нь түүнийг зууг багтаагч алаг уутандаа хийж, зуун гурамсан эрээн дээсээрээ боож аваад, идэж барагдашгүй тост гурилаа идээд, үүрч явахдаа нэг ч үг алдалгүй аваад хүрч ир хэмээгээд, амирлуулагч хүлэмж хаданд хүрч ирсний тул Амгалан сайн явдалт хаан хэмээн нэр өгөөд, зам мөрийг нь зааж өгч явуулав.

Тэр хаан багшийн зааж өгсөн зам мөрийн аюулыг арилган явсаар очсонд мөн хэлсэн ёсоор шидэт хүүрийг үзээд, хөөсөнд Амари нэрт модонд авирч гарав. Тэр модны ёзоорт очоод өгүүлрүүн:

- Багш минь Нагаржуна буюу. Сүх минь цагаан саран нэрт буй. Хүнс минь барагдашгүй тост гурил буй. Сав минь зууг багтаагч алаг уут буй. Дээс минь зуун гурамсан эрээн дээс буй. Би өөрөө Амгалан сайн явдалт хаан буюу. Үхдэл чи бууж ир. Эс ирвээс модыг чинь тас огтолмуй хэмээн өгүүлсэнд, шидэт хүүр:

- Модыг бүү огтол. Би бууж очъё хэмээгээд доош бууж ирсэнд уутандаа дүрээд, дээсээрээ боож, тост гурилаа идээд, үүрч олон өдөр болсонд Шидэт хүүр өгүүлрүүн:

- Өдөр уртын учир ихэд алжаав. Эс бөгөөс чи нэгэн хууль өгүүл. Эс бөгөөс би өгүүлсүгэй хэмээсэнд хаан үл дуугарав. Шидэт хүүр бас өгүүлрүүн:

- Чи өгүүлбээс толгойгоо дохь. Намайг өгүүл хэмээвээс толгойгоо дохь гэсэнд хаан юу ч эс дуугаран толгойгоо гэхихэд, Шидэт хүүр өгүүлрүүн:

- Тэндээс балар эрт нөгчсөн цагт баяны хөвгүүн, модчны хөвгүүн, эмчийн хөвгүүн, тоочийн хөвгүүн, төмөрчний хөвгүүн зургуул эцэг эхээсээ оргон нэгдэж, хүнс аваад, өөр нэгэн улс руу явжээ. Нэгэн голын бэлчирт хүрээд тэнд хүн бүр нэг сүнсний мод босгоод, өөр өөрийн голд идээ эрэхээр одож зургаан жил болоод, эндээ уулзацгаая гэж болзоод, хэрвээ хэн нэгэн эндээ ирэхэд бидний мод өнгө хувхайрсан болбоос түүний явсан зүгт явъя хэмээн тогтжээ.

Баяны хүү нэгэн голыг өгсөж явахад тэр голын эхэнд ой, өлөн хоёрын уулзварт нэгэн жижигхэн байшин байх бөгөөд хаалганы дэргэд очив. Тэнд их өтөлсөн өвгөн эмгэн хоёр байжээ. Тэр хоёр

- Хүү чи хаанаас ирж хааг зорьж явна вэ? гэхэд Хүү

- Би холоос ирсэн билээ. Идээ эрэхийн тулд энд ирэв гэхэд өвгөн эмгэн хоёр

- Тийм бол чиний ирсэн чинь сайн байна! Бидэнд бие бялдар сайхан гоо үзэсгэлэнтэй нэгэн охин бий. Чи түүнийг аваад, миний хүү бол гэх үед тэр охин гадаа ирсэнд түүнийг үзээд, “эцэг эхээсээ буруулж ирсэн минь зөвдлөө. Энэ тэнгэрийн охидоос ч үлэмж гайхамшиг үзэсгэлэнт буюу. Үүнийг аваад энд сууя” гэж бодов. Тэр охин:

- Хүү чи ирсэн чинь маш сайн гээд хэдэн үг солилцон ойлголцож, гэртээ орж амраглан жаргаж суув.

Тэр голын адагт нэгэн их хаан байдаг ажээ. Түүний зарц нь хавар усанд наадан, явж байтал голын эхэнд баяны хүүгийн гэрийн элдэв зүйлээр үүдсэн бэлзэг усанд урсаж ирэхийг аваад, тэр маш үнэтэй эдлэл тул хаандаа аваачиж өгөв. Хаан түүнийг үзээд, ихэд гайхан зарцдаа,

- Энэ голын эхэнд энэ бэлзгийг зүүсэн нэгэн хатан буй ажээ. Түүнийг миний дэргэд авчир гэж илгээжээ. Тэр ирж, түүнийг үзээд, түүнийг үзэсгэлэнг үзэж ханашгүй сайхан юм гэж гайхан бодоод очиж,

- Хаан чамайг авчир гэлээ гээд, баяны хүүгийн хамт авчирч хаанд өгөв. Хаан үзээд

- Энэ бол тэнгэрийн охин буюу. Үүний дэргэд миний бусад хатад нохой гахайн адил хэмээн зарлиг болоод, тэр охиныг үлэмж дотночлов. Охин хааныг бус гагцхүү баяны хүүг л сэтгэлдээ бодон сууна. Энэ байдлыг хаан ухаж мэдээд зарцдаа

- Энэ баяны хүүг үгүй болго хэмээн тушаав. Тэр хүүг наадамд авч яваад, нэгэн мөрний хязгаар газар авчирч булаад, дээрээс нь том хадаар дарж алав.

Тэндээс нөхөд нь зүг зүгээр нөгөө болзсон газраа цуглан ирж үзвэл баяны хүү байхгүй сүнсний мод нь хувхайрсныг хараад, түүний явсан голд ирж эс олсонд тоочийн хүү тоолж үзээд, тэр баяны хүү ийм нэгэн газарт их хаданд дарагджээ хэмээн мэдээд, эрж олоод, хадыг зайлуулах арга эс олсонд төмөрчний хүү алх авч тэр хадыг хэмхчин худаг малтаад, хүүрийг нь гаргав. Эмчийн хүү үхсэнийг эдгээх эм найруулж, аманд нь цутгаснаар амилан босож, юу болсныг асуулцан ярилцаад,

- Чи ямар шалтгаанаар үхэв гэж асуужээ. Хүү болсон явдлыг нэг бүрчлэн өгүүлсэнд нөхөд нь,

- Тийм гоо эм бөгөөс гайхамшигтай ажгуу. Одоо яаж түүнийг ямар аргаар авах вэ гэж зөвлөлдөж, модчийн хүү модоор гарди үйлдээд, дотор нь орж, дээш нь дэлдвээс дээшээ, доош нь дэлдвэл доошоо, хөндлөн дэлдвээс хөндлөн явах ийм унааг сэдэж хийв. Түүнийг зураачийн хүү элдэв будгаар будаад, амьд мэт болгожээ. Түүний дотор баяны хүү ороод, халин нисэж, хааны орд харшийн дэргэд эргэн тойрон байхад хаан болон шадар түшмэд нь үзээд гайхаж,

- Энэ мэт шувууг урьд эс үзэв. Сонсоогүй юм байна гээд хатандаа хэлж, орд харшийн давхар дээр элдэв зүйлийн идээг өг гэсэнд хатан нь идээ аваад, орд харшийн дээвэр дээр гарч суухад, тэр шувуу тэнд бууж ирээд, үеийн хоёр модон гардийн хаалгаар золголдсонд хатан ихэд баясаж,

- Чамтай золголдох сэтгэлийн дотор чи үгүй байтал өдгөө золголдох болжээ. Энэ хувилгаант шувууг яаж бүтээгээ вэ? гэсэнд өнгөрсөн явдлыг бүгдийг нарийлан тоолж өгүүлээд

- Өдгөө хааны хатан болсоор сууна уу? Хоёул үнэн дураар гэргий бололцох аваас энэ модон гардийн дотор наашаа ор. Огторгуйгаар нисэж одвоос хор хомс үл болно гэсэнд хатан,

- Чамтай баясалцъя, урьд учралцсан нөхрийн дээд хэмээн өгүүлээд, тэр модон гардийн дотор ороод, огторгуйгаар нисэж одоход хаан түшмэдийн хамт ирээд,

- Аяа, сэтгэлд зохист тэр шувуунд идээ өгөхийн тулд хатнаа илгээсэнд хатныг минь огторгуйд авч одов хэмээн газарт хөрвөөн гашуудав. Тэндээс баяны хүү модон гардийн оньсыг доош дэлдээд, нөхдийнхөө дэргэд буугаад урьдаар өөрөө гарч ирсэнд нөхөд нь

- Хэрэг чинь бүтэв үү гэхэд “Хэрэг минь маш сайн бүтэв” гэв... Хоорондоо муудалцаж, охиныг хутгаар цавчилж алав хэмээсэнд Сайн амгалан явдалт хаан,

- Хөөрхий хайран охин хэмээн өгүүлсэнд шидэт хүүр,

- Заяагаа барсан хаан үг алдав. Сарвад үл сууна хэмээгээд алдуулан нисэж одов...

Шидэт хүүрийн үлгэр. УБ 1992. 5-10 дахь тал. Хэсэглэн авав.

ЗОХИОЛЫН ӨГҮҮЛЭГДЭХҮҮН БҮТЭЦ БА ҮЙЛ ЯВДЛЫН ДАРААЛЛЫГ ХҮҮРНЭЛИЙН УЧИР ХОЛБОГДЛООР ТАЙЛБАРЛАХ

Задлан шинжлэх асуулт, даалгавар

1. Зохиолын дотроос танил биш үгсийг ялган тэмдэглээд, тайлбар толь ашиглан утгыг тодруулна уу. “аюух мэт”, “өгүүлрүүн”, “түүн лүгээ”, зарлиг болруун” хэмээх үгсийг монгол бичгээр бичээд, орчин цагийн ярианы хэлэнд хөрвүүлэн буулгана уу.
2. Зохиол хэрхэн эхэлсэн бэ? Ах дүү хоёрт тохиолдсон хэрэг явдлын дарааллыг тодруулж бичнэ үү.
3. Илбийн увдисаар дамжуулж зохиолд ямар уран сэтгэмжийг үзүүлж байна вэ? Дүү ханхүү болон долоон илбэчин юу юунд хувилсныг доор хүснэгтэд зэрэгцүүлэн жагсааж бичээд зүй тогтлыг ажиглан тайлбарлана уу.

Дүү нь юу юунд хувилсан бэ?	Долоон илбэчин юу юунд хувилсан бэ?
1. Морь	
2. Загас	
3.	

4. Зохиолын өгүүлэгдэхүүний гол зангилаа нь хаана байна вэ? Долоон илбэчингээс зугтаж байсан дүүгийн амийг хэн хэрхэн аварсан бэ?
5. Ханхүү шидэт хүүрийг үүрэн явах болсны учир шалтгаан болон үүрэг зорилго нь чухам юу вэ? Түүний зорилгоо биелүүлэхэд юу саад болж байна вэ?
6. Зохиолын үйл явдал цаашид хэрхэн өрнөж байна вэ?
7. Шидэт хүүрийн ярьсан үлгэр түүхийг сонсоод, ханхүү үг алдах бүрт шидэт хүүр анх байсан газартаа очиж, ханхүү хүүрийг дахин барьж, үүрэн явах энэ өгүүлэмж нь зохиолын үйл явдлыг өрнүүлэхэд хэрхэн тусалж байгааг ажиглана уу.
8. Шидэт хүүрийг барихаар ханхүүгийн очсон үхдэлээр дүүрсэн хавцлын үзэгдэх орчныг төсөөлнө үү.

ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО

Хажлагат зохиол:

- Зохиолын үйл явдлыг өрнүүлж буй бүлэг бүрийн эхлэл болон төгсгөлд утга салгах, нэгтгэх, зорилгоор зориуд давтан оруулсан зохиомж бүхий зохиолыг хажлагат зохиол гэнэ.

9. Нагаржуна багшийн зарлигийг хатамжлан дагасан ханхүүгийн шийдвэрийг та хэрхэн үнэлж байна вэ? Хэрвээ ханхүүгийн оронд та байсан бол хэрхэх байсан бэ?
10. Энэ зохиолын гол хүүрнэн өгүүлэгч нь хэддүгээр биеэс өгүүлж байна вэ? Мөн шидэт хүүр ханхүүд үлгэр хүүрнэхдээ хэддүгээр биеэс өгүүлж байна вэ? Үүнээс үндэслээд үлгэрийн хүүрнэлийн онцлогийг тодорхойлно уу.
11. Шидэт хүүрийн өгүүлсэн эхний үлгэрийг сэргээн санана уу. Ханхүүгийн үг алдахад хүрсэн шалтгааныг тодорхой мэдэхийн тулд эх зохиолыг номын сангаас авч, гүйцээн уншаарай.

Хэсэглэл 2

...Тэндээс бас урьдчилан сэрүүн үхээрт Шидэт хүүрийг авахаар одож хүрээд, бардам үг өгүүлсэнд, хүүр буусныг уутандаа хийгээд дээсээр боож, тосоо идэн үүрч ирэхдээ олон өдөр болсонд наран уртад бие ядрав.

- Бас чи мэргэн хууль өгүүл, эс бөгөөс би өгүүлье. Чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэхч, намайг өгүүл гэвэл тэргүүнээ дохь хэмээсэнд хаан толгойгоо дохиход Шидэт хүүр өгүүлрүүн:

- Тийн бөгөөс балар эрт нэгэн цагт, нэгэн маш жаргалант улсад Самандарасми нэрт хаан бөлгөө. Тэрбээр нэгэн хатан авснаас Нарны гэрэл нэрт хөвгүүн төрөөд, хатан нь халив. Бас нэгэн хатан авбаас түүнээс Сарны гэрэл нэрт хөвгүүн төрөв. Тэндээс хэзээд тэр хатан “Энэ Нарны гэрэл нэрт их хөвгүүн болбоос миний өчүүхэн хөвгүүнд хан ор үл хүртээнэ. Өдгөө нэгэн аргаар Нарны гэрэлийг алаад, би хөвгүүндээ хан орныг хүртүүлсүгэй” хэмээн сэтгэж, нэгэн цагт худлаар бархирч хөрвөлөн тарчлав. Түүнийг хаан үзэж:

- Сайн царайт минь чамд ямар өвчин болов хэмээхэд:

- Надад эцэг эхийн дэргэд бүхий цагаас ийм нэгэн өвчин бүлгээ. Өдгөө урьдаас үлэмж өвдөнө. Нэгэн арга буй, бүтээхэд бэрх. Өдгөө үхэх болжээ хэмээсэнд хаан:

- Чи үхвээс зүрх зогсох мэт тулд хан орноо ч тэвчих бөгөөс хайрлах юм үгүй, аргыг өгүүлтүгэй хэмээвээс хатан:

- Арга нь хоёр хөвгүүний алин ч болов нэгний зүрхийг гүнждийн тосонд чанаж, идвээс эдгэх болно. Нарны гэрэлийг хаан тэвчихүйеэ бэрх. Сарны гэрэл миний биеэс төрсөн тул түүний зүрх миний аманд үл орох. Өдгөө үхэхээс өөр аргагүй хэмээн өчсөнд, хаан хатны үг ба өвчнийг дуулан ядаж:

- Маш хайрт болбоос, өдгөө үхэх чинь магад бөгөөс Нарны гэрэлийг яргачнаа өгтүгэй хэмээн ам алдав.

Тэндээс Сарны гэрэл тэдгээр үгсийг сонсоод, ахынхаа дэргэд очоод уйлан:

- Ахай эжий хоёр энэ мэт зөвлөлдөнө. Нөгөө өдөр чамайг магад ална. Хэрхэх билээ хэмээн өгүүлсэнд ах нь:

- Тэр мэт бөгөөс чи эцэг эхийгээ хүндлээд, мэнд амгалан байтугай. Би буруулах цаг болжээ хэмээсэнд Сарны гэрэл гашуудан:

- Ах чамаас хагацан, энд үл сууна. Чамайг хаана одвоос тэнд одно хэмээгээд түүнчлэн бололцов. Төдий маргааш алахын тэр шөнө хүнс эрвээс хатан мэднэ хэмээн айж, нэгэн тахилын орноо хүнээс дормын хатсан гурилыг нэгэн өчүүхэн туламд гуйж аваад, арван тавны шөнө саран ургахын үед ах дүү хоёр хотоос гараад, өмнө зүг зугтав. Даваа хийгээд голыг огтолж өдөр шөнөгүй явбаас нэгэн өдөр усгүй голд хүрч, тэнд дормын гурил нь барагдан, усгүйн тулд Сарны гэрэл хөсөрт унаж, явж эс чадав. Ах нь өршөөж:

- Ус эрэхээр одож ирсүгэй, хатуужиж бай хэмээгээд нэгэн уулын өнцөгт ус эрж эс олоод, жич харьж ирвээс дүү нь умдаасаж үхсэн байв. Тэнд Нарны гэрэл гашууд дарагдаад, дүүгийн хүүрийг чулуугаар хүрээлэн бариад, нөгөө төрөлд хамт төрөх ерөөлийг ерөөж, тэндээс хоёр давааг давж одвоос нэгэн хадны амсарт улаан хаалга байв.

Түүний дотор орвоос, нэгэн өвгөн арш бүлгээ.

- Хөөрхий хөвгүүн чи хаанаас ирэв, өршөөх мэт буюу хэмээвээс тэр хөвгүүн шалтгааныг нарийн өгүүлсэнд

- Тийн бөгөөс миний хөвгүүн бол хэмээж болгоов.

- Эхлээд хоёулаа чиний дүүгийн ясны газарт очъё хэмээгээд, ус хийгээд, идээ ундааныг авч одов. Тэндээс Сарны гэрэл хөвгүүнд өчүүхэн идээ илдэж өгсөөр

эдгээжээ. Тэндээс тэр гурвуул аршийн гэрт хүрч ирэв. Хэзээд тэр улсын адагт нэгэн их агуу хүчин төгсгөсөн хаан буй ажгуу. Түүний албатууд тарианд ус татах цагт тэр голын эхэнд их нуур бөлгөө. Тэр нуурт агч лусын хаадыг тахихын тулд он бүр нэгэн барс жилт хөвгүүнийг өргөх бөлгөө. Нэгэн жилд тэр улсын барс жилт хөвгүүд барагдаж, хамаг зүгт эрвээс эс олов. Мал адуулагч нэгэн хөвгүүн:

- Энэ голын эхэнд нэгэн өвгөн аршид нэгэн барс жилт хөвгүүн бүлгээ. Бид адгуус адуулахаар очиж үзлээ хэмээвээс, хаан сонсоод:

- Түүнийг авч ир хэмээн гурван хүнийг илгээв. Тэд аршийн хаалгыг цохивоос арш гарч ирээд,

- Юу вэ хэмээвээс

- Хааны зарлиг, чамд барс жилт хөвгүүн буй ажгуу. Түүнийг чинь хан орны тулд хэрэг бүхийн тул над өгч илгээ хэмээн зарлиг болов хэмээвээс арш:

- Юу өгүүлнэ, надад хөвгүүн үгүй хэмээгээд гэртээ ороод хаалгаа хааж, хөвгүүнээ бутанд хийгээд, амсрыг нь шавраар шавж, тутарганы архи хийсэн бутан мэт адил атал, хааны зарц тэр хүн:

- Хаалга эвдээд, гэрийг нэгжье хэмээгээд гэрт оров. Нэгжиж эс олоод, өвгөн чамд хөвгүүн үгүй бөгөөс биднийг юунд зовоов хэмээгээд шийдмээр цохив. Тэнд Нарны гэрэл эс тэсээд,

- Ахайг бүү цохь, би энд байна хэмээн гарч ирвээс түүнийг тэр хүн бариад хөтөлж одов.

Арш гашууд дарагдан ихэд уйлав. Тэд хөвгүүнийг хааны хотод авч одвоос хааны охин үзэж, тэр хөвгүүнд дурлаж, хагацан ядаж хүзүүнээс тэврэн үйлдэв. Албатууд бүгд,

- Барс жилт хөвгүүнийг өргөх цаг болжээ, энэ өдөр хэмээн өчив. Хаан:

- Тийм болтугай хэмээсэнд тэдгээр албат хөтлөн завдвас тэр охин:

- Үүнийг уснаа үл орхи. Үл болох бөгөөс намайг орхитугай хэмээвээс, түүнийг хаан сонсож, охиноо,

- Хан орныг үл сэтгэнэ энэ хэмээн барс жилт хөвгүүн лүгээ хамт ширлэж, усанд хая хэмээсэнд тэр хаан ганц зарлигтай бүхүйн тулд албат бүгд зарлигийн ёсоор болгосугай хэмээгээд хамт хүлээд ширлэж, лусын хаадыг тахихын тулд усанд хаяв. Тэнд Нарны гэрэл сэтгэлдээ,

- Аяа, хохой, би барс жилтэй учраас уснаа хаягдвас хаягд, надад тачаасан энэ хааны охин миний мөрт үхэх боллоо хэмээн сэтгэж байв. Охины сэтгэлд,

- Би доорд төрөлт бүхийн тулд хан эцэг минь энэ мэт үйлдвээс болго гэж үү. Сэтгэлд зохист энэ хөвгүүнийг юунд хаяна хэмээн сэтгэж, нааш цааш өршөөлцөн бүхүйг тэр Лусын хаан мэдэж, нуурын хязгаарт гаргаж тавив...

- ...Ах дүү хоёул сэтгэшгүй агуу хүчин лүгээ сэлт хотод ирсэнд эртний тэр хорт хатан ах дүү нарыг үзээд, гайхаж цусаар бөөлжиж үхэв хэмээсэнд, Амгалан явдалт хаан,

- Зөв ч биз хэмээсэнд, шидэт хүүр:

- Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулан нисээд алдуулав...

Шидэт хүүрийн үлгэр.

УБ 1992. 25-29 дахь тал. Хэсэглэн авав.

А
Я

ҮГИЙН ТАЙЛБАР

Дором

Шашины ёсны нэг зүйл зан үйлд зориулж цагаан будаа арвайн гурил, улаан буудай тэргүүтнээр хийсэн шовх оройтой гурвалжин балин

Арш

Аглагт сууж, шашины ёсны бясалгал, даяан хийх хүн

Тутарга

Цагаан будаа

Ясны газар

Шарилын газар

ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ХОЛБОО ХАМААРЛААР ГОЛ БА ТУСЛАХ, СӨРӨГ ДҮРИЙГ ТОДОРХОЙЛОХ

Задлан шинжлэх асуулт, даалгавар:

1. Үгсийг хам сэдвийн хүрээнд тайлбарлаарай.

Хан ор	
Буруулах	
Тулам	
Хатуужиж бай	
Адуулах	
Шийдэм	

2. Үлгэрийн энэ хэсэглэлд гарч байгаа дүрүүдийг тоочоод, холбоо хамаарлыг бүдүүвчээр харуулна уу.
3. Гол ба туслах дүр, сөрөг дүрийг тодорхойлон, үндэслэлээ тайлбарлаарай.
4. Самандарасами хааныг шийдвэр зарлиг гаргахад хэний ямар үг нөлөөлсөн бэ? Хэрвээ чи хааны оронд байсан бол яах байсан бэ?
5. Сарны гэрэл хөвгүүний ээжийн санаа, зорилго, түүндээ хүрэхийн тулд хэрэгжүүлж байгаа аргыг та нар хэрхэн дүгнэж байна вэ?
6. Эцэг эхийн гаргасан шийдвэр хоёр хүүг юу хийхэд хүргэсэн бэ? Хоёр хүүгийн сонгосон замыг та нар зөвтгөж байна уу?
7. Самандарасами хаан, улсын адагт байх агуу хүчин төгсгөсөн хаан хоёрын гаргасан шийдвэрийн ижил ба ялгаатай талыг харьцуулан тайлбарлаарай.
8. Хан хөвгүүдийн зорилгыг тэдний хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь шинжлээрэй.
9. Нарны гэрэл хөвгүүн хаадын гаргасан шийдвэрийг хэрхэн даван туулдаг бэ?
10. Хаадын харгис шийдвэрийн шууд ба дам хохирогчид нь хэн бэ? Яагаад ингэж үзэж байна вэ?
11. Энэ үлгэрт хэдэн хаан гарч байна вэ? Тэдний үг үйлдлийг харьцуулж, гаргасан шийдвэрийн шалтгаан үр дагаварт дүгнэлт хийгээрэй.
12. Шидэт хүүр дараагийн удаа ямар сонин сайхан үлгэрийг хүүрнэх бол? Сайн амгалан явдалт хаан үлгэрийг сонсоод үг алдах болов уу? Эх зохиолыг бүрэн эхээр нь уншаарай.

Өөрийгөө үнэлэх даалгавар:

1. Өрнийн тууль, дорнын үлгэрт гарч байгаа дүрүүдийг харьцуулан адил ба ялгаатай талыг тодруулна уу. /5/
2. Өрнө, дорнын соёлын ямар ялгаа харагдаж байна вэ? Зан заншил, ахуй амьдрал, тайлга тахилгын зан үйлээс жишээлэн тайлбарлана уу. /5/

Илэрхийлэх урлан: Бичих

3. Хэсэглэлийг сайн уншаад жүжигчилсэн хэлбэрт оруулаарай. Ингэхдээ харилцан яриа, горим, хажуу тийш, үзэгчдэд гэсэн хэлбэрийг оруулахаа бүү мартаарай. Жүжгийнхээ дүрүүдийг хуваарилж, үгээ цээжлэн тоглоход бэлтгээрэй. /10/

Илэрхийлэх урлан: Дүрд тоглох

4. Ингээд ангийнхандаа өөрсдийн найруулсан жүжгээ тоглож сонирхуулаарай. Дүрүүдээ дараах шалгуурын дагуу үнэлж шилдэг тоглогчоо тодруулаарай. /10/

Сонгосон үзэгдэл	Дүрийн хэл яриаг эзэмшсэн байдал	Дүрийн онцлогийг гаргасан байдал	Сэтгэлийн өнгө аясыг гаргаж байгаа байдал	Дуу хоолойны өнгө аяс	Нүүр царайны хувирал, дохио зангаа
Бичвэр-3					
Бичвэр-4					


Нийт-30 оноо

НОМ УНШЛАГАД ХӨТЛӨХҮЙ



ХОМЕРИЙН ТУУЛЬС

Орчуулж найруулсан: Ц.Цэдэндамба
 Редактор: Ж.Бадраа
 Эрхлэн гаргасан газар: Улсын хэвлэлийн газар
 Эрхлэн гаргасан огноо: 1974



ШИДЭТ ХҮҮРИЙН ҮЛГЭР

Монгол бичгээс буулгасан: А.Дашдэмбэрэл
 Редактор: Ж.Ганчимэг, Б.Равдан
 Эрхлэн гаргасан газар: "Соёмбо" хэвлэлийн газар
 Эрхлэн гаргасан огноо: 1992

Өөрийн үнэлгээ

(Бичих чадвар)

1. Шинэ мөр, гарчиг, эхлэл, төгсгөлийг ялгаруулан, гаргацтай бичих
2. Ухаарч ойлгосноо тодорхой төлөвлөгөө, дэс дарааллаар эрэмбэлэн ойлгомжтой, цэгцтэй бичих
3. Ухаарч ойлгосноо ой тойндoo сайтар тунгаан төлөвлөж, туршилт, ноорог хэрэглэхгүй шууд эмхлэн бичих
4. Багш болон нөхдийнхөө яриаг сонсонгоо гол зүйлийг ялган оновчтой тэмдэглэх
5. Сурах бичиг болон бусад ном, эх сурвалжийг уншаад чухал гэж үзсэн зүйлээ эмхлэн цэгцэлж, тэмдэглэх
6. Бичиж буй зүйлийн агуулга, утга санаа, ач холбогдлоос хамааран тоочимж, хүүрнэмж, эргэцүүлэмж, тайлбарламжийг зөв, оновчтой хослуулан буюу дагнан бичих
7. Эсээ, эх зохиомж зэрэг бичвэрээ уншсан ном, сонссон зүйл, аман зохиол өөрийн болон бусдын амьдралын туршлагаар баяжуулан бичих
8. Эхийн эхлэл, өрнөл, төгсгөлийн харьцаа, хамаарал, хэмжээ, агуулгыг зүй зохистой тохируулан бичих
9. Бичиж буй зүйлдээ өөрийн үзэл хандлагыг ойлгомжтой үндэслэл сайтай илэрхийлэх
10. Бичсэн зүйлээ хянах, найруулгын болон үг үсгийн алдааг өөрөө олж, засаж сайжруулах, сийрүүлэн бичих

Сурагч та:

Чадвар бүрт “Тийм”, “Үгүй” гэж хариулах ба “Тийм” гэсэн хариулт нэмэгдэхийн хэрээр чадамж тань ахиж байгааг мэдэрч урамших болно.

ДҮГНЭЛТ 5:

ЗОХИОЛЫН БААТАР, ДҮР

Зохиолын баатрууд бол зохиолчийн уран сэтгэмжээс төрсөн байдаг. Энэ уран сэтгэмжийн ертөнц бол маш агуу уудам бөгөөд үлгэрт гардаг идтэн шидтэн, лусын дагина, чөтгөр шуламс бол үүний гэрч юм.

Зохиолын баатрууд мөн бодит байдлаас төрдөг. Зохиолын дүрүүд нь хэдийгээр уран саналгаас төрдөг боловч заримдаа зохиолч цэвэр бодит байдлаас зээлдэж авсан байдаг. Жишээ нь: XIII зууны тухай бичсэн олонх зохиолд Чингис хаан гардаг ч энэ бол бодит байдлыг хуулсан гэсэн үг биш билээ.

Бодит байдал, уран сэтгэмж хоёрын дундаас зохиолын баатар төрдөг. Зохиолчдын урлах эрдэм нь амьдралд тохиолдож болох хүмүүсийн дүрийг бүтээхэд оршино. Хүний амьдрал хэчнээн бодитой, сонирхолтой байдаг ч түүний мөн чанарыг бүрэн гүйцэд таньж мэдэж чаддаггүй. Харин түүнийг зөвхөн уран сайхны дүрээр нээн үзүүлэх боломжтой.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

Адилтгал	Адилтгал нь юмсыг харьцуулан, нэг юмыг нөгөөтэй адил болохыг хэлэхдээ холбоос үг ашиглалгүйгээр хэлэх уран дүрслэлийн арга юм.	35-р тал
Ахиулал	Хүний сэтгэлийн хөдөлгөөн, үйлийн явц, өрнөлийг багаас их рүү, энгийнээс нарийн руу эрчимжүүлэн ахиулж илэрхийлэх давталтын өвөрмөц хэлбэрийг ахиулал гэнэ.	57-р тал
Баатарлаг туульс	Домог зүйн дээд тэнгэр нарын эрх сүрийг үгүйсгэж, хүний хүч чадлыг батлан үзүүлж буй, монгол үндэстний магтах багтах сэтгэлгээ, тоочин дүрслэх түүхэн туршлагын өвөрмөц нэгдэл болсон аялгуут аман яруу найргийг баатарлаг туульс гэнэ.	19-р тал
Бадаг	Холбоц хийгээд аялгын нэгэн хэмнэлд захирагдан тодорхой утга төгсгөж буй айзамт шадын нийлбэрийг бадаг гэнэ.	32-р тал
Гол дүр	Үзэл бодол, үйл хэрэг, эрхэм нандин чанараараа дагуулж, асуудлын шийдлийг олж, шийдвэрийг гаргаж буй давуу хүчнийг гол дүр гэнэ. Гол дүртэй бүхий л талаараа зөрчилдөж буй хүн буюу сөрөг хүчнийг эсрэг дүр хэлнэ. Харин туслах дүр нь гол дүрийн үзэл бодол, үйл хэргийг дэмжин оролцож байдаг.	71-р тал
Далд санаа	Далд санаа гэж далд утгат үгс болон адилтгал, бэлгэдлийг ашиглаж, зохиогчийн санаагаа нуухыг хэлнэ. Шүлгийн далд санаа нь яруу найрагчийн зохиолдоо өгүүлж буй хам сэдэвтэй холбогдон илэрнэ.	37-р тал
Дууль	Үйл явдалтай, эмгэнэлт шинжтэй, уянга - туульсын шүлэглэлт зохиолыг дууль гэнэ	58-р тал
Дүр	Зохиолын өгүүлэгдэхүүний гол зангилааг тээж явдаг төлөөлөл хүнийг дүр гэнэ. Уншигчийн зүгээс дүрийг ёс суртахуун, зан төрхийн шинж болоод шийдвэр гаргах оролцоогоор нь гол дүр, сөрөг дүр, туслах дүр гэж ялгадаг.	70-р тал
Дүрийн өсөлт	Өмнөө тавьсан зорилгодоо тууштай байж, тохиолдсон саад бэрхшээлийг шударга үйлдлээр даван туулсаар үүрэг зорилгоо биелүүлж, үйл хэргээ баталж буй гол дүрийн хөгжил дэвшил, бие хүний ололтыг хэлнэ.	93-р тал
Ерөөл	Аливаа баяр ёслол, хурим найрын үед ирээдүйн аз жаргал, сайн сайхныг бэлгэдэн хэлдэг зан үйлийн уран шүлэглэлийг ерөөл гэнэ	11-р тал
Жүжиг	Тайзан дээр унших буюу тоглож үзүүлэхэд зориулсан бүтээлийг жүжиг гэнэ.	108-р тал
Зохиолын өгүүлэгдэхүүн	Зохиолын утга агуулгыг илэрхийлэх гол хэрэг явдлын ерөнхий бүдүүвч, тогтолцоог өгүүлэгдэхүүн гэнэ.	96-р тал
Зүйрлэл	Зүйрлэл нь нэг юмыг нөгөөтэй нь харьцуулах уран дүрслэлийн арга бөгөөд шиг, мэт, адил гэх мэт холбоосоор танигдаж байдаг.	31-р тал
Иргэний яруу найраг	Сэдэв, утгын хувьд хүн төрөлхтнийг зовоосон дайн, үхэл мөхлийг ариутган эргэцүүлэх, оршин байгаа дэглэмийн эсрэг тэмцэх, үндэсний үнэ цэнт зүйлээ хамгаалах үйлсэд чиглэж, жигшил, зэвүүцэл, эсэргүүцэл, итгэл найдлагын сэтгэгдлийг бүтээж буй яруу найргийг иргэний яруу найраг гэнэ.	39-р тал
Магтаал, цол	Хүчит бөхчүүд болон хурдан хүлгийнхээ хийморь золбоог сэргээн бадрах зорилгоор магтан дуулсан аман яруу найргийн нэгэн зүйлийг цол гэнэ. Цол нь магтаалын өвөрмөц хэлбэр юм.	13-р тал
Найраглал	Нэг талаас туульсын зохиол адил баатрын хэрэг явдлыг хүүрнэн өгүүлэх атлаа нөгөө талаас гол баатрын юм уу, өгүүлэгчийн бодол санаа, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх шүлэглэсэн зохиолын томоохон хэлбэрийг найраглал гэнэ.	57-р тал
Найруулга	Тодорхой сэтгэгдэл төрүүлэхийн тулд бичвэрийн утгад нөлөөлөх (жишээ нь: үг, өгүүлбэр, дүрслэл) тогтсон аргыг найруулга гэнэ. Найруулга нь хувь хүний, тодорхой цаг үеийн бүтээлүүд, тодорхой төрөл болон бичвэрийн хэлбэрүүдийг ялгана.	31-р тал

Нөхцөл байдал	Дүрүүдийн хоорондын харилцааны нөхцөл байдал, дүрүүдийг үзүүлсэн орон, цагийн нийгэм, түүх, соёлын онцлогийг хэлнэ.	50-р тал
Сэдэв	Зохиолыг туурвих шалтгаан болсон үүдэл санаа юм.	82-р тал
Тууж	Гол баатрын амьдралын мөчлөг үеийг өгүүлж, цаг хугацааны орчил харьцаагаараа баатрын дүрийн өсөлтийг гаргадаг туульсын зохиолын томоохон зүйлийг тууж гэнэ.	82-р тал
Туульсын баатар	Туульсын баатар нь хүний хувь заяаг эрхшээгч дээд тэнгэр нарын эрх сүрийг үгүйсгэж, хүний хүч чадлыг батлан үзүүлж буй, эртний домог зүйгээс уламжлан хөгжсөн аман зохиолын баатар юм.	22-р тал
Түүхэн дүр	Нийгмийн тодорхой түүхэн цаг үед амьдарч байсан, улс үндэстний бахархал болсон бодит хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааг уран зохиолд дүрслэн үзүүлснийг хэлнэ.	49-р тал
Орчин	Зохиолын хэрэг явдал болж буй орон ба цагийн нэгдлийг хэлнэ.	72-р тал
Уран давталт	Уран сайхны зорилгоор үг, хэллэг, өгүүлбэр, мөр, бадгийг давтах ур маяг	51-р тал
Уран дүрслэл	Өгүүлж байгаа зүйлийг уран дүрслэлтэй болгохын тулд үгийн утгыг шилжүүлж хэрэглэснийг уран дүрслэл гэнэ. Уран дүрлэлд адилтгал, зүйрлэл, хүншүүлэл, амьдчилал зэрэг орно.	47-р тал
Утга \санаа\	Зохиолын бүрэлдэхүүн хэсгүүд, дүр, үйл явдлаар дамжин уншигчдад тодорхой ойлголт болж хүрэх төвлөрсөн санааг утга гэнэ.	82-р тал
Уянгын баатар	Уянгын зохиолд бодол санаа, сэтгэл хөдлөл, мэдрэмж зэрэг дотоод ертөнцийг илэрхийлж буй дүрийг уянгын баатар гэнэ. Яруу найрагт их төлөв нэгдүгээр биеэс санаагаа илэрхийлдэг тул "би баатар" гэж нэрлэх нь бий.	60-р тал
Хажлагат зохиол	Зохиолын үйл явдлыг өрнүүлж буй бүлэг бүрийн эхлэл болон төгсгөлд утга салгах, нэгтгэх зорилгоор зориуд давтан оруулсан зохиомж бүхий зохиолыг хажлагат зохиол гэнэ.	140-р тал
Холбоц	Яруу найрагт ижил төсөөтэй авиагаар холбон, айзам хэмнэл бүрдүүлснийг холбоц гэнэ. Монгол шүлгийн холбоц нь гол төлөв үгийн эхлэл болон төгсгөлд сонсогдоно.	51-р тал
Хошин шог зохиол	Нийгмийн ахуй ба хүмүүсийн амьдрал, зан харилцаанд байгаа гэм, дутагдлыг инээдэмтэй шог аясаар шүүмжлэн үзүүлсэн зохиолыг хошин шог зохиол гэнэ.	78-р тал
Хошин жүжиг	Нийгэм, хүмүүсийн аж төрөл, зан суртахууны харилцаанаас үүсэлтэй шүүмжлэлт өнгө аяс, хөгжилтэй хошин өгүүлэмж бүхий жүжгийн зохиолын зүйлийг хошин жүжиг гэнэ.	117-р тал
Хүүрнэн өгүүлэгч	Өгүүллэг, тууж дахь түүхийг ярьж буй хүнийг хүүрнэн өгүүлэгч гэнэ. Тодруулж хэлбэл, зохиолын хэрэг явдлыг өгүүлж буй нэг ба гуравдугаар биеийн дүр юм.	74-р тал
Хэтрүүлэл	Юмс, үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж байдлыг ерийн байдлаас нь ихэсгэн давуулж, дүрслэх уран дүрслэлийн ур маягийг хэтрүүлэл гэнэ.	19-р тал
Шад	Шүлгийн нэг мөрийг шад гэнэ. Шүлгийн шадыг бичигт тэмдэглэсэн хэвлэлийн горимыг мөр гэнэ.	32-р тал
Шастир	Эртний түүхэн зохиолын нэгэн зүйлийг шастир гэнэ.	48-р тал
Яруу асуулт	Уншигчдын анхаарлыг төвлөрүүлэн татах, уянгын баатрын ухаарал, сэтгэл хөдлөлийн эрчим, тэмүүллийг идэвхжүүлэх уран сайхны учир зорилгоор хэрэглэсэн өгүүлбэр зүйн ур маягийг яруу асуулт гэнэ.	35-р тал

НОМ ЗҮЙ

Бэгзийн Явуухулан. Түүвэр зохиол. УБ., 1985 он.

Гаадамба Ш, Цэрэнсодном Д. Монгол аман зохиолын дээж бичиг. УБ., 1967 он.

Галбаатар Д. Уран зохиол: Онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь. УБ., 2012 он.

Монгол ардын баатарлаг тууль (МАБТ). «МАЗ-ын чуулган» II боть. Эмхэтгэж, удиртгал, тайлбар бичсэн Ж.Цолоо, УХГ., УБ., 1982 он.

Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын дээж зуун билиг. УБ., 1956 он.

Дашбалбар О. Шидэт ертөнц I боть. УБ., 2003 он.

Дулам С, Хасбаатар Ц. Уран зохиолын онолын үүд. УБ., 1980 он.

Дулам С. Сэнхрэл уянга. УБ., 2004 он.

Лувсанцэрэн П. Усны эргүүлэг ба Борзооны явдал. УБ., 2013 он.

Монгол ардын зан үйлийн аман зохиол. ШУА., ХЗХ., УБ., 1987 он.

Монголын уран зохиолын дээжис. 2-р боть. Би хаана төрөө вэ? УБ., 1994 он.

Монголын сонгомол өгүүллэг. УБ., 2005 он.

Монголын уран зохиолын дээжис “ 93-р боть. Монгол ардын хошин шог үлгэр. ШУАХЗХ., УБ., 1984 он.

Монголын шилдэг жүжиг. УБ., 1981 он.

Нандинбилиг Г. Яруу найргийг задлан шинжилж, заан сургахуй. УБ, 2012 он.

Нандинбилиг Г. Жүжгийн зохиолыг задлан шинжилж, заан сургахуй. УБ, 2013 он.

Нандинбилиг Г. Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургах нь. УБ, 2016 он.

Ойдов Ч. Жүжгүүд. УБ., 1957 он.

Хомерийн туульс. Орчуулсан Ц.Цэдэндамба. УБ, 1974 он.

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Гарын авлага. БСШУЯ, УБ, 2015 он.

Шидэт хүүрийн үлгэр. Тэргүүн дэвтэр. Монгол бичгээс буулгасан А.Дашдэмбэрэл. Редактор Ж.Ганчимэг нар. “Соёмбо” хэвлэлийн газар. УБ., 1992 он.

Театр- 75. УДЭТ-ын 75 жилийн ойд зориулав. УБ., 2006 он.

Эрийн сайн Хан харангуй. Гар бичмэл эхүүдийг харьцуулан боловсруулж, оршил бичиж, тайлбар сэлт үлдсэн Р.Нарантуяа. УБ., 1986 он.